



СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
БАГШ, ТУСЛАХ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, СОЁЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА





**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
БАГШ, ТУСЛАХ БАГШ НАРТ ЗОРИУЛСАН**

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, СОЁЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

**Улаанбаатар
2023**

Энэхүү гарын авлагыг Боловсрол, шинжлэх ухааны яам, Азийн хөгжлийн банктай хамтран Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй «Тэгш хамруулах боловсролыг дэмжих» төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах, тэдэнд сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх, боловсрол эзэмших эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх орчин, хэрэглэгдэхүүнийг зөв, үр дүнтэй ашиглах талаар сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш, туслах багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулав. Тус сургалтын гарын авлагын агуулга нь санхүүжүүлэгч байгууллагын албан ёсны байр суурийг илтгэхгүй.

Сургалтын гарын авлагыг хэсэгчлэн болон бүрэн ашиглах тохиолдолд эх сурвалжийг заавал дурдана уу.

БОЛОВСРУУЛСАН:

Зөвлөх багийн ахлагч, Олон улсын зөвлөх, Доктор Жулиа Хэйс

МОДУЛЬ 1: **Жулиа Хэйс**, Тэгш хамруулах боловсролын олон улсын зөвлөх, доктор

МОДУЛЬ 2: **Б.Саранзаяа**, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш

МОДУЛЬ 3: **Б.Саранзаяа**, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш

МОДУЛЬ 4: **Х.Бямбажав**, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш

МОДУЛЬ 5: **Ч.Байгалмаа**, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш, доктор, дэд профессор

МОДУЛЬ 6: **Б.Энхтуяа**, Нийслэлийн Ерөнхий боловсролын 70 дугаар сургуулийн багш

МОДУЛЬ 7: **Ч.Байгалмаа**, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш, доктор, дэд профессор

МОДУЛЬ 8: **Г.Батцэнгэл**, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор

МОДУЛЬ 9: **Жулиа Хэйс**, Тэгш хамруулах боловсролын олон улсын зөвлөх, доктор

ХЯНАСАН:

Ч.Байгалмаа, МУБИС-ийн БоСС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийн багш, доктор, дэд профессор

Хэвлэлийн хуудас: 22 хх

Хэвлэсэн тоо: 300 ширхэг

Хэвлэсэн газар: “Очир Принтинг” ХХК

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	7-8
ГАРЫН АВЛАГЫН ТАНИЛЦУУЛГА	9
МОДУЛЬ 1: ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦОО	10-40
МОДУЛЬ 2: ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ	41-71
МОДУЛЬ 3: ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ	72-106
МОДУЛЬ 4: СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ	107-137
МОДУЛЬ 5: ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ	138-176
МОДУЛЬ 6: ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ	177-202
МОДУЛЬ 7: СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ	203-231
МОДУЛЬ 8: СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ	232-255
МОДУЛЬ 9: ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН УДИРДЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО	256-274

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БЕГ	Боловсролын Ерөнхий Газар
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГСТ	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
ДБ	Дэлхийн Банк
ICF	Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХБ	Хөгжлийн бэрхшээл
ХБХЭТК	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн Тухай Конвенц
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБИБ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХСБ	Тэгш хамран сургах боловсрол
СТЗ	Суралцахуйн түгээмэл загвар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЯОУХАБ	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

ӨМНӨХ ҮГ

Монгол Улс бол Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилгын хүрээнд 2030 он гэхэд бүх хүүхдэд чанартай, хүртээмжтэй тэгш боловсрол олгох үүрэг хүлээсэн дэлхийн олон орны нэг бөгөөд үүнд боловсролын үйлчилгээг бүрэн авч чадаагүй, ерөнхий боловсролын тогтолцооноос гадна, тусгаарлагдсан орчинд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах асуудал мөн хамаарна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц (ХБХЭТК)-ын ерөнхий зөвлөмж 4-т (НҮБ, 2016) тэгш хамран сургах боловсролын асуудал бол хүн бүрийн сурч боловсрох үндсэн эрх хэмээн тодорхойлжээ. Ерөнхий зөвлөмж 4-т бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахуйг дэмжих, суралцахуйн орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтойг дурджээ. Өөрөөр хэлбэл бүх шатны сургалтын байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих нэгдсэн тогтолцоо бүхий сурч боловсрох үндсэн орчин, үйл явцын төв байх ёстой гэжээ. Цаашилбал хүүхдийн хөгжлийн ялгаатай хэрэгцээ, суралцах хурд, суралцах хэв маягт тохирсон уян хатан сургалтын хөтөлбөр, багшлахуйн болон суралцахуйн материал бүхий тохируулгат орчин бүрдсэн байх ёстой юм. Энэ орчныг бүрдүүлэхийн тулд багш, сургуулийн удирдлагуудын чадавхыг бэхжүүлж, тэдэнд дэмжлэг үзүүлэх шаардлагатайг онцолсон байна.

Дээрх зорилгын хүрээнд БШУЯ, АХБ хамтран хэрэгжүүлж буй G9208-MON: **“Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл”**-ийн зөвлөх багаас **“Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагаа”** сэдвээр СӨБ-ын байгууллагын болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан сургалтын модуль бүхий гарын авлага бэлтгэн хүргэж байна.

Тус гарын авлагын агуулгыг сургууль, цэцэрлэгийн багш, захирлуудын сургалтын бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулахын тулд зөвлөх баг төслийн зорилтот сургууль, цэцэрлэгийн багш нар, удирдах ажилтнуудаас сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааг санал асуулгын болон фокус бүлгийн ярилцлагын аргаар хийж, үр дүнд шинжилгээ хийсэн юм. Судалгаагаар багш нарт тулгарч буй нийтлэг асуудал, бэрхшээл, сургалт, хөгжлийн суурь хэрэгцээг хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрээр тодорхойлсон ба энэхүү судалгааны үр дүнд үндэслэн хөгжлийн бэрхшээлийн төрөл бүрээр Суралцахуйн түгээмэл загварын үндсэн зарчимд суурилсан арга зүйн зөвлөмж бүхий сургалтын гарын авлага боловсруулж, холбогдох дасгал ажил, хэрэглэгдэхүүн, үнэлгээ зэргээр баяжуулав.

Энэхүү сургалтын гарын авлага нь тэгш хамран сургах боловсролыг сургууль, цэцэрлэгийн орчинд хэрэгжүүлэхийг зорьж байгаа захирал, эрхлэгч, багш нарын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хөтөч болж, тэгш оролцоо, тэгш боломжийг бүрдүүлж ажиллахад дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

ГАРЫН АВЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Сургалтын гарын авлагын зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн мэдлэг, ойлголт, чадвар бүхий цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн багш бэлтгэх, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ашиглаж буй багш порталд байршуулж, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх юм.

Гарын авлагын бүтэц

Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагаа сэдэвт энэхүү гарын авлага нь нийт 48 цаг үзэж судлах 9 модулиас бүрдсэн бөгөөд модуль тус бүрт ерөнхий мэдээлэл, дасгал, үйл ажиллагаа, хавсралт, нэмэлт судлах материалын жагсаалт зэргийг багтаав.

Та бүхэн модуль хичээлээ судлахын зэрэгцээ цахим эх сурвалжуудаас сургалтад хэрэглэх нэмэлт материал, видео хичээлүүдийг үзэж, мэдлэг, ойлголтоо бататгах боломжтой.

Та бүхэнд амжилт хүсье

МОДУЛЬ 1:

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦОО



Зорилго	Тэгш хамран сургах боловсролын бодлого, тогтолцоо, соёл, орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх
Зорилт	<ul style="list-style-type: none"> • Тэгш хамран сургах боловсролын бодлого, тогтолцооны талаар үндсэн ойлголт өгөх • Тэгш хамран сургах боловсролын соёл, орчин бүрдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх • Суралцахуйн түгээмэл загварт суурилсан тэгш хамран сургах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, анги танхим сургалтын орчноо сайжруулах хандлага төлөвшүүлэх
Хугацаа	5 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Тэгш хамран сургах боловсролын бодлого, тогтолцоо (120 минут)</p> <p>Сэдэв 2. Тэгш хамран сургах боловсролын орчин ба соёл (90 минут)</p> <p>Сэдэв 3. Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагаа (90 минут)</p>	

СЭДЭВ 1. ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТОГТОЛЦОО

Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрх, хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургахад чиглэсэн бодлого, чиг хандлага, үндсэн ухагдахууныг тайлбарлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тэгш хамран сургах боловсролын бодлого, холбогдон гарсан хууль эрх зүйн баримт бичгийн талаар тайлбарлах
- Тэгш хамран сургах боловсролын бодлого, хууль, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх
- Тэгш хамран сургахад чиглэсэн тогтолцоо, сургалтын хөтөлбөрийн хувилбаруудыг харьцуулан тодорхойлох

Хугацаа: 120 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 3: Багийн ажилд зориулсан асуултыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 4: Хүснэгтийг дэлгэц цаасан дээр томоор зурж бэлтгэсэн байх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тэгш хамран сургах боловсролын бодлого, түүнийг хэрэгжүүлж буй байдал (55 минут)

1. Тус үйл ажиллагааны хүрээнд тэгш хамран сургах боловсролын бодлого, түүний хэрэгжилтийн талаар судална гэдгийг хэлж, оролцогчдыг 5 багт хуваана. Баг тус бүрт дараах асуултаас нэг нэгийг оноон өгч, багаараа ярилцан өөрсдийн санааг дэлгэц цаасан дээр бичихийг хүснэ. Тэдэнд 10 минутын хугацаа өгнө.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрхийг манай улсад хэрхэн баталгаажуулсан байдаг вэ?
 - Монгол Улс тэгш хамран сургах боловсролын талаар ямар бодлого баримталж байна вэ?

- Манай улсад ТХСБ-ын чиглэлээр бодлогын ямар баримт бичиг, журам байдаг вэ? Тэдгээрийг гол санааг илэрхийлнэ үү.
 - Танай сургууль, цэцэрлэг ТХСБ-ын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа вэ?
 - Хэрвээ ТХСБ-ын бодлогыг хэрэгжүүлж эхлээгүй бол өөрийн сургууль, цэцэрлэгтээ хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?
2. Баг тус бүр бичсэн зүйлээ ээлжлэн танилцуулна. Бусад багаас асууж тодруулах болон нэмэх зүйл байгаа эсэхийг лавлана.
 3. Баг бүрт хавсралт 1-ийг тараан өгч, уншиж судлахыг хүснэ. Судлах явцдаа багуудын танилцуулсан зүйлтэй нийцэж байгааг эсэхийг багаараа хэлэлцэн тодорхойлно.
 4. Дараах асуултыг ашиглан баг тус бүрийн танилцуулсан зүйл бүрээр бүгдээрээ хамтран ярилцаж, дүгнэнэ. Шаардлагатай бол багш нэмж тайлбарлана.
 - Тухайн багийн танилцуулсан зүйл хэр үнэн зөв, бодитой байна вэ?
 - Тус багийн гаргасан санаанд тусгагдаагүй ямар санаанууд байна вэ?
 - Тус багийн танилцуулсан зүйлээс засаж өөрчлөх ямар санаа байна вэ?
 - Тэгш хамран сургах боловсролтой холбоотой бодлогын баримт бичиг, журамд тусгагдсан ямар зүйл, заалтууд бодит амьдрал дээр ихэнхдээ хэрэгжихгүй байна вэ? Үүний шалтгаан нь юу вэ?

Үйл ажиллагаа 2: Тэгш хамран сургах боловсролд чиглэсэн тогтолцооны талаарх ойлголт (60 минут)

1. Оролцогчдоос дараах асуултыг асууж, ярилцана.
 - Та бүхэн тэгш хамран сургах боловсролд чиглэсэн тогтолцоог хэрхэн ойлгож байна вэ?
 - Тэгш хамран сургахад чиглэсэн тогтолцоог бий болоход ямар хүчин зүйлс нөлөөлнө гэж үзэж байна вэ?

Оролцогчдын хэлсэн зүйлийг самбарт эсвэл дэлгэц цаасан дээр бичиж тэмдэглэнэ.

2. Оролцогчид өмнөх 5 багаар үргэлжлүүлэн ажиллана. Баг тус бүрт хавсралт 2-ыг хавсралт 3-т байгаа асуултын хамт тараан өгнө.
3. Хавсралт 3-т байгаа асуултын хариуг хавсралт 2-т байгаа мэдээллийг уншиж судлах замаар олж авна гэдгийг тайлбарлаж, тэдэнд 15-20 минутын хугацаа өгнө.
4. Багууд тараах материал дахь мэдээллийг судалж дууссаны дараа асуулт хариултын уралдааныг дараах байдлаар зохион байгуулна.

- Дэлгэц цаасан урьдчилан зурж бэлтгэсэн хүснэгтийг (хавсралт 4) самбар дээр эсвэл хананд байрлуулна.
- Багш хавсралт 3-т байгаа асуултаас асууж, хамгийн түрүүнд гараа өргөсөн баг хариулна.
- Асуултад зөв хариулсан бол тус багт 1 оноо өгнө. Хэрвээ хариулт буруу эсвэл хангалтгүй бол дараагийн баг хариулна.
- Хамгийн олон асуултад үнэн зөв хариулсан багийг ялагчаар тодруулна.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцаж сэдвийг дүгнэнэ.

- ТХСБ-ын бодлого, тогтолцооны талаар юу мэдэж авсан бэ?
- ТХСБ-ын бодлогыг өөрийн цэцэрлэг, сургуульд хэрхэн хэрэгжүүлэх вэ?
- Бүх суралцагчдын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх боломжтой юу? Үүнийг хэн хийх вэ?

ХАВСРАЛТ 1

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО - ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Тэгш хамран сургах боловсрол гэж суралцахуйн бүхий л үйл явцад тулгарах аливаа саад, бэрхшээлийг тодорхойлж, түүнийг арилгах замаар бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид чанартай, тэгш боломж, нөхцөлд суралцах үйл явцыг хэлнэ.¹ Өөрөөр хэлбэл боловсрол, сургалтын хүртээмж, явц, үр дүн нь тухайн суралцагчийн ар гэрийн байдал, эцэг эхийн боловсрол ба орлогын түвшин, амьдарч буй газар орон, үндэс угсаа, хэл соёл, хөгжлийн онцлог зэрэг тухайн хүнээс өөрөөс нь хамаарахгүй хүчин зүйлээс шалтгаалдаг байж болохгүй юм.²

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.7 дугаар заалтаар Монгол хүний сурч боловсрох эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр Боловсролын тухай хуулийн 5.1.4-д “иргэнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ...” ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох, тэгш боломж нөхцөлөөр хангах зарчмыг баримтлах тухай зааснаас гадна тус хуулийн 6.1-д иргэн бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу сурч эзэмших эрхтэй болохыг тусгажээ.

2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд бусад хүүхдийн хамт сургуульд сурч боловсрох эрхтэй, бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ гэж тодорхой заасан байна. Тухайлбал, тус хуулийн 12.1-д “Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй” хэмээн тодорхой заасан бол 13.1-д “Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана”, 14.3.1-д Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн бэрхшээлээс нь үл хамаарч бүх шатны боловсролын байгууллагад бүрэн хамруулах” тухай хуульчилсан байдаг.

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн суралцах орчныг бүх шатны сургалтын байгууллагад бий болгох тухай дээрх заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой мөн хуулийн 16.2-р хэсэгт «бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна” хэмээн заажээ.

1 <https://www.unesco.org/en/education/inclusion>

2 Бүх нийтийн боловсролын төлөө ИНБ, Тодорхой бүлгийн хүүхдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд, чанарын судалгааны тайлан, 2020

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын 2017.06.09 өдрийн №46 тоот тогтоол батлагдсан байна. Тус тогтоолын холбогдох заалтуудад:

- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, холбогдох байгууллага, албан тушаалтныг оролцуулан сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрогт байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог нарийвчлан гаргаж, тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэн ажиллах;
- Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгдүүлж ажиллах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах зэрэг тодорхой зохицуулалтуудыг тусгажээ.

Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургахад чиглэсэн бодлого, хууль эрх зүйн хэд хэдэн баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж байна. Бодлого, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байна. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050 болон Боловсролын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөнд бүх хүүхдийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангахын тулд тэгш хамран сургах боловсролын тогтолцоог бэхжүүлэх зорилт тавигдсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа 2050”-д хүн бүрт чанартай боловсрол эзэмших, тэгш боломжийг бий болгох зорилтыг дэвшүүлж, эхний үе шат буюу 2030 он хүртэл тэгш хамруулсан боловсролын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Тухайлбал, боловсролын салбар тус бүрт иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах зорилтыг тусгасан байна. Боловсролд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрт шаардлагатай дэмжлэг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.



2021 оны 9 дүгээр сард батлагдсан “Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030”-д бүх түвшний боловсрол, сургалтын үйл ажиллагааг хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн хэрэгцээ, хөгжлийн онцлогт нийцүүлэн, уян хатан байдлаар зохион байгуулах, ингэхдээ мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах, орон зай, цаг хугацаанаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих нээлттэй сан, цахим сургалтыг хөгжүүлэх, суралцагчийн сурлагын амжилтын ялгааг багасгах, багш бүрт ялгаатай хэрэгцээтэй суралцагчидтай ажиллах чадвар эзэмшүүлэх, сургалтын орчныг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тохируулан тохижуулах, шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлуудыг тусгажээ.



Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн холбогдох арга зүй, сурган сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд дараах журам, тогтоолууд батлагдан гарсан байна.

МУ-ын БСШУС-ын сайдын 2018 оны А/155 тоот тушаалаар батлагдсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, аргачлал”

МУ-ын БШУ-ны сайдын 2022 оны А/206 тоот тушаалаар батлагдсан «Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ГСТ боловсруулах аргачлал»

Тус үйл явц нь хүүхдийн хөгжлийн бодит байдал, бэрхшээлийн онцлогт тулгуурлан сургуулийн болон гэрийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах, тэдний хөгжлийг дэмжсэн сургалтын агуулгатай, урт болон ойрын хугацааны зорилтыг багтаасан багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийг багтаасан тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах үйл явцад холбогдох бүх талын (ангийн багш, суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчид, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, эмч гэх мэт) оролцоог хангахыг зорьсон нь хүүхэд холбогдох боловсролын түвшинд хамаарах чанартай боловсролыг авахад шаардлагатай дэмжлэг, боломжийг бүрдүүлэхэд чиглэжээ. Гэвч дэлхийн бусад улс оронд түгээмэл ажиглагддаг асуудал болох бодлого ба хэрэгжилтийн шатанд зөрүүтэй, үр дүн багатай байх, сургалтын байгууллагын түвшинд төлөвлөгөөг бие даан боловсруулах мэдлэг, чадвар дутагдаж байгаа нь салбарын мэргэжлийн байгууллагуудын болон донор байгууллагуудын хийсэн судалгааны үр дүнгээс харагдаж байна.³

3 IRIM, 2019; НҮБ-ын БШУСБ, 2020

БСШУС-ын сайдын А/292 тоот тушаалаар 2019 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хэв шинжтэй ерөнхий боловсролын сургуульд суралцахад сургалтыг хэрхэн зохион байгуулах, дэмжлэгийг хэрхэн үзүүлэх талаар тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 01 - ний өдрийн “Журамд нэмэлт оруулах тухай” 208 дугаар тогтоол

Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн. Ингэснээр дараах ач холбогдолтой гэж үзсэн:

- Цэцэрлэг, сургуульд хамрагдаагүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамран сургах тойргийнхоо цэцэрлэг, сургуульд хамрагдах нөхцөл бүрдэх;
- Ердийн сургуульд ажиллаж байгаа багш ангийн нийт суралцагчтай ажиллахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хичээлийн бус цагаар хэрэгжүүлэх нэмэлт ажлын чанар, үр дүн сайжрах;
- Ердийн сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын чанарт ахиц гарах, нийгэмших, биеэ авч явах, амьдрах чадварт ахиц гарах.

Засгийн газрын 2020 оны 208 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар”-ыг БСШУС-ын сайдын 2020 оны А/296 дугаар тушаалаар баталж, энэхүү заавар 2021 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.

Заавар батлагдсанаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын орон нутаг дахь салбар комисс”-ын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдсон хүүхэдтэй ажиллаж байгаа цэцэрлэгийн багш, туслах багш, бага, дунд, ахлах анги удирдсан болон хүүхэд хөгжлийн танхимын багш ажлын үр дүнгээ үнэлүүлж нэмэгдэл хөлс авах боломж бүрдсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл” батлагдсан.

“Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл” нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ганцаарчилсан сургалт явуулах, тэдний хөгжлийг дэмжих ажил зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагчдыг зөвлөгөө мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах талаар ерөнхий боловсролын сургуулийн удирдлагад удирдамж болох юм.

«Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай» Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар тогтоол

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах хүрээнд бүх шатны сургалтын байгууллагад сургалтын хүртээмжтэй орчин бүрдүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2020 оны 235 дугаар тогтоол батлагджээ.

Тогтоолоор тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын суралцах эрхийг хангах чиглэлээр ойрын ирээдүйд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон юм.

ХАВСРАЛТ 2

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛД ЧИГЛЭСЭН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Хөгжлийн бэрхшээлийг анагаахын загварын үүднээс тайлбарлаж, ойлгох хандлага Монголчуудын дунд түгээмэл.⁴ Энэ нь бэрхшээлийг хүүхдийн бие эрхтэнд байдаг “асуудал” хэмээн ойлгож, улмаар тухайн хүүхдэд үзүүлж буй дэмжлэг нь асуудлыг эмчилж, сэргээн засахад илүүтэй чиглэгддэг гэсэн үг юм. Гэвч энэ загвар нь хүрээлэн буй орчны нөлөө, бэрхшээл нь тухайн хүүхдэд хэрхэн нөлөөлж буйг төдийлөн анхаарч үздэггүй. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлийг анагаахын загвараар тайлбарлавал: «асуудал хүүхдийн бие эрхтэнд эсвэл оюун санаанд байна» хэмээн үзэж, дараах зүйлд анхаарал хандуулна.

- Асуудлыг олох хэрэгтэй
- Асуудлыг эмчилж, эдгээх хэрэгтэй

Тиймээс Английн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн зүтгэлтэн Оливер (1990) хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварыг боловсруулжээ. Энэ загвар нь хөгжлийн бэрхшээлийг хувь хүний онцлог шинж гэхээсээ илүүтэй хүрээлэн буй орчны нөлөөгөөр нийгмээс бий болгож буй асуудал гэж үздэг. Жишээлбэл, нийгмийн саад бэрхшээл буюу сөрөг хандлага, хөдөлгөөний саад бэрхшээл буюу хүртээмжгүй байдлаар зохиомжлогдсон барилга байгууламж эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чадвар чадамжид тохирохгүй, зөвхөн унших, бичих чадварт суурилсан сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт. Иймд хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар нь асуудал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд биш, орчинд нь байна гэж үздэг.

Хөгжлийн бэрхшээлийг нийгмийн загвараар тайлбарлавал «Суралцахуйн, харааны, сонсголын зэрэг бэрхшээлтэй байна гэдэг нь нийгмийн хэвийн үзэгдэл юм» гэж үзнэ. Тухайлбал:

- Асуудал эргэн тойронд оршиж байна
- Материаллаг зүйл болон нийгмийн саад бэрхшээлүүд
- Хүүхдийг эмчлэх, засан сайжруулахаас илүү нийгэм, орчныг өөрчлөхөд анхаардаг



4 Батхуяг, 2021

Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлж буй хамгийн сүүлийн үеийн хандлага нь анагаахын болон нийгмийн загварыг хослуулан авч үзсэн бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, Тогтвортой Хөгжлийн Зорилтын хэрэгжилттэй нийцүүлэн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас био-психо- нийгмийн загварыг боловсруулсан байдаг. Хөгжлийн бэрхшээлийг өргөн хүрээнд авч үзвэл, хөгжлийн бэрхшээлтэй хүний согог, эрүүл мэндийн байдлаас гадна нийгмийн амьдралд оролцоход нь саад болж буй хүчин зүйлс, түүний харилцан хамаарлыг давхар анхаарах ёстой гэж Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д тайлбарлажээ. Гэхдээ эдгээр хүчин зүйлс нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхцөл байдал, онцлогоос мөн хамаарна.⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйлийн 1.1.1 хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолт нь хөгжлийн бэрхшээл гэдэг нь зөвхөн эрүүл мэндийн нөхцөл байдлыг илэрхийлсэн ойлголт биш харин нийгэм, хүрээлэн буй орчны зүгээс тухайн хүнд үзүүлж буй хязгаарлалтууд юм гэсэн НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын тодорхойлолттой нийцэж байгаа юм. Энэ загварын үндсэн санаа нь тухайн хүний сурч боловсрох, нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй хүндрэлийн түвшин нь тухайн хүний амьдралын чанар, хүйс, оршин буй орон нутаг /хот суурин, хөдөө, алслагдмал орчин/, үндэс угсаатай харилцан хамааралтай гэдгийг авч үзсэн явдал юм. Монгол Улсын нийт хүн амын 28.4%-ийг ядуу иргэд эзэлж байгаа бөгөөд ядуурал нь хөгжлийн бэрхшээлийг бий болгох шалтгаан болохоос гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд ядууралд илүү өртөж байгааг харуулж байна.⁶ Ядууралд нэгэнт өртсөн тохиолдолд тухайн иргэн, өрх эмзэг байдалд орж, тусгаарлагдах, хангалттай тэжээллэг хоол хүнс хэрэглэх, баталгаатай орон байр, ариун цэврийн байгууламжтай байх боломжоор дутагдах гэх мэт олон асуудалд өртөхөөс гадна тухайн ХБ-тэй иргэнийг асран хамгаалагч нь орлогын эх үүсвэрээ алдсанаар эрүүл мэндийн байгууллагаас дэмжлэг авах боломж мөн тэр хэрээр хязгаарлагдаж эхэлдэг.⁷

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын Ерөнхий зөвлөмж 4-т тэгш хамран сургах боловсрол нь бүхий л суралцагчдын суурь эрх гэж заасан бөгөөд дараах зарчмаар томъёологдоно гэж үзсэн. Үүнд:

“Бүх суралцагчдын сайн сайхан байдлыг эн тэргүүнд тавьж, тэдний төрөлхийн эрхэм чадвар, бие даасан байдлыг хүндэтгэж, нийгмийн амьдралд оролцож, хувь нэмрээ оруулах тухайн хүний чадвар чадамж болон хувь хүний зүгээс тавих шаардлагыг хүлээн зөвшөөрнө.”

5 Норвич 2014.

6 Митра, Посарах & Вик 2012

7 Женкин. 2017

Ерөнхий зөвлөмж нь тогтолцоо бүхэлдээ гэсэн арга хандлагыг авч үзэхийг санал болгодог. Өөрөөр хэлбэл, төрийн бүх түвшинд соёл, бодлого, үйл ажиллагаагаа өөрчлөх замаар хүүхдийн сурах үйл явцыг боловсролын тогтолцооны орчинд нь дэмжих үзэл санааг тууштай баримтална. Улмаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сургахад дагаад сургалтын хөтөлбөр, багшлахуйн болон суралцахуйн арга барилын тохируулга зэрэг бүтцийн өөрчлөлт хийгдэхгүй бол тэгш хамран сургах боловсрол жинхэнэ утгаараа хэрэгжих боломжгүй гэж үздэг.

Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг харгалзан үзэж, тэдний чадвар чадамж, шаардлага, сурах хэв маягт нийцсэн уян хатан сургалтын хөтөлбөр боловсруулж, багшлахуйн болон суралцахуйн арга барилаар дэмжих нь зүйтэй хэмээн тайлбарлажээ. Ацедогийн (2011) үзэж буйгаар бүх суралцагчийн хэрэгцээнд тохирсон тэгш хамруулах хөтөлбөр нь суралцагчдын сурах хэв маягт нийцэж өөрчлөгдөх боломжтой, тэдний хэрэгцээ, шаардлагад тохирсон мэдлэг чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн, суралцагчид амжилт гаргаж буйгаа хэмжих боломжтой, энгийн чадваруудыг олон янзаар авч үзсэн ахицын үнэлгээний системийг агуулсан бүтэцтэй байна гэжээ. Гэсэн хэдий ч дэлхийн өмнөд бүсийн олон орны сургалтын хөтөлбөр хэт нүсэр, уян хатан бус байдгийг Роуз, Алкотт нар онцолжээ.

Өөрчлөх, шинэчлэх, тохируулга хийх боломжгүй уян хатан бус сургалтын хөтөлбөр нь сургуулийн орчинд тэгш хамран сургах боловсрол хэрэгжихэд төдийлөн нэмэр болдоггүйг олон орны судалгаа батлан харуулжээ.⁸ Сургалтын үр дүнгийн цар хүрээ, олон талт байдлыг өргөжүүлж, сурагчид тэрхүү үр дүнд хүрэх арга хувилбарыг нэмэгдүүлэх нь тэгш хамруулах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.⁹

Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын (НУБШУСБ) Боловсролын олон улсын товчооноос ангийн орчинд тэгш хамран сургах боловсролын соёл болоод үйл ажиллагааг хөгжүүлэхийн тулд дараах найман үзүүлэлтийг боловсруулжээ. Үүнд:

- Бүх суралцагчийн онцлогийг харгалзаж, хичээлээ төлөвлөсөн байх
- Хичээл нь бүх суралцагчийн оролцоог идэвхжүүлсэн байх
- Сурагчид бие даан сурах үйл явцад идэвхтэй оролцдог байх
- Сурагчид бие биеийнхээ сурах үйлийг дэмжиж, урамшуулдаг байх
- Сурагчид шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудалтай тулгарахад тусалдаг байх
- Харилцан бие биеэ хүндэлсэн ангийн сахилга баттай байх
- Сурагчид сэтгэл гонсойж, санаа зовсон үедээ ярилцах хүнтэй гэдгээ мэдэрдэг байх
- Үнэлгээ нь бүх суралцагчийн ололт амжилтыг сайшаадаг байх

8 Роуз & Алкотт, 2015; ТХТХБЕА, 2011; Шуелка, 2018

9 ТХТХБЕА, 2017; Нелсон, 2014

Гэсэн хэдий ч сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон байдлаар боловсруулах асуудал одоо ч маргаан дагуулсан хэвээр байна. Жишээлбэл, Кени болон Руанда улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношинд тохируулж, тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Харин олон улсын судалгааны бүтээлүүдэд¹⁰ үүн шиг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг төдийлөн сайшаадаггүй. Энэ нь хүүхдийг бусдаасаа тусгаарлагдсан орчинд сурах хэрэгтэй гэсэн санааг дэмжээд зогсохгүй ХБХ-тэй зөвхөн тусгай, мэргэшсэн багш ажиллах ёстой мэт ойлголт төрүүлдэг байна. Энэ нь багш нар төрөл бүрийн суралцахуйн хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах чадвартаа эргэлзэхэд хүргэдэг. Түүний оронд хүртээмжтэй сурган хүмүүжүүлэх ухааныг урьтал болгож, ангид зааж буй аливаа сэдвийн агуулга бүх хүүхдэд тохирсон хүртээмжтэй байх ёстой гэж олон улсын судалгааны бүтээлүүд үзсэн байна.¹¹ Улс орнууд сургалтын хөтөлбөрөө хүүхэд бүрийн онцлогт тохируулж, хүртээмжтэй болгох гурван аргыг тодорхойлжээ.

Доорх хүснэгтэд дэлхийн бусад улс оронд хэрэглэж байгаа хөтөлбөрөө өөрчлөх, тохируулга хийхээс эхлээд бие даах чадварыг хөгжүүлэх нэмэлт заавар, зааварчилгаа өгөх зэрэг олон чухал санааг багтаасан гурван арга замыг тайлбарлалаа.

Хүснэгт 1: Сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэх хувилбарууд

Сургалтын хөтөлбөрийн төрөл	Тодорхойлолт	Жишээ
Тохируулгат сургалтын хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энгийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтын үр дүнд хүрэх ч тухайн хүүхдийн чадварт нийцүүлэн тохируулга хийснээр тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ.	Харааны бэрхшээлтэй хүүхэд брайль сурах бичиг ашиглах, сонсголын бэрхшээлтэй хүүхэд дохионы хэлээр мэдээлэл авах гэх мэт
Баяжуулсан сургалтын хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энгийн хүүхэдтэй ижил агуулга судлах бөгөөд бие даах чадварыг дэмжсэн нэмэлт заавар, зөвлөмж багтсан байна.	Харааны бэрхшээлтэй хүүхдэд хөдөлгөөний болон орон зайн баримжааны чадвар эзэмшүүлэх
Өөрчилсөн сургалтын хөтөлбөр	Бусад хүүхэдтэй ижил агуулга судлах ч сургалтын үр дүн өөр байх магадлалтай тул шаардлагатай тохиолдолд хувь хүний онцлогт тохируулан сургалтын хөтөлбөрийг өөрчилсөн байна. Гэхдээ энэ нь ижил оноштой бүх хүүхдэд зориулсан стандарт хөтөлбөр биш юм.	Оюун ухааны бэрхшээлтэй хүүхэд бусдаасаа бага үг сурах хандлагатай байдаг.

Эх сурвалж: Хэйс, Тернбулл, Моран нар (2018)

10 Флориан & Линклейтер, 2010; Хэйс, Тернбулл & Моран, 2021)

11 Флориан & Спрат 2013; Уэстбрук, 2013) Хэйс, Тернбулл, Моран (2018)

ХАВСРАЛТ 3

БАГИЙН АЖИЛД ЗОРИУЛСАН АСУУЛТ

1. Хөгжлийн бэрхшээлийг тайлбарласан анагаахын, нийгмийн, био-психо-нийгмийн загвар тус бүрийн онцлогийг харьцуулан тайлбарлана уу.
2. «Тогтолцоо бүхэлдээ» гэсэн арга хандлага нь ямар үзэл санааг илэрхийлдэг вэ?
3. Бүх суралцагчийн хэрэгцээнд нийцсэн тэгш хамруулах хөтөлбөр ямар онцлогтой байх вэ?
4. Ангид тэгш хамран сургах боловсролын соёл, үйл ажиллагааг хөгжүүлэхэд анхаарах зүйлийг нэрлэнэ үү.
5. Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс нь хамааран тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зөв үү? Энэ нь хэр оновчтой вэ?
6. Суралцагчдын хэрэгцээнд нийцүүлсэн сургалтын хөтөлбөрийн ямар хувилбарууд байдаг вэ?
7. Тохируулгат сургалтын хөтөлбөр гэж юу вэ? Тодорхой хөгжлийн бэрхшээл дээр жишээ гаргаж, тайлбарлана уу.
8. Баяжуулсан сургалтын хөтөлбөр гэж юу вэ? Тодорхой хөгжлийн бэрхшээл дээр жишээ гаргаж, тайлбарлана уу.
9. Өөрчилсөн сургалтын хөтөлбөр гэж юу вэ? Тодорхой хөгжлийн бэрхшээл дээр жишээ гаргаж, тайлбарлана уу.

ХАВСРАЛТ 4

АСУУЛТ, ХАРИУЛТЫН УРАЛДААНЫГ ДҮГНЭХ ХУУДАС

Баг	Асуулт									Нийт оноо
	1	2	3	4	5	6	7	8	9	
I										
II										
III										
IV										
V										

СЭДЭВ 2: ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ОРЧИН БА СОЁЛ

Зорилго: Тэгш хамран сургах боловсролын соёл, орчин, жендэрийн мэдрэмжтэй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд соёл, жендэрийн хүчин зүйлийг анхаарч авч үзэх талаар тайлбарлах
- Тэгш хамран сургах боловсролын орчин бий болгоход шаардлагатай мэдээлэл, ойлголт, арга хэлбэрийг тодорхойлох
- Практик зөвлөмжийг судалж, сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Соёл ба жендэрийн мэдрэмжтэй байдал (45 минут)

1. Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд жендэрийн тэгш байдал, соёлын ялгаатай байдал, түүний үзүүлэх нөлөөний талаар судална гэдгийг хэлж, оролцогчдоос дараах асуултыг асууж, ярилцана.
 - Та бүхэн “жендэрийн тэгш байдал”, “соёлын ялгаатай байдал” гэсэн ойлголтуудыг хэрхэн тодорхойлох вэ?
 - Боловсролд тэгш хамруулахад соёл, жендэрийн мэдрэмжтэй хандана гэдгийг хэрхэн ойлгох вэ?

Оролцогчдын хэлсэн санааг самбарт эсвэл дэлгэц цаасан дээр бичиж тэмдэглэнэ.

2. Оролцогчдыг сууж буй байрлалаар нь 3 хүнтэй багт хуваана. Баг тус бүрт хавсралт 1-ийг тараан өгч, багийн гишүүд өөрт оногдсон хэсгийг уншиж судлаад бусад гишүүддээ тайлбарлана.
3. Багш урьдчилан бэлтгэсэн слайд ашиглан (хавсралт 1-д байгаа мэдээллийг PPT слайд байдлаар бэлтгэсэн байх) товч танилцуулан, ярилцаж нэгдсэн ойлголтод хүрнэ.

Үйл ажиллагаа 2: Тэгш хамран сургах боловсролын орчныг хэрхэн бүрдүүлэх тухай (40 минут)

1. Тэгш хамран сургах боловсролын орчин бүрдүүлэхэд шаардлагатай хүний нөөц, эх сурвалж, хүчин зүйлс тэдгээрийн үзүүлэх нөлөөний талаар судална гэдгийг хэлнэ. Оролцогчдыг сууж буй байрлалаар нь 2 багт хуваана. Баг тус бүрт дараах асуултаас нэг нэгийг оноон өгч, багаараа ярилцан өөрсдийн санааг дэлгэц цаасан дээр бичихийг хүснэ. Тэдэнд 10 минутын хугацаа өгнө.
 - Та бүхэн тэгш, хүртээмжтэй сургалтын орчин гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлох вэ?
 - Та бүхний бодлоор боловсролд тэгш хамруулах орчин нь сургалтын үйл явцад хэрхэн нөлөөлөх вэ?
2. Баг тус бүр бичсэн зүйлээ ээлжлэн танилцуулна. Бусад багаас асууж тодруулах болон нэмэх зүйл байгаа эсэхийг лавлана. Баг бүрийн танилцуулгад тулгуурлан хавсралт 2-т байгаа мэдээллийг товч танилцуулж, нэгдсэн ойлголтод хүрнэ.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцаж сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд шинээр юуг мэдэж авсан бэ?
- Эдгээрийг өөрийн цэцэрлэг, сургуульд хэрхэн хэрэгжүүлэх вэ?

ХАВСРАЛТ 1

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД СОЁЛЫН БОЛОН ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БАЙДАЛ

Монгол Улсын урт хугацааны хөтөлбөр “Алсын хараа 2050”-д “Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангана” гэсэн зорилт дэвшүүлсэн. 2022 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 1.2 хувь, ерөнхий боловсролын сургуульд 19.8 хувь, мэргэжлийн боловсролын сургуульд 65 хувь, их дээд боловсролын байгууллагад 38.7 хувь нь эрэгтэй багш ажиллаж байна.

Боловсролын тухай Монгол Улсын хууль (5.1.4 дэх заалт). Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана.

Дэлхий нийтийн нийтлэг зорилго болсон ТХЗ-ын 4 дэх зорилго болон Монгол улсын Боловсролын тухай хуульд боловсролын бүх түвшинд “тэгш хамруулах”, **“жендэрийн тэгш байдал”**-ыг хангах нийтлэг зорилго дэвшүүлсэн нь маш чухал ач холбогдолтой юм. Боловсрол дахь жендэрийн тэгш байдал нь охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй хүмүүст бүрэн боловсрол эзэмших боломж олгохоос гадна чанартай боловсролоор дамжуулан тэднийг адил тэгш чадавхжуулахыг шаарддаг:

- Охид, хөвгүүд боловсролын үйлчилгээнд хамрагдах, боловсрол эзэмших, үр шимийг нь хүртэх эрхээ бүрэн эдлэхэд учрах саад бэрхшээлийг арилгах;
- Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг үл зөвшөөрөх;
- Боловсролоор дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх

Тайлбар: Жендэрийн хэвшмэл үзэл (stereotype) гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн шинж чанар, байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх нийгэмд тогтсон итгэл үнэмшил, хүлээлт.

- Эмэгтэйчүүдийг цалин хөлсгүй (гэрийн) хөдөлмөрийн (хүүхэд асрагч), эрэгтэйчүүдийг цалин хөлстэй (ажил эрхэлдэг, тэжээгч) хөдөлмөрийн үүрэгтэйгээр, эмэгтэйг эрх мэдэлгүй, эрэгтэйг эрх мэдэлтэй, ноёрхогч,
- эмэгтэйг гэрт, эрэгтэйг нийтийн амьдралын хүрээнд, эмэгтэйг өрөвч зөөлөн, сул дорой, аймхай, хамааралтай, эрэгтэйг түрэмгий, хэрцгий, зоригтой, гэмт хэрэгтэн гэх мэтчилэн хэт нэг тал руу туйлширч байвал хэвшмэл үзлээр хандаж байна гэж үзнэ.
- Алагчлах буюу тодорхой үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн анги, давхраа зэрэг нийгмийн категорийн талаарх өөрсдийн соёлын итгэл үнэмшил, үзэл сурталд суурилан илүүд эсвэл дорд үзсэн үзэл хандлага. Жишээ нь, тодорхой категорийн хүний бие махбод, сэтгэл зүй, нийгмийн чанаруудыг дөвийлгөж,

сул талыг өгүүлэхгүй атлаа бусдын сайныг бус, сул талыг тодотгож, нэр, хоч, шошго нааж, үл тоосон, хэн ч бишээр хандсан, үл үзэгдэгч болгож буй илэрхийлэл үүнд хамаарна. Санаатай, санамсаргүйгээр дорд үзсэн “нэр, хоч, шошго”-ыг хэрэглэхийг үүнд хамааруулна.¹²

“Тэгш хамарсан”, “жендэрийн мэдрэмжтэй” сургууль, цэцэрлэг ямар байх вэ?

Тэгш хамарсан, жендэрийн мэдрэмжтэй сургууль, цэцэрлэг нь охид, хөвгүүд, өөр хэлээр ярьдаг угсаатны цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн зэрэг ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд оюун санааны, нийгмийн болон материаллаг орчин бүрдүүлж чанартай боловсролын үйлчилгээ үзүүлнэ.

Жендэрийн мэдрэмжтэй сургууль, цэцэрлэг¹³ нь тэгш эрх, тэгш байдлыг хангах, ялангуяа охид хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн таатай орчин бүрдүүлэхэд анхаардаг. Түүнчлэн охид хөвгүүдэд найрсаг, аюулгүй, хамгаалагдсан сургалтын орчныг мэдрүүлэх ёстой. Сургууль хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид, жендэрийн мэдрэмжтэй, чанартай боловсрол олгоход онцгой анхаарал хандуулах ёстой.

НҮБ-ын Хүүхдийн сангаас боловсруулсан эрхэд суурилсан, хүүхдэд ээлтэй сургуулийн тогтолцоо¹⁴

Эрхэд суурилсан, хүүхдэд ээлтэй сургуулийн тогтолцоо нь хүүхдийн эрхийг хангах болон чанартай боловсрол эзэмшихэд нь туслах маш чухал арга хэрэгсэл болдог. Энэхүү тогтолцооны хүрээнд хүүхдэд ээлтэй сургууль нь хүүхдийн сурах сэдэл тэмүүлэл төрүүлэх, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх зорилготой. Хүүхдэд ээлтэй сургуулийн үндсэн хоёр шинж чанар:

- 1) Хүүхдийг эрж хайж, илрүүлдэг сургууль: Сургуулийн гадна байгаа хүүхдүүдийг олж илрүүлж, сургалтад хамруулах талаар онцгой анхаарч, хүүхдийг эрх бүхий субъект гэж үзэх.
- 2) Хүүхэд төвтэй сургууль: хүүхдийн дээд ашиг сонирхлыг хүндэтгэдэг, хүүхдийн эрхийг бүх талаар хэрэгжүүлэхэд манлайлдаг, хүүхдийн эрүүл мэнд, хүнс тэжээлийн байдал, эсэн мэнд байх зэрэг бүх асуудалд анхаарал хандуулдаг.

Жендэр ба хөгжлийн бэрхшээл хоёрыг хамтатган авч үзье. Хөгжлийн бэрхшээлтэй бүх хүүхэд дээрэлхүүлэх, ялгаварлан гадуурхагдах, сургуульд явах боломжгүй болох, эсвэл сургууль завсардах зэрэг хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй байдаг. Гэсэн хэдий ч охид, хөвгүүдийн хооронд ялгаатай утга агуулна. Бид У гэдэг хөгжлийн бэрхшээлтэй охины нөхцөл байдлыг бодож үзвэл тэр өөрийн үеийн эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад хүчирхийллийн өндөр эрсдэлд байх магадлалтай.

12 Нийгэм, жендэрийн зөвлөх үйлчилгээний эцсийн тайлан

13 Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага. 2020

http://portal.merit.mn/dataset/cddfeb83-3a46-4451-ac9a-02f6f02f6536/resource/90f85693-36ab-45b3-a98d-48e1a9e38c41/download/grb_mn.pdf

14 НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдэд ээлтэй сургууль: https://www.unicef.org/french/lifeskills/index_7260.html

Бага болон дундаас доогуур орлоготой улс орны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид ерөнхийдөө давхар гадуурхалд өртдөг: нэг нь хүйс, нөгөө нь хөгжлийн бэрхшээлтэй чадваргүй байдал нь юм. Тэдний боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах, ажил хийх магадлал нь хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн, эсвэл эрүүл эмэгтэйтэй харьцуулахад доогуур байна. Тухайн эмэгтэй нийгмийн ангиллын эдгээр хоёр сул талын улмаас ялгаварлагдан гадуурхагддаг.

Хөвгүүд ч гэсэн чадвар алдалт, хөгжлийн бэрхшээлээс болж ялгаварлан гадуурхалтай тулгардаг. Тодорхой төрлийн бэрхшээлийн улмаас хөвгүүд бага сургуулиас эхлээд охидоос илүүтэй сургууль завсарддаг.¹⁵ Хөвгүүдийн сургууль завсардалтын асуудал малчин өрхүүдэд илүү түгээмэл ажиглагддаг бөгөөд малчин бус өрхтэй харьцуулахад эдгээр өрхүүдэд эрэгтэй хүүхдийн сургууль завсардалтын түвшин илүү өндөр байдаг.

Жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга зүй гэдэг нь эмэгтэй, эрэгтэй сурагчдын суралцахуйн онцлог хэрэгцээ, хэв шинжийг харгалзан үзсэн багшлахуйн болон суралцахуйн үйл явц юм. Энэ нь нийгэмд оршдог тэгш бус байдлыг анхааран үзэж, багш эрэгтэй, эмэгтэй хүүхдийг аливаа сургалтын үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцох тэгш боломжоор хангахад анхаарах ёстой гэсэн үг юм.

Соёлын ялгаатай байдал. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох, нийгмийн амьдралд оролцоход тулгарч болзошгүй хүндрэл, бэрхшээлийн түвшин нь тухайн хүүхдийн амьдралын чанар, хүйс, оршин буй орон нутаг (хот суурин, хөдөө, алслагдмал орчин), үндэс угсаа, нийгэм соёлын ялгаатай байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байдаг.

Монгол Улсын нийт хүн амын 28.4 хувийг ядуу иргэд эзэлж байгаа бөгөөд ядуурал хэмээх үзэгдэл нь хөгжлийн бэрхшээлийг бий болгох шалтгаан болохоос гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд ядууралд илүү өртөж байна.¹⁶ Ядууралд нэгэнт өртсөн тохиолдолд тухайн иргэн, өрх эмзэг байдалд орж, тусгаарлагдах, хангалттай тэжээллэг хоол хүнс хэрэглэх, баталгаатай орон байр, ариун цэврийн байгууламжтай байх боломжоор дутагдах гэх мэт олон асуудалд өртдөгөөс гадна тухайн ХБ-тэй иргэнийг асран хамгаалагч нь орлогын эх үүсвэрээ алдсанаар эрүүл мэндийн байгууллагаас дэмжлэг авах боломж мөн тэр хэрээр хязгаарлагдаж эхэлдэг.¹⁷

Монгол Улсын хувьд үндэстэн ястны 97 орчим хувь нь Монгол, тэдгээрийн 86 хувь нь халх монгол үндэстэн байдаг. Харин үлдсэн 14 хувь нь нийгэм, хэл, соёлын хувьд өөр хоорондоо ялгаатай ястан үндэстэн байдгаас 3.9 хувийг казах иргэд бүрдүүлдэг. Нийт хүн амын ¼ нь нүүдлийн уламжлалт мал аж ахуй эрхэлдэг малчид байна. Эдгээр иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, ингэхдээ тэдний өвөрмөц соёл, гэр бүлийн онцлог шинж байдлыг хадгалан үлдээх нь харьцангуй хүнд асуудал байдаг.¹⁸

15 Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй 2020

16 Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн хураангуй 2020

17 Женкин. 2017

18 Dyer, 2016

Боловсролд хүйсийн ялгаатай байдал байсаар байгаа бөгөөд тэр дундаа эрэгтэй хүүхдийн боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургалтын байгууллагад элсэн суралцах түвшин анги ахих тусам буурч байгаа нь бодит үзэгдэл юм.¹⁹ Бусад улстай харьцуулахад, эцэг эхчүүд охидоо хөвгүүдээс илүү сургуульд хамруулах сонирхолтой байдаг ч²⁰ дэлхий нийтэд хөгжлийн бэрхшээлтэй охид хүчирхийлэлд өртөх, дээрэлхүүлэх үзэгдэл илүү түгээмэл байгаа юм.²¹

19 Шэйлциг & Ньюиман, 2020

20 Банзрагч, Мизуноя & Баяржаргал 2019

21 НҮБ-ын охидын боловсрол санаачилга 2017

ХАВСРАЛТ 2

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ОРЧИН

Ерөнхий мэдээлэл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын 24

(1) дүгээр зүйлд оролцогч улсууд ямарваа нэгэн ялгаварлан гадуурхалгүйгээр тэгш боломжоор хангасан нөхцөлийн үндсэн дээр сурч боловсрох эрхийг баталгаажуулах ёстой гэж заасан байдаг. Ялгаварлан гадуурхалтгүй байх эрхэд тусгаарлагдахгүй байх эрх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах эрх багтах төдийгүй хүртээмжтэй суралцах орчин, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах үүрэг хүлээсэн нөхцөл багтсан байдаг гэж үздэг.

Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсролд тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газраас хэд хэдэн хууль эрх зүйн баримт бичгүүдийг баталсан билээ. Энэхүү ажлын хүрээнд “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам” (Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/184 дүгээр тушаал)-ыг 2020 онд баталсан байдаг.

Харааны бэрхшээлтэй суралцагчдын суралцахуйн хэв маягийн ялгаатай байдлыг харгалзсан сургалтын орчин, арга зүй. Жишээлбэл, тэгш хамран сургах боловсролд хамрагдаж байгаа харааны бэрхшээлтэй сурагчийг амжилттай сургах ажлын эхлэл нь тэднийг орон зай, хөдөлгөөний чиг баримжаатай болгож, бие даан аюулгүй зорчиход тусгайлан бэлтгэх явдал юм. Орон зайн баримжааны чадвар нь тухайн сурагч хүрээлэн буй орчин болон байгаа газрынхаа тухай ойлголттой болоход тусалдаг. Хөдөлгөөний чадварт тусгай техникүүд шаардагддаг ба тэдгээр нь сурагчийг нэг газраас нөгөө газар руу чөлөөтэй явахад ашиглагддаг.

СЭДЭВ 3. ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилго: Суралцахуйн түгээмэл загварт суурилсан тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Суралцахуйн түгээмэл загвар, түүний үндсэн 3 зарчмыг тайлбарлах
- Суралцахуйн түгээмэл загварт суурилсан ба уламжлалт заах арга барилын ялгааг тодорхойлж, дүн шинжилгээ хийх

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч, стикер цаас
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчдын 1/2 тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Тараах материалыг карт байдлаар бэлтгэж хэвлэх
- Хавсралт 3: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Суралцахуйн түгээмэл загвар, түүний үндсэн зарчмыг тодорхойлох (30 минут)

1. Тус сэдвийн хүрээнд тэгш хамран сургах боловсролыг сургууль, анги танхимд хэрэгжүүлэхэд “Суралцахуйн түгээмэл загвар”-ыг ашиглахын ач холбогдол, давуу талыг бодит жишээн дээр үндэслэн судална гэдгийг хэлж, оролцогчдоос дараах асуултыг асууж, ярилцана.
 - Та бүхэн суралцахуйн түгээмэл загварыг хэрхэн тодорхойлох вэ?
 - Суралцахуйн түгээмэл загварын үндсэн 3 зарчим юу вэ?
 - Суралцахуйн түгээмэл загварыг ашиглах нь ямар ач холбогдолтой вэ?Оролцогчдын хэлсэн зүйлийг самбарт эсвэл дэлгэц цаасан дээр бичиж тэмдэглэнэ. Эдгээр зүйлийн талаар судалж, өөрсдийн ойлголт мэдлэгээ хэр бодитой болохыг үнэлж дүгнэнэ гэдгийг тайлбарлана.
2. Оролцогчдод хосоороо ажиллана гэдгийг хэлнэ. Хос тус бүрт хавсралт 1-ийг тарааж өгөх ба хосууд тус материалыг хуваан авч судална. Оролцогч бүр өөрт оногдсон материалыг судлаад хосдоо тайлбарлана.

3. Бүгдээрээ хамтран дараах асуултын дагуу ярилцаж, багш асуулт бүртэй холбоотой мэдээллийг слайд ашиглан тайлбарлах замаар нэгдсэн ойлголтод хүрнэ.
 - Суралцахуйн түгээмэл загварын тодорхойлолт та нарын тодорхойлсонтой юугаараа ижил төстэй болон ялгаатай байна вэ?
 - Багшлахуйн үйл ажиллагааг хэрхэн суралцахуйн түгээмэл загвартай хэрхэн уялдуулах боломжтой вэ?
 - Суралцахуйн түгээмэл загварын 3 зарчмыг зөв тодорхойлсон байна уу? Эдгээр 3 зарчмыг илэрхийлэх ямар 3 асуулт байна вэ?
 - Бүх суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн, сэдэлжүүлж оролцоог хангах ямар ямар арга замууд байж болох вэ?
 - Суралцагчдад мэдлэг мэдээллийг олон хэлбэрээр хэрхэн үзүүлж болох вэ?
 - Сурсан мэдсэнээ илэрхийлэх олон төрлийн ямар аргууд байж болох вэ?

Үйл ажиллагаа 2: Суралцахуйн түгээмэл загвар ба уламжлалт заах арга барилын ялгаа (35 минут)

1. Оролцогчдоос дараах асуултыг асууж, ярилцана.
 - Суралцахуйн түгээмэл загварт суурилсан болон уламжлалт заах арга зүйн гол ялгаа юу вэ?
2. Оролцогчдыг 4 багт хуваана. Баг тус бүрт хавсралт 2-т байгаа уламжлалт болон суралцахуйн түгээмэл загварын зарчимд суурилсан заах аргын онцлогийг харуулсан картуудыг хольж, ойролцоо тоогоор хуваан өгнө. Багш танхимын ханан дээр «уламжлалт заах арга барил», «суралцахуйн түгээмэл загварт суурилсан заах арга барил» гэсэн гарчгийг хооронд нь нэлээд зайтай байрлуулна.
3. Баг тус бүр өөрт оногдсон картыг уншиж танилцаад дээрх 2 гарчигт тохируулан байрлуулна. Карт бүрийг зөв байрлуулсан эсэхийг хамтран ярилцаж, хэрвээ буруу байрлуулсан бол зөв байрлуулахыг оролцогчдоос хүснэ. Багш хавсралт 2-ыг чиглүүлэг болгон ашиглана. Баг бүр өөрсдийн байрлуулсан карт бүрийн агуулгыг бусдадаа тайлбарлана. Дараа нь дүгнэн ярилцаж, нэгдсэн ойлголтод хүрнэ.

Үйл ажиллагаа 3: Суралцагчийн үйл ажиллагааны бэрхшээл ба суралцахуйн түгээмэл загвар (20 минут)

1. Оролцогчдыг 4-5 багт хуваана. Баг бүрт хавсралт 3-ыг тараан өгч, уншиж судлаад, бусад багуудаас асуух 3-5 асуулт зохиохыг хүснэ. Багууд өөрсдийн зохиосон асуулт бүрийг нэг нэг стикер цаасан дээр бичнэ.

2. Багуудаас асуултуудыг цуглуулан авч, хооронд нь холиод буцааж сугалуулна. Өөрсдийн асуулт таарсан ч сугалсан асуултад хариулна гэдгийг тайлбарлана.
3. Багууд өөрт оногдсон асуултуудад ээлжлэн хариулна. Хариулт зөв эсэхийг бусад багуудаас асууж ярилцана. Нэмж хэлэх зүйл байгаа эсэхийг бусад багаас лавлаж, шаардлагатай тохиолдолд багш нэмж тайлбарлана.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцаж сэдвийг дүгнэнэ.

- Тухайн сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Сурсан зүйлээ хэрхэн ашиглах вэ?
- Суралцахуйн түгээмэл загварыг сургууль, ангийн түвшинд хэрэглэснээр бүх сурагчдын сурах үйл явцад хэрхэн нөлөө үзүүлэх вэ?

ХАВСРАЛТ 1

ТЭГШ ХАМРАН СУРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАР

Ерөнхий мэдээлэл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог, сурах хэв маягийг харгалзан үзсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь нэлээдгүй хүч хөдөлмөр шаарддаг ажил юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношинд тохируулж, тусгайлан боловсруулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх нь хүүхдийг бусдаас тусгаарлагдсан орчинд сурах хэрэгтэй гэсэн санааг өөгшүүлээд зогсохгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зөвхөн тусгай, мэргэшсэн багш ажиллах ёстой мэтээр ойлголт төрүүлдэг.

Харин хүртээмжтэй сурган хүмүүжүүлэх ухааныг урьтал болгож, ангид заагдаж буй аливаа сэдвийн агуулга бүх хүүхдэд тохирсон хүртээмжтэй байх ёстой гэж олон улсын судалгааны бүтээлд үзсэн байна.²² Үүний тулд багш нар багшлахуйн арга барилаа суралцахуйн түгээмэл загвартай уялдуулах хэрэгтэй.

- *Суралцахуйн үйл ажиллагааг бүх хүүхдийг хамруулах байдлаар төлөвлөсөн байх*
- *Суралцахуйн үйл ажиллагаа нь бүх хүүхдийн оролцоог дэмжсэн байх*
- *Үнэлгээ нь бүх хүүхдийн амжилтыг дэмжсэн, урамшуулсан байх*
- *Ангийн сахилга бат дэг журам хэмээх ойлголт нь харилцан бие биеэ хүндэтгэх зарчимд суурилсан байх*
- *Ажилтнуудтайгаа хамт төлөвлөх, төлөвлөгөөний дагуу хичээлээ заах, хамтдаа үр дүнгээ нягтлах*
- *Туслах багш нар нь бүх хүүхдийн суралцах болон оролцоог хангахад нь дэмжлэг үзүүлдэг байх*
- *Тухайн орон нутгийн сургуулийн боломж, эх сурвалж, ашиглалт нь тодорхой (эцэг эх, нутгийн иргэд, бусад байгууллагатай хамтран ажиллах гэх мэт) байх*

Суралцахуйн түгээмэл загвар (СТЗ) гэдэг нь хамгийн боломжит байдлаар бүх хүн хэрэглэхэд тохиромжтой, оролцоог хангасан хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд тохирсон загвар юм. Суралцахуйн хэв маягийн онолд суурилсан энэхүү загвар нь хэсэг бүлэг сурагчдын хэрэгцээг авч үзэхээс илүүтэй бүх суралцагчийн сургалтын хэрэгцээг хангахад чиглэдэг²³. СТЗ нь олон төрлөөр оролцоог хангах (“яагаад” суралцаж байгаа вэ буюу сурах сэдэл); олон төрлөөр үзүүлэх боломж бүрдүүлэх («юу» сурах вэ буюу мэдлэг, мэдээллийг олон янзаар үзүүлэх, таниулах); олон төрлөөр илэрхийлэх боломж олгох («хэрхэн» суралцах вэ буюу сурсан, мэдсэнээ олон янзаар илэрхийлэх) гэсэн үндсэн гурван зарчмын

²² Флориан & Спрат 2013; Уэстбрук., 2013

²³ CAST, 2018; UNICEF & Johnstone, 2014

хүрээнд тодорхойлогдоно. Эдгээр зарчмын хүрээнд АНУ-ын Тусгай технологийн хэрэглээний төвөөс 9 удирдамж, сурагчдын олон талт хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх судалгаанд суурилсан 31 практик зөвлөмжийг багтаасан эмхэтгэлийг боловсруулсан юм.²⁴ Энэхүү загвар нь “зарим хүнд чухал» зүйл нь бараг «бүх хүнд тохиромжтой» зүйл байдаг гэсэн гол санаанд суурилдаг.²⁵

Сургуулийн түвшинд СТЗ-ын гурван зарчмыг хэрэглэх нь

Ангид суралцаж буй хүүхэд бүр хүсэл сонирхол, чадвар, хүйс, гэр бүлийн орчин, мэдлэг туршлагын хувьд харилцан адилгүй байдаг. Иймд хүүхэд бүрт тохирсон нэг хэв загварын багшлахуйн арга барил байх боломжгүй юм. Харин СТЗ-ын гурван зарчмыг хэрэгжүүлснээр багш хичээлийг илүү тэгш хүртээмжтэй, хүүхдүүдийн оролцоог бүрэн хангасан хэлбэрээр заах боломж бүрддэг.

- Сэдэлжүүлж оролцоог хангах арга замууд: “Яагаад” суралцаж байгаа вэ? Хүүхдийн сурах сэдэл, өөрийнх нь сонирхол, хүсэл эрмэлзэлд нийцсэн хичээлд сурагчид идэвхтэй, тууштай оролцох хандлагатай байдаг. Тиймээс багш багшлахуйн болон суралцахуйн үйл явцыг сурагчдын онцлогт тохируулан олон арга замаар хэрхэн сэдэлжүүлж, оролцоог хангах вэ гэдэгт чиглүүлэх хэрэгтэй.²⁶ Хүүхдийн мэдлэг туршлага, суурь боловсрол, ар гэрийн байдал нь тухайн хүүхэд “яагаад” суралцаж байгаа вэ гэдэгт ихээхэн нөлөөтэй байдаг учраас багш сурагчдын амьдралд ойр, бодит нөхцөл байдалд тулгуурласан арга барилаар ажиллах нь чухал юм. Хэдий ижил сургалтын хөтөлбөрөөр хичээллэдэг ч хөдөө, орон нутагт амьдарч буй хүүхдийн сурах сэдэл хотод амьдардаг сурагчийнхаас ялгаатай байж болно. Гэвч хөдөө амьдардаг сурагч хотын амьдрал, нөхцөл байдлыг сонирхох, эсрэгээрээ хотын сурагч ч ялгаагүй хөдөөгийн амьдралыг сонирхдог байж болох учраас багш суралцагчдын нийтлэг хүсэл сонирхлыг харгалзан үзэхийн зэрэгцээ сурагч бүрийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн хэлбэрээр хичээлээ заах хэрэгтэй.
- Мэдлэг мэдээллийг олон хэлбэрээр үзүүлэх арга замууд: “Юу” сурч байгаа вэ? Хүүхэд бүр багшийн заасан хичээлийг өөр өөрийнхөөрөө ойлгодог. Жишээлбэл, хараа, сонсголын эсвэл суралцахуйн бэрхшээлтэй, хэл яриа болон нийгэмшихүйн бэрхшээлтэй хүүхдүүд аливаа мэдээллийг өөрийн гэсэн онцлог арга барилаар хүлээж авдаг. Зарим суралцагч хэвлэмэл материалаас илүү харааны болон сонсголын хүртэхүйгээрээ дамжуулан мэдээллийг хурдан ойлгож болно. Тиймээс сурагчдад мэдээллийг олон хэлбэрээр үзүүлэх боломж олгосноор хүүхдүүд мэдээллийн агуулгын мөн чанар болон агуулга хоорондын холбоог ойлгох боломж бүрддэг.

24 Холл, Мейер, & Поуз, 2012

25 Meyer et al., 2014

26 Pereira et al., 2018

Суралцахад учирч буй саад бэрхшээлийг багасгахын тулд багшийн зааж буй мэдлэг бүх хүүхдийн мэдээлэл хүлээж авах онцлогт тохирсон байх ёстойг бодолцоорой. Үүний тулд 1) ижил мэдээллийг олон хэлбэрээр хүргэх (хараа, сонсгол, хүрэлцэхүйн хүртэхүйгээр дамжуулах гэх мэт); 2) мэдээллийг хүлээн авагч өөрөө тохируулах боломжтой хэлбэрээр өгөх (текстийг томруулах, дууг өсгөх боломжтой байх гэх мэт). Ийнхүү мэдээллийг олон хэлбэрээр үзүүлж, дамжуулах нь дан ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах үйл явцыг дэмжиж байгаа хэрэг биш бөгөөд бусад сурагчдын мэдээлэл хүлээн авах, ойлгох хэрэгцээг хамтад нь харгалзан үзсэн зарчим юм.

- Үйлдэл хийх, илэрхийлэх арга замууд: “Хэрхэн” суралцаж байгаа вэ? Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг. Жишээлбэл, хүнд хэлбэрийн хөдөлгөөний бэрхшээлтэй, харилцааны бэрхшээлтэй хүүхэд аливаа дасгал даалгаврыг бусадтай адил ойлгож, гүйцэтгэх боломж хомс байдаг. Зарим сурагч өөрийгөө бичгээр сайн илэрхийлэх бол зарим нь хэл яриагаараа илэрхийлдэг. Харааны бэрхшээлтэй хүүхдэд үзэг харандаа бариулаад бичгээр шалгалт авбал тухайн хүүхэд сурсан мэдсэнээ хангалттай хэмжээнд илэрхийлж чадахгүй байж болно. Хэрэв багш тухайн хүүхдийн бичгийн чадварыг үнэлэхийг зориогүй бол өөр ямар нэг аргаар өөрийгөө илэрхийлэх боломж олгох ёстой.

Хичээлийн агуулга, сэдвийн талаар юу сурснаа илэрхийлэх олон төрлийн арга барилыг зааж өгснөөр хүүхэд бүр өөрийн онцлог, чадвартаа тохируулан өөрийгөө илэрхийлэх боломж бүрдэнэ.²⁷ Хэдийгээр суралцахуйн түгээмэл загварын үндсэн зарчмуудтай уялдсан арга барил нь тусгайлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулагдаагүй боловч бүх хүүхдийн суралцах үйл явцад дэмжлэг үзүүлдэг.

27 Хэйс, Тернбулл ба Моран, 2018

ХАВСРАЛТ 2

СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАР БОЛОН УЛАМЖЛАЛТ ЗААХ АРГА БАРИЛЫН ЯЛГАА

Уламжлалт заах арга барил	Суралцахуйн түгээмэл загварт суурилсан заах арга барил
<p>Юу заахад хичээлийн зорилго төвлөрдөг. Сурагчдад заах хичээлийн агуулгад гол анхаарлаа хандуулдаг. Хичээл “ердийн” сурагчдад зориулагдсан учир багш хичээлийг нэг л байдлаар ангийн бүх сурагчдад хүргэнэ. Жишээлбэл, багш Монголын хаадын талаар сэдэв заахдаа тэдний нэрийг, он сартай нь самбар дээр бичээд, сурагчид хуулж бичих.</p>	<p>Юуг, хэрхэн заахад хичээлийн зорилго төвлөрдөг. Багш сурагчдынхаа суралцах хэв маяг, чадвар, онцлог хэрэгцээнд тохируулж хичээлээ бэлтгэж, олон хувилбараар заана.</p> <p>“Ердийн” сурагч гэсэн ойлголт байхгүй. Хичээлийн удиртгал хэсгийг уламжлалт маягаар заасан ч текстийн тайлбартай бичлэг үзүүлж болно. Мөн сурагчид Монголын хаадын давуу болон сул талыг харьцуулсан тоглоом тоглож болох юм.</p>
<p>Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулж тохируулга хийдэг. Зөвхөн ГСТ хэрэгжиж буй хүүхдэд зориулж, суралцахуйн үйл явцыг дэмжин ангийн нөхөдтэйгөө ижил агуулга судлах үүднээс тохируулга, өөрчлөлт хийдэг. Жишээ нь, ГСТ-өөр хичээллэж байгаа хүүхдэд хэвлэмэл номыг аудио хэлбэрт хувирган өгөх ба энэ нь ангийн бусад сурагчдад хүртээмжгүй байж болно.</p>	<p>Бүх сурагчдын хэрэгцээг харгалзаж, тохируулга хийдэг. Тохируулга, өөрчлөлтийг ангийн бүх хүүхдийн хэрэгцээ шаардлагад тохируулж хийнэ. Учир нь хичээлийг олон хэлбэрээр хүргэх нь бүх хүүхдийн нийтлэг хэрэгцээг хангаж байна гэсэн үг юм. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдаасаа тусгаарлагдах эрсдэлийг бууруулдаг. Жишээ нь, багш тухайн сэдвийг заахдаа ном ашиглаж байвал номыг бүгдэд хүртээмжтэй байдлаар буюу брайль, онлайн эсвэл том үсгээр бичсэн гэх зэрэг олон хэлбэрээр өгнө.</p>
<p>Тогтсон ангийн зохион байгуулалттай. Уламжлалт ангид ширээнүүдийг ар араас нь эгнүүлэн байрлуулж, багш самбарын өмнө гарч бүх хүүхдэд хандсан байдалтай хичээлээ заах нь элбэг.</p>	<p>Уян хатан ангийн зохион байгуулалттай. Сурагчид бие даан чимээгүй орчинд хичээллэх, бүлгээр ажиллах, ангиараа хамтран хийх зэрэг олон төрлийн үйл ажиллагаанд зориулж ангийн зай талбайг өөр өөрөөр зохиомжилж болох, уян хатан зохион байгуулалттай байдаг. Сурагчдын ялгаатай онцлог хэрэгцээ, хичээлийн агуулгаас хамаарч багш ангийн аль ч зайд чөлөөтэй зорчих боломжтой байна.</p>
<p>Сурагчдын мэдлэг ойлголтыг үнэлэх нэг арга барилтай. Сурагчид сурсан мэдсэнээ нэг л арга барилаар илэрхийлдэг. Жишээ нь, номын тэмдэглэл хөтлөх, даалгаврыг зөвхөн эсээ байдлаар бичүүлж авах гэх зэрэг.</p>	<p>Сурагчдыг үнэлэх олон төрлийн үнэлгээний арга барилтай. Сурагчид өөрсдийн мэдлэг чадвар, хөгжлийн ялгаатай түвшнээс шалтгаалж сурсан мэдлэгээ өөр өөр арга хэлбэрээр илэрхийлэх боломжтой. Жишээ нь, сурагчид уншсан номын тэмдэглэлээ бичлэг, танилцуулга, эсээ зэрэг өөрт тохирсон байдлаар үзүүлэх.</p>
<p>Дүнгийн амжилтаар суралцагчийн гүйцэтгэлийг хэмждэг. Суралцагчид шалгалт, асуулт хариулт, төслийн даалгаврын гүйцэтгэлээр багшаас дүн авдаг ч энэ нь зорилгодоо хүрэх, үр дүнтэй суралцах үйл явцын нэг хэсэг болдоггүй.</p>	<p>Дүнгийн амжилтыг тавьсан зорилгодоо хүрэх алхам гэж үздэг. Сурагч багшаас үнэлгээ, санал зөвлөмж авч түүнийгээ суралцах үйл явц, зорилго чиглэлдээ тусгадаг.</p>

ХАВСРАЛТ 3

Хүүхдийн оношилгоо, ХБ-ийн ангиллаас илүүтэй тухайн хүүхэд өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоход ямар бэрхшээлтэй тулгарч буйд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Багш нар бэрхшээлийн төрөл болон оношилгоонд ач холбогдол өгөхөөс илүүтэй олон улсад хөгжлийн бэрхшээлийг тодорхойлоход өргөн хэрэглэдэг Вашингтон бүлгийн арга барилд түлхүү анхаарал хандуулах нь зүйтэй. Энэ нь тухайн хүүхэд өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоход ямар бэрхшээлтэй тулгарч байна гэдгийг гол шалгуур болгон авч үздэг аргачлал юм. Хэрэв бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг авч үзэхдээ дан ганц оношилгоонд суурилбал адилхан оноштой хүүхэд бүрт адил хэрэгцээ, дэмжлэг тусалцаа хэрэгтэй болно гэсэн үг юм (жишээ нь, Дауны хам шинж). Түүнчлэн албан ёсоор оношлогдоогүй ч өдөр тутамдаа тодорхой хэмжээний бэрхшээлтэй учирдаг хүүхдүүд дэмжлэг тусалцаа авч чадахгүй, орхигдох эрсдэлтэй. Тиймээс багш хүүхдүүдээ ажиглаж ямар хүндрэл бэрхшээл тулгарч байна гэдэгт анхаарлаа түлхүү хандуулах учиртай. Багш нар багшлахуйн үйл явцдаа дараах төрлийн бэрхшээлтэй хүүхэдтэй таарч болно.

- Харааны бэрхшээл
- Сонсголын бэрхшээл
- Суралцахуйн бэрхшээл
- Хэл яриа, харилцааны бэрхшээл
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээл
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэг

Зарим багш нар хараа, сонсгол, харилцаа болон хөдөлгөөний огт чадамжгүй хүүхэдтэй ажиллах хэрэгцээ шаардлага тулгарч болно. Үйл ажиллагааны бэрхшээлийг илүүтэй анхаарна гэдэг нь тухайн хүүхдэд онош тавих эсвэл оношийг өөрчилнө гэсэн үг огтхон ч биш.

Харин багш хүүхдэд суралцахад ямар хүндрэл бэрхшээл тулгарч буйг мэдсэнээр тухайн хүүхдийг практик арга зүйгээр дэмжиж, боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлнэ. Жишээлбэл, аутизмын хүрээний эмгэгтэй нэг хүүхэд суралцахуйн, хэл ярианы, харилцааны, зан үйлийн гэх мэт хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй байж болох ба аутизмтай өөр нэг хүүхэд зөвхөн зан төлөв, нийгэмшихтэй холбоотой бэрхшээл, асуудалтай тулгардаг байж болно.

Тиймээс эдгээр бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүйг багш нар эзэмшиж чадвал, адилхан аутизмтай ч тэдний ялгаатай онцлог хэрэгцээнд тохируулан багшилж, мөн харилцаа, зан үйл зэрэг бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйн үйл явцыг дэмжих бүрэн боломжтой юм.

Дараах зарчмуудыг ашиглан сургалтын орчноо тэгш, хүртээмжтэй болгох боломжтой.

Олон төрлөөр

- Оролцох (яагаад сурч байгаа вэ?)
- Үзүүлэх (юу сурч байгаа вэ?)
- Илэрхийлэх (сурснаа хэрхэн илэрхийлж байгаа вэ?)
- Бүх хүүхдэд зориулсан загвар

Хүснэгт 1: Суралцахуйн түгээмэл загвар - оролцох, үзүүлэх, илэрхийлэх зарчмуудыг жишээгээр тайлбарлах нь

Сэдэлжүүлж оролцоог хангах арга замууд	Олон хэлбэрээр үзүүлэх арга замууд	Үйлдэл хийх, илэрхийлэх арга замууд
<p>Уян хатан заах арга зүйг дэмжсэн сургалтын хөтөлбөр</p> <p>(хосоор ажиллах, жижиг бүлгээр ажиллах, цахим даалгавар, ангийн хэлэлцүүлэг гэх мэт)</p>	<p>Сурагчдад аливаа агуулгыг олон хэлбэрээр үзүүлэх, таниулахыг дэмжсэн сургалтын хөтөлбөр</p> <p>(практик дадлага ажлууд, ажлын хүснэгт, бичлэг, туршилт хийх, үзүүлэн, аудио бичлэг, мэдрэгч гэх мэт олон хэлбэр)</p>	<p>Сурсан мэдсэнээ ашиглах, түүнийгээ олон арга замаар илэрхийлэхийг дэмжсэн сургалтын хөтөлбөр Сурагчид хүртээмжтэй байдлаар сурсан мэдлэгээ ашиглах, илэрхийлэхийг дэмжсэн үнэлгээний тогтолцоо (Үнэлэхдээ зөвхөн бичих чадварт анхаарах бус туслах төхөөрөмж, явцаар нь үнэлэх аргачлалыг давхар ашигласан байна)</p>

МОДУЛЬ 2:

**ГАНЦААРЧИЛСАН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР,
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ**



Зорилго	Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах арга зүйд суралцах
Зорилт	<ul style="list-style-type: none"> • Ганцаарчилсан сургалт ба Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)-ний талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх • ГСТ-г боловсруулж, анхаарах зүйлсийг тайлбарлаж чаддаг болох • Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх арга зүйд суралцах • Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, практикт хэрэгжүүлэх арга зүйд суралцах
Хугацаа	6 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Ганцаарчилсан сургалт ба ГСТ (90 минут)</p> <p>Сэдэв 2. ГСТ боловсруулах арга зүй (90 минут)</p> <p>Сэдэв 3. Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх (90 минут)</p> <p>Сэдэв 4. Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй (90 минут)</p>	

СЭДЭВ 1: ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТ БА ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Ганцаарчилсан сургалт ба ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Ганцаарчилсан сургалтын онцлог ба ГСТ-ний талаар бусдад тайлбарлах
- Ганцаарчилсан сургалт зохион байгуулах болон ГСТ боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
- Ганцаарчилсан сургалтыг зохион байгуулахад багшийн зүгээс анхаарах зүйлийг тодорхойлох
- ГСТ боловсруулахын давуу болон сул талыг хэлэлцэх

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- РРТ слайд, зөөврийн компьютер, проектор, дэлгэц самбар
- Хавсралт 1: Багшид зориулсан материал
- Хавсралт 2: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 3: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх

Үйл ажиллагаа 1: Ганцаарчилсан сургалт ба ГСТ-ний онцлог (25 минут)

1. ГСТ-ний талаарх оролцогчдын ойлголтыг тодруулах зорилгоор дараах асуултыг асууж, харилцан ярилцана.

- Ганцаарчилсан сургалт гэж юуг хэлэх вэ?
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гэж юу вэ?

Оролцогчдын хэлсэн зүйлийг самбарт эсвэл дэлгэц цаасан дээр дараах байдлаар зэрэгцүүлэн бичнэ.

Ганцаарчилсан сургалт	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

2. Хавсралт 1-д байгаа мэдээллийг багш слайд байдлаар бэлтгэн танилцуулж, оролцогчдын гаргасан санаатай ижил төстэй болон ялгаатай зүйлийн талаар хамтран ярилцана.

Үйл ажиллагаа 2: Ганцаарчилсан сургалт ба ГСТ-ний хэрэгцээ шаардлага (60 минут)

1. Оролцогчдыг 4 багт хуваана. Багуудад хавсралт 2 ба 3-ыг тараан өгч судлуулна.
2. Тус хоёр сэдвээр мэтгэлцээн зохион байгуулна гэдгийг хэлж мэтгэлцээний үед баримтлах дараах дүрмийг танилцуулна.
 - Баг бүрээс 3 гишүүн гарч ирж, няцаагч эсвэл нотлогч тал болохоо сугална
 - Багшаас өгсөн материал дээр нэмэлтээр мэдээлэл цуглуулан оролцох
 - Мэтгэлцээний 3 зарчмыг баримтлах (Суралцахын тулд мэтгэлцэх; Үнэнийг баримтлах; Бусдыг хүндэтгэх)
3. “Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг ганцаарчилсан сургалтаар хөгжүүлэх боломжтой”, “Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хөгжүүлэх боломжтой” гэсэн сэдвээр мэтгэлцээн зохион байгуулна. Оролцогчид гол мэдээллийг тэмдэглэж авна.
4. Мэтгэлцээнийг дүгнэн, хамтран ярилцаж нэгдсэн ойлголтод хүрнэ.

Дүгнэлт (5 минут)

Тус хичээлийн агуулгыг бататган, дараах асуултын дагуу оролцогчид юу ойлгосон талаар харилцан ярилцаж дүгнэлт хийнэ.

- Ганцаарчилсан сургалтын талаар юуг шинээр мэдэж авсан бэ?
- ГСТ-ний талаар шинээр мэдэж авсан ямар зүйл байна вэ?
- Мэтгэлцээний үр дүнд дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн хандлагын өөрчлөлт гарсан уу?

ХАВСРАЛТ 1

Ганцаарчилсан сургалт	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
<p>➤ Ганцаарчилсан сургалт нь тухайн хувь хүүхдийн хэрэгцээ, хөгжих, сурах боломжийг дэмжсэн сургалтын хэлбэр юм.</p>	<p>➤ Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) нь хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, төлөв байдлыг үнэлэн тогтоож, урт, богино хугацааны зорилго, зорилтууд, сургалтын агуулга, багшийн дэмжлэг, арга зүй зэргийн төлөвлөлт, хэрэгжилт, явцын болон эцсийн үнэлгээ хийх үйл ажиллагаануудыг нэгтгэн хөтлөх баримт бичиг юм.</p>

ХАВСРАЛТ 2

МЭТГЭЛЦЭЭНИЙ СЭДЭВ 1. ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТААР БОЛОВСРОЛЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

Ганцаарчилсан сургалт нь:

- Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, оношилгоонд суурилан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах;
- Хүүхдэд зориулсан сургалтын чиглэл, агуулга, арга зүйг тодорхойлж, өөрийн үнэлгээ хийх боломж олгох;
- Хувь хүүхдийн оюуны болон бие махбодын хөгжил, бие даасан байдлыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн багш хүүхдийн хамтын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Сургалтын үйл ажиллагаанд хувь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх

Ганцаарчилсан сургалтын зорилго нь хүүхдийн хөгжих, сурах, ахуй амьдралын үйл ажиллагаанд тулгамдаж буй бэрхшээлийг багасгах, боломжит дээд түвшинд хөгжүүлэхэд оршино. Ганцаарчилсан сургалтыг хэрэгжүүлэхэд багш, сургуулийн удирдлага, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн хамтын оролцоо чухал.

Ганцаарчилсан сургалтын онцлог

1. Ганцаарчилсан сургалтад хувь хүүхдийг хамруулах асуудлаар боловсролын байгууллагад эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүсэлт гаргасныг үндэслэн хамруулах (Ганцаарчилсан сургалтын бэлтгэл үед хүүхдийн хөгжих, сурах бодит боломжийг таньж мэдэх, хүүхдийн ялгаатай хэрэгцээ, хүүхдийн сонирхол, мэдлэгийн хүрээ, ахуй амьдралын нөхцөлийг судлах, ГСТ, хөтөлбөр боловсруулах, мэдээллийг хүлээн авахад шаардлагатай сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг аудио, брайль, том шрифтээр бичвэр материал, сурах бичиг, зурган карт, үгэн карт байдлаар бэлтгэх гэх мэт);

2. Ганцаарчилсан сургалтыг зохион байгуулахад хувь хүүхдийн гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчийн саналыг хүлээн авч, хүүхдийн хэрэгцээ, хөгжлийн түвшнийг харгалзан туслалцаа, зөвлөгөө өгөх;
3. Хүүхдийн ойрын хөгжлийн бүсэд тэдний ерөнхий мэдлэг, чадварыг бий болгох;
4. Сургалтын орчин нь сурагч бие дааж суралцахад саадгүй байх боломжийг хангах;
5. Эрэгтэй ба эмэгтэй сурагчийн хүйсийн онцлог, биеийн эрүүл мэндийн байдал зэргийг онцгой анхаарах;
6. Хүүхэд өөрийн тухай эерэг өөдрөгөөр боддог болох;

Багшийн анхаарах зүйлс

- Ганцаарчилсан сургалтын үзэл баримтлал, хэрэгцээ, ач холбогдол, үнэ цэнийг хүүхэд, багш, эцэг эхчүүд ойлгосон байх;
- Хүүхдийг ажиглах, хөгжлийн бодит үнэлгээ, оношилгоо хийх орчин үеийн арга, багшлах арга зүйд суралцсан байх;
- Ганцаарчилсан сургалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шатыг оновчтой төлөвлөх;
- Ганцаарчилсан сургалтыг хэрэгжүүлэх орчны зураглалыг тодорхойлох, сонгох боломжийг олгох;
- Хүүхдийн хөгжих, сурах арга барилын ялгаатай байдлыг харгалзсан, хүүхдэд хөгжүүлэх шаардлагатай чадваруудыг дэмжихэд чиглэгдсэн агуулгыг ГСТ-д түлхүү тусгах замаар сурах үйлийг дэмжсэн байх;
- Ганцаарчилсан сургалтад шаардлагатай тохируулгат орчин, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, хангах;
- Хүүхдийн гаргасан алдааг чухалд тооцохгүй, үнэлэхгүй харин хөгжих, сурах үйлд гарч байгаа ахиц өөрчлөлтийг магтаж урамшуулах;
- Эцэг эх, хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;
- Багш, сэтгэл зүйч, хүүхэд, эцэг эхчүүд нэг зорилготой хамтарч ажиллах;

Эдгээр нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд ганцаарчлан сургах асуудал яригдах боломжгүй.

ЕБС-д тэгш хамран суралцаж буй хүүхдийн ганцаарчилсан сургалтад хүүхэд төвтэй сургалтын идэвхтэй арга зүйн зэрэгцээ тухайн хүүхдийн ялгаатай хэрэгцээг дэмжих сургалтын аргуудыг хэрэглэхийг зөвлөж байна.

БСШУС-ын сайдын А/155 (2018) тушаалаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал”-ыг баталсан нь ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэж, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах боломжийг олгож байна.

Ганцаарчилсан сургалтыг үр дүнтэй зохион байгуулахын тулд багш хувь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлог, яагаад сурлагаар хоцрогдсон, ажиллах чадварын түвшин, сонирхол, ахуйн нөхцөл байдлын бодит судалгааг нарийвчлан судалж оношилно.

ХАВСРАЛТ 3

МЭТГЭЛЦЭЭНИЙ СЭДЭВ 2. ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ХҮҮХДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гэж юу вэ?

Хүүхдийн хөгжлийн онцлог, боловсролын хэрэгцээ, бодит байдлыг тухай бүрт нь үнэлж, түүнд үндэслэн урт ба богино хугацааны зорилт, сургалтын агуулга, багшийн дэмжлэг, арга зүйг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тооцох үйл ажиллагааг нэгтгэн боловсруулсан баримт бичиг юм.

Давуу талууд:

- Хүүхдийн бодит байдлын судалгаа хийгдэнэ.
- Хүүхэд сургуульд орохын өмнө ба дараа, одоо байгаа бодит байдлын тухай мэдээллийг нэг баримт бичигт нэгтгэнэ.
- Бодит байдалд нийцсэн зорилт дэвшүүлнэ.
- Багш нар хоорондоо хүүхдийн дэвшүүлсэн зорилтын талаар мэдээллээ хуваалцаж чадна.
- Ямар агуулгыг хэрхэн заах чиглэл тодорхой болно.
- Хувь хүүхдийн бодит чадварыг үнэлж, оношилгоо хийх, ГСТ, хөтөлбөрөөр хичээллэх боломжийг олгох, боловсруулах (агуулга, арга зүй, тохируулгат сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ);
- ГСТ, хөтөлбөрийг боловсруулахад багш, хүүхэд, эцэг эх хамтын оролцоотой байх;
- Боловсролын засан сайжруулах дэмжлэг, туслалцааг цаг алдалгүй авах;
- Багшийн хувьд тухайн хүүхдэд тохирсон сургалтын аргыг сонгох, хэрэгжүүлэх;
- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг эзэмшихийн тулд хүүхдийн хийж буй үйлдэл, үйл ажиллагааг бүрэн ажиглах, шаардлагатай тохиолдолд дэмжих, ахицыг хянах;

- Хүүхдийн анхаарал төвлөрөх чадвар нэмэгдэх;
- Сургалтын явцад гарсан алдааг хугацаа алдалгүй засаж залруулах, байнгын өөрчлөгдөж буй нөхцөлд хялбархан дасан зохицоход туслах;
- Хувь хүүхдэд тохирсон сургалтын үйл ажиллагааны хугацаа, хүүхдийн ажиллах хурд, арга зүйг тодорхойлсон байх;
- Бүх судлагдахууны хувьд ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах эсвэл нэмэлтээр ганцаарчилсан сургалтыг зохион байгуулах сонголтыг хийх (хэл засал, нийгэм ахуйн баримжаа, эмчилгээний биеийн тамир, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх гэх мэт) боломжийг бүрдүүлэх;
- Сургалтын агуулгыг нэгтгэсэн (интеграци) арга зүйгээр явуулах;
- Ганцаарчилсан сургалт нь хувь хүүхдийн бие даан сурах арга барил эзэмших, бие хүний төлөвшил (бие даах чадвар, хөдөлмөрч байдал, бүтээлч, хариуцлагатай хараат бус байх чадвар) сайжрахад чиглэсэн байх;
- Бусдын муу нөлөөнд автахгүй байх, эерэг үлгэр дуурайлалд суралцах, эерэг орчныг бүрдүүлэх, сурах тэмүүллийг сайжруулах;
- Ганцаарчилсан сургалтаар хувь хүүхдийн ерөнхий мэдлэг, чадварыг боломжит дээд түвшинд хөгжүүлэх; БСШУС-ын сайдын А/292 тушаал (2019)
- ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах

Сул тал:

- Хүүхдийн хэрэгцээ, сонирхол, хөгжлийн болон сурах чадварын түвшин харилцан адилгүй өөр байдаг тул ГСТ боловсруулах, арга зүйг төлөвлөхөд цаг хугацаа шаардагдах;
- Багшаас чадвар, тэвчээр, сэтгэл зүйн бэлтгэл шаардах;
- Сургалтын хэрэглэгдэхүүн, орчин бүрдүүлэх;
- Үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа суралцах, харилцах нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал тул хүүхдийн харилцаа нийгэмшлийн чадварт сөрөг нөлөө үзүүлэх;
- Багаар, хамтран ажиллах, бусдын өмнө үүрэг хариуцлага хүлээх талын чадварууд сул хөгжих;
- Хүүхдийг ЕБС дээр зохион байгуулагддаг спорт, урлагийн, нийгмийн амьдралын үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулж, үе тэнгийн найз нөхөдтэйгээ харилцах, нийгэмшлийн чадварыг дэмжихэд анхаарна.

Яагаад ГСТ боловсруулах шаардлагатай вэ?

1. Хөгжлийн ялгаатай хүүхэд нэг бүрийн онцлог, хэрэгцээг зөв тодорхойлж, түүнд тохирсон боловсролын үйлчилгээ үзүүлэхийн тулд
2. Хүүхдийн хөгжлийн бодит байдалд тулгуурлан сургуулийн болон гэрийн орчинд хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоог тодорхойлж, хэрэглэх
3. Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлж, түүний ахуй амьдрал, суралцах явцад тулгарч буй бэрхшээлийг багасгах, арилгах

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах үйл явц

1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх тухай хүсэлтийг хүүхэд, эцэг эх, анги удирдсан багшийн аль нэг тал гаргаж болно.
2. Хүсэлт гаргасан тохиолдолд АУБ хүүхэд, эцэг эх, багшийн уулзалтыг зохион байгуулж, харилцан зөвшөөрсний үндсэн дээр ГСТ-г боловсруулж эхэлнэ.
3. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулмагц захирал эсвэл сургалтын менежер танилцан батална.

СЭДЭВ 2: ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

Зорилго: Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйд суралцах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- ГСТ-ний бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг хэрхэн бөглөх зааврыг тайлбарлах
- Бодит кейс ашиглан ГСТ боловсруулах
- Боловсруулсан ГСТ-ний жишээн дээр бүрэлдэхүүн хэсэг тус бүрт дүн шинжилгээ хийх

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- РРТ слайд, зөөврийн компьютер, проектор
- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг нэг хувь хэвлэж, тасархай зураасын дагуу хайчилж бэлтгэх
- Хавсралт 2: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 3: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх

Үйл ажиллагаа 1: ГСТ боловсруулах заавар ба анхаарах зүйл (35 минут)

1. ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлсийн талаар судална гэдгийг хэлж, оролцогчдыг 5 багт хуваана. Уншиж судлах материалыг (хавсралт 1) баг бүрт дараах байдлаар тараан өгнө.
 - 1-р баг: ГСТ-ний зорилго, зарчим, хүсэлт ба шийдвэрлэх арга зам, бүтэц
 - 2-р баг: ГСТ сурагчийн бодит байдлын судалгаа
 - 3-р баг: ГСТ урт хугацааны зорилт, дэмжлэгийн орчин
 - 4-р баг: ГСТ богино хугацааны зорилт, жилийн эцсийн үнэлгээ
 - 5-р баг: ГСТ хэрэгжүүлэхэд багшийн анхаарах зүйлс
2. Багууд судалсан мэдээллээ бусдадаа ээлжлэн тайлбарлана. Бусад багийн гишүүдээс асууж тодруулах зүйл байгаа эсэхийг лавлана. Шаардлагатай тохиолдолд багш нэмж тайлбарлана.

Үйл ажиллагаа 2: ГСТ боловсруулах дадлага ажил (50 минут)

1. Оролцогчдыг 5-6 хүнтэй багт хуваана. Багууд өртөөгөөр ажиллах бөгөөд өртөө бүрт ГСТ-ийн жишиг загвар (хавсралт 2) байгаа гэдгийг хэлнэ.
2. Тус загварыг ашиглан баг бүр өөрсдөө бодит кейс гарган, тус кейс дээр ГСТ боловсруулна.
3. Баг бүрээс 1 гишүүн суудалдаа үлдэж, бусад гишүүд тойрог замаар өртөөчилж бусад багийн боловсруулсан ГСТ-тэй танилцана. Багийн гишүүн бүр ээлжлэн өөрийн өртөөн дээр үлдэж, зочлон ирж буй бусад багийн гишүүдэд өөрийн багийн боловсруулсан ГСТ-г танилцуулна.
4. Боловсруулсан ГСТ (хавсралт 3)-г багуудад өгч уншиж танилцахыг хүснэ. Тус төлөвлөгөө нь тэдний хийсэн ГСТ-нөөс юугаараа ялгаатай болон ижил төстэй байгааг багаараа ярилцаж, дүн шинжилгээ хийнэ.
5. Дараах асуултын дагуу ярилцана.
 - ГСТ боловсруулахад хэн оролцох ёстой вэ?
 - Нэгэнт боловсруулсан ГСТ-г өөрчлөх боломжтой юу?
 - ГСТ-ний биелэлтийг хэн хянах вэ?
 - ГСТ боловсруулахад анхаарах хамгийн чухал зүйлс юу байна вэ?

Дүгнэлт (5 минут)

Тус сэдвийн хүрээнд судалсан зүйлийг дараах байдлаар дүгнэнэ.

Оролцогчид суудлаасаа босож тойрч зогсоод, жижиг бөмбөгийг нэг нэгэндээ дамжуулан тус хичээлээс ойлгосон зүйлсээ нэг өгүүлбэрээр хэлнэ.

ХАВСРАЛТ 1

1-р баг: ГСТ-ний зорилго, зарчим, хүсэлт ба шийдвэрлэх арга зам, бүтэц

ГСТ-ний зорилго

1. Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, түүнд тохирсон тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг үзүүлэх
2. Хүүхдийн хөгжлийн бодит байдалд тулгуурлан сургуулийн болон гэрийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоог тодорхойлж, хэрэглэх
3. Сурагчийн хөгжлийн ахицыг үнэлж, түүний ахуй амьдрал, суралцах үйлд тулгарч буй бэрхшээлийг арилгах

ГСТ боловсруулахад баримтлах зарчим:

- Суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түүний хөгжлийг дэмжсэн байх;
- Зорилт биелэгдэхүйц байх;
- Хүүхдэд дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Тогтоосон хугацаанд шинэчлэн боловсруулж байх;
- Оролцогч талууд харилцан хүлээн зөвшөөрсөн байх;
- Нууцлалыг чанд хадгалах.

ГСТ-өөр хичээллэх хүсэлтийг гаргах, шийдвэрлэх арга зам:

- ГСТ-өөр хичээллэх хүсэлтийг сурагч эсвэл эцэг эх, асран хамгаалагч эсвэл анги удирдсан багш гаргаж болно.
- Хүсэлт гаргасан тохиолдолд гурван тал /сурагч, эцэг эх, хариуцах багш/-ын уулзалтыг анги удирдсан багш зохион байгуулна.
- Сурагч, эцэг эх ба асран хамгаалагч нь суралцагчийн ГСТ-г боловсруулахад санал хүсэлтээ илэрхийлж, түүний агуулгад тусгуулж болно.
- Сонирхогч талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ГСТ-өөр хичээллэхээр болбол холбогдох материалыг бүрдүүлэн сургуулийн комисст хандана.
- Сургуулийн комисс хуралдаж, эцсийн шийдвэрийг гаргана.
- Сургуулийн комисст тухайн сургуулийн захирал, сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагч, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш, судлагдахуун болон заслын багш зэрэг хүмүүсийн төлөөлөл орно.

ГСТ-ний үлгэрчилсэн загварын бүтэц:

1. Сурагчийн бодит байдлын судалгаа
2. Урт хугацааны зорилт, дэмжлэгийн орчин
3. Богино хугацааны зорилт, багш, мэргэжилтний дэмжлэг, арга зүй, үнэлгээ
4. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж
5. ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс

2-р баг: ГСТ Сурагчийн бодит байдлын судалгаа

Нэг. “Сурагчийн бодит байдлын судалгаа” хэсэгт бичигдэх мэдээллийг сурагчийн эцэг, эх /асран хамгаалагч/-ээс асууж бөглөнө. Үүнд:

- 1.1. Сургуулийн комиссын хуралдааны огноо
- 1.2. Сурагчийн овог нэр
- 1.3. Регистрийн дугаар
- 1.4. Сургуульд элсэн орсон огноо
- 1.5. Анги, бүлэг
- 1.6. Хүйс
- 1.7. Төрсөн огноо
- 1.8. Ам бүлийн тоо
- 1.9. Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд
- 1.10. Гэр бүлийн харилцааны төлөв байдал
- 1.11. Цэцэрлэгт явсан эсэх
- 1.12. Эцэг эх асран хамгаалагчийн нэр
- 1.13. Оршин суугаа хаяг
- 1.14. Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ дүгнэлт
- 1.15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүгнэлт
- 1.16. Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх
- 1.17. Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх
- 1.18. Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх
- 1.19. Төрсний дараах /0-24 сар хүртэл/ хүүхдийн хөгжлийн түвшний онцлог байдал
- 1.20. Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/
- 1.21. ГСТ-нд хамрагдах үеийн хөгжлийн түвшин
- 1.22. Оролцогч талуудын хүсэл зорилго

- 1.23. Энэхүү хэсгийн мэдээллийг бүрэн бөглөсөн гэж үзсэн тохиолдолд тэмдэглэл хөтөлсөн багш болон сурагчийн эцэг, эх /асран хамгаалагч/ нар танилцан гарын үсэг зурна.

3-р баг: ГСТ-ний урт хугацааны зорилт, дэмжлэгийн орчин

Хоёр. “Урт хугацааны зорилт” хэсэгт сурагчийн тухайн хичээлийн жилд эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн хүрэх түвшнийг тодорхойлж дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхэд үзүүлэх дэмжлэгийн орчныг сонгож бичнэ.

- 2.1. Тус хэсгийн хүснэгтийн талд “Сурагчийн овог нэр”, “Анги, бүлэг”, “Хүйс”, “Төрсөн огноо” зэргийг дахин бичнэ.
- 2.2. “Урт хугацааны зорилт” хэсэгт сурагчийн тухайн хичээлийн жилд эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн хүрэх түвшнийг хүүхдийн хөгжлийн айн түвшинд нийцүүлэн зөвхөн шаардлагатай “ай”-н хувьд зорилтыг тодорхойлж бичнэ. Бүх “ай”-г заавал хамрах албагүй.
 - Сурагчийн урт хугацааны зорилтыг тодорхойлоход хүүхдийн хөгжлийн айн ангиллыг ашиглана.
- 2.3. “Дэмжлэгийн орчин” хэсэгт “Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг”, “Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг”, “Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг” гэсэн 3 төрлийн дэмжлэгийн орчныг хэрхэн бүрдүүлж, хэзээ, ямар чиглэлийн дэмжлэг үзүүлэхийг тодорхойлж бичнэ.

4-р баг: ГСТ-ний богино хугацааны зорилт, жилийн эцсийн үнэлгээ

Гурав. “Богино хугацааны зорилт” хэсэгт өмнөх буюу “Урт хугацааны зорилт”-д хүрэх алхмыг хэд хэдэн богино хугацаанд хуваан 3 дэмжлэгийн орчин тус бүрээр зорилт болгон тодорхойлох бөгөөд багшийн хэрэглэх арга зүй, үзүүлэх дэмжлэг зэргийг тус тус тодорхойлж бичнэ.

- 3.1. “Сурагчийн овог нэр”, “Анги, бүлэг”, “Хүйс”, “Төрсөн огноо” зэргийг дахин бичнэ.
- 3.2. Урт хугацааны зорилтыг өмнөх хуудаснаас хуулбарлан бичнэ. Учир нь урт хугацааны зорилт хэсэгт бичигдээгүй зорилтыг богино хугацааны зорилтын хүснэгтэд бичихгүй.
- 3.3. Богино хугацааны зорилтын дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/ гэсэн хэсэг дээр “урт хугацааны зорилт” хэсэг дээр сонгогдсон дэмжлэгийн орчныг “Урт хугацааны зорилт” хуудаснаас шууд хуулбарлан бичнэ.
- 3.4. Богино хугацааны зорилт нь тухайн сурагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлага, чадамжтай уялдуулан урт хугацааны зорилтыг биелүүлэхэд чиглэсэн үе шаттай хэрэгжүүлэх улирлын зорилтууд байна.

- 3.5. Сурагчийн хийх үйл ажиллагаа
- 3.6. Багшийн дэмжлэг, арга зүй
- 3.7. Эцэг эхийн дэмжлэг, туслалцаа
- 3.8. Улирлын үнэлгээ
 - Суралцагчийн үнэлгээ
 - Багшийн үнэлгээ
- 3.9. Дэмжлэгийн орчин тус бүрээр хуудсыг нэмж бөглөнө
- 3.10. Богино хугацааны зорилтыг биелүүлэхэд “Хичээл судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг”-ийг тодорхойлохдоо хүүхдийн өдөр тутмын амьдралд зайлшгүй шаардлагатай, хэрэгтэй мэдлэг, чадварыг хичээлийн агуулгадаа сонгон оруулах хэрэгтэй.

Дөрөв. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж хэсэгт “Богино хугацааны зорилт” хэсэгт бичигдсэн “Улирлын үнэлгээ” хэсгийн үнэлгээнд тулгуурласан дүгнэлтийг “Ололт амжилт” болон “Сайжруулах чиглэл, зөвлөмж” гэсэн үзүүлэлтийн дагуу анги удирдсан багш бичнэ.

- 4.1. “Сурагчийн овог нэр”, “Анги, бүлэг”, “Хүйс”, “Төрсөн огноо” зэргийг дахин бичнэ.
- 4.2. “Урт хугацааны зорилт” хэсэгт тухайн хичээлийн жилд сурагч биелүүлэх “Урт хугацааны зорилт” хэсэгт бичигдсэн зорилт тус бүрийг нэг бүрчлэн хуулбарлан бичнэ.
- 4.3. “Ололт амжилт” хэсэгт Урт хугацааны зорилтын биелэлтийн явцыг үнэлж, сурагчид гарсан эерэг өөрчлөлт, ололт амжилт, ахицыг тус тус бичнэ.
- 4.4. Сайжруулах чиглэл зөвлөмж

5-р баг: ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс

ГСТ-г боловсруулахад анхаарах зүйлс:

- 5.1. Зорилтыг эерэг хэлбэрээр бичнэ.
- 5.2. Ямар зүйлийг чаддаг болох тухай дэлгэрэнгүй тодорхой бичих.
- 5.3. Богино хугацааны зорилт нь тавьсан хугацаандаа биелэгдэхүйц байхаар бичнэ.
- 5.4. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн давуу ба сул тал, онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзсан байх.
- 5.5. Арга зүйн дэмжлэг үзүүлэх явцад тухайн хүүхдэд ахиц гарах бүрт урамшуулан дэмжих олон талт аргыг хэрэглэн итгэл төрүүлдэг байх.
- 5.6. Хүүхдэд эзэмшүүлж буй мэдлэг, дадал чадварыг хэрэглээ болгон хэвшүүлэхэд гэрийн нөхцөлд яаж хамтран ажиллахыг тусгахыг эрмэлзсэн байх.

- 5.7. Хүүхдийн хүрч чадах түвшинг хэт ахиулан тавихгүй байх.
- 5.8. Багш нар хамтарч ажилласан байх.
- 5.9. Улирал бүрт хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэн ГСТ-нд өөрчлөлт оруулах эсэхийг нягталж байх.
- 5.10. Хичээлийн явц дахь хүүхдийн байдалд ажиглалт хийн, цаашид анхаарах бусад анхаарах зүйлийн талаар бичих.
- 5.11. Үнэлгээ хийх явцад, хичээлийн явц дахь хүүхдийн байдлыг нэмээд, хүүхдийн бүтээл, тарааж өгөх материал, тест, багшийн тэмдэглэл зэргийг ашиглан үнэлгээ хийх.
- 5.12. Эцэг эх, асран хамгаалагчтай нь мэдээлэл солилцон, гэртээ байх үеийн байдалд нь дүн шинжилгээ хийж түүнийг мөн үнэлгээндээ тусгана.
- 5.13. Дэвшүүлсэн зорилт, арга зүй, багшийн дэмжлэгийн үнэлгээ нь дараагийн улирлын богино хугацааны зорилт болон арга зүйтэй холбох зорилготой үнэлгээ тул аль болох нарийвчлан тодорхой бичих.

ХАВСРАЛТ 2

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Сурагчийн бодит байдлын судалгаа.			
Сургуулийн комиссын хуралдааны огноо:	Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт:		
Сурагчийн овог, нэр:	Суралцахуйн бэрхшээлтэй огноо:		
Регистрийн дугаар: □□□□□□□□□□	Сургуульд элсэн орсон огноо, (нас)	Онош: Оюуны хөгжлийн; Харааны; Тулгуур эрхтний; Сонстголын; Аутизм; Даун; Хэл яриа; Суралцахуй; Сэтгэл хөдлөл; Бусад	
Анги, бүлэг:	Төрсөн огноо:		
Ам бүлийн тоо:	Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд:	Дагалдах өвчин, өвчний тухай мэдээлэл:	
Гэр бүлийн харилцааны төлөв байдал:			
Цэцэрлэгт явсан эсэх (Тийм/ Үгүй).	Эцэг, эх /асран хамгаалагч/ -ийн нэр Холбоо барих утас:	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэр:	
Хэрвээ тийм бол, цэцэрлэгийн нэр:	И-мэйл хаяг:.....		
Хэрвээ үгүй бол, яваагүй шалтгаан:			
Оршин суугаа хаяг:			
Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх /Тийм/ Үгүй /:		Хэрвээ тийм бол, Сорилын нэр:	Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх /Тийм/ Үгүй /:
Хэрвээ тийм бол, онош тавьсан эрүүл мэндийн байгууллагын нэр:		Хэрвээ тийм бол, онош тавьсан эрүүл мэндийн байгууллагын нэр:	
Онош:		Онош:	Үнэлгээний үр дүн:
Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх: (Тийм /Үгүй);			Тийм бол тухайн эрүүл байгууллагын нэр, тавигдсан онош, хяналтын давтамж:

Төрсний дараах (0-24 сар хүртэл) үеийн хөгжлийн түвшний онцлог байдал:	
Сургуульд бэлтгэгдсэн байдал (2-5 нас):	
ГСТ-д хамрагдах үеийн хөгжлийн түвшин:	Өөртөө үйлчлэх энгийн чадварууд
	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол
	Нийгэмшихүй
	Бие бялдар, хөдөлгөөн
	Анги удирдсан багшийн тодорхойлолт
	Оролцогч талуудын хүсэл, зорилго
Эцэг эх /асран хамгаалагч/:	
Багш:	

Тэмдэглэл хөтөлсөн багшийн нэр, гарын үсэг:

ОГНОО:

Танилцсан эцэг, эх (асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг:

ОГНОО:

Урт хугацааны зорилт дэвшүүлэх хэсэг
(Хичээлийн жил: /)

Суралцагчийн овог, нэр: Анги, бүлэг: Хүйс Төрсөн огноо (нас)

Хөгжлийн ай	Урт хугацааны зорилт	Дэмжлэгийн орчин		
		Хичээлийн бус цагийн үйл ажиллагааны дэмжлэг	Засан сайжруулах үйл ажиллагааны дэмжлэг	Судлагдахууны хүрээнд үзүүлэх дэмжлэг
Өөртөө үйлчлэх энгийн чадварууд				
Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол				
Нийгэмшихүй				
Бие бялдар, хөдөлгөөн				

*Зөвхөн шаардлагатай гэж үзсэн хөгжлийн айн зорилтыг дэвшүүлнэ.

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн нэр, гарын үсэг:

Танилцсан эцэг (эх, асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг:

Богино хугацааны зорилт дэвшүүлэх болон багшийн дэмжлэгийн арга зүй, улирал тус бүрээр үнэлгээ хийх
3. Богино хугацааны зорилт

Суралцагчийн овог, нэр: Анги, бүлэг: Хүйс Төрсөн огноо (нас)

Урт хугацааны зорилт:

Дэмжлэгийн орчин /хэзээ, хаана/	Улирал	Богино хугацааны зорилт	Сурагчийн хийх үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг, арга зүй	Эцэг, эхийн дэмжлэг туслалцаа	Дэмжлэгийн орчин		
						Сурагчийн үнэлгээ	Багшийн үнэлгээ	Үнэлгээ өгсөн хүний нэр
	1-р улирал							
	2-р улирал							
	3-р улирал							
	4-р улирал							
	1-р улирал							
	2-р улирал							
	3-р улирал							
	4-р улирал							

4. Жилийн эцсийн нэгдсэн үнэлгээ, зөвлөмж

Суралцагчийн овог, нэр: Анги, бүлэг: Хүйс Төрсөн огноо (нас)

№	Урт хугацааны зорилт:	Дүгнэлт	
		Ололт, амжилт	Сайжруулах чиглэл, зөвлөмж

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн нэр, гарын үсэг:

Огноо:

Танилцсан эцэг (эх, асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг:

Огноо:

ХАВСРАЛТ 3

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ. НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ДУГААР
СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

1. Сурагчийн бодит байдлын судалгаа.		Сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээ, дүгнэлт: Суралцахуйн бэрхшээлтэй огноо: 2020.09.10	
Сургуулийн комиссын хуралдааны огноо: 2020.09.10		Суралцахуйн бэрхшээлтэй огноо: 2020.09.10	
Сурагчийн овог, нэр: М. овогтой О		Онош: Оюуны хөгжлийн; Харааны; Тулгуур эрхтний; Сонсголын; Аугизм; Даун; Хэл яриа; ✓ Суралцахуй; Сэтгэл хөдлөл; бусад	
Регистрийн дугаар: □ □ □ □ □ □ □ □ □ □		Дагалдах өвчин, өвчний тухай мэдээлэл: Төрөхдөө бүтэлтэй төрсөн. Тархины даралттай эмчилгээ хийлгэж байсан.	
Анги, бүлэг: 3.6	Хүйс: эр	Төрсөн огноо: 2012 он	Жич:сургуулийн эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын үнэлгээгээр “Суралцахуйн бэрхшээлтэй” гэж урьдчилсан байдлаар дүгнэгдлээ. Цаашид сургалтын явцад ажиглаж, дахин хөгжлийн үнэлгээнд хамрагдах шаардлагатай.
Ам бүлийн тоо: 4	Хамт амьдардаг гэр бүлийн гишүүд: Аав, ээж, эгч	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэр:	
Эцэг эхийн харилцааны байдал: Эелдэг харилцаатай, гэр бүлдээ нөхөрсөг, хамтач	Эцэг, эх /асран хамгаалагч/ -ийн нэр О.Н	Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт орж, оношлуулсан эсэх (Тийм/ Үгүй)	Хөгжлийн үнэлгээний сорилд хамрагдсан эсэх / Тийм/ Үгүй /: Хэрвээ тийм бол, Сорилын нэр: Үнэлгээ хийсэн байгууллагын нэр Үнэлгээний үр дүн:
Цэцэрлэгт явсан эсэх (Тийм/ Үгүй).	Холбоо барих утас: 8800 И-мэйл хаяг:.....	Хэрвээ тийм бол, Онош тавьсан эрүүл мэндийн байгууллагын нэр: Онош:	
Хэрвээ тийм бол, цэцэрлэгийн нэр: Мойлхон цэцэрлэг			
Хэрвээ үгүй бол, яваагүй шалтгаан:			

Оршин суугаа хаяг: СБД-ийн 9-р хороо ...	Эрүүл мэндийн байгууллагын хяналтад байдаг эсэх: (Тийм / Үгүй); Тийм бол тухайн эрүүл байгууллагын нэр, тавигдсан нэр, хяналтын давтамж:
Төрсний дараах /0-24 сар хүртэл/ үеийн хөгжлийн түвшний онцлог байдал:	Хэвийн хөгжилтэй байсан.
Сургуульд бэлтгэгдсэн байдал /2-5 нас/:	Бусадтай нээлттэй харилцдаг. Дуулах, бүжиглэх дуртай. Хувийн цэцэрлэгт явдаг байсан. Цэцэрлэгт 2 жил явсан. Дүрс, тоо, өнгө танихдаа олон удаагийн давталтаар муухан мэддэг болсон, үсэг, тоо бичиж сураагүй байсан. Сургуульд суралцах бэлтгэл хангагдаагүй.
Өөртөө үйлчлэх энгийн чадварууд	Өөрөө бие даан хувцасладаг, хоолоо өөрөө иддэг, гараа тогтмол угаадаг. Өөртөө үйлчлэх чадвар сайн.
	Юмыг тогтоохдоо удаан, өнгө мэддэг. Үг, холбоо үг, өгүүлбэрийг бичихдээ ойролцоо дуудлагатай үсгийг сольж буруу бичдэг.
ГСТ-д хамрагдах үеийн хөгжлийн түвшин:	Бусадтай харилцахдаа сайн, өөрийнхөө дураараа байх хандлагатай. Бусдыг даган дуурайх дуртай.
Бие бялдар, хөдөлгөөн	Гүйх дуртай, бие бялдар хэвийн хөгжилтэй. Гар, хурууны хөдөлгөөн удаан.
Анги удирдсан багшийн тодорхойлолт	Ойролцоо дуудлагатай үсгийг сольж бичдэг болон дуудлагаараа бичдэг.
Сурагч:	Би зөв бичдэг болмоор байна.
Эцэг эх /асран хамгаалагч/:	Энэ хичээлийн жилийн хувьд бичих чадварыг сайжруулах хүсэлтэй. Монгол хэлний хичээлийн хувьд зөв бичдэг болох, математикийн хичээлийн хувьд 100 хүртэл тооны дотор нэмэх, хасах, үржих, хуваах, жиших үйлдлийг бие даан гүйцэтгэж чаддаг болгомсоор байна.
Оролцогч талуудын хүсэл, зорилго	Ойролцоо дуудлагатай авиаг сонголоороо зөв хүртэж сонсдог болох, хараагаараа тухайн үсгүүдийн ялгааг мэддэг болох, үсгүүдийг сольж бичдэг, дуудлагаараа бичдэг алдаа гаргахгүй зөв бичдэг болох, 100 хүртэлх тооны дотор нэмэх, хасах, үржих, хуваах, жиших үйлдлийг бие дааж чаддаг болгох

ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨМЖ

Суралцагчийн овог М нэр: О Анги, бүлэг: 36 Хүйс: Эр Төрсөн огноо (нас): 2015 он, 8 нас

№	Урт хугацааны зорилт:	Дүгнэлт	Сайжруулах чиглэл, зөвлөмж
1	Зөв бичиж сурах	<p>Ололт, амжилт</p> <p>Дуу чимээ болон авиаг ялган сонсож сурсан. Авиаг дуудах үеийн өгүүлэх эрхтний байрлал сайн мэддэг болсон.</p> <p>Үсгийн төсөөтэй зүйлийг сайн нэрлэж олдог. Үсгийг янз бүрийн зүйлээр бүтээж чаддаг.</p> <p>Авиаг загварчилж үгийн утгыг ойлгодог болсон.</p> <p>Холбоо үгийг зургаар бүтээж, өгүүлбэрт оруулж зөв өгүүлбэр бүтээж сурлаа.</p> <p>Зурагт карт ба үгэн карт ашиглан нүдлэх цээж бичигт сайжирсан.</p> <p>Зүйр цэцэн үг, оньсого, богино эхийг өмнө нь сайн бэлтгэж бичдэг, гэхдээ алдаатай бичдэг байсан бол одоо бэлтгэлгүй зөв бичиж байна.</p>	<p>Сайжруулах чиглэл, зөвлөмж</p> <p>Авиан сонсгол хөгжүүлэх ажлыг тасралтгүй хийх нь чухал юм.</p> <p>Авиаг задлаг нийлэг аргаар таних, үсгийн төсөөтэй зүйлийг олох, нэрлэх, үсгийг төрөл зүйлийн материалаар бүтээх ажлыг сайн хийлгэх.</p> <p>Авиаг үгийн эхэн, дунд, адагт дуудагдаж байгаагаар ялган сонсох ажил маш чухал.</p> <p>Нүдлэх болон сонголоор жижиг эхийг зөв бичихэд дадлага ажлыг тасралтгүй хийх хэрэгтэй.</p> <p>Танин мэдэхүйн үйлийг хөгжүүлэх дасгал, даалгаврыг нэмэлтээр ажиллана.</p>

Тэмдэглэл хөтөлсөн анги удирдсан багшийн нэр, гарын үсэг: Огноо: 20 ... 05.20

Танилцсан эцэг (эх, асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг: Огноо: 20

СЭДЭВ 3: ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ

Зорилго: Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх арга зүйн талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Боловсролын тусгай хэрэгцээтэй сургуулийн насны болон сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх журам, ажиглалтын хуудасны талаар бусдад тайлбарлах
- Боловсролын тусгай хэрэгцээтэй сургуулийн насны болон сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлж турших, дүн шинжилгээ хийх

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- PPT, зөөврийн компьютер, проектор, дэлгэц цаас, маркер
- Хавсралт 1: БШУ-ны сайдын А/280 тушаалын хавсралтыг өгсөн линк ашиглан татаж, тараах материал болгон багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 2: БСШУ-ны сайдын А/301 тушаалын 2 дугаар хавсралтыг өгсөн линк ашиглан татаж, тараах материал болгон багийн тоогоор хэвлэх

Үйл ажиллагаа 1: Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг үнэлэх тухай ойлголт (15 минут)

1. Доорх асуултыг ашиглан хүүхдэд гарч буй ахицыг хэрхэн үнэлж болох талаар оролцогчдын санаа бодлыг сонсоно.
 - Хүүхдийн хөгжил ахицыг хэзээ үнэлэх вэ?
 - Хүүхдийн хүрч чадах түвшнийг хэрхэн тодорхойлох вэ?
 - Эцэг эхийг үнэлгээнд хэрхэн татан оролцуулах вэ?

Үйл ажиллагаа 2: Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлж буй байдал, сайн туршлага (20 минут)

1. Оролцогчдыг 3-4 багт хуваана. Багууд гишүүд өөрсдийн цэцэрлэг, сургуульд суралцаж буй боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн ахиц өөрчлөлтийг хэрхэн үнэлдэг талаарх туршлагаа хуваалцан ярина.
2. Багаараа ярилцсан зүйлээсээ бусдад сайн туршлага болохуйц жишээнүүдийг дэлгэц цаасан дээр тоймлон бичихийг хүснэ.
3. Баг бүр өөрсдийн бичсэн сайн туршлагаа бусад багуудад ээлжлэн танилцуулна.

Үйл ажиллагаа 3: Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх (50 минут)

1. Оролцогчдыг дараах байдлаар багт хуваана.
 - 1-р баг - Цэцэрлэгийн багш нар
 - 2-р баг - Бага ангийн багш нар
 - 3-р баг - Дунд ангийн багш нар
2. Баг тус бүрт тараах материалыг дараах байдлаар тарааж өгнө.
 - Цэцэрлэгийн багш нарт БШУ-ны сайдын А/280 тоот тушаалын хавсралт – Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын хавсралт – Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур (хавсралт 1) -ыг өгнө.
 - Бага болон дунд ангийн багш нарын багт БСШУ-ны сайдын 2015 оны А/301 тоот тушаалын 2 дугаар хавсралт - Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудсыг (хавсралт 2) өгнө.
3. Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх эдгээр ажиглалтын хуудас дахь мэдээлэлтэй танилцахыг хүснэ.
4. Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас болон өмнөх сэдвийн хүрээнд ажилласан кейсийг ашиглан үнэлгээ хийнэ.
5. Баг бүр өөрсдийн хийсэн үнэлгээг ээлжлэн танилцуулна. Тус үнэлгээний үр дүнг ГСТ-д хэрхэн ашиглах талаар хамтран ажиллана.

Дүгнэлт (5 минут)

Хичээлийн дүгнэлтийг дараах байдлаар хийнэ.

- Үзсэн хичээлийн агуулгыг бататган ярилцаж, оролцогчид бие биеэсээ ээлжлэн асуулт асууж, хариулна.
- Оролцогчид өөрсдийн шинээр мэдэж авсан зүйлээ бодит практикт хэрхэн ашиглах талаар санаа бодлоо илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 1

БШУ-ны сайдын 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн А/280 тоот тушаалын хавсралт – Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын хавсралтын линк - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211164&showType=1>

ХАВСРАЛТ 2

БСШУ-ны сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/301 тоот тушаалын 2 дугаар хавсралт - Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудасны линк - <https://education-profiles.org/sites/default/files/2020-03/%D1%81%D0%B0%D0%B9%D0%B4%D1%8B%D0%BD%20155-%D1%80%20%D1%82%D1%83%D1%88%D0%B0%D0%B0%D0%BB.pdf>

СЭДЭВ 4: ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Зорилго: Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд суралцах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Ганцаарчилсан сургалтын жишиг хөтөлбөрт дүн шинжилгээ хийх
- Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр бие даан боловсруулах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- РРТ, зөөврийн компьютер, проектор, дэлгэц цаас, маркер
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчдын 1/2 тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Тараах материалыг оролцогчдын 1/2 тоогоор хэвлэх

Үйл ажиллагаа 1: Ганцаарчилсан сургалтын жишиг хөтөлбөрт анализ хийх (30 минут)

1. Оролцогчид хосоороо ажиллана. Хос бүрт хавсралт 1-д байгаа зөвлөмжийг тараан өгч, уншиж судлахыг хүснэ.
2. Хос бүрт хавсралт 2-т байгаа “Ганцаарчилсан сургалтын жишиг хөтөлбөр”-ийг өгч, шалгуур боловсруулан, түүний дагуу анализ хийх даалгавар гүйцэтгүүлнэ.

Үйл ажиллагаа 2: Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах (40 минут)

1. Оролцогчид цэцэрлэг, сургууль дээрээ өөрийн ажиллаж байсан хүүхдийн жишээн дээр ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулна.
2. Оролцогчид гурав гурваараа баг болж өөрсдийн боловсруулсан ГСХ-өө ярилцаж, аль нь хамгийн оновчтой болсон талаар хамтран дүгнэлт хийнэ.
3. Хамгийн шилдэг ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн 3 жишээтэй танилцана.

Үйл ажиллагаа 3: Боловсролын тусгай хэрэгцээтэй суралцагчтай ажиллаж байсан туршлага (15 минут)

1. Багш нар хоорондоо боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчтай ажиллаж байсан туршлагаа хуваалцана.
2. Нээлттэй хэлэлцүүлэг хийж, чөлөөт асуулт хариулт өрнүүлнэ.

Дүгнэлт (5 минут)

Үзсэн хичээлийн агуулгыг бататгаж, ойлгосон зүйлийнхээ талаар хажууд сууж буй оролцогчтойгоо ярилцан дүгнэлт хийнэ.

ХАВСРАЛТ 1

ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД БАГШИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Бичих бэрхшээл нь бага ангийн хүүхдэд элбэг тохиолддог. Бичих үйл ажиллагаа нь хараа, сонсгол, хэл яриа, хөдөлгөөний эрхтний нэгдмэл үйл ажиллагаа юм. Бичих бэрхшээлийн үед дараах хэлбэрийн бэрхшээлүүд тохиолдоно. Үүнд:

- Дуудлагаараа бичих
- Ойролцоо дуудлагатай авиаг сольж бичих
- Дүрмийн алдаатай бичих
- Харааны тусгалын алдаа
- Задлаг, нийлэг аргыг хангалттай эзэмшээгүйн алдаа

Бичих бэрхшээлтэй хүүхдийн суралцах явцад илрэх шинж, онцлог:

- Зурлагаараа ижил төстэй үсгийг бичихдээ сольж буруу бичих, ойлгогдохгүй гаргацгүй бичих, урвуу бичих, үсэг бичихдээ удах, зурлага дутуу буюу илүү бичих, бичмэл дармал үсгийг хольж бичих, үсэг, үгийг нийлүүлэн үргэлжлүүлэн бичих
- Өгүүлбэрт цэг, таслал орхих, өгүүлбэрийн эхлэл төгсгөлийг мэдэхгүй алдаа гаргах, үгийг буруу байрлуулан бичих
- Зохион бичлэг бичихдээ агуулгаа төлөвлөж чадахгүй, санаагаа илэрхийлэн бичихгүй, бичлэгийн бүтэц, тэмдэглэгээний алдаа гаргах байдлаар илэрнэ.

Бичих бэрхшээлтэй хүүхдэд хурууны жижиг булчин, хараа, орон зайн баримжаа, төрөл бүрийн байрлалд зураас, зурлага, дүрс зурах зэрэг дасгал хийлгэхийн зэрэгцээ эцэг эхчүүд хүүхдийн бичих үед гарч байгаа бэрхшээлийг даван туулахад дэмжлэг туслалцаа үзүүлж, тохирох дасгал, даалгаврыг хүүхэдтэйгээ хамтран хийх хэрэгтэй. Хүүхдийн гаргасан амжилт, оролдлогыг байнга сайшааж, дэмжиж тусалж байгаарай.

- Хүүхдийн бичих үед ямар хүндрэл гарч байгаа, шинж байдлын талаар тэмдэглэл хөтлөх, дүгнэлт хийж, дэмжлэг үзүүлж ажиллах;
- Танин мэдэхүйн үйл ажиллагааг хөгжүүлэх дасгал, гар, хурууны жижиг булчингийн дасгал хийх (зааврын дагуу хийх, булчин суллах, алжаал тайлах массаж хийх гэх мэт);
- Гар, хурууны мэдрэхүйн үйл ажиллагааг хөгжүүлэх дасгалыг тогтмол хийх (баримлын шавраар үсэг, дүрс хийх, жижиг, том ширхэгтэй эд зүйлийг тэмтрэх);
- Хараа, дүрслэлийн ой тогтоолтыг сайжруулах дасгалыг тогтмол хийх;

ХАВСРАЛТ 2

Оролцогчдод зориулсан материал 1:

Ганцаарчилсан сургалтын жишээ: Ээлжит хичээлийн сэдэв: "Ойролцоо дуудлагатай авиа, үсгийн ялгаварчлал ("Д"- "Т")"

Зорилго:



• "Д"- "Т" авиа, үсгийг үг, өгүүлбэрт ялгаж сонсох, бичих











Зорилт:

• "Д"- "Т" авиа дуудах үеийн өгүүлэх эрхтний байрлалыг мэдэх -Авиан сонсгол хөгжүүлэх дасгал хийх

• Харааны хүртэхүй хөгжүүлэх дасгал хийх "Д"- "Т" үсгийг үг, өгүүлбэрт бичих

Хэрэглэгдэхүүн: Зурагт болон үгт карт, зургууд, толь, байгалийн болон байгалийн биш дуу, авианы аудио бичлэг, ТЕМ Хичээлийн явц:

Алхам	Үйл ажиллагаа	Тайлбар
I <u>алхам</u> (Авиа дуудах үеийн өгүүлэх эрхтний байрлалыг мэдэх)	<ul style="list-style-type: none"> • Т-Д Өгүүлэх эрхтний дасгал, амьсгалын дасгал, дууны дасгал • "Д"- "Т" авиа дуудах үеийн өгүүлэх эрхтний байрлал • "Д"- "Т" авиа дуудах үеийн өгүүлэх эрхтний байрлалын ялга  	Өгүүлэх эрхтний профил, толь ашиглан Д, Т авиаг хэлэх үеийн өгүүлэх эрхтний байрлалын ялгааг ойлгуулна. Хүүхдийн өгүүлэх эрхтний байрлалыг зөв тавьж өгнө.
II <u>алхам</u> (Авиан сонсгол хөгжүүлэх дасгал хийх)	<ul style="list-style-type: none"> • "Т" авиа үгийн эхэнд сонсогдвол гараа өргөх, "Д" авиа үгийн төгсгөлд сонсогдвол ширээгээ товшоорой. Дал, шат, дүү, дөч, амт, хот, дэр, данх, бут, дээс, дамар, дөрөв, Бат • Холбоо үсгийг зөв дуудах өд сөд, малын төл, уул тал, галын дөл, өт тоо тоолох, галт тэрэг • Цэгийн оронд "Т", "Д" үсгийн аль тохирохыг нь олж бичих, сонсголд үг өгч сонгох дасгал ажиллах ө . . өл, . ав, . ээл, у . ас, . өмс, а . уу, ша . ар, дэв . эр Холбоо үсгийн утгыг ярилцах ор дэр - тэр хүн Дал мөр - тал нутаг тав дух - дух магнай 	

<p><u>III алхам</u> (Харааны хүртэхүй хөгжүүлэх дасгал хийх)</p>	<p>Нуугдсан зүйлсийг олох</p>  <p>"Д", "Т" үсгийн хэсгүүдийг таних</p>  <p>Машины замыг дагаж тодорхойлох</p> 									
<p><u>IV алхам</u> (“Д”-“Т” үсгүүдийг үг, өгүүлбэрт бичих)</p>	<ul style="list-style-type: none"> • “Д”-“Т” үсгийг ижил төстэй зүйлтэй харьцуулах  <p>Тэвхийтэл татсан майхан шиг Тэртээ дуганы дээвэр шиг Д үсэг</p>  <p>Дархан хүний дөш аятай Данхар толгойтой Т үсэг</p>	 								
<p><u>III алхам</u> (Харааны хүртэхүй хөгжүүлэх дасгал хийх)</p>	<ul style="list-style-type: none"> • Зургийг Д, Т үсгийн дор ялган байрлуулах (соронз самбарт)  <ul style="list-style-type: none"> • Дараах үгсийг оролцуулан, холбоо үг үүсгэн бичих үхрийн тооны адуу аадар • Өгөгдсөн үеэр өгүүлбэр зохиох та - Та таавар таа. ту - Та нар мал туу. • Өгүүлбэр дээр ажиллах  <p>Шувууны өд хөнгөн. Дэрэм өт хорхой харав.</p> <ul style="list-style-type: none"> • Өгүүлбэрээс “Д” үсэг орсон үгсийг түүж бичих Дүү Намайг Дондог гэдэг. Би нэгдүгээр ангид сурдаг. • Өгүүлбэр унших Монгол орон тал нутаг ихтэй. Бат шатар тоглох дуртай. • Онъсогыг тааж, ярилцах <table border="0"> <tr> <td>Тов тов тошлой</td> <td>Дээрээ дэн шаргал</td> </tr> <tr> <td>Товруу мөнгөн тошлой</td> <td>Дундаа дун цагаан</td> </tr> <tr> <td>Толгой дээрээс уналаа</td> <td>Доороо азай буурал</td> </tr> <tr> <td>/ Мөндөр/</td> <td>/өрөм, сүү, хусам/</td> </tr> </table>	Тов тов тошлой	Дээрээ дэн шаргал	Товруу мөнгөн тошлой	Дундаа дун цагаан	Толгой дээрээс уналаа	Доороо азай буурал	/ Мөндөр/	/өрөм, сүү, хусам/	
Тов тов тошлой	Дээрээ дэн шаргал									
Товруу мөнгөн тошлой	Дундаа дун цагаан									
Толгой дээрээс уналаа	Доороо азай буурал									
/ Мөндөр/	/өрөм, сүү, хусам/									
<p><u>V алхам</u> (Гэрийн даалгавар)</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрийн даалгавар: Зургийг ажиглаж, нэрлэж бичээд, үгийн утгыг ярилцан, өгүүлбэр зохиох 									

МОДУЛЬ 3:

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ



Зорилго	Харааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог, харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, стратеги болон үнэлгээний аргачлалыг судлах
Зорилт	<ul style="list-style-type: none"> ▪ Харааны бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах талаар үндсэн ойлголттой болох ▪ Харааны бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг таньж мэдэх ▪ Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцах, орчин бүрдүүлэх талаарх ойлголтоо нэмэгдүүлэх ▪ Үнэлгээний аргачлалын талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх
Хугацаа	6 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Харааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог, тэдэнд үзүүлэх дэмжлэг (90 минут)</p> <p>Сэдэв 2. Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй (120 минут)</p> <p>Сэдэв 3. Харааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, орчин, тохируулгат сургалтын хэрэглэгдэхүүн (90 минут)</p> <p>Сэдэв 4. Харааны бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээ (60 минут)</p>	

СЭДЭВ 1: ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ, ТЭДЭНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

Зорилго: Харааны бэрхшээл, харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах онцлог, багшийн зүгээс хүүхдэд үзүүлэх дэмжлэгийн талаар ерөнхий ойлголттой болох

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Харааны бэрхшээл, түүний төрөл, харааны бэрхшээлтэй хүүхдийн сурах онцлогийг тайлбарлах
- Харааны бэрхшээлтэй хүүхдэд тулгарах асуудал болон багшийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох
- Харааны бэрхшээлтэй хүүхдийн хүрэлцэх, үнэрлэх, амтлах мэдрэхүйг хөгжүүлэх арга зүйг ашиглах
- Харааны бэрхшээлтэй хүүхдийн сонсох, бичих чадварыг хөгжүүлэх арга зүйг бусдад заах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- PPT слайд, зөөврийн компьютер, проектор, дэлгэц
- Хавсралт 1-3: Тараах материал тус бүрийг нэг нэг хувь хэвлэх
- Хавсралт 4: Карт хэлбэрээр бэлтгэх
- Хавсралт 5-8: Тараах материал тус бүрийг нэг нэг хувь хэвлэх
- Хавсралт 9: Тараах материалыг оролцогчийн тоогоор хэвлэх

Үйл ажиллагаа 1: Харааны бэрхшээлийн талаарх ойлголт (25 минут)

1. Харааны бэрхшээлийн талаарх оролцогчдын ойлголтыг тодруулах зорилгоор дараах асуултыг ашиглан харилцан ярилцана.
 - Харааны бэрхшээлийг өөрийн үгээр тайлбарлана уу.
 - Харааны бэрхшээл яаж үүсдэг вэ?
2. Оролцогчдыг 3 багт хуваана. Баг тус бүрт хавсралт 1, 2, 3-ыг нэг нэгээр оноож өгнө. Тухайлбал:
 - 1-р баг – Харааны бэрхшээлийн талаарх ерөнхий ойлголт
 - 2-р баг – Харааны бэрхшээлийн төрөл
 - 3-р баг – Харааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог

Багууд өөрт оногдсон мэдээллийг уншиж судлаад, бусдадаа ээлжлэн танилцуулна.

Үйл ажиллагаа 2: Харааны бэрхшээлтэй хүүхдэд тулгарах асуудал ба дэмжлэгийн хэлбэрүүд (30 минут)

1. Өмнөх багаар үргэлжлүүлэн ажиллана. Хавсралт 4-т байгаа мэдээллийг карт хэлбэрээр бэлтгэх бөгөөд картыг хольж баг бүрт ойролцоо тоогоор хувааж өгнө. Танхимын ханан дээр дараах 4 гарчгийг байрлуулна.
 - Суралцах үед тулгарч болох асуудлууд
 - Өдөр тутамд тулгарч болох асуудал
 - Суралцах үед үзүүлэх дэмжлэгийн хэлбэр
 - Өдөр тутамд үзүүлэх дэмжлэгийн хэлбэр
2. Багууд өөрт оногдсон картыг эдгээрийн алинд хамаарагдахыг шийдэж, тохирох гарчгийн доор байрлуулна. Зөв байрлуулсан эсэхийг хамтран ярилцана. Багш хавсралт 4-ийг ашиглан чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 3: Харааны бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах, багшийн зүгээс үзүүлэх дэмжлэг (30 минут)

1. Оролцогчдыг 4 багт хуваана. Багууд өртөөгөөр явж дараах материалуудыг судална. Үүнд:
 - 1-р өртөө – Харааны бэрхшээлтэй хүүхдийн тэмтрэх мэдрэхүйг хөгжүүлэх арга (хавсралт 5)
 - 2-р өртөө – Харааны бэрхшээлтэй хүүхдийн үнэрлэх, амтлах мэдрэхүйг хөгжүүлэх арга (хавсралт 6)
 - 3-р өртөө – Харааны бэрхшээлтэй сурагчийн сонсох чадварыг хөгжүүлэх арга зүй (хавсралт 7)
 - 4-р өртөө – Харааны бэрхшээлтэй сурагчийн бичих чадварыг хөгжүүлэх арга зүй (хавсралт 8)
2. Баг бүр хамгийн сүүлийн өртөөнд судалсан зүйлээ ашиглан, хэлэлцүүлэг хийх асуултууд зохиох даалгавар өгнө.
3. Багууд өөрсдийн зохиосон асуултаа ээлжлэн асууж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Дүгнэлт (5 минут)

Оролцогчдод хавсралт 9-д байгаа өөрийн үнэлгээний хуудас тараан өгч, өнөөдрийн хичээлийг ойлгосон эсэх талаар өөрийн үнэлгээний хуудсан дээр тэмдэглэгээ хийхийг хүснэ.

ХАВСРАЛТ 1

ХАРААНЫ БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

- 17-р зууны сүүл үе хүртэл хараагүй хүмүүсийг нийгмээс тусгаарладаг байжээ.
- 1254 онд Францын 9-р Людвик Парист харааны бэрхшээлтэй 300 хүний багтаамжтай асрамжийн газар нээсэн.
- 18-р зууны дунд үеэс хүнлэг энэрэнгүй үзлийн үүднээс хандах болж тэдний онцлогт тохирсон сургалт явуулах боломжийг судалж эхэлсэн.
- 1784 онд 12 сурагчтай анхны хараагүй хүүхдийн анги байгуулагдсан.
- 1829 онд Францын иргэн Луй Брайль “Брайль үсэг”-ийг зохиосон.
- 1882 онд Брайлийн системээр анхны номыг Францад хэвлэсэн.

Харааны бэрхшээл: ДЭМБ /2001/

Харааны эрхтэнд өөрчлөлт гарснаар “Харах чадвар, харааны хүрээ, гэрэл мэдрэх, өнгө мэдрэх, нүдний хөдөлгөөн, үйл ажиллагаа, нүдний хараа зэрэг харахуйн бэрхшээлийг үүсгэж”, “Алхах, явах, суралцах, харилцах, өөртөө үйлчлэх гэх мэт үйл ажиллагааны хязгаарлалт”, “Нийгмийн оролцооны хязгаарлалт”-ыг бий болгож буй байдал.

Харааны үйл ажиллагаа

- Харааны чадвар – Хэлбэр дүрс ялгах үйл ажиллагаа
- Өнгө мэдрэх – Өнгө ялгах торлог бүрхэвчийн үйл ажиллагаа
- Гэрэл мэдрэх – Гэрлийг мэдэрч, гэрлийн түвшнийг ялгах торлог бүрхэвчийн үйл ажиллагаа
- Хоёр нүдний харах үйл ажиллагаа

Боловсролын тодорхойлолт: Харааны бэрхшээлээс шалтгаалан амьдралын явцад гарч буй олон янзын саад, бэрхшээлийг даван туулах, багасгахын тулд тусгай агуулга бүхий сургалт, тусгай дэмжлэгтэйгээр боловсрол эзэмших шаардлагатай байдал.

Хараа гэж юу вэ?

Харааны эрхтэн ба харааны анализаторын гүйцэтгэж буй үүрэг бөгөөд янз бүрийн объектоос ялгарах эсвэл тусах гэрлийн энергийг хүлээн авч, хувиргах, эргэн тойрныхоо ертөнцийн талаар мэдээлэл авахаас бүрддэг.

Харах гэдэг нь гэрлийн тусламжтайгаар аливаа зүйлийн хэлбэр, хэмжээ, дүрс, өнгө зэргийг хараандаа тусгахтай холбоотой мэдрэхүйн үйл ажиллагаа юм. Харааны бэрхшээл гэдэг нь харах мэдрэхүйн чадвараа бүрмөсөн буюу тодорхой түвшинд алдахыг хэлнэ. Харааны бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд хэр их зүйл харж чадаж байна, нарийн харж чадаж байна уу гэдгээс хамаарч бэрхшээлийн хэлбэр харилцан адилгүй байна.

ХАВСРАЛТ 2

ХАРААНЫ БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ

Тифлопедагогика (грек хэлээр typos - сохор) - харааны бэрхшээлтэй хүний боловсрол, сурган хүмүүжүүлэх зүйн тухай судалдаг шинжлэх ухаан юм. Харааны бэрхшээлтэй хүмүүс харилцаа холбоо, сэтгэц биеийн хөгжил, үйл ажиллагааны өвөрмөц онцлогтой байдаг.

Харааны бэрхшээлийн ангилал

- 1. Огт хараагүй** - харааны бүрэн алдагдалтай (гэрлийн ямар ч мэдрэмжгүй, харааны задлан ялгах хэсэг бүрэн ажиллахгүй хүүхэд)
- 2. Үлдэгдэл хараатай** - нарны ба хурц гэрлийн туяаг мэдэрдэг, харааг самбараар шалгах боломжгүй, маш ойрын зайнаас хүний хурууг тоолох чадвартай, өмнөх замаа харах төдий, том овор хэмжээтэй зүйлийг ялгах төдий хүүхэд
- 3. Сул хараатай** - холын зайд юмсыг харах чадвар, ойрын зайд юмсыг харах чадвар буурсан, төвлөрсөн болон хажуугийн юмсыг харах харааны алдагдалтай хүүхэд

Харааны бэрхшээлийн төрлүүд:

- Харааны түвшний бэрхшээл: Юмны хэлбэр дүрсийг ялган хүлээж авч чадахгүй байх бэрхшээл
- Гэрлийн мэдрэхүйн бэрхшээл: Тахиан сохор
- Харааны нарийсалт: 20-оос доош градусаар харж буйг бүрэн хараагүй хүнтэй адилхан үзэж болно
- Хугарлын саатал: Хол, ойрын хараа
- Өнгө мэдрэх, ялгах бэрхшээл: Бүх өнгийг нэг өнгөөр харахыг “1 өнгөний сохор”, улаан, ногоон 2 өнгийг ялгаж чадахгүй байдлыг “2 өнгөний сохор” гэж нэрлэх нь бий.

Харааны бэрхшээл

- Бүрэн хараагүй: Брайль үсэг ашигладаг, ихэнх мэдээллээ хүртэх, сонсох гэх мэт харааны хүртэхүйгээс бусад хэлбэрээр суралцах шаардлагатай байдал. Бүрэн хараагүй хүүхдийн ихэнх нь харааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд суралцдаг.
- Сул хараатай: Энгийн үсэг хэрэглэх боломжтой боловч, үсгийг томруулах, линз зэрэг туслах хэрэгсэл, дэмжлэг шаардлагатай байдал. Сул хараатай хүүхэд нь тусгай сургууль болон тусгай анги, энгийн тэгш хамран сургах боловсрол, нөөц ангид үндсэн хичээлээ судална.

Сул хараатай хүүхдийн харах байдал нь олон янз байдаг. Тэдгээрээс авч үзвэл: сарниулж харах, бүдгэрүүлж харах, цайралттай харах, гэрлийн бууралттай харах, төвийн хараагүй, харах хүрээ хязгаарлагдсан гэх мэт. Эдгээр харах байдал дангаараа байхаас гадна хавсран тохиолддог.

ХАВСРАЛТ 3

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Харах эрхтний үйл ажиллагаагаар хүртэх мэдээллийг бусад мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар нөхөж авна. Хүн хараагүй болоход дээд мэдрэлийн үйл ажиллагаанд өөрчлөлт ордог ба аливаа зүйлийг нарийвчлан тогтоох ялгах таних онцгой чадвартай байдаг. Мөн үнэрлэх, сонсох, тэмтрэх эрхтний мэдрэхүйг сайжруулах нь харааны үйл ажиллагааг нөхөх үндэс болно. Төрөлхийн хараагүй хүүхдүүд орчноо тэмтрэх мэдрэхүйгээр дамжуулан мэдэрдэг. Харин 7-14 наснаас хойш хараагүй болсон бол сэтгэл санааны хямралаас хурдан гарч чаддаг. Хараатай байх үедээ мэдэрсэн, харсан зүйлээ насан туршдаа мартдаггүй.

Харааны бэрхшээлтэй хүүхэд бие даан хийж сурсан байх хөдөлгөөнүүд:

- Түлхүүрээр хаалга онгойлгох, хаах;
- Шилний бөглөөг онгойлгох, эргүүлэн таглах;
- Аяганд ус дүүртэл хийх;
- Товч товчлох, тайлах, оёх;
- Гутлаа үдэх;
- Баримлын шавар болон цаасаар төрөл бүрийн дүрс хийж тоглох;
- Модны навчаар наамал хийх;
- Дүрсүүдийг нийлүүлэн бодит зүйл хийх;
- Алхаар хадаас хадах зэрэг маш олон зүйлийг нэрлэж болно.


Харааны бэрхшээлтэй хүүхдийн харааны түвшнийг сургалтад харгалзах боломжийг хүснэгтээр харуулъя.

Хараагүй	Брайль бичиг + тэмтрэх хэлбэрийн сургалт
Сул хараатай (үлдэгдэл хараатай)	Брайль бичиг + хөдөлгөөний баримжаа зэрэгт хараагаа хэрэглэх боломжтой
Сул хараатай	Харааны нэмэлт хэрэгсэл (нүдний шил, линз) ашиглан ердийн сургалтад хамрагдах боломжтой

ХАВСРАЛТ 4

Суралцах үед тулгарч болох асуудлууд	Дэмжлэгийн хэлбэрүүд
<ul style="list-style-type: none"> · Үсэг андуурах · Удаан унших · Мөр алгасаж унших · Ойлгохгүй байх · Үсэг үсгээр бус үгээр уншиж агуулгыг ойлгох · Хэмжилт, хэмжүүрийг унших үед алдаа гаргах нь хялбар · Нүүрээ ойртуулж зурдаг учир хоёр цэгийг холбох, дүрсийг бүтнээр харахад хүндрэлтэй · Өөрийн бүтээсэн зураг дүрсийг хянахад хүндрэлтэй · Ном, сурах бичгийн тохиромжгүй, хүртээмжгүй байдал · Багш, ажилтнуудын буруу ойлголт, хандлага · Сургуулийн орчны хүртээмжгүй байдал · Гэрэлтүүлэг, нэмэлт хэрэгслийн хангалтгүй, тохиромжгүй байдал 	<ul style="list-style-type: none"> · Нэг өгүүлбэрийг давтан уншуулах /хугацааг хэмжих/ · Зөв бөгөөд хурдан уншуулах · Уншиж дууссан мөрнөөс харааг салгалгүйгээр дараагийн мөрөнд шилжиж сургах · Уншсан мөрний эхний үгэнд буцах · Уншсан мөрний төгсгөл хэсгээс дараагийн мөрөнд шилжих · Олон удаа бичүүлэх бус зөв бичүүлэх · Томоор хэвлэх · Хуулан бичиж буй номыг ойрхон тавих (харьцуулж харах, зөв бичиж буйгаа шалгах) · Зөв дарааллаар бичих · Самбарт болон агаарт бичих · Хэрэглэгдэхүүнийг бэлтгэх · Харахад хялбар тоо, дүрс ашиглах · График, хүснэгтийг хялбаршуулах · Үсэг, дүрсний хэмжээг томруулах · Графикийн зураас, шугамыг өргөн болгох · Шугаман графикийн зураасны өнгийг бараан өнгөөр хийх · Баганан графикийг өнгөөр ялгах, үсгэн тэмдэглэгээ ялгагдахуйц байх · Дэвшин суралцахад таатай боломжоор хангах · Нэмэлт хэрэгслийн хүртээмжтэй байдал · Багш, ажилтнуудын зөв ойлголт, хандлага · Сургуулийн орчныг хүртээмжтэй болгох

Үсгийн хэмжээ оновчгүй	<table border="1"> <thead> <tr> <th>Хэрэглэж буй үсэг</th> <th>Үсгийн тоо /хэмжээ/ /хүл</th> <th>Хөндөг /Фонг</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1, 0</td><td>2, 88</td><td>8</td></tr> <tr><td>0, 9</td><td>3, 21</td><td>9</td></tr> <tr><td>0, 8</td><td>3, 60</td><td>10</td></tr> <tr><td>0, 7</td><td>4, 11</td><td>12</td></tr> <tr><td>0, 6</td><td>4, 80</td><td>14</td></tr> <tr><td>0, 5</td><td>5, 76</td><td>16</td></tr> <tr><td>0, 4</td><td>7, 20</td><td>20</td></tr> <tr><td>0, 3</td><td>9, 60</td><td>28</td></tr> <tr><td>0, 2</td><td>14, 40</td><td>40</td></tr> </tbody> </table>	Хэрэглэж буй үсэг	Үсгийн тоо /хэмжээ/ /хүл	Хөндөг /Фонг	1, 0	2, 88	8	0, 9	3, 21	9	0, 8	3, 60	10	0, 7	4, 11	12	0, 6	4, 80	14	0, 5	5, 76	16	0, 4	7, 20	20	0, 3	9, 60	28	0, 2	14, 40	40
	Хэрэглэж буй үсэг	Үсгийн тоо /хэмжээ/ /хүл	Хөндөг /Фонг																												
	1, 0	2, 88	8																												
	0, 9	3, 21	9																												
	0, 8	3, 60	10																												
	0, 7	4, 11	12																												
	0, 6	4, 80	14																												
	0, 5	5, 76	16																												
	0, 4	7, 20	20																												
	0, 3	9, 60	28																												
0, 2	14, 40	40																													

<p>Үсгийн хэлбэр оновчгүй</p>	
-------------------------------	---

Өдөр тутамд тулгарч болох асуудал	Дэмжлэгийн хэлбэрүүд
<ul style="list-style-type: none"> · Хол байгаа зүйлийг сайн харж чадахгүй учраас таньдаг хүнээ анзааралгүй өнгөрөх, андуурах · Хурдан хөдөлгөөнтэй хорхой, амьтныг харж чаддаггүй · Өндөр байшин, барилгыг бүхэл хэсгээр ойлгох боломжгүй учраас хэсэг хэсгээр нь харж мэдээлэл авдаг · Ойроос унших, линз зэргээр томруулж унших үед зөвхөн тэр хэсгийг хардаг учраас бүхэл хэсгийн агуулгаар ойлгоход хүндрэлтэй · Мэдээллийг хүртэх саад · Орчны эд материалын саад · Бусад хүмүүсийн ойлголтын саад · Оролцооны хязгаарлалт 	<ul style="list-style-type: none"> · Заавар өгөх үед “Тэр”, “Энэ”, “Тийшээ”, “Ийшээ” гэж хэлэх буруу бөгөөд “Юу”, “Хаана” байгааг мэдэхгүй учраас “3 метр яваад баруун”, “Нэг алхмын урд”, эд зүйлийг тайлбарлах үедээ нэрийг нь хэлэх зэргээр тодорхой заавар өгөх хэрэгтэй · Хоол ширээнд тавих үедээ цагийн тооны дагуу хэлэх · Хүртэж мэдрэх боломжтой зүйл бол гарт нь хүрэх зөвшөөрөл авч эд зүйлд хүргээд, тайлбарлах · Шаардлагатай бол тайлбар тэмдэглэгээг уншиж өгөх · Дуут гэрлэн дохио ашиглах · Олон нийтийн газар, тээврийн хэрэгсэл дэх дуут мэдээлэл · Ялгаатай байдлыг ойлгож, хамтрах · Хөтөч замыг стандартын дагуу тавих · Олон нийтийн газар дахь хөтөч зам, ханын бариул хийх

ХАВСРАЛТ 5

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ТЭМТРЭХ МЭДРЭХҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА

Хүрэлцэхүйн мэдрэмжээр дамжуулан мэдээлэл авах

1. Орчны талаарх мэдлэг: Хэрхэн орчинтой танилцдаг вэ?
 - Гараа сунгаад хүрэх
 - Гараа хөдөлгөөд хайх
 - Эд зүйлд хүрч таних
2. Биеийн шилжилт хөдөлгөөн
 - Биеийн шилжилт хийж эд зүйлд хүрэх
 - Зөвхөн гараар бус хөлийн улаар дамжуулан шал, газраас мэдээлэл авах (Шилжилт хөдөлгөөн хийснээр илүү их мэдээлэл авах боломжтой)
3. Үйл ажиллагаа: Өдөр тутмын амьдралд хүрэлцэх мэдрэмжээ хэрхэн ашиглаж чаддаг вэ?
 - Атгах, цохих, хайх гэх мэт хөдөлгөөний чадамж
 - Эд зүйлийн байрлал
 - Зүг чиглэл
 - Хөдөлгөөний чиглэл
4. Брайль бичиг

Тэмтрэх мэдрэхүйг хөгжүүлэх арга

Тэмтрэх мэдрэхүйгээр дамжуулан харааны бэрхшээлтэй хүүхэд хүрээлэн байгаа орчны талаар төсөөлөлтэй болно. Ямар нэг биетийг зөвхөн тэмтэрч үзсэний дараа түүний хэлбэр, хэмжээ, жин, халуун, хүйтэн, гадаад байдлын талаар үнэн бодит мэдээлэл авна. Хүүхэд нохой хуцах дууг сонссон ч түүнийг хэзээ ч тэмтэрч үзээгүй бол нохой гэж ямар амьтан болохыг мэдэхгүй. Зөвхөн нэг төрлийн үүлдрийн нохой биш олон төрлийн нохойг гараар нь тэмтрүүлж, бариулж таниулсны эцэст хүүхэд нохойны талаар зөв төсөөлөлтэй болно.

Хүүхдийг бүр бага наснаас эхлэн орчныхоо зүйлсийг тэмтэрч мэдрүүлж сургах хэрэгтэй. Хүүхдийн гараараа тэмтэрч судалсан зүйл дангаараа түүнийг орчинтой танилцуулж чадахгүй юм. Тэмтэрч, гартаа барьж судлах үйл ажиллагаа түүний гарын хөдөлгөөнийг хөгжүүлэх анхны алхам болж өгнө. Зөв тэмтэрч сураагүй хүүхдүүд бэрхшээлтэй тулгарч болно.



ХАВСРАЛТ 6

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ҮНЭРЛЭХ МЭДРЭХҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА

Үнэрлэх ба амтлах мэдрэхүйг хөгжүүлэх арга:

Үнэрлэх ба амтлах мэдрэхүйг хөгжүүлэх дадлага ажлыг хичээлийн бус цагаар хүүхэд хөгжлийн танхимд хийлгэх нь илүү үр дүнтэй. Харааны бэрхшээлтэй хүүхэд үнэрлэх мэдрэхүйгээр дараах чадваруудыг эзэмшсэн байх ёстой.

- Үнэрийг мэдэрдэг (үнэрлэж чаддаг байх);
- Ижил төсөөтэй болон өөр үнэрийг ялгах;
- Талхны мухлаг, кофены газар, жимсний дэлгүүр гэх мэт эргэн тойрны байдал, хаана явж байгааг мэдэх зэрэг.

Дараах амтлах чадварыг эзэмшсэн байх ёстой.

- Төрөл бүрийн амттаныг ялгах (давс, чихэр, тараг, сүү, кофе гэх мэт);
- Хүнсний зүйлүүдийг амтаар нь ялгах.

Үнэрлэх ба амтлах мэдрэхүйг хөгжүүлэх дасгалууд:

- Дараах зүйлүүдийг хүүхэд өвөрмөц үнэрээр нь ялгах (цавуу, үнэртэй ус, жүрж, саван, айраг, загас)
- Дараах зүйлүүдийг амтаар нь ялгах (давс, перец, чихэр, нимбэг, крем гэх мэт)
- Муудсан ба шинэ хүнсний зүйлийг ялгаж сурах (гашилсан ба гашлаагүй сүү, шинэ ба удсан мах, жимс ба хүнсний ногоо)
- Төрөл бүрийн мод, цэцгийн үнэрийг ялгаж сурах (Энэ чадвар нь түүнийг ганцаараа орон зайд баримжаалан явахад тусална)
- Хүүхдээр үнэр хаанаас гарч байгааг мэдрэх, дадлага хийлгэх
- Хүүхэд үнэрээр уг өрөө байр ямар зориулалттай болохыг мэддэг байх. Жишээ нь, халуун усны өрөө, талхны цех, эмнэлэг, ногооны дэлгүүр гэх мэт.

Дараах тоглоомыг 2 минутын хугацаанд хажуугийн хүнтэйгээ тоглож үзэх

Үнэрээр нь таньж мэдэх тоглоом



ХАВСРАЛТ 7

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧИЙН СОНСОХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Сонсох чадварыг хөгжүүлэх арга зүй:

Харааны бэрхшээлтэй сурагч нь сонсох чадвар дээр тулгуурлан суралцдаг.

Тиймээс энэ чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.

- Сурагчтай харилцан ярилцах эсвэл нэрээр нь дуудах үедээ заавал түүн рүү харах
- Цэвэр бөгөөд энгийн дуу хоолойгоор ярих. Сурагч яг таны өөдөөс харж байгаа эсэхийг анзаарах
- Заавар зөвлөгөөг зөвхөн аман хэлбэрээр өгөх. Сурагч нэгэн зэрэг хэдэн алхамт зааврыг дагаж хийж байгааг тэмдэглэж авах
- Сонсох чадварыг хөгжүүлэхийн тулд телевиз, радио, дуу хураагуур, хуурцгийг ашиглах.

Хараагүй сурагчийн сонсох чадварыг сайн хөгжүүлэх нь маш чухал юм. Бага ангийн хэлний хичээлүүд дээр сонсох чадварыг хөгжүүлдэг бөгөөд энэ нь хараагүй сурагчдад маш үр дүнтэй хичээл болно. Монгол хэлний хичээлээр нэмэлтээр хүүхдэд дараах чадваруудыг эзэмшүүлнэ.

Уншигчийг сонсох:

Хэн нэгэн тухайн сурагчид уншиж өгөх нь дараах давуу талтай:

- Бусад сурагчдын адил ямар ч хоцрогдолгүй уншина
- Уншигч нь гүйлгэж унших замаар текстээс хэрэгтэй мэдээллийг хайх боломжтой
- Үг үсэг, цэг таслал нэг бүрийг унших замаар мэдээллийг өгөх боломжтой. Энэхүү арга нь шалгалт өгөхөд ашиглагдаж болно.
- Брайль унших чадварыг хөгжүүлэхийн тулд тухайн сурагч брайлаар унших хөтөлбөрт хамрагдах хэрэгтэй. Энгийн унших чадварын хөтөлбөрт ч хамрагдаж болно. Брайлаар унших, бичих чадварыг хөгжүүлэх арга зүйг өмнө өгүүлсний дагуу харааны бүрэн алдагдалтай хүүхдийн хувьд нэмэлт үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Сонсох чадварыг хөгжүүлэх ямар тоглоом байж болох талаар багаараа ярилцан 2-3 тоглоомын арга бичээрэй.

ХАВСРАЛТ 8

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАГЧИЙН БИЧИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Харааны бэрхшээлтэй хүүхдийг брайль үсгээр уншуулах, бичүүлэх ажил нь сурах хүсэл сонирхлыг өдөөх, танин мэдэхүйг хөгжүүлэх, нөхөн сэргээх үйл ажиллагаанд тулгуурлан явагдана. Хүүхэд харахгүйн улмаас түүний хөгжил дутуу явагдана. Үүнд:

- Харааны алдагдлын улмаас суралцахуй хөгжихгүй буюу дутмаг байх
- Орон зайн баримжаа, дасах зохицох чадвар, ойлголт дутуу хөгжих, багасах, алдагдах
- Давхар (хавсарсан) бэрхшээлийн улмаас хөдөлгөөний эвсэл, гар хурууны хөдөлгөөнийг зохицуулах мэдрэмж буурах

Харааны бэрхшээлтэй сурагчийн бичих чадварыг хөгжүүлэх арга зүй

- Брайлаар гарын үсэг хэрхэн зурах талаар зааж өгнө. Тууш шугамтай цаас болон гарын үсэг зурах хөтөч хэрэгтэй.
- Брайлаар бичих чадвар суусны дараа буюу 3-4 ангид компьютерын гартай ажиллах чадварыг заах.
- Аль болох бага наснаас нь компьютертой харьцах боломжоор хангах. Ингэхийн тулд зарим тохируулгат хэрэглэгдэхүүнүүд ашиглаж болно.
- Сурагч нь үгийг үсэглэж чаддаг байхын сацуу брайль үг болон үсгийн хөтөч тайлбар ашиглаж чаддаг байх хэрэгтэй.
- Брайль үсгийн мэдлэг нэмэгдэхийн хэрээр электрон брайль бичигч, шрифтийг хэрхэн ашиглахыг заах.
- Тэмдэглэж авах хувилбарууд: багшийн хэлсний дагуу цээжээр бичих, сурагчид брайлаар хэвлэсэн хуулбар өгөх, дэлгэц уншигчаар тоглуулах, дуу хураах, дараа нь түүнийг тоглуулж, тэмдэглэх, бичээч ашиглах, тэмдэглэл хөтлөхдөө үе тэнгийнхнээсээ тусламж хүсэхэд суралцана.
- Тэмдэглэлийг зөв бичиж байгааг үе үе шалгах.

ХАВСРАЛТ 9

ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

№	Өөрийн үнэлгээний чиглэл	Тийм (+)	Үгүй (-)
1.	Даалгавруудыг гүйцэтгэх явцад багш та хичээлийн зорилгодоо хүрсэн үү?		
2.	Даалгаврууд танд ойлгомжтой, агуулгыг оновчтой тодорхойлж чадсан уу?		
3.	Суралцах явцад бусад багийн мэдээллийг бүрэн дүүрэн ойлгосон уу?		
4.	Шинэ мэдлэгийг тэмдэглэн авсан эсэх		
5.	Та өнөөдрийн хичээлийг хэдэн хувьтай ойлгосон гэж дүгнэж байна?		
6.	Харааны бэрхшээлийн талаарх хичээлийн өмнөх таны хандлага өөрчлөгдсөн үү?		
7.	Харааны бэрхшээлийн талаарх таны ойлголт мэдлэг нэмэгдсэн үү?		
8.	Харааны бэрхшээлтэй сурагч ЕБС-д энгийн хүүхдүүдтэй хамт суралцах боломжтой юу?		
9.	Өнөөдрийн хичээлээр харааны бэрхшээлтэй хүүхдийн талаарх ерөнхий ойлголт мэдлэгийг эзэмшиж чадсан уу?		

СЭДЭВ 2: ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Зорилго: Сул хараатай болон бүрэн хараагүй хүүхэдтэй ажиллах ерөнхий арга зүйн талаар ойлголттой болох, харааны бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургахад багш, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллах арга зүйд суралцах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Ердийн сургуульд бүрэн хараагүй болон сул хараатай хүүхэдтэй ажиллах арга зүйг бусдад тайлбарлах
- Багш нар хоорондоо болон эцэг эх, асран хамгаалагчтай хэрхэн хамтран ажиллах арга зүйг боловсруулах
- Харааны бэрхшээлтэй хүүхдийн эзэмшвэл зохих нийгмийн чадварыг хэрхэн хөгжүүлэх талаар санаа бодлоо илэрхийлэх

Хугацаа: 120 минут

Хэрэглэгдэхүүн:

- РРТ слайд, зөөврийн компьютер, проектор,
- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчийн 1/2 тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Тараах материалыг оролцогчийн тоогоор хэвлэх
- Хавсралт 3: Багшид зориулсан материал
- Хавсралт 4-6: Тараах материал тус бүрийг 3 хувь хэвлэх
- Хавсралт 7: Тараах материалыг 1 хувь хэвлэх
- Хавсралт 8: Тараах материалыг 1 хувь хэвлэж, насны бүлгээр салган хайчилж бэлтгэх

Үйл ажиллагаа 1: Харааны бэрхшээлтэй хүүхдийн бодит нөхцөл байдлыг тодорхойлох (15 минут)

1. Оролцогчид хосоороо ажиллана. Тэдэнд кейс өгөх ба тухайн кейс дэх хүүхдийн онцлогийг өгсөн зааврын (хавсралт 1) дагуу тодорхойлж бичнэ.
2. Өөрийн тодорхойлсон зүйлээ багшийн өгсөн загварт байгаа мэдээлэлтэй харьцуулан, ижил төстэй болон ялгаатай зүйлийг илрүүлж, аль нь зөв эсэх талаар хамтран хэлэлцэнэ.

Үйл ажиллагаа 2: Ердийн сургуульд харааны бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах арга зүйд суралцах (25 минут)

1. Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт зориулсан арга зүйн зөвлөмжийг дасгал ажиллах замаар судална гэдгийг хэлж оролцогч бүрт хавсралт 2-ыг тараана. Танхимын нэг захаас эхлэн нэг хүн нэг асуулт уншиж, бусад оролцогчид хариултыг хэлнэ. Зөв хариулсан эсэхийг багш хавсралт 3-ыг ашиглан нягталж чиглүүлнэ.
2. Оролцогчдыг 3 багт хуваана. Баг бүрт бүрэн хараагүй (хавсралт 4) болон сул хараатай хүүхдийн онцлогийн (хавсралт 5) тухай, мөн тэдэнтэй хэрхэн ажиллах арга зүйн (хавсралт 6) талаарх унших материал тарааж өгнө. Нэг баг дотроо 3 хэсэгт хуваагдан эдгээр материалыг судлаад өөр хоорондоо ээлжлэн тайлбарлана.
3. Уншиж судалсан зүйлээ бүгдээрээ хамтран ярилцаж, юу мэдэж авсан талаар дүгнэн хэлэлцэнэ.

Үйл ажиллагаа 3: Эцэг эхтэй хамтран ажиллах нь (45 минут)

1. Оролцогчдыг 4 багт хуваана. Баг бүрт “Харааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах арга зүй” (хавсралт 7) тараах материалд байгаа эцэг эх, асран хамгаалагчдын мэдвэл зохих зүйлээс дараах байдлаар оноож өгнө.
 - 1 дүгээр багт 1-4 дэх мэдээлэл
 - 2 дугаар багт 5-8 дахь мэдээлэл
 - 3 дугаар багт 9-12 дахь мэдээлэл
 - 4 дүгээр багт 12-15 дахь мэдээлэл

Баг тус бүр өөрт оногдсон мэдээллийн дагуу багш эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах арга зүйг боловсруулж, бусдадаа танилцуулахыг хүснэ.

2. Багууд өөрсдийн бэлтгэсэн мэдээллийг ээлжлэн танилцуулах ба бусад багийн зүгээс тодруулах, нэмэх санаа байгаа эсэхийг лавлаж, хамтран ярилцана.

Үйл ажиллагаа 4: Харааны бэрхшээлтэй хүүхдийн эзэмшвэл зохих нийгмийн чадварыг таньж мэдэх (30 минут)

1. Оролцогчид өмнөх багаараа үргэлжлүүлэн ажиллана. Баг бүрт насны бүлэг тус бүрээр харааны бэрхшээлтэй хүүхдийн эзэмшвэл зохих нийгмийн чадварын жагсаалтыг дараах байдлаар тарааж өгнө.
 - 1 дүгээр багт 0-5 насны хүүхдийн нийгмийн чадвар
 - 2 дугаар багт 5-11 насны хүүхдийн нийгмийн чадвар
 - 3 дугаар багт 11-14 насны хүүхдийн нийгмийн чадвар
 - 4 дүгээр багт 14-18 насны хүүхдийн нийгмийн чадвар


2. Өөрт оногдсон материалыг уншиж судлаад, багшийн өгөх дохиогоор нэгэн зэрэг нар зөв тойрон дараагийн багт унших материалыг шилжүүлнэ. Ийм байдлаар нэг материалыг 3 минутын хугацаанд багаараа хамтран уншиж, харааны бэрхшээлтэй хүүхдийн эзэмшвэл зохих нийгмийн чадварыг насны бүлэг тус бүрээр судална.
3. Багш дараах асуултыг асууж, оролцогчдын хэлсэн санааг самбарт эсвэл дэлгэц цаасан дээр тэмдэглэж харилцан ярилцана.
 - Харааны бэрхшээлтэй хүүхдэд эдгээр чадварыг хэрхэн эзэмшүүлэх вэ?
 - Үүний тулд багш, эцэг эх, асран хамгаалагч юу хийх хэрэгтэй вэ?
 - Эдгээр чадварыг эзэмшүүлэхэд дээрх хүмүүсээс гадна өөр хэн оролцож болох вэ?

Дүгнэлт (5 минут)

Оролцогчид жижиг бөмбөг нэг нэгэндээ дамжуулан өнөөдрийн хичээлээс сурч мэдсэн зүйлсээ нэг өгүүлбэрээр хэлж, дүгнэлт хийнэ.

Сургагч багшид зориулсан материал 1:

ХАВСРАЛТ 1



ХАВСРАЛТ 2

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙН ТАЛААРХ ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

№	Өөрийн үнэлгээний чиглэл	Тийм (+)	Үгүй (-)
1. Хүүхдийн сонирхол, чадвар чадамжид тулгуурлан хичээлээ заах			
1.	Харааны бэрхшээлтэй хүүхдүүд юуг, хэрхэн сонирхох нь хүүхдийн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байдаг.		
2.	Тиймээс багш тухайн хүүхдийн сонирхолд нийцсэн байдлаар арга барилаа өөрчлөх хэрэгтэй.		
3.	Шинэлэг арга барил нь харааны бэрхшээлтэй хүүхдэд тохирсон байх ба ангийн бүх суралцагчийн нийтлэг хэрэгцээг харгалзахгүй байж болно.		
4.	Зарим сурагч ганцаараа хичээллэхийг илүүд үздэг бол зарим нь багийн ажилд идэвх, санаачилгатай оролцдог.		
5.	Бүх суралцагчийн нөхцөл байдалд тохирсон, тэдний оролцоог хангах тогтсон оновчтой загвар гэж байдаггүй.		
6.	Багш хүүхдийнхээ хэрэгцээ сонирхлыг танин мэдэж, өөртэй нь болон эцэг эхтэй нь ярилцах нь хамгийн үр дүнтэй арга юм.		
2. Хэн ярьж буйг хүүхдэд мэдэгдэх			
7.	Хүүхэд ангийн нэг хэсэг болсноо мэдэрсэн үедээ, мөн ангид өөртэй нь хамт ямар хүмүүс байгааг мэдсэн үедээ хичээлийн үйл ажиллагаанд идэвхгүй оролцож эхэлдэг.		
8.	Хэрэв ангид хараагүй хүүхэд байвал багш өөрийгөө танилцуулаад, өөр ямар хүмүүс ангид байгааг танилцуулах хэрэгтэй.		
9.	Тухайн хараагүй хүүхэдтэй харилцах бүртээ нэрээр нь дуудаж, өөртэй нь ярьж буй гэдгээ мэдэгдэх шаардлагагүй.		
10.	Харааны бэрхшээлтэй хүүхдийн харах талбайг хамгийн их байхаар тооцож, багш байрлалаа болон бичих арга барилаа тохируулах хэрэгтэй.		
11.	Багш араас нь хурц нарны гэрэл туссан газар зогсож хичээлээ тайлбарлаж болно.		
12.	Хурц гэрэл багшийн араас тусах нь багшийн царайг харах боломжийг өгдөг.		
13.	Самбар дээр сүүдэр эсвэл гэрэл тусахгүй байхад анхаарах нь зүйтэй.		
14.	Цэвэр нямбай бичих хэрэгтэй.		
15.	Нэг өнгийн бал, маркер, шохойгоор бичээрэй. Тод ялгагдах өнгөөр бичих шаардлагагүй.		
16.	Аль болох урт өгүүлбэр ашиглахгүй, өгүүлбэрийг мөр хооронд хувааж бичихгүй байх.		
3. Сурагчдын суудлыг хуваарилах			
17.	Харааны бэрхшээлтэй хүүхдийг самбараас хол ард суулгах нь зөв.		
18.	Тухайн хүүхдэд тусгаарлагдаж буй мэт мэдрэмж төрүүлэхгүйн тулд ширээний найз нь ердийн хараатай хүүхэд байх хэрэгтэй.		

19.	Ангийн хаалга, сул хараатай хүүхдийн ширээ, сандал дээр тод өнгийн наалт наавал хүүхэд хурц ирмэг, өнцөгтэй зүйлсийг илүү сайн харах боломжтой.		
20.	Ариун цэврийн өрөө харааны бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжтэй, цэвэрхэн, ашиглахад хялбар байх шаардлагагүй.		
4. Нам гүм чимээгүй орчинд хичээл хийх боломж олгох			
21.	Харааны бэрхшээлтэй хүүхэд бусдын адил суралцахын тулд сонсголын мэдрэхүйгээ түлхүү ашигладаг.		
22.	Тиймээс тухайн хүүхдийн суралцаж буй ангийн орчинд нам гүм, чимээ шуугиангүй байх шаардлагатай.		
23.	Чимээ шуугиантай нөхцөлд хүүхэд суралцах нь олон зэрэг анхаарлаа хандуулах боломжийг нэмэгдүүлдэг сайн талтай.		
24.	Чимээ шуугиангүй орчин нь бүх хүүхдэд хичээлээ хийх таатай орчин болдог.		
5. Хичээлээ тэмдэглэх, нэг хичээлээс нөгөөд шилжих			
25.	Хичээлээ тэмдэглэх, нэг хичээлээс нөгөөд шилжихэд ангийн найз нөхөд туслах шаардлагагүй.		
26.	Бусад суралцагчид харааны бэрхшээлтэй хүүхдэдээ тэмдэглэл хөтлөх, нэг хичээлээс нөгөөд шилжих, хүртээмжтэй хэлбэрээр суралцахад нь тусалдаг “найзын систем”-ийг бий болгох хэрэгтэй.		
27.	Тусламж хэрэгтэй эсэхийг асуулгүй хүүхдэд шууд туслах нь зөв.		
28.	Тухайн хүүхдээс асууж хэрэгтэй тохиолдолд л туслах ёстой.		
29.	Харааны бэрхшээлтэй хүүхэд таны гарын тохойноос үл ялиг дээр буюу гарын булчин хэсгээс барина.		
30.	Хэрэв бүр бага насны хүүхэд байвал бугуйнаас тань барьж болно.		
31.	Бүх хүн харааны бэрхшээлтэй хүүхдийн гараас атгана.		
32.	Хараатай хүн харааны бэрхшээлтэй хүүхдээс ямагт хагас алхмын өмнө явна.		
33.	Хэрэв нарийн замаар явах хэрэгтэй бол хөтөлж буй гараа ардаа гаргаад тухай хүүхэд таны араас алхана.		
34.	Шатаар явахдаа өгсөж эсвэл уруудаж буйг хүүхдэд хэлэх шаардлагагүй, түүнийг шатны бариулаас холдуулахад л болно.		
35.	Дунд болон ахлах сургуулиудад коридорын ачаалал багатай үед харааны бэрхшээлтэй хүүхдийг хичээл дуусахаас 5 минутын өмнө завсарлахыг зөвшөөрөх нь зүйтэй.		
6. Орон зайн баримжаа, хөдөлгөөний чадвар			
36.	Хараагүй болон сул хараатай хүүхдийн аль алинд орон зайн баримжаатай болох, хөдөлгөөний чадварт суралцах хэрэгцээ байдаг.		
37.	Орон зайн баримжаатай байна гэдэг нь хүүхэд хаана байгаагаа, хаашаа явахаа, ямар замаар явахаа мэдэж байна гэсэн үг юм.		
38.	Хөдөлгөөн нь хүүхдийг хүссэн газарт нь очиход тусалдаг чадвар юм.		
39.	Хэрэв орон нутагт орон зайн баримжаа олгох, хөдөлгөөний чадвар сайжруулах сургалт хийдэг мэргэжилтэн байвал тус сургалтыг явуулах боломжтой.		

7. Олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах			
40.	Бүх суралцагчийг мэдээлэл хүлээн авах тэгш боломжоор хангахын тулд мэдээллийг харааны бус хувилбараар хүргэх нь чухал.		
41.	Багш хараагүй болон сул хараатай сурагчдын сонсгол, хүрэлцэхүй, амтлах, үнэрлэх мэдрэхүйг ашиглах замаар мэдээлэл хүлээн авах хэрэгцээг хангах боломж бололцоог эрэлхийлэх шаардлагагүй.		
42.	Бүх зураг, график, видео, хөдөлгөөнт дүрс дээр тайлбар бичих нь зүйтэй.		
43.	Агуулгыг дүрслэхдээ брайль график болон гол дүрслэлийг илэрхийлэх объект ашиглаж болно.		
44.	Харилцан үйлчлэл эсвэл дүрслэлийг тайлбарлахдаа биет үзүүлэн, орон зайн баримжаа олгох загварыг ашиглана.		
45.	Харж ойлгох мэдээллийн гол санаа, шилжилтийг тайлбарлахдаа дуу чимээ ашиглаж болно.		
46.	Аливаа зүйлийн гол шинж чанарыг маш тодорхой ярьж, тайлбарлаж өгнө (жишээ нь: тэмээ хоёр бөхтэй, урт хүзүүтэй, гонзгой нүүртэй гэх мэт).		
8. Харааны бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийж, түүнийгээ илэрхийлэх арга замууд			
47.	Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул багш сурагчдаа өөрсдийгөө илэрхийлэх нэг арга замыг заах хэрэгтэй.		
48.	Туслах хэрэгслээр хангаж, хэрхэн ашиглахыг зааж өгөх нь чухал.		
49.	Харааны бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж байгаа гол зорилго нь тэднийг ирээдүйн амьдралд бэлтгэж буй явдал юм.		
50.	Тиймээс тухайн хүүхэд ирээдүйд гэртээ ч, ажил дээрээ ч хэрэглэх технологид эртнээс суралцаж, бэлтгэлтэй байх нь чухал юм.		
51.	Суралцахуйн үйл явцаар дамжуулж сурагчдад өөрийгөө илэрхийлэх олон арга зам зааж өгөх нь тэдний одоогийн болон ирээдүйн гүйцэтгэлийг үнэлэхэд чухал ач холбогдолтой.		
52.	Сургалтын агуулга нь хүүхдийн чадамж болон аливаа дасгал даалгаврыг гүйцэтгэхэд аль хэрэгсэл нь илүү тохиромжтой гэдгийг сурагчдад заахад чиглэгдэх ёстой.		

ХАВСРАЛТ 3

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ СЭДЭЛЖҮҮЛЖ ОРОЛЦООГ ХАНГАХ АРГА ЗАМУУД

Суралцагчдын сурах сэдэл харилцан адилгүй учир багш хүүхдийн суралцах үйл явцыг олон арга замаар хангах нь зүйтэй.

Хүүхдийн сонирхол, чадвар чадамжид тулгуурлан хичээлээ заах:

- Хэн ярьж буйг хүүхдэд мэдэгдэх
 - Харааны бэрхшээлтэй хүүхдийн харах талбайг хамгийн их байхаар тооцож, багш байрлалаа болон бичих арга барилаа тохируулах
 - Сурагчдын суудлыг хуваарилах
 - Нам гүм, чимээгүй орчинд хичээл хийх боломж олгох
 - Хичээлээ тэмдэглэх, нэг хичээлээс нөгөөд шилжихэд ангийн найз нөхөд нь тусалдаг байх
1. Эхлээд тухайн хүүхдээс тусламж хэрэгтэй эсэхийг асууна. Хэрэгтэй тохиолдолд л туслаарай. Харааны бэрхшээлтэй хүүхэд таны гарын тохойноос үл ялиг дээр буюу гарын булчин хэсгээс барина. Хэрэв бүр бага насны хүүхэд байвал бугуйнаас тань барьж болно. Зөвхөн эцэг эх, найзууд нь бэрхшээлтэй хүүхдийн гараас атгана.
 2. Хараатай хүн харааны бэрхшээлтэй хүүхдээс ямагт хагас алхмын өмнө явна. Хэрэв нарийн замаар явах хэрэгтэй болбол хөтөлж буй гараа ардаа гаргаад тухайн хүүхэд таны араас алхана.
 3. Шатаар явахдаа өгсөж эсвэл уруудаж буйг хүүхдэд хэлж, түүнийг шатны бариул руу чиглүүлнэ. Дунд болон ахлах сургуулиудад коридорын ачаалал багатай үед харааны бэрхшээлтэй хүүхдийг хичээл дуусахаас 5 минутын өмнө засварлахыг зөвшөөрөх нь зүйтэй.
 - Орон зайн баримжаа, хөдөлгөөний чадварт сургах
 - Харааны бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдлэгээ олон хэлбэрээр үзүүлэх арга замуудыг ашиглах
 - Олон мэдрэхүйг зэрэг ашиглах замаар суралцах
 - Харааны бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийж, илэрхийлэх арга замуудыг ашиглах

ХАВСРАЛТ 4

БҮРЭН ХАРААГҮЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Бүрэн хараагүй суралцагч

- Эрт үеийн – 5 наснаас өмнө
- Хожуу үеийн – 6 наснаас хойш
- Харааны түвшин тогтоох оношилгоогоор 0,01-ээс бага

Сонсгол, хүрэлцэхүй, үнэрлэх мэдрэхүйг хослуулан мэдээллийг авна.

- Төрөлхийн хараагүй хүмүүсийн танин мэдэхүйн дээд үйлийн хөгжил нь (анхаарал, логик сэтгэлгээ, ой санамж, хэл яриа) хэвийн хөгждөг.
- Хожуу хараагүй болсон хүүхдүүд төрөлхийн хараагүй хүүхдүүдээс ялгарах ялгаа нь хараагаа алдсан хугацаанаас хамаардаг: Хожуу хараагаа алдсан байх тусам тухайн хүүхдэд харааны төсөөлөл сайн байх бөгөөд үүнийг аман тайлбар хийх замаар дахин сэргээн сануулж болно.
- Хэрэв харааны санах ойг хөгжүүлэхгүй бол хараагаа алдсаны дараа хадгалагдсан хэсэг, харааны дүрслэл аажмаар алдагддаг. Хараагүй хүүхэд хадгалагдсан анализаторуудад суурилж хүрээлэн буй ертөнцийн тухай бүрэн мэдлэг олж авч, сэтгэцийн хөгжлийн өндөр түвшинд хүрэх бүрэн боломжтой.
- Харааны согог үүсэх хугацаа нь хүүхдийн сэтгэц, бие махбодын хөгжлийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. Эрт хараагүй болох тусам хоёрдогч өөрчлөлт буюу сэтгэц физиологийн онцлог, өвөрмөц байдлууд илүү их ажиглагддаг. Төрөлхийн хараагүй хүүхдийн сэтгэцийн хөгжил хэвийн хараатай хүүхдийн нэгэн адил байдаг боловч харааны чиг баримжаагүй байдал нь нийгэмд дасан зохицох, туршлага хуримтлуулах болон хөдөлгөөний хүрээнд ихээхэн нөлөөлдөг.
- Хараагүй хүмүүсийн хувьд дуу чимээ нь чиг баримжаагаа олох гол хүчин зүйл болдог.
- Хараагаа алдах нь сэтгэл хөдлөл-зоригийн хүрээний, зан чанарын, туршлагын өвөрмөц байдлыг бий болгодог. Хараагүй хүүхдүүдэд тоглоом тоглох, хичээлээ хийх, мэргэжил эзэмших гэх мэт үйл ажиллагаануудад хүндрэлүүд үүсдэг.
- Нас ахих тусам харааны бэрхшээлтэй хүмүүс ахуйн асуудлуудтай тулгардаг бөгөөд энэ нь амьдрах үйл явцыг хүндрүүлэх, аливаа зүйлд сөрөг хариу үйлдэл, хандлагатай болгодог. Үүнд: өөртөө итгэлгүй байдал, амьдралын идэвхгүй байдал, өөрийгөө тусгаарлах хандлага, бусад тохиолдолд цочимтгой, цухалдуу байдал нэмэгдэх, уур уцаартай, түрэмгий болдог.

ХАВСРАЛТ 5

СУЛ ХАРААТАЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Өсөлт, хөгжил эсвэл өдөр тутмын болон нийгмийн амьдралд ямар нэгэн саад үүсгэж буй харааны функц, харааны мэдрэхүйн байдал

- Хөнгөн хэлбэр – 0,04-0,3 хүртэл
- Хүнд хэлбэр – 0,02-0,04 бага

Сул хараатай хүмүүс аливаа зүйлийг ихэвчлэн дараах байдлаар хардаг:

- Фокус алдагдах
- Гэрлийн бууралттай (тахиаан сохор, шөнийн харалган)
- Гэрлийн илүүдэл (цайж харагдах)
- Харааны хүрээ бага
- Зураг, газрын зургийг ялгаж чадахгүй байх (хар цагаанаар харах)
- Хэмжээг тодорхойлж чаддаггүй (шатны өндөр, нам)
- Харагдах байдал бүүдгэр (манан татсан мэт)
- Сүүмэлзэх, тогтворгүй харагдах

ХАВСРАЛТ 6

ЕБС-ИЙН БАГШ НАР ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИН, ХАМТРАН АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ

№	Хэрэглэгдэхүүний төрөл	Сул хараатай хүүхдэд	Бүрэн хараагүй хүүхдэд
1	Видео болон аудио бичлэг	Видео бичлэгийг сул хараатай хүүхэдтэй ажиллахдаа ашиглаж болно. Ингэхдээ таны бэлтгэсэн бичлэгийн дүрс болон өнгөний ялгарал маш сайн байх хэрэгтэй бөгөөд түүнээс гадна хэт олон өнгө оруулахгүй байх, учир нь сул хараатай хүүхдийн дунд өнгө ялгах чадвар нь алдагдсан хүүхдүүд байж болно. Мөн тухайн хүүхэд видео бичлэгийг харахаас гадна тус агуулгыг тайлбарлаж буйг ойлгож танин мэдэх нь чухал учир дуу авиа нь хэт өндөр давтамжтай бус, хүүхэд хүлээн авч сонсох боломжтой байхаар бэлтгэгдсэн байх шаардлагатай. Тайлбарлаж буй агуулга нь хүүхдэд ойлгомжтой, хэт нуршуу биш, нэгэн хэвийн уйтгартай биш байх тал дээр анхаарах хэрэгтэй.	Бүрэн хараагүй хүүхдэд видео бичлэг үзүүлэхээс илүү аудио бичлэг үзүүлэх нь тохиромжтой. Учир нь тухайн хүүхэд огт харахгүй учир видео бичлэгт юу гарч байгааг харах боломжгүй юм. Харин аудио бичлэгийг бэлтгэхдээ аль болох хүүхдэд ойр ойлгомжтой байхаас гадна дууны өнгөний тохиргоог (тухайн агуулгын аль хэсэгт нь өндөр, аль хэсэгт нь нам дуугаар уншиж тайлбарлах) аудио бэлтгэж буй багш анхаарах хэрэгтэй.
		Видео болон аудио бичлэгийг бэлтгэхдээ тухайн хичээлийн агуулгын хүрээ болон хүүхдийн нас сэтгэхүй, бэрхшээлийн онцлогийг харгалзсан байх	

2	Зураг болон бичвэр хосолсон хэвлэмэл хэрэглэгдэхүүн	Сул хараатай хүүхдүүд нь мэдээллийг тодорхой хэмжээнд хараагаараа хүртэж хүлээж авах боломжтой учир зургийг хэт олон өнгө хослуулахгүйгээр цөөн өнгө сонгож харагдах хэмжээг томруулсан байх шаардлагатай. Харин бичвэр мэдээллийг хүүхэд нэг бүрийн харах чадвараас хамааран өөр өөр хэмжээгээр хэвлэх хэрэгтэй боловч хамгийн багадаа 20 болон түүнээс дээш хэмжээгээр мөн түүнийгээ давхар брайль бичгээр буулгасан байх шаардлагатай. Агуулгыг тухайн хүүхдэд ойлгомжтой, цөөн үг хэллэгээр тайлбарлан бичих хэрэгтэй бөгөөд хэтэрхий олон хуудас хэрэглэгдэхүүн нь хүүхдийг залхаах эрсдэлтэй байдаг.	Бүрэн хараагүй хүүхэд зураг болон бичвэрийг харахгүй учир зургийг аль болох тэмтэрч ойлгож болохоор товойлгон бэлтгэж, бүх бичвэрийг брайль хэлбэрт шилжүүлэн бэлтгэх хэрэгтэй. Ингэснээр хүүхэд иймэрхүү байдлаар зураг болон бичвэрийг тэмтэрч тухайн агуулгын талаар илүү сайн ойлголттой болох боломжтой.
3	Дан бичвэр мэдээлэл агуулсан хэвлэмэл хэрэглэгдэхүүн	Бичвэр мэдээллийг бэлтгэхдээ үсгийн хэмжээ хамгийн багадаа 20 буюу түүнээс дээш хэмжээтэй байх бөгөөд бичвэр болон цаасны өнгийн харьцаа хар цагаан байвал хүүхэд хүртэж хүлээж авах чадвар илүү сайн байх болно. Зарим сул хараатай хүүхдүүд бэрхшээлийнхээ онцлогоос хамааран цагаан суурин дээр бичигдсэн бараан бичгийг харахгүй байх тохиолдол байдаг. Ийм тохиолдолд хар бараан өнгийн суурин дээр тод шар өнгөөр бичих хэрэгтэй. Бичвэрийг бичихдээ бичмэл бус дармал хэвээр бичвэл тухайн хүүхдэд илүү хүртээмжтэй болно.	Хэрэглэгдэхүүнийг бэлтгэхдээ товч бөгөөд тодорхой, ойлгомжтой богино өгүүлбэрээр бичиж брайль хэлбэрт шилжүүлсэн байх. Брайлаар бичихдээ цэг болон таслалыг алдахгүй зөв бичихэд маш сайн анхаарах хэрэгтэй. Алдаж бичсэн тохиолдолд бичвэрийн агуулга алдагдаж тухайн мэдээллийг уншиж буй хүүхдэд буруу ойлголт өгч болзошгүйг анхаарах шаардлагатай.
4	Биет хэрэглэгдэхүүн	Биет хэрэглэгдэхүүн нь хүүхдэд аюулгүй, удаан эдэлгээтэй материалаар хийгдсэн байх. Мөн өөр дээрээ тухайн хичээлийн агуулгыг шингээсэн байж болно. Ийм тохиолдолд тухайн мэдээллийг том үсгээр тэмдэглэхээс гадна брайлаар бичиж тэмдэглэсэн байна. Жишээлбэл, бөмбөрцөг байгаа тохиолдолд бөмбөрцөг гэдэг бичгийг дармал болон брайлаар бичиж тэмдэглэж өгнө.	

ХАВСРАЛТ 7

БАГШ ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧТАЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Эцэг эхчүүд хүүхдээ хамгийн сайн мэддэг. Тиймээс эцэг эх, асран хамгаалагчтай багш ажиллахдаа дараах зүйлийг анхаарч ажиллах хэрэгтэй.

Эцэг эхчүүд хүүхдээ хэрхэн дэмжин ажиллах талаар дараах мэдээллийг мэдэх шаардлагатай.

1. Хүүхдэдээ хэрхэн туслах талаар мэдлэгтэй байх
2. Хүүхдээ аливаа зүйлийг алхамчлан сурахад бэлтгэж заах
3. Сурах үйл ажиллагааны онцлог буюу хүүхдээ хэрхэн сурах чадвартайг илрүүлэх
4. Хүүхдээ юу харж чадаж байгааг олж мэдэх
5. Харилцааны чадвар эзэмшүүлэх
6. Сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх
7. Өдөр тутмын үйл ажиллагаанд хүүхдээ сургах
8. Эцэг эхчүүд хүүхдийн аюулгүй байдлыг маш сайн хангах
9. Хөдөлгөөний чадварыг эзэмшүүлэхэд анхаарч ажиллах
10. Хүүхдээ хаана байгаагаа мэдэхэд нь туслах (орон зай)
11. Бэлгийн хүчирхийллээс сэргийлэх
12. Хамт олны нэгэн гишүүн болгоход дэмжин ажиллах
13. Сургууль, цэцэрлэгт элсэн ороход хүүхдээ бэлтгэх
14. Яагаад хүүхдүүд хараагүй болдог мөн хэрхэн сэргийлэх талаар мэдлэгтэй байх
15. Хүүхэд том болоход анхаарах зүйлсийн талаар мэддэг байх

ХАВСРАЛТ 8

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ НИЙГМИЙН ЧАДВАРЫН ЖАГСААЛТ

Дараах жагсаалт нь тухайн насны хэвийн хараатай хүүхдийн нийгмийн суурь чадварыг илэрхийлнэ.

Нярай, бага насны болон сургуулийн өмнөх насны хүүхэд (0-5 нас)

- Аливаа зүйлийг ойлгож мэдсэнээ эсвэл бусадтай ярилцахдаа тохиромжтой дохио зангаа, нүүрний хувирал ашиглан өөрийгөө илэрхийлэх
- Бусадтай ярилцахдаа нүдний харцаар харилцаа тогтоох (нүдний харцны чиглэл)
- Бусадтай харилцахдаа эерэг хариу үйлдэл үзүүлэх
- Эд зүйл, тоглоомыг зохистой байдлаар ашиглан ганцаараа тоглох
- Дуу шуугианд болон өөр хоорондоо ноцолдож тоглон баясах
- Дэргэд нь тоглож байгаа хүүхдүүдтэй харилцах
- Идэвхтэй, жүжиглэн тоглож байгаа бусад хүүхдүүдтэй харилцах
- Энгийн хүсэлтээ хэлэх буюу дохио зангаагаар илэрхийлэх
- Хүмүүстэй уулзахдаа мэндлэх дохио зангаа хэрэглэх
- Хүмүүстэй харилцахдаа толгойгоо өргөх буюу тэдэн рүү харах
- Үе тэнгийнхэн болон томчуудтай харилцахдаа биеийн тохиромжтой хөдөлгөөн хийх

Сургуулийн бага ангийн сурагч (5-11 нас)

- Нийгмийн орчин нөхцөлд нүдний харцаар харилцаа тогтоох
- Бусадтай харилцахдаа хувийн зохистой орон зайг (45см) барих
- Энгийн харилцааг өөрөө эхлүүлэх
- Бусадтай 2-5 минут харилцан ярих энэ нь эхлэл, дунд үе, төгсгөл хэсэгтэй байх
- Үе тэнгийн хүүхдүүдтэй тоглоом болон бусад эд зүйлсээ харамлалгүй хамт тоглох
- Уучлаарай, баярлалаа гэх зэрэг найрсаг харилцааны үг хэллэг хэрэглэх
- Бусдыг магтах
- Гар барих зэргээр бусадтай харилцах
- Нүдээ анивчих, чичрэх зэрэг тохиромжгүй үйлдэл хийхгүй байх
- Ангид гараа өргөх, дараалалд зогсох зэрэг тухайн орчинд тохиромжтой үйлдэл хийх
- Бусдын яриаг таслахгүй байх, бусадтай ярилцах, тоглох үедээ ээлжээ хүлээх
- Өөрийн насанд тохирох тоглоомоор тоглох болон бусад үйл ажиллагаанд оролцох
- Томчуудаас хараат бус сонголт хийж, шийдвэр гаргах, өөрөө хариуцлага хүлээх
- Тохиромжтой хувцаслах

Сургуулийн дунд ангийн сурагч (11-14 нас)

- Нийгмийн өвөрмөц нөхцөл байдалд нүдний харц, биеийн байрлал, орон зай зэргийг тохиромжтой байдлаар ашиглаж байгаагаа харуулах
- Өөрийн мэдрэмж, санаа бодлоо нүүрний хувирал, гарын хөдөлгөөнөөр илэрхийлэх
- Үеийнхэн болон насанд хүрэгчидтэй 10 минутаас доошгүй хугацаагаар харилцан ярилцах
- Дундуур нь таслалгүй харилцан ярианд оролцох, асуултад өөрийн өнцгөөс хандах
- Бусдад үлгэр дуурайл үзүүлж, янз бүрийн нөхцөлд бусдын мэдрэмжийг ойлгодог
- Нийгмийн онцлог нөхцөл байдалд тохируулан хувцсаа сонгож өмсдөг байх
- Хувийн ариун цэврийн талаар мэддэг байх, хувцсаа бохирдсон, үрчийснийг мэддэг байх
- Нийгмийн янз бүрийн үйл ажиллагаанд харааны бэрхшээлтэй болон хэвийн хараатай үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа оролцдог байх
- Үе тэнгийнхэнтэйгээ цагийг өнгөрүүлдэг, хамтдаа дэлгүүр, кино театрт үйлчлүүлэх
- Нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд өөрийн хийсэн үйлдэлдээ эзэн болж чаддаг

Сургуулийн ахлах ангийн хүүхэд (14-18 нас)

- Нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд өөрийн хэрэгцээг илэрхийлэх
- Үе тэнгийнхэн болон насанд хүрэгчидтэй өөртөө итгэлтэйгээр харилцах
- Өөртөө итгэлтэй байдлаар бусдаас тусламж дэмжлэг хүсэх
- Нийгмийн онцлог нөхцөл байдалд тохирох зан байдлыг тодорхойлохын тулд нийгмийн нөхцөл байдлыг үнэлэх
- Тодорхой нөхцөл байдалд тохирох нийгмийн чадварыг ашиглах (бусадтай болзох, ажлын ярилцлагад орох гэх зэрэг үед)
- Хэт давамгайлахгүйгээр сонирхолтой сэдвээр бусадтай ярилцах
- Тохиромжтой нөхцөлд бусдыг магтах, магтаалыг хүлээн авах
- Бусдад үлгэр дуурайл болж, шаардлагатай нөхцөлд бусдад дэмжлэг үзүүлэх
- Бүжиг, хурал уулзалт, сургуулийн томоохон арга хэмжээ зэрэг олон хүн хамарсан үйл ажиллагааны үед бусадтай үр дүнтэй харилцах
- Үгэн бус харилцааны дохио зангааг оновчтой ойлгож мэдрэх
- Янз бүрийн нөхцөл байдалд нийгмийн ёс журмыг оновчтой дагаж мөрдөх
- Ажлын болон коллежийн ярилцлагын явцад нийгмийн чадварыг зохистой ашиглах (цагтаа ирэх, нүдний харцаараа харилцаа тогтоох, оновчтой асуулт асуух гэх зэрэг)
- Янз бүрийн орчин нөхцөлд хүмүүсийн гаргаж буй зан үйлийг бодитой, шударгаар үнэлэх
- Нийгмийн тодорхой нөхцөл байдлын талаарх мэдээллийг итгэлтэй найдвартай найз нөхөд, хамтрагч нараас авах
- Өөрийн өвөрмөц хэрэгцээ, дасан зохицох байдал зэргийг илэрхийлэн өөрийн харааны бэрхшээлийн талаар бусадтай ярилцах
- Нийгмийн бүхий л нөхцөл байдалд тохируулан хувцаслах, өөрөө бие даан болон найз нөхөд, бусад хүмүүстэй хамтран хувцсаа сонгох

СЭДЭВ 3: ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИХ ТӨХӨӨРӨМЖ, ТОХИРУУЛГАТ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Зорилго: Харааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, тохируулгат орчин, сургалтын хэрэглэгдэхүүний талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа багшийн зүгээс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох
- Хичээл сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх туслах төхөөрөмжийн талаар тайлбарлах
- Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх
- Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын орчин хэрхэн бүрдүүлэх талаар санаа бодлоо хуваалцах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- PPT слайд, зөөврийн компьютер, проектор
- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчдын тоогоор хэвлэх
- Баримлын шавар
- Өнгийн цаас, хайч цавуу
- Гарын доорх материал

Үйл ажиллагаа 1: Хичээл сургалтын материалд багшийн зүгээс үзүүлэх дэмжлэг (25 минут)

1. Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа багшийн зүгээс ямар дэмжлэг үзүүлэх боломжтой талаар дараах асуултыг асууж оролцогчдын санаа бодлыг сонсоно.
 - Та харааны бэрхшээлтэй хүүхдэд хичээл заахдаа ямар арга барил ашигладаг вэ?
 - Мэдээллийг хүүхдэд ямар байдлаар өгдөг вэ?
 - Харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа тарааж өгөх ямар материал, хэрэглэгдэхүүн ашигладаг вэ?
2. Хичээл сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх орчин үеийн дараах туслах төхөөрөмжийг слайд болон бодит зүйлс ашиглан танилцуулна.

- a. Самбар, Шивүүр, Цагаан таяг, Өнгө танигч
- b. Унших, бичих төхөөрөмж, Ярьдаг цаг
- c. Брайль үгийн сүлжээ, Томруулагч линз
- d. Бичвэр бичигч самбар

Үйл ажиллагаа 2: Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн (35 минут)

1. Оролцогчдыг мэргэжлийн чиглэл бүрээр баг болгон хуваана. Багш хэрэглэгдэхүүний загвар танилцуулна. (Слайд болон бэлэн хэрэглэгдэхүүн ашиглах).
2. Баг бүрт гарын доорх материал өгөх ба багууд багшийн өгсөн материалаар харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ. Хэрэглэгдэхүүнийг суралцахуйн түгээмэл загварын дагуу хийхэд анхаарна гэдгийг сануулна.
3. Бэлтгэсэн хичээлийн хэрэглэгдэхүүнийг бусдадаа ээлжлэн танилцуулна.

Үйл ажиллагаа 3: Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын орчин нөхцөл (25 минут)

1. Оролцогчдод хавсралт 1-ийг тараан өгч, мэдээллийг уншиж судлаад өөрийн санаа бодлыг нэмж хэлэхийг хүснэ.
2. Оролцогчид 3-5 хүнтэй баг бүрдүүлж, харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын орчныг ямар байдлаар бүрдүүлэх талаар өөрсдийн сургууль дээр хийж болох зүйлсийг хамтран боловсруулна.
3. Өөрсдийн боловсруулсан санааг ээлжлэн танилцуулж, санал бодлоо хуваалцана.

Дүгнэлт: (5 минут)

Үзсэн хичээлийн агуулгыг бататгах зорилгоор оролцогч бүр бусдаасаа асуулт асууж ярилцана. Хамгийн олон асуулт асуусан оролцогчийг урамшуулна.

ХАВСРАЛТ 1

ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ОРЧИН

Сургалтын орчин бүрдүүлэх:

- Суудлыг нь зөв сонгох (Харааны бэрхшээлтэй хүүхдийг самбарт ойр суудалд суулгах хэрэгтэй)
- Нүдний шил нь таарсан эсэхэд анхаарах
- Хүүхэд аливаа биетийг нүдэндээ ойртуулан барьж томруулж харж чаддаг эсэх
- Ашиглаж болох томруулагч хэрэгслийг бэлтгэх
- Ажиллах орчныг бүрэн танилцуулах
- Тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх
- Сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах хугацааг зөв тооцох

Орчинд тохируулга хийх

- Унших тохиромжтой арга техникийг зааж өгөх
- Саравчтай малгай, нарны шил, бараан шил зэргийг ашиглах
- Нарны болон бусад гэрлийн гялбалтыг бууруулах эсвэл өөрт тохируулах
- Хүүхдийн сууж буй байршлыг өөрчлөх
- Ажлын орчин дахь хараа сарних нөхцөлийг бууруулах
- Унших тохиромжтой арга техник

Анги танхимын нөхцөл

- Харааны бэрхшээлийн онцлогт тохируулан ажлын байран дахь гэрэлтүүлгийг хосолсон гэрэлтүүлгийн тусламжтайгаар тус тусад нь тохируулан тогтооно. Хосолсон систем дэх нийт гэрэлтүүлэг дор хаяж 20% байх ёстой.
- Байгалийн гэрэл багасах тусам тус тусын бүлгийн гэрэлтүүлгийг үе шаттайгаар асаах замаар хиймэл гэрлийг автоматаар тохируулан асаах шаардлагатай. Харааны бэрхшээлтэй хүнд нарны тусгал шууд тусахаас сэргийлж, хөшиг эсвэл хаалт ашиглах шаардлагатай, гэрэлтүүлгийг мэдэгдэхүйц бууруулж болохгүй.
- Техник хэрэгсэл: тохируулга бүхий оптик хэрэгсэл, цахилгаан оптик хэрэгсэл, том тэмдэгтийн хэвлэгч ба хөвөгч, харааны талбайг өргөтгөгч.

СЭДЭВ 4: ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ҮНЭЛГЭЭ

Зорилго: Үнэлгээний аргачлалыг харааны бэрхшээлтэй хүүхдийн чадварт нийцүүлж тохируулах талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Хүүхэд аливаа эд, зүйлсийг харж чадах зайг тогтоох, үнэлгээ хийх арга зүйн талаар ойлголттой болох
- Харааны бэрхшээлтэй хүүхэд ангид байгаа эсэхийг тодорхойлох
- Хүүхдийн мэдлэг ойлголтыг үнэлэхэд тохирсон үнэлгээний систем, хичээлийн үнэлгээ хийх ерөнхий аргачлалын талаар тайлбарлах
- Харааны бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн чадварыг үнэлэх

Хугацаа: 60 минут

Хэрэглэгдэхүүн:

- PPT слайд, зөөврийн компьютер, проектор, дэлгэц
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчийн тоогоор хэвлэх
- Нүдний хаалт-15 ширхэг (маск ашиглаж болно)
- 1 удаагийн аяга ба ус

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Хүүхдийн аливаа эд зүйлийг харж чадах зайг тогтоох, үнэлгээ хийх арга зүй (15 минут)

1. Оролцогчдод хавсралт 1-д байгаа мэдээллийг товч танилцуулна.
2. Оролцогчид хосоороо ажиллана. Хавсралт 2-т жагсаан бичсэн дасгал ажлын хуудсыг урьдчилж бэлтгэсэн байна. Оролцогчид хосоор болон багийн зохион байгуулалтаар багш, сурагчийн дүрд тоглох аргаар дадлага ажлыг гүйцэтгэнэ. Дадлага ажлыг хийхдээ нүдний хаалт хэрэглэнэ.
3. Багууд өөрсдийн хэсгээс ойлгосон зүйлээ бусад оролцогчдод ээлжлэн 3-4 минутад багтаан танилцуулна.

Үйл ажиллагаа 2: Харааны бэрхшээлийг тодорхойлох энгийн арга (15 минут)

1. Харааны бэрхшээлтэй хүүхэд ангид байгаа эсэхийг тодорхойлох энгийн аргыг слайд (хавсралт 3) ашиглан танилцуулна.
2. Оролцогчдод дараах даалгаврыг өгнө.
 - Хэрэв танай ангид бага зэрэг эсвэл маш их бэрхшээлтэй тулгардаг, юу ч хардаггүй, хийж чаддаггүй хүүхдүүд байдаг бол тэднийг ангид зааж буй

агуулга, сэдвийг ойлгож, суралцахад нь ямар арга хэмжээ, дэмжлэг үзүүлж ажилласнаа жагсаан бичнэ үү.

3. Оролцогчид гурав гурваараа баг болж өөрийн туршлагаа солилцон ярилцана. Өөрсдийн туршиж үзсэн, хэрэгжүүлсэн арга хэмжээ, дэмжлэг нь хүүхдэд хэрхэн нөлөөлсөн, дэмжлэг болж чадаж байсан эсэхийг хэлэлцэнэ.

Үйл ажиллагаа 3: Хичээлийн үнэлгээ хийх аргачлал, суралцагчийн нийгмийн чадварыг үнэлэх (25 минут)

1. Багш суралцагчдыг үнэлэхдээ анхаарах зүйлс, ахицыг үнэлэхэд баримтлах 6 үйл ажиллагааг слайд ашиглан танилцуулна.
2. Судлагдахууны онцлогийг харгалзан хэрхэн үнэлгээ хийх талаар слайд ашиглан мэдээлэл танилцуулж, ярилцана. Тухайлбал:
 - Эх хэл, нийгмийн шинжлэх ухааны хичээлийн үнэлгээ
 - Тоо, байгалийн шинжлэх ухааны хичээлийн үнэлгээ
 - Дүрслэх урлаг, биеийн тамирын хичээлийн үнэлгээ
3. Харааны бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн чадварыг үнэлэх материалыг танилцуулна.

Дүгнэлт (5 минут)

Үзсэн хичээлийн агуулгыг бататгаж, тус сэдвийг судалснаар юу ойлгосон талаар хажууд сууж буй оролцогчидтой ярилцаж харилцан нэгнээ дүгнэнэ.

ХАВСРАЛТ 1

ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ



Хүүхдийн мэдлэг ойлголтыг үнэлэхэд тохирсон үнэлгээний системтэй байх.

Суралцагчийг үнэлэхдээ хүүхэд бүр сурсан мэдлэг, ойлголтоо илэрхийлж, харуулж чадах байдлаар үнэлэх нь зүйтэй. Харааны бэрхшээлтэй хүүхдэд үзэг харандаа бариулаад бичгээр шалгалт авбал тухайн хүүхэд сурсан мэдлэгээ хангалттай хэмжээнд илэрхийлж чадахгүй байж мэднэ. Хэрэв багш тухайн хүүхдийн бичгийн чадварыг

үнэлэхийг зориогүй бол өөр ямар нэг аргаар өөрийгөө илэрхийлэх боломж олгох ёстой. Тиймээс хүүхдийн онцлогт тохирсон хэлбэрээр дасгал, даалгавар өгөх, хугацааг нь сунгах зэрэг тохируулга хийх нь тухайн хүүхдэд төдийгүй багш, ангийн бусад хүүхдүүдэд ч тохирсон арга байж болно. Ахицаар үнэлэх гэдэг нь өдөр бүр хүүхдийн гүйцэтгэлийг ажиглаж, тогтмол санал, зөвлөмжөө өгч байхыг хэлдэг.

ХАВСРАЛТ 2

- 1) Цочроогч руу анхаарч байгааг шалгах
- 2) Үлдэгдэл хараагаа ашиглан тухайн биетэд хүрэх чадварыг ажиглах
- 3) Нүдний хөдөлгөөнөө хянах-дагуулж харах, нүдээ хөдөлгөхгүй харах (ширтэх)
- 4) Дагуулж харах
- 5) Нүдний хөдөлгөөнийг хянах
- 6) Гүйлгэн харах чадвар
- 7) Өмнөө байгаа зүйлийг олох
- 8) Зам даган явах
- 9) Саадыг тойрох
- 10) Үйлдлийг дуурайх, зарим хэсгүүдийг тохируулах
- 11) Нүүрний хувирлыг дуурайх, харах чадвар
- 12) Хэмжээгээр нь ижилсүүлэх
- 13) Төвөгтэй зураг
- 14) Хийсвэр дүрс

ХАВСРАЛТ 3

Харааны бэрхшээлтэй байж магадгүй хүүхэд танай ангид байгаа эсэхийг тодорхойлж, доор дурдсан асуултад хариулаарай.

А. Эдгээр хүүхдүүд харааны шил зүүдэг үү? Хэрэв харааны шил зүүдэг боловч харах бэрхшээлтэй бол доорх зүйлийг тодруулж асуугаарай.

1. Харааны шилтэй учир харахад огт бэрхшээл тулгардаггүй
2. Бага зэрэг бэрхшээл тулгардаг
3. Маш их бэрхшээл тулгардаг
4. Шилтэй боловч юу ч харж, хийж чадахгүй байна.

Б. Харин нүдний шил зүүдэггүй гэж хариулсан хүүхдүүдээс дараах асуултыг асууна. Чи аливаа зүйлийг харахдаа ямар нэг бэрхшээлтэй тулгардаг уу? гэж асуугаад доорх хариултуудаас аль нэгийг нь сонгуулаарай.

1. Огт бэрхшээл тулгардаггүй
2. Бага зэрэг бэрхшээл тулгардаг
3. Маш их бэрхшээл тулгардаг
4. Юу ч харж, хийж чадахгүй байна.

МОДУЛЬ 4:

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ



СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ

Зорилго	Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хүртээмжтэй орчин бүрдүүлж, сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг эзэмших
Зорилт	<ul style="list-style-type: none">Сонсголын бэрхшээлд хандаж буй орчин үеийн дэлхий нийтийн чиг хандлагын талаар ойлголттой болохСонсгол, сонсголын бууралт, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг таньж мэдэхСонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан тохируулгат орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүн бэлтгэхСонсголын бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах талаар үндсэн ойлголттой болохМонгол дохионы хэлний цагаан толгойг хурууны үсгээр үсэглэж, монгол дохионы хэлний анхан шатны харилцааны чадвар эзэмшихБагш, эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах талаарх мэдлэгээ дээшлүүлэх
Хугацаа	6 цаг
Модулийн агуулгын хүрээ	
Сэдэв 1. Сонсгол бууралт, сонсголын бэрхшээлийн тухай ерөнхий ойлголт (90 минут) Сэдэв 2. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог (90 минут) Сэдэв 3. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцахуйг дэмжих арга замууд (90 минут) Сэдэв 4. Монгол дохионы хэл (90 минут)	

СЭДЭВ 1: СОНГОЛ БУУРАЛТ, СОНГОЛЫН БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Зорилго: Сонгол бууралт түүний хэлбэр, сонголын бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Сонголын бэрхшээлд хандаж буй нийгмийн загварыг тайлбарлах
- Хүний сонсох эрхтэн, сонголын талаар ярилцах
- Сонгол бууралт, сонгол бууралтын хэлбэр, сонгол бууралтын зэрэг, сонгол бууралтын шалтгааныг тодорхойлох
- Сонголын бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг тайлбарлах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- PPT слайд, компьютер, проектор, дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Бичлэг: https://www.youtube.com/watch?v=tD5p_a5MqAw&t=2s
- Хавсралт 1-4: Багшид зориулсан мэдээлэл

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Сонголын бэрхшээлд хандаж буй нийгмийн болон анагаахын загвар, сонголгүйн судлал (10 минут)

1. Оролцогчдоос сонголын бэрхшээл гэж юу болох талаар асууж, ярилцана. Ярилцлагын үндсэн дээр сонголын бэрхшээлд хандаж буй анагаахын болон нийгмийн загварын тухай хавсралт 1-д байгаа мэдээллийг ашиглан тайлбарлана. Сонголын бэрхшээлтэй хүмүүсийн дийлэнххэсэг нь өөрсдийгөө хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж үздэггүй бөгөөд харин хэл, соёлын хувьд цөөнх гэж үздэг талаар тайлбарлана.
2. Дараах асуултыг асууж, ярилцана.
 - Ямар чиглэлээр бэлтгэгдсэн мэргэжилтнүүд сонголын бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг вэ?
3. Оролцогчдын хэлсэн санаан дээр тулгуурлан дэлхийн олон их дээд сургуулиудад “Сонголгүйн судлал” чиглэлээр бүх түвшинд мэргэжилтнүүд бэлтгэж байгаа бөгөөд сонголгүйн судлалын судалгааны салбаруудын талаар слайд ашиглан мэдээлэл өгнө.

Үйл ажиллагаа 2: Сонголын эрхтний үүрэг ба сонсох механизм (20 минут)

1. Сонсгол гэж юу вэ? (хүний сонсох чадвар) гэсэн асуулт асууж, сонсголын эрхтнийг нэрлэхийг хүснэ.
2. Оролцогчдыг 3 багт хуваана. Багуудад чихний хэсэг тус бүрийг (гадна чих, дунд чих, дотор чих) оноон өгч, үүргийг нь тодорхойлох даалгавар өгнө. Багш хавсралт 2-т байгаа сонсголын эрхтний зурагт үзүүлэн харуулж, багууд өөрсдийн тодорхойлсон үүргийг тайлбарлана.
3. Хүн дуу чимээг сонороор хэрхэн хүлээж авдаг вэ? гэсэн асуулт асууж, товч ярилцана. Хүний сонсох механизмыг харуулсан бичлэг (хэрэглэгдэхүүн хэсэгт байгаа линкийг ашиглах) үзүүлж, дүгнэн ярилцана. Гадна болон дунд чих нь дуу чимээг дамжуулах хэсэг, харин дотор чих бол дуу чимээг хүлээн авах хэсэг юм гэсэн ойлголтод хүрнэ.

Үйл ажиллагаа 3: Сонсгол бууралт, түүнийг шалгах арга (30 минут)

1. Оролцогчдоос дараах асуултыг асууж, ярилцана.
 - Сонсгол бууралт чихний бүтцийн хаана үүсэх боломжтой вэ?
 - Дуу чимээний чанга сул болон давтамжийг хэмжих нэгжийг юу гэж нэрлэдэг вэ?
 - Сонсгол бууралтыг хэрхэн ангилан авч үздэг вэ?
2. Оролцогчдын хэлсэн зүйл дээр багш нэмэлт мэдээлэл (хавсралт 3) өгч тайлбарлана.
3. Сонсголоо шалгуулж байсан хүн байгаа эсэхийг оролцогчдоос асууна. Хэрэв тийм бол хэрхэн шалгуулсан талаар тодруулж асууна. Сонсгол бууралтыг оношлох аргуудын талаар ойлголт өгнө.
4. Сонсгол шалгах аудиометр хэмээх багажийн тухай танилцуулж, сонсгол бууралтыг шалгасан үр дүнг харуулсан аудиограмм, аудиограмм ярианы гадилын тухай (хавсралт 3) тайлбар өгнө.
5. Оролцогчдыг ухаалаг гар утсан дээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын hearWHO аппликэйшн татахыг хүснэ. Тус аппликэйшнийг ашиглан сонсголоо шалгах боломжтой гэдгийг хэлнэ.

Үйл ажиллагаа 4: Сонголын бэрхшээлийн талаар судлах (25 минут)

1. Оролцогчдоос “Сонсголын бэрхшээл гэж юуг хэлэх вэ?” гэсэн асуултыг давтан асууна.
2. Тэдний гаргасан санаан дээр тулгуурлан багш хавсралт 4-т байгаа тодорхойлолт, ангилал болон тус бэрхшээл үүсэх зарим шалтгааны талаар нэмж тайлбарлана.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Та бүхэн тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Сонсгол гэж юу вэ? Сонсгол бууралтын хэдэн хэлбэр байдаг вэ?
- Сонсгол бууралтын зэрэг тус бүрийн сонсголын босго хэд байх вэ?
- Сонсгол бууралтыг ямар аргуудаар шалгах боломжтой вэ?
- Сонсгол бууралтын зэргийг хэрхэн тодорхойлох вэ?

ХАВСРАЛТ 1

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛД ХАНДАХ ЗАГВАР

Анагаахын загвар

Биологийн болон анагаах ухааны үзэл баримтлалд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэвийн хөгжилтэй хүний гүйцэтгэх «хэм хэмжээ»-нээс хазайлттай буюу өөрчлөлттэй гэж үздэг бөгөөд «сонсголгүй хүнийг сонсголтой хүний хэвийн хэм хэмжээнд хүргэх» асуудалд анхаарлаа хандуулдаг.

Сонсголгүйн судлал / Нийгмийн загвар

Сонсголгүй хүнийг ойлгох нийгэм, соёлын хандлага нь сонсголгүй хүнийг сонсголтой хүнтэй харьцуулж үзсэн байдлаар бус харин дохионы хэл хэмээх эх хэлтэй хүмүүс гэж үздэг. Өөрөөр хэлбэл тэднийг нийгэмд өөрсдийн бие даасан соёл болох сонсголгүй хүмүүсийн соёлтой (Deaf culture) гэж хүлээн зөвшөөрдөг.

Сонсголгүйн судлал (Deaf studies) хэмээх шинжлэх ухааны салбар эрчимтэй хөгжиж байна. Сонсголгүйн судлал нь дараах зүйлсийг судалдаг:

Сонсголгүйн судлалын судалгааны хүрээ

- Сонсголгүйн соёл
- Сонсголгүй хүмүүс
- Дохионы хэл
- Сонсголгүйн түүх
- Биеийн хэл
- Нийгмийн ур чадварууд
- Хувь хүний ур чадварууд


ХАВСРАЛТ 2

СОНГОЛЫН ЭРХТНИЙ БҮТЭЦ

Сонгол

Организм сонголын эрхтнүүдийн тусламжтайгаар дуу авиаг хүлээн авах чадвар

Сонсох гэдэг нь хэл яриа болон бичгийн чадварын хөгжлийн хамгийн эхний алхам юм. “Сонсох” → “тархины хөгжил- сонголын хөгжил” гэсэн дарааллаар хөгждөг.



ХАВСРАЛТ 3

СОНГОЛ БУУРАЛТ, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

Сонгол бууралт

Хэвийн сонголотой хүний адил сонсож чадахгүй байдлыг сонгол бууралт гэнэ.

Дамжуулах хэлбэрийн сонгол бууралт:

Гадна чихний суваг болон дунд чихээр ямар нэг шалтгааны улмаас сонгол муу дамжихыг хэлнэ.

Мэдрэл-мэдрэхүйн гаралтай сонгол бууралт:

Дун болон сонголын мэдрэлд, эсвэл хоёулангаас нь шалтгаалсан.

Холимог хэлбэрийн сонголын бууралт

Сонсгол бууралтыг дамжуулах, мэдрэл мэдрэхүйн болон холимог хэлбэрийн сонсгол бууралт гэж ангилан авч үздэг. Хүүхэд аль хэлбэрийн сонсгол бууралттай гэдгээс дараа дараагийн үзүүлэх дэмжлэг, боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна.

Дуу чимээг хэмжих нэгж: Дуу чимээний чанга сулыг хэмжих нэгж нь децибель (дБ), харин дууны давтамжийг (цахилгаан долгионы хурд) герцээр (Гц) хэмждэг.

Хүснэгт 1. Сонсгол бууралтын зэргийн ангилал

Бууралтын зэрэг	Аудиометрийн сорилын түвшин	Үгэн аудиометрийн сорилын түвшин
Хэвийн сонсгол	25 дБ-ээс доош	Шивнээ яриаг сонсоно.
Хөнгөн	26-40 дБ (I түвшин)	Энгийн яриаг 1м дотор сонсож, давтана.
Дунд	41-55 дБ (II түвшин)	Чанга дуу авиаг 1м дотор сонсож, давтан хэлж чадна.
Хүнд	56-70 дБ (III түвшин)	Чихэнд хашхирч хэлсэн үгийн заримыг нь сонсоно.
Гүнзгий	71-90 дБ (IV түвшин)	Хашхирч хэлсэн үгийг сонсохгүй, ойлгохгүй.

90 дБ-ээс дээш бол дүлийрэл гэж үзнэ.



Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багшийн хувьд тухайн сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сонсголоороо харилцах боломж нь хэр түвшинд байдаг (хэр зайд бие дааж хэл яриагаар холбоо тогтоох боломжтой, энэхүү холбоо нь ямар чанартай байдаг), түүнчлэн хүүхдүүд болон тэдний эцэг эхэд хамгийн оновчтой боловсролын чиглэлийг санал болгох нь чухал юм. Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн сонсголоор харилцах «Дүр зураг»-ийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулсан.

Хүснэгт 2. Сонсголын бэрхшээлтэй хүний сонсголоороо харилцах боломж

дБ-ээр сонсгол алдагдлын зэрэг	Сонсголоор хүлээж авах чанар	Бие даан харилцах боломж	Санал болгож буй боловсролын чиглэл
Сонсгол бууралтын 1-р зэрэг 26-40 дБ	3-6 м хүртэлх яриаг тод сонсоно.	Боломжтой	Сонсголын аппараттай ерөнхий боловсролын сургуульд суралцах бүрэн боломжтой
Сонсгол бууралтын 2-р зэрэг 41-55 дБ	1-3 м хүртэлх яриаг тод сонсоно	Боломжтой	Сонсгол, дуудлагыг хөгжүүлэх
Сонсгол бууралтын 3-р зэрэг 56-70 дБ	Чихэн дээр чанга яриаг тод сонсоно	Хүндрэлтэй	Сонсгол, дуудлагыг хөгжүүлэх
Сонсгол бууралтын 4-р зэрэг 71-90 дБ	Чихэн дээр хашхирахад тод сонсохгүй	Бэрхшээлтэй	Харилцаанд дохионы хэл ашиглах, сургалтыг хос хэлний арга зүйгээр явуулах
Дүлийрэл 91-ээс дээш дБ	Сонсохгүй	Боломжгүй	Харилцаанд дохионы хэл ашиглах, сургалтыг хос хэлний арга зүйгээр явуулах

Сонгол бууралтыг оношлох

Сонголын үзлэгийг субъектив болон объектив гэсэн 2 бүлэг аргаар явуулдаг. Хамгийн түгээмэл арга бол аудиометрээр сонгол шалгах явдал юм. Аудиометрийн үр дүнг аудиограмм дээр үзүүлдэг. Аялгуут босгын аудиометрээр сонгол шалгасан байдал



Аудиограмм ярианы гадил

ХАВСРАЛТ 4

СОНГОЛЫН БЭРХШЭЭЛ

Сонголын бэрхшээл. Сонголын бэрхшээл: Дуу чимээг хүлээж авах, ойлгох чадварын хэсэгчилсэн (сонгол бууралт) болон бүрэн (дүлийрэл) алдагдал юм.



СЭДЭВ 2: СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Зорилго: Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог, тэдний хэрэгцээ шаардлагын талаар ойлголттой болж, сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг эзэмших

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Сонсголын өөр өөр төрлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг тайлбарлах
- Сонсголын бэрхшээлийн төрөл хэлбэр бүрээр хүүхдэд тохирсон арга зүйг тодорхойлох

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Компьютер, проектор, дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Багшид зориулсан мэдээлэл
- Хавсралт 2-4: Тараах материал тус бүрийг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 5: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох (15 минут)

1. Өмнөх хичээлээр үзсэн агуулгыг сэргээн санана. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд гэж ямар хүүхдийг хэлэх вэ? гэсэн асуулт асууж, тодорхойлолт гаргана. Багш хавсралт 1-д байгаа мэдээллийг ашиглан чиглүүлнэ.
2. Сонсгол бууралтыг зэргээр нь, мөн цаг хугацааны хувьд хэзээ үүссэнээр нь ангилсан гэдгийг сэргээн санаж, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг хэрхэн ангилж болох вэ? гэсэн асуулт асууна. Сонсголын бэрхшээлтэй хүүхэд сонсголоо алдсан хугацаа нь цаашдын хөгжилд маш их нөлөө үзүүлдэг тухай хэлж, ангиллыг (хавсралт 1) танилцуулна.
3. Оролцогчдод жижиг хэмжээтэй англи хэлний цагаан толгойн хурууны үсэгтэй (I, L, Y- үсгүүдтэй) тараах материал өгнө. Ижил хурууны үсэг сугалсан хүмүүс нэг баг болно. Баг бүрт ямар хурууны үсэг таарсныг асууж, үсгийг хуруугаар үсэглүүлнэ. Энэхүү гурван үсгийг нэг дор зэрэг үсэглэх даалгавар өгнө. Эдгээр дохио нь хүн бүрт танил мэт боловч тэр бүр утгыг нь мэддэггүй талаар тайлбарлана.

Үйл ажиллагаа 2: Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг таньж мэдэх (30 минут)

1. Сонсголын бэрхшээлийн ангилал тус бүрээр хүүхдүүдийн онцлогийн талаар судална гэдгийг хэлнэ. Оролцогчдыг багт 4 хувааж, баг тус бүрт сонсголын

бэрхшээлийн ангиллаас нэг ангиллыг өгнө. Тус хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд нь ямар онцлогтой байх талаар ярилцаж, бичих даалгавар өгнө (Тухайн ангиллын хувьд хүүхдийн хэл ярианы хөгжлийн онцлог, танин мэдэх үйлийн онцлог гэх мэт)

2. Баг бүр өөрсдийн бэлтгэсэн мэдээллээ бусад багуудад танилцуулна. Эдгээр мэдээллийг нэгтгэж багш нэмж тайлбарлана.
3. Багш, суралцагчид хамтран сонсголын бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий онцлогийн талаар зураглал (хавсралт 1) гаргана.

Үйл ажиллагаа 3: Ангилал тус бүрийн хүрээнд сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг боловсруулах (40 минут)

1. Өмнөх багаараа үргэлжлүүлэн сонсголын бэрхшээлийн өөрт оногдсон ангилал тус бүрийн хүрээнд тухайн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн хувилбар боловсруулах даалгавар өгнө. Ингэхдээ тухайн төрлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогийг харгалзан үзэхийг анхааруулна.
2. Баг тус бүр өөрсдийн боловсруулсан арга зүйн хувилбарыг танилцуулна.
3. Баг бүрт хавсралт 2, 3, 4-ыг тараан өгч, өөрсдийн боловсруулсан арга зүйд нэмж тусгах зүйл байгаа эсэхийг дүгнэн ярилцахыг хүснэ. Эдгээр арга зүйг нэгтгэн дүгнэж, бүгдээрээ хамтран ярилцана. Шаардлагатай тохиолдолд багш нэмж тайлбарлана.
4. Багш хавсралт 5-д байгаа мэдээллийг танилцуулж, ярилцана.

Дүгнэлт (5 минут)


Дараах асуултын дагуу ярилцаж, тус сэдвийг дүгнэнэ.

- Та бүхэн тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Төрөл бүрийн сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогийг харьцуулан тайлбарлана уу.
- Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргуудыг нэрлэнэ үү.
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн суралцах хэв маягийг харгалзан хэрхэн дэмжлэг үзүүлж болох вэ?

ХАВСРАЛТ 1

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд: Нэг эсвэл хоёр чихэндээ тогтонги (өөрөөр хэлбэл эргэшгүй) сонсгол бууралттай хүүхдийг сонсголын бэрхшээлтэй хүүхэд гэнэ. Энэ үед дуун мэдээллийг хүлээн авахад хүндрэлтэй (сонсгол бууралттай хүүхэд) эсвэл огт боломжгүй (дүлийрэлтэй хүүхэд) болдог.



Р.М. Боскис сонсголын бэрхшээлийн үед хэл ярианы хөгжлийн түвшин дараах хүчин зүйлсээс шалтгаална гэж үзсэн¹. Үүнд:

- Сонсголын бэрхшээлийн зэрэг
- Сонсголын бэрхшээл үүссэн хугацаа
- Сонсголын бэрхшээлтэй болсны дараа хүүхдийг хөгжүүлэх, сурган хүмүүжүүлэх нөхцөл
- Хүүхдийн хувийн онцлог

Түр зуурын сонсгол бууралттай хүүхдүүд байх бөгөөд энэ нь хүний насан туршийн бэрхшээл биш хэдий ч тухайн хүний хэл ярианы хөгжилд сөргөөр нөлөөлдөг.

Нэг талын сонсголтой хүүхдүүд чимээний эх үүсвэрийг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Эдгээр хүүхдүүд нь багшийн заасан хичээлийн агуулгаас хоцрох, ангийн үйл ажиллагаа, хэлэлцүүлэгт оролцохдоо хүндрэлтэй тулгарах нь нэлээд тохиолддог.

Хэрэв тухайн хүүхдүүд багшийн ярьсныг ойлгоогүй бол мэдлэг, ойлголт, үгийн сангийн хувьд бусдаасаа хоцрохоос гадна анхаарал төвлөрүүлэх гэж хэт их хичээснээс ядрах, сэтгэлээр унах, анхаарал төвлөрөлт нь буурах зэрэг үр дагавартай. Сургуулийн зүгээс хүүхдийг зөв дэмжиж тусалж чадвал сонсголын алдагдалтай хүүхдүүд бусдын адил сурч боловсорч, хөгжих бүрэн боломжтой.

¹ (Камнева В.П., Афанасьева О.О., Харламенков А.Е., 2016)

Төрөл бүрийн түвшний сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд²

Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд янз бүрийн онцлогтой байдаг. Бэрхшээл хаана үүссэн, сонсгол алдагдлын түвшин зэргээс шалтгаалан сонсох чадвар өөр өөр байдаг.

Ихэвчлэн дамжуулах хэлбэрийн сонсгол алдагдлын үед хөнгөн болон хүндэвтэр хэлбэрийн бэрхшээлтэй байх нь олон бөгөөд сонсголын аппарат хэрэглэснээр дуу чимээг бүрэн хүлээн авах боломжтой гэж үздэг.

Харин мэдрэл, мэдрэхүйн гаралтай сонсгол алдагдлын үед хүнд хэлбэрийн бэрхшээлтэй байх нь цөөнгүй бөгөөд сонсголын аппаратын үр дүн нь хүн хүний хувьд өөр өөр байдаг. Мөн дуу чимээг хүлээн авч байгаа ч үг бүрийг ялган ойлгож чаддаггүй (үгийн авиаг сонсож байгаа ч үгийн утгыг ойлгож чаддаггүй) байх нь бий.

Сул эсвэл чанга дуу чимээг хүлээн авдаг эсвэл давтамжийн аль нэг хэсгийг сонсож чадахгүй байх зэрэг олон янз байна. Жишээ нь: чанга дууг илүү хүлээн авдаг бол өдөр тутмын амьдралд сонсох бэрхшээл гарахгүй ч сул дуутай гийгүүлэгчийг хүлээн авахад саад бэрхшээл тохиолддог учраас авиа дуудлагын өөрчлөлт, хоцрогдол үүсэх тохиолдол ч байна. Хэдийд сонсголын бэрхшээлтэй болсон нь суралцах чадварыг тодорхойлох чухал хүчин зүйл болдог. Хүүхэд чихээрээ сонсож хүлээн авсан үг, дуу авиагаар хэл яриаг эзэмшдэг учраас эрт үед сонсголд бэрхшээл үүссэн бол аман яриаг зөв цэвэр эзэмшихэд хүндрэлтэй байдаг.

Сонсголгүй хүүхдийн онцлог

Хүүхэд бүр нас сэтгэхүйн онцлог, хөгжлөөрөө харилцан адилгүй байдаг. Үүнтэй адил сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд ч сэтгэхүйн хөгжлөөрөө харилцан адилгүй байдаг. Гэхдээ энэ байдал нь тухайн хүүхдээс гэхээсээ илүү хүүхдийн өсөж төрсөн орчин, боловсролын үйлчилгээний чанар гэх зэрэг хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг.



2 (Хаяаши Кензо, Торогие Такаши, Исава Шинзо, Ишикура Кенжи, Такано Миюки, 2018)

ХАВСРАЛТ 2

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ СОНСГОЛГҮЙ ХҮҮХДИЙГ СУРГАХ АМАН АРГА³

Сонсголгүй хүүхдүүдийн хэрэглэж байсан дохио зангааг ашиглан дохионы хэлээр сургалт явуулах болсноор дохионы хэл үүссэн гэдэг (manual method). Үүний дараа Герман, Англи зэрэг улсад дохионы хэл төдийгүй аман яриагаар боловсрол олгох болжээ. Уруулаас унших зэрэг харааны хүртэхүйн үйл ажиллагаагаар аман ярианы хэлний сургалтад чиглэх болсноор амны хайрцагнаас унших арга (oral method) эхэлсэн. Энэхүү аргын гол зорилго нь сонсголын бэрхшээлтэй хүүхэд тэр дундаа сул сонсголтой хүүхдийн тухайн аман хэлээрээ утга төгөлдөр, ойлгомжтой ярих чадвар эзэмшүүлэх, зөв тод хэллэгт сургах, сонороор мэдээлэл хүлээж авах чадварыг сайжруулах зорилготой байдаг.

Сонсголын бэрхшээлтэй боловч өгүүлэх эрхтэнд бэрхшээл байхгүй тохиолдолд онолын хувьд аман яриа сурах боломжтой гэж үздэг тул зарим тохиолдолд сонсголгүй хүүхдэд ч энэхүү аргаар аман хэлийг заадаг туршлага бий.

Энэ нь хүүхдэд байгаа үлдэгдэл сонсох чадварыг ашиглан харааны хүртэхүй болон арьс хүрэлцэхүйн мэдрэхүй, чичиргээний эх үүсвэрийг тодорхойлох чадвар зэрэг дээр суурилан авиа дуудлагыг сайжруулах сургалт юм. Гэхдээ энэ аргыг сонсголгүй хүүхдийн хувьд байгалийн бус зохиомол сургалтын арга гэж үздэг. Орчин үед аман хэлний арга зүй нь сонсголгүй хүүхдэд тийм ч оновчтой арга биш гэдэг нь нотлогдсон.

Харин энэ аргыг сул сонсголтой, мөн сонсголын аппарат, суулгацтай хүүхдүүдтэй ажиллахад ашиглавал илүү тохиромжтой.

Аман хэлний арга зүй дараах зүйлс дээр тулгуурлана. Үүнд:

- Ярианы хэл дээр суурилна
- Хөнгөн хэлбэрийн сул сонсголтой бол тухайн хүүхдийн сонсгол, дуудлагыг хөгжүүлэх
- Хүндэвтэр хэлбэрийн сонсгол бууралттай бол сонсголын аппаратын тусламжтайгаар сонсох чадварыг хөгжүүлэх
- Ерөнхий эрдмийн хичээлүүдээс гадна хэл заслын хичээлийг судлах нь зүйтэй бөгөөд энэхүү хичээл нь сонсгол, хэл яриаг хөгжүүлэх гол хичээл болох ба ганцаарчилсан болон бүлгээр хичээллэдэг.
- Мөн бусад бүх судлагдахууны багш нар тухайн сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сонсгол, дуудлагын чадварыг хөгжүүлэхэд хамтарч ажиллах хэрэгтэй.

3 (Хаяаши Кензо, Торогие Такаши, Исава Шинзо, Ишикура Кенжи, Такано Миюки, 2018)

Аман хэлний арга зүйгээр хичээллэхэд дараах дарааллыг баримтална.

- Ярианы амьсгал хөгжүүлэх: Ярих үед буюу үг, өгүүлбэрийг хэлэхдээ амьсгалаа зөв хуваарилах
- Дуу бий болгох ба хөгжүүлэх: Ярих үедээ дууны өнгөө зөв тохируулж сурах, ярих үедээ зөв, тод, ойлгомжтой ярих
- Авиа тавих, авиа дуудлагын өөрчлөлтийг засах гэх мэт.

Дээрх сургалтыг дараах аргуудаар явуулдаг.

- Дуурайлгах арга
- Механик арга
- Холимог арга

ХАВСРАЛТ 3

СОНГОЛГҮЙ ХҮҮХДИЙГ СУРГАХ ЦОГЦ ХАРИЛЦААНЫ АРГА⁴

Хүүхдийн үлдэгдэл сонсголыг ашиглах нь чухал боловч тогтонги, хүнд зэргийн сонсгол алдагдалтай хүүхдэд харааны хүртэхүйгээр мэдээлэл авах хэлбэр болон уруулаас унших аргаар аман яриаг эзэмшүүлэх нь хүндрэлтэй. Мөн хэл яриаг жам ёсоор буюу хар аяндаа сургахад бус сургалтаар хэл яриаг эзэмшүүлэх нь тухайн сонсголгүй хүүхэд болон түүний ойр тойрныхон, гэр бүлээс асар их хүчин чармайлт шаарддаг.

Мөн зарим багш нар аман ярианы сургалтын аргын үр дүнд сэтгэл хангалуун бус байв. Эдгээрээс үүдэн 1960-аад оны хоёрдугаар хагаст хүмүүс хоорондын харилцааг чухалчлан үзэх болсноор “Цогц харилцаа” хэмээх үзэл баримтлал барууны орнуудад, тэр дундаа Америкт бий болсон. “Боломжтой гэх бүх арга барилаар (уруулаас унших, хэл яриа, бичиг, дохио, хурууны үсэг, үзүүлэн таниулах материал ашиглах гэх мэт) харилцах” гэсэн үзэл санаа гарч ирсэн.

Гэвч тухайн үед дохионы хэлний судалгаа хангалттай бус төдийгүй тухайн үеийн сонсголын бэрхшээлтэй хүний хэрэглэж байсан хэлийг харилцааны бүрэн төгс хэрэглэгдэхүүн гэж үзээгүй. Үүнээс аман ярианы хэлээр харилцах явцдаа зарим үед дохионы хэлний үг хэрэглэх, ярианы хэлний өгүүлбэрийн дүрмийн дагуу англи маягийн дохионы хэлийг шинэчлэн зохиосон (Manually coded English). Энэ нь хэл зүйн үүднээс дохионы хэлийг хүлээн авсан зүйл биш байсан бөгөөд суралцах болон хэл ярианы сургалтад найдаж байсан үр дүнг гаргаж чадаагүй. Гэсэн ч хүүхдийн хувьд харааны хүртэхүйгээр ойлгох чадвар дээшилсэн нь танхимын сургалтад багш, хүүхдүүдийн хоорондын харилцааг идэвхтэй болгосон гэгддэг.

4 (Хаяаши Кензо, Торогие Такаши, Исава Шинзо, Ишикура Кенжи, Такано Миюки, 2018)

ХАВСРАЛТ 4

ДОХИОНЫ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ БА ХОС ХЭЛИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ОРОЛДЛОГО⁵

Цогц харилцаанд оруулж ирсэн дохионы хэл нь сонсголгүй хүний хэрэглэдэг дохионы хэлнээс өөр байв. Гэвч 1960-аад оноос эхлэн Америк, Европт дохионы хэлний хэл шинжлэлийн судалгаа эрчимтэй явагдаж эхэлснээр сонсголгүй хүний дохионы хэл нь өөрийн гэсэн бүтэц, дүрэм, үгсийн сантай бие даасан хэл болох нь мэдэгдсэн. Үүнийг үндэслэн дохионы хэлийг сонсголын бэрхшээлтэй хүний нэгдүгээр хэл, аман яриаг хоёрдугаар хэл болгон сургах “Хос хэл”-ний сургалтын үзэл санаа гарч ирсэн. Латин хэлний *bi*— хоёр, *lingua* — хэл хэмээх үгсээс гаралтай бөгөөд монгол хэлэнд хос хэл гэж орчуулагдана. «Хос хэлний хандлага» сургалтын тогтолцоо нь 80-аад оны эхээр дэлхийд сонсголгүйн боловсролд шинэ чиглэл болон гарч ирсэн. Тус аргад хамгийн анх 1983 онд Швед улс шилжсэн. Үүний дараа Европын бусад улс орон болон АНУ-д сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудад хос хэлний аргаар сургалт явуулах болсон бөгөөд энэ нь маш амжилттай болж, олон нийтийн анхаарлыг татаж эхэлсэн.

Ихэнх сонсголгүй хүмүүс өөрийн улсын дохионы хэл болон ярианы хэлний аль алинд нь тодорхой хэмжээнд суралцсан байдаг. Хэн нэгэн дохионы хэлийг үндсэн хэл гэж үздэг, хэн нэгэн ярианы хэлийг илүүд үздэг боловч сонсголгүй хүмүүс харилцааны нөхцөл байдлаас шалтгаалан аль алиныг нь ашиглаж болно. Сонсголгүй хүмүүсийн сургалтад хос хэлний хандлага нь боловсролын үйл явцын монгол хэлний (эсвэл өөр үндэсний), монгол дохионы хэл (эсвэл өөр) хоёр тэгш эрхтэй, тэгш үнэлэмжтэй хэрэгслүүдийг ашиглах боломжийг авч үздэг. Хоёр хэл нь хоёул сонсголтой болон сонсголгүй багш, сурагч, эцэг эхийн харилцаанд эрх тэгш түншүүд болдог.⁶

Төрөлхийн сонсголгүй хүүхдүүдийн дийлэнх нь оюун ухаан, сэтгэхүйн хувьд хэвийн хөгжилтэй байдаг тул тэдэнд төрсөн цагаас нь эх хэл болох дохионы хэлийг нь эзэмшүүлснээр цаашид жирийн сонсголтой хүүхдийн сурч эзэмшиж болох тэр бүхнийг сурч эзэмших боломжтой болдог. Хос хэл соёлын арга зүйд сонсголын бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлтэй гэж үздэггүй. Харин тэднийг өөрсдийн бие даасан хэл, соёл бүхий нийгмийн цөөнх гэж үздэг. Одоогийн байдлаар энэхүү аргыг хамгийн ирээдүйтэй арга зүйн чиглэл гэж үзэж байна.

Өнөөдөр дэлхий дахинд сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудалд ихээхэн өөрчлөлтүүд гарч байна. Тухайлбал: Тэгш хамран сургах боловсролын (*inclusive education*) тогтолцоо юм. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмшиж байгаа тусгай сургууль төдийгүй энгийн сургуулийн энгийн ангид үзүүлэх боловсролын үйлчилгээ ч өргөжиж байна. Үүнтэй уялдан сонсголын аппарат (*hearing aid*), дунгийн суулгац (*cochlear implants*), сонсголын тархины баганын суулгац (*auditory brainstem implants*) зэрэг анагаах ухаан дахь техник, технологийн хөгжил, түүний хэрэглээ ч нэмэгдэж байна.

5 (Хаяаши Кензо, Торогие Такаши, Исава Шинзо, Ишикура Кенжи, Такано Миюки, 2018)

6 (Камнева В.П., Афанасьева О.О., Харламенков А.Е., 2016)

ХАВСРАЛТ 5

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХ ХЭВ МАЯГ

Сонсголын бэрхшээлтэй хүүхэд нь ихэвчлэн мэдээллийг харааны хүртэхүй дээр суурилан хүлээж авдаг. Өөрөөр хэлбэл тэдний дунд харааны хэв маягтай суралцагч олон байдаг гэсэн үг юм. Эдгээр суралцагчид нь хэлний болон орон зайн гэсэн 2 хэлбэрээр суралцдаг. Сонсголгүй хүүхэд мэдээллийг дохионы хэлээр авахаас гадна мөн бичгийн хэлээр мэдлэг эзэмшинэ.

“Харааны орон зай”-н хэв шинжтэй суралцагчдад мэдээллийг биетээр, үзүүлэн, график, бүдүүвч, бичлэгээр хүргэвэл илүү үр дүнтэй.

Ийм хэв шинж бүхий суралцагчдын суралцах орчныг бүрдүүлэхийн тулд:

- График, дүрслэл, диаграмм зэрэг харах зориулалттай зүйлсийг ашиглах
- Унших болон тэмдэглэх тохиолдолд товчлол хийх, зураглал хийх, жагсаалт гаргах зэргийг хийлгэх
- Тараах материал дээр ажиллуулахдаа бичиж тэмдэглэх орон зайг гаргаж өгөх
- Ярилцахдаа дохионы хэл ашиглах
- Тайлбарлаж буй зүйлийг илүү ойлгомжтой болгохын тулд тэмдэглэх цааснуудыг ашиглаж хананд өлгөх
- Тэмдэглэл хөтлөхөд гол санаа, гол үгийг тодруулах
- Оюун санааг нь сатааруулж буй зүйлсийг хасах
- Хэрэв боломжтой бол бичвэр материалыг үзүүлэн таниулах материалтай хослуулан хэрэглэх
- Сургалтын арга зүйдээ биеэр үзүүлэх болон дүрд тоглох арга зүйг хэрэглэх

СЭДЭВ 3: СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗАМУУД

Зорилго: Суралцахуйн түгээмэл загварын зарчмыг баримтлан сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг, чадвар эзэмших

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг сэдэлжүүлж оролцоог хангах арга замуудыг тодорхойлох
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд тохируулан анги зохион байгуулалт, сургалтын орчныг бүрдүүлэх хувилбар гаргах
- Сонсголын бэрхшээлтэй хүүхэд сурсан мэдлэг, чадвараа үзүүлэх арга замуудыг тодорхойлох
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн бодит чадварт нийцүүлэн үнэлгээний аргачлалыг боловсруулах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Компьютер, проектор, дэлгэц цаас, маркер, цаасан скок
- Хавсралт 1: Тараах материалыг 2-3 хувь хэвлэх
- Хавсралт 2: Тараах материалыг 2-3 хувь хэвлэх
- Хавсралт 3: Тараах материалыг 2-3 хувь хэвлэх
- Хавсралт 4: Багшид зориулсан материал
- Хавсралт 5: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Суралцахуйн түгээмэл загварыг ашиглан сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах (45 минут)

1. Суралцахуйн түгээмэл загварын талаар сэргээн санаж ярилцана.
2. Оролцогчдыг 3 багт хувааж, СТЗ-ын үндсэн гурван зарчмыг нэг нэгээр оноож, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд хэрхэн хэрэгжүүлж ажиллах хувилбар боловсруулахыг хүснэ.
3. Баг бүр өөрсдийн хийсэн зүйлээ бусад багуудад танилцуулна. Бусад багаас нэмэх санаа байгаа эсэхийг асууж, гарсан санаануудыг дэлгэц цаасан дээр нэмж бичнэ.

4. Баг бүрийн хийсэн зүйлтэй холбоотой унших материалыг (хавсралт 1, 2, 3) тарааж өгнө. Багууд өөрсдийн хийсэн зүйлийг тараах материалд байгаа мэдээлэлтэй харьцуулж, дүгнэн ярилцана.
5. Өөрсдийн судалсан зүйлээ бусад багийнханд танилцуулж, хамтран ярилцана.

Үйл ажиллагаа 2: Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад бусад анхаарах зүйлсийг тодорхойлох (40 минут)

1. Өмнө ярилцсан зүйлээс өөр бусад анхаарах зүйлийн талаар оролцогчдоос асууж, тэдний хэлсэн санааг дэлгэц цаасан дээр бичиж тэмдэглэнэ.
2. Багш хавсралт 4-т байгаа үнэлгээний талаарх мэдээллийг оролцогчдод танилцуулж тайлбарлана.
3. Оролцогчдыг 3-4 багт хувааж, хавсралт 5-ыг тарааж өгнө. Баг бүр дотроо 2 хэсэгт хуваагдан дараах 2 хэсэг мэдээллийг нэг нэгээр уншиж судална.

- Багш, эцэг эх, асран хамгаалагч нартай ажиллах стратеги
- Багш нар хоорондоо хамтарч ажиллах стратеги

Уншиж судалсан мэдээллээ багийн гишүүддээ тайлбарлаж, санаа бодлоо хуваалцана.

Дүгнэлт (5 минут)

Тус сэдвийн хүрээнд судалсан зүйлээ хамтран ярилцаж, дүгнэлт хийнэ. Үүнийг дараах байдлаар хийж болно.

- Оролцогчид өөрсдийн сурч мэдсэн зүйлээ нэг нэг өгүүлбэрээр илэрхийлэх
- Сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх гурван санааг хэлэх

ХАВСРАЛТ 1

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙГ СЭДЭЛЖҮҮЛЖ ОРОЛЦООГ ХАНГАХ АРГА ЗАМУУД

Суралцагчдын сурах сэдэл харилцан адилгүй учир багш хүүхдийг суралцах үйл явцад идэвхтэй оролцуулах олон арга замыг хэрэглэх нь зүйтэй.

Хүүхдийн сурах сэдлийг өдөөж, оролцоог хангах нь хүүхдийн хүсэл сонирхлыг татаж, сэтгэл хөдлөлөө зохицуулах боломж олгохоос гадна дасгал даалгаврыг хүчин чармайлт гарган гүйцэтгэх, суралцах үйл явцад идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Иймд багш сурагчийн сурах сэдэлд тохирсон оролцоог хангах олон арга замыг бодолцож багшлахуйн болон суралцахуйн үйл явцыг зохион байгуулах хэрэгтэй.

Сонсголын алдагдалтай сурагч багшийн хэлсэн мэдээллийг сонсохгүй өнгөрөөх, буруу сонсох эрсдэлтэй бөгөөд тэр хэрээрээ тухайн хүүхэд хичээлд оролцох идэвх сонирхол буурч байдаг. Тиймээс багш ангид болж буй үйл ажиллагаанд бүх хүүхэд идэвхтэй оролцдог сургалтын орчныг бүрдүүлснээр энэхүү асуудлыг шийдэх боломжтой.

Ангийн зохион байгуулалт ба сургалтын орчин

Багшийн байрлал. Сургалтын явцад сурагч багшийг төвөггүй харж, сонсох боломжтой байх ёстой. Багш аль болох урд эгнээнээс хичээлээ заах бөгөөд ярьж байхдаа алхах, хөдөлгөөн хийхээс зайлсхийх хэрэгтэй. Мөн самбар дээр бичих үедээ ярихгүй байх, нүүрэн дээр нь сүүдэр тусахуйц цонхны дэргэд очиж зогсохгүй байхад анхаарах нь зүйтэй.

Сурагчийн суудлын хуваарилалт. Бэрхшээлтэй хүүхэд аль болох ангийн урд, үргэлж дэмжиж тусалдаг найзтайгаа хамт суух нь зөв. Мөн тухайн хүүхэд бусдын яриаг уруулын хөдөлгөөнөөр уншихын тулд бага зэрэг нэг тийшээ хазайсан байрлалтай сууж болно.

Ухэлбэрээр ширээ сандлаа байрлуулах: Ухэлбэрээр ширээ сандлаа байрлуулбал бэрхшээлтэй хүүхэд хэн ярьж буйг харах боломжтой болно.

Ангид аль болох дуу чимээ гаргахгүй байх: Хүүхэд сонсголын аппарат зүүж байгаа тохиолдолд уг төхөөрөмж нь хүний яриа болон орчны дуу чимээг хамтад нь өсгөдөг. Тиймээс ангийн дуу шуугиан бэрхшээлтэй хүүхдэд илүү ачаалал өгч, төвөг учруулж мэднэ. Иймд багш чимээтэй орчинд хичээллэж байгаа бол хаалгаа хаах, хичээл заах үедээ ангийг аль болох нам гүм байлгах, ангийн тусгаарлах ханын өмнө номын тавиур, аяганы тавиур байрлуулах, сандлын хөл шал зурж байвал резинээр бэхлэх зэрэг арга хэмжээ авч болно. Мөн бэрхшээлтэй хүүхдийг ангийн хаалга, халаагуур зэрэг чимээ шуугианы эх үүсвэрээс аль болох хол суулгах ёстойг бодолцоорой.



Сонсголын аппараттай хүүхдийг чимээгүй орчинд хичээлээ хийх боломжийг бүрдүүлээрэй

Санаагаа давтан хэлж, нэгтгэн дүгнэ. Хэрэв сонсголын алдагдалтай хүүхэд ангийн хойноос багшийн хэлсэн үгийг сонсоогүй бол багш санаагаа давтан хэлэх, ангийн урд байгаа сурагчдын санааг нэгтгэн дүгнэж, өөр үгээр илэрхийлэх зэрэг арга техник хэрэглэж болно.

Хүүхдэд ярьж буйгаа мэдэгдэж дохио өгөх. Багш ангийн бусад сурагчдыг бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахаас өмнө дохио өгөх, өөрийгөө танилцуулах, нэг нэгээрээ ярих зэрэг дадалд хэвшүүлээрэй.

Сайн найзын дэмжлэг. Хэрэв хүүхэд ямар нэг зүйл сонсохгүй орхигдуулбал давтан хэлж өгч, бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйн үйл явцад дэмжлэг үзүүлэх “сонсголтой найз”-тай байх хэрэгтэй. Бэрхшээлтэй хүүхэд заавал багшийн дэмжлэгийг хүлээлгүйгээр найзаасаа туслалцаа авч, дасгал даалгавраа хийж гүйцэтгэх боломжтой.

Дохио өгөх болон хүний нүд рүү эгцлэн харах: Хүүхэд бусдын яриаг эхнээс нь алдалгүй сонсохын тулд ярьж эхлэхээсээ өмнө бусдын нүд рүү эгцлэн харах арга зүйг ашиглавал үр дүнтэй. “Бүх хүмүүс тэр зүг рүү хардаг” гэх мэт хүүхдэд ойр үг хэллэг хэрэглэвэл бэрхшээлтэй хүүхэд ойлгож, заасан зүг рүү харах боломж бүрдэнэ.

Мэдлэг ойлголтыг нь шалгах. Сурагч таны заасан заавар зөвлөгөөг ойлгож, шинэ үг сурч буй эсэхийг нягтлахдаа нээлттэй асуулт асуух болон тухайн суралцагчтай хэлэлцүүлэг өрнүүлэх аргуудыг ашиглаарай. Хэрэв сурагч танаас нэмэлт тусламж хүсвэл тухайн хүүхэд хичээлд анхаараагүйдээ биш, сонсоогүй өнгөрөөсөн байх нь элбэг. Тиймээс сурагч санамсаргүй байдлаар таны асуусан асуултад хариулахгүй байж мэднэ. Мөн зарим тохиолдолд сурагч хэл яриагаар болон бичгээр аливааг илэрхийлэхдээ алдаа гаргаж болох бөгөөд энэ нь тухайн хүүхдийн сонсголын алдагдал, хөгжлийн хоцрогдолтой холбоотой юм.

ХАВСРАЛТ 2

СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДЭД АГУУЛГЫГ ОЛОН ХЭЛБЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

Суралцагчид мэдээллийг харилцан адилгүй хүлээж авч, ойлгодог учир багш сурагчдыг мэдлэг эзэмших олон арга замаар хангах хэрэгтэй.

Дүрслэлийн арга барилыг ашиглах

Харааны мэдрэхүйд тулгуурласан дүрслэлийн аргыг ашиглах нь сонсголын бүрэн алдагдалтай хүүхдүүд сонсох, хэл яриа болоод уруулын хөдөлгөөн унших байдлаар мэдээлэл хүлээж авахаас гадна шинээр заагдсан сэдвийн агуулга, нөхцөл байдлыг ойлгоход дэм болдог. Дүрслэлийн арга барил нь шинэ санаа, үгийг зураглан ойлгоход дэмжлэг үзүүлэхээс гадна харааны санах ойн чадварыг дэмжиж, өмнө сурсан мэдлэгээ бататгахад тустай. Тус аргыг ашиглахдаа багш дараах зүйлийг анхаараарай.

Үзүүлж буй дүрслэлээ тодорхой зааж өгөх.
Бусад сурагчид энэ тухай ангийн хэлэлцүүлгийн үед ярилцаж болно.

Бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн дүрэм журмыг ойлгуулж, тогтоолгохын тулд цагийн хуваарийн үзүүлэн, утгын зураглалын аргыг ашиглаарай.

Хүүхэдтэй дахин харьцаж эхлэхээс өмнө тухайн хүүхдэд дүрслэлийг харж ойлгох хангалттай цаг өгөөрэй.
Энэ нь хүүхдэд анхаарлаа буцаад багшид хандуулахад шаардлагатай хугацааг өгнө.

Хүүхдийн суралцахуйн түвшнээс хамаарч багш дүрслэлийн аргыг ашиглаж болох жишээнүүд:

Сургуулийн өмнөх болон бага ангид: Үлгэр түүх, дуу шүлэг, заавар зөвлөмж, ангийн дэг журам, аялал, сургуулийн орчин, хэл яриагаар болон бичгэн текстээр өгдөг тайлбаруудыг боломжтой бүх газарт зурган дүрслэлээр үзүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, хүүхдийн суралцахуйн үйл явц, ойлголтыг дэмжихийн тулд бодит эд зүйл, үлгэрийн уут, хүүхэлдэй, гэрэл зураг, зураг, диаграмм, чимэглэл, эд зүйлсийг ашиглах.

Дунд, ахлах ангид: Харах боломжтой байдлаар бэлтгэсэн мэдээлэл: Хэрэв багш мэдээллийг зөвхөн хэл яриагаар дамжуулан хүргэвэл сонсголын алдагдалтай болоод бүрэн сонсголгүй хүүхдийн суралцахуйн явцад хүндрэл учирна. Тиймээс хичээлийн агуулгын түлхүүр үг, шинэ үг, суралцахуйн зорилго зэрэг чухал мэдээллүүдийг цаасан дээр бичиж бэрхшээлтэй хүүхдэд тохирсон байдлаар өгөх ёстой. Түүнчлэн гэрийн даалгаврыг зөвхөн амаар өгвөл тухайн сурагч бичиж авахад хүндрэлтэй байх тул мөн цаасан дээр бичсэн хувилбарыг хүүхдэд дагалдуулж өгөөрэй.

DVD болон дуу авианд тулгуурласан хичээлийн материал: Сонсголын алдагдалтай хүүхдүүдийн хувьд бичлэг болон дуу авианд суурилсан мэдээлэл хүлээн авахад хүндрэлтэй учир агуулгыг хэвлэмэл байдлаар өгөх эсвэл бичлэг дээр хадмал тайлбар оруулах хэрэгтэй. Бүрэн сонсголгүй хүүхэд мэдээлэл хүлээж авах боломжгүй учир агуулгыг хэвлэмэл байдлаар өгөх эсвэл тэмдэглэл хөтөлж өгөх хүн хэрэгтэй болно. Дохионы хэлний орчуулгатай бичлэг үзүүлж болно.

ХАВСРАЛТ 3

СОНГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮД СУРСАН ЗҮЙЛЭЭ АШИГЛАХ, ТҮҮНИЙГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ АРГА ЗАМУУД

Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул суралцагчид өөрсдийгөө илэрхийлэх олон арга замыг хэрэглэх нь зүйтэй.

Дохионы хэл ашиглах

Сургуулийн өмнөх насны хүүхдээс эхлээд хүүхэд бүр дохионы хэл сурч эзэмшиж, харилцааны үндсэн хэрэгслээ болгох чадвартай байдаг. Гэвч ердийн хүмүүсийн өдөр тутамдаа ашигладаг хэл ч бүс нутгийнхаа онцлогоос хамаарч харилцан адилгүй байдагтай адил дохионы хэл мөн өөр байна. Энэ нь Монгол дохионы хэл хэрэглэдэг монгол хүн Солонгос эсвэл Оросын дохионы хэлийг ойлгохгүй гэсэн үг юм. Тиймээс багш дохионы хэл сурч, сурагчтай харилцахаар шийдсэн бол бүх нийтээр хэрэглэдэг Монгол дохионы хэл сурах нь чухал. Дохионы хэл нь хүүхдүүдийн суралцахуйн үйл явцыг дэмждэг чухал харилцааны хэрэгслийн нэг бөгөөд бүх насны хүн сурах боломжтой. Ангийн бүх сурагчид дохионы хэлээр түлхүү хэрэглэгддэг үгсийг илэрхийлж сурснаар сонсголын бэрхшээлтэй найзтайгаа төвөггүй харилцах боломж бүрдэх бөгөөд энэ нь өөрийгөө илэрхийлэх чадвар сул хүүхдүүдийн харилцааны чадварыг хөгжүүлэхэд дөхөм болдог.

Хүүхдийн сэтгэл санааны тогтвортой байдлыг дэмжих

Багш төдийгүй сургуулийн хүрээнд сонсголгүй хүүхдийн сэтгэл зүйн эрүүл мэнд, тогтвортой байдалд санаа тавьж, хүүхдийг тэсвэр тэвчээртэй, өөрийгөө эергээр үнэлдэг хүн болон хүмүүжих явцад хувь нэмрээ оруулах хэрэгтэй.

Сонсголгүй сурагчид бусад хүүхдүүд ч мөн буруу сонсож, буруу ойлгож, алдаа гаргадаг гэдгийг тайлбарлаж өгөөрэй. Үеийн найз нөхөд нь өөртэй нь төстэй арга туршлага, онцлог хэрэгцээтэй гэдгийг мэдэх нь тухайн хүүхдийн сэтгэл зүйд эергээр нөлөөлнө.

Сонсголгүй хүүхэд өөрт нь ямар хэрэгцээ байгааг зөв илэрхийлэх, жижиг бүлгийн харилцаанд орох замаар нийгэмших чадвараа хөгжүүлэхэд сургуулийн бусад ажилчдаас ямар дэмжлэг, туслалцаа хэрэгцээ байгааг тэдэнд илэрхийлж хэлэх боломж олгоорой.

Сонсголгүй сурагчийг сургуулиас гадуур ямар орчин хүлээж буйг, ямар хүндрэл бэрхшээл учирч болох, асуудлыг хэрхэн шийдэж болох арга барилд сургаарай.

Харааны хүртэхүйд зориулсан зурган илэрхийлэл, үлгэр түүх, бусад хэрэглэгдэхүүнүүд нь бүх сурагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан үзсэн байх ёстойг анхаараарай.

Бусад сонсголгүй том хүн, хүүхэдтэй уулзах боломжоор хангах. Эцэг эх болон орон нутгийн сонсголгүй иргэдийн бүлэг үүнийг бодит болгоход тусалж болно. Сонсголгүй хүүхдийг мэдрэмжээ зөв “тодорхойлоход” нь туслаарай.

Хүүхдийн нийгмийн харилцааг дэмжих

Сонсголгүй хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ шууд харилцаж чаддаггүй тул бусдын өнцгөөс нөхцөл байдлыг харах, дүгнэх чадвар сул байдаг. Иймд багш тусгай багшлахуйн арга барилаар хүүхэдтэй ажиллах хэрэгцээ гарна.

Ихэнхдээ сургуулийн хамгийн чимээ шуугиан ихтэй газруудад бусадтайгаа харилцах, нийгэмших боломж гардаг учраас сонсголын бэрхшээлтэй хүүхдэд хүндрэл тулгардаг. Сургуулийн дотор болон гадаа хүүхдүүд нэг нэгээрээ эсвэл жижиг бүлгийн хүрээнд харилцаа үүсгэж, нийгэмших боломжтой газар байгаа эсэхийг сайн бодолцоорой. Сэтгэл хөдлөлийн тухай ярилцах. Нийгмийн хэм хэмжээг ойлгосноор нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх боломж бүрддэг. Ердийн сонсголтой хүүхэд амьдралын туршлагаараа дамжуулж хэм хэмжээний талаар ойлголттой болдог бол сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хувьд энэ боломж хязгаарлагдмал байна.



Сонсголгүй хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ шууд харилцаж чаддаггүй тул бусдын өнцгөөс нөхцөл байдлыг харах, дүгнэх чадвар сул байдаг.

Зан төлөв, бухимдлаа удирдах

Сонсголгүй хүүхэд тэсвэр хатуужилтай бөгөөд өөрийгөө эергээр үнэлдэг байх хэрэгтэй. Эдгээр чадварууд нь хүүхдийг тодорхой нөхцөл байдал тулгарахад даван гарах, илүү өргөн хүрээний нийгмийн харилцаанд орсон ч хэрэгцээгээ хангах боломжийг олгодог. Харин сургуулийн зүгээс нэг талдаа тухайн хүүхдийн ялгаатай байдалд нийцүүлж тохируулга хийх, нөгөө талдаа бэрхшээлтэй хүүхдийг бусад сурагчидтай адил зан төлөвөө удирдаж, биеэ авч явахыг сануулж байх буюу тэнцвэрийг барих хэрэгтэй. Сонсголгүй хүүхдийн зан төлөвийн тогтворгүй байдал нь дараах хүчин зүйлсээс болж үүсэж мэднэ.



Эргэн тойрондоо юу болж буйг хангалттай хэмжээнд ойлгож, сонсож чадахгүй байгаадаа гутрах

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн анхаарал төвлөрөх хугацаа богино байдгийн дээр хүний яриаг сонсохын тулд анхаарлаа илүү төвлөрүүлж ядаргаанд орох

Бусад хүүхдүүдээс шоолж, дээрэлхсэн хандлага мэдрэх

Сургуулийн зүгээс дараах байдлаар хүүхдийн эерэг зан төлөвийг дэмжих боломжтой:

- Хүүхэд дүрэм журам, тогтсон дадлыг ойлгож буй эсэхэд санаа тавих
- Цагийн хуваарь, горимд өөрчлөлт оруулах талаар тайлбарлаж, ярилцах
- Дүрэм журам, хүлээлтийг тайлбарлаж үзүүлэх бөгөөд хэрэв зөрчвөл ямар үр дүн гарахыг тайлбарлах
- Тулгарсан хүндрэл бэрхшээлийн талаар ярилцвал хүүхэд юуг буруу хийснээ ойлгоно. Сонсголгүй хүүхдүүдийн хувьд бусдын сэтгэл хөдлөл, сэтгэл зүйн байдлыг ойлгох чадвар сул байдаг тул тэсвэр хатуужлын талаар сайтар тайлбарлаж өгөх нь чухал юм.
- Хүүхдийн сонсох чадвар ямар түвшинд буй, тэдний туршлага, тулгардаг хүндрэл бэрхшээлийг ажиглах эсвэл хүүхдээс асуух байдлаар ерөнхий мэдээлэл цуглуулснаар багш тухайн хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт нийцүүлэн тохируулга хийх боломж бүрдэнэ.

ХАВСРАЛТ 4

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫГ ХҮҮХДИЙН ЧАДВАРТ НИЙЦҮҮЛЖ ТОХИРУУЛАХ

Үнэлгээний аргачлалыг тохируулах, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд суралцахуйн дэмжлэг үзүүлснээр тухайн хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ ижил хэмжээнд суралцаж, ахиц гаргах боломжтой бөгөөд үр дүн нь насны онцлогт илүү суурилсан байна.

Хүүхдийг үнэлэхдээ багш дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

Тухайн хүүхэд хүний яриаг сайн ойлгодог гэдэг нь хэлний мэдлэг сайн гэсэн үг биш юм. Сонсголгүй хүүхдүүд өгсөн асуулт, даалгаврыг ойлгохгүй байх тохиолдол ч байдаг.

Зарим стандарт шалгалт нь сонсголын бэрхшээлтэй хүүхдэд тохиромжгүй байдаг. Сурагч ямар агуулгатай шалгалтыг хэрхэн өгөхөө бүрэн ойлгож байх нь чухал.

Хүүхдийн ахицыг тогтмол тэмдэглэх хэрэгтэй. Бага насны хүүхэд бол үйл ажиллагаанд оролцож буй зургуудыг ашиглан, тэдний ахиц, амжилтыг үнэлэх нь зүйтэй.

ХАВСРАЛТ 5

БАГШ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧТАЙ ХЭРХЭН АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад багш, эцэг эх, хүүхэд гэсэн гурвалсан холбоог маш сайн хангаж ажиллах хэрэгтэй. Хэрэв эцэг эх нь сонсголтой, дохионы хэл мэддэггүй бол сонсголгүй хүүхдийн хувьд зөвхөн сургуулийн орчин л нийгмийн харилцаанд орох орчин болдог. Харин гэр бүлийн гишүүдийн хооронд зөвхөн ахуйн хар дохио зангаагаар харилцдаг. Энэ нь хүүхдийн сэтгэл зүйн байдал болон нийгмийн хөгжилд ихээхэн хүндрэл бэрхшээлийг дагуулдаг. Тиймээс хэрэв хүүхэд нь бүрэн сонсголгүй бол эцэг эх нь хүүхдийнхээ өмнө хариуцлага хүлээж, дохионы хэлэнд тодорхой хэмжээнд суралцах ёстой. Эцэг эхийн дохионы хэлний чадварыг сайжруулахын тулд сургууль болон багш нарын зүгээс дотоод нөөц бололцоогоо ашиглан байнгын тасралтгүй дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тус сургалтыг зөвхөн эцэг эхийг оролцуулах байдлаар бус эцэг эх, хүүхдүүд хамтдаа суралцах байдлаар зохион байгуулж болно. Сонсголгүй хүмүүсийн соёлын онцлогоос сонсголгүй хүмүүс дохионы хэлд суралцаж буй сонсголтой хүмүүст маш уриалгахан таатай ханддаг бөгөөд тэдэнд дохионы хэл сурахад нь туслах эрмэлзэлтэй байдаг. Дохионы хэлний сургалтыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулах эсвэл мэргэжлийн байгууллагаас захиалгат сургалтуудыг авах нь үр дүнтэй.

БАГШ НАР ХООРОНДОО ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Сонсголгүй хүүхдэд хичээл зааж буй багш нар дараах зүйлс дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Үүнд:

- Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нар дохионы хэлний өндөр чадвартай, сонсголгүй хүүхдийн онцлог, ахуй соёлын талаар гүнзгий мэдлэгтэй байх хэрэгтэй
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдийг сургаж буй олон улсын чиг хандлагын талаар ойлголттой байж, тэрхүү арга зүйг хичээл практиктаа хэрэгжүүлж ажиллах (хос хэл, хос соёлын хөтөлбөр, сул сонсголтой хүүхдэд хавсарсан хэлний арга зүй гэх мэт)
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдтэйгээ тулж харилцах (зарим тохиолдолд багш нар дохионы хэл сайн мэдэхгүйн улмаас дохионы хэл мэддэг хүүхдээр дамжуулан харилцах тохиолдол цөөнгүй байдаг)
- Анхаарлаа төвлөрүүлэх чадварыг сайжруулах
- Үгийн нөөцийг нэмэгдүүлэх
- Хичээл хоорондын интеграци хийх
- Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд тохирсон орчин бүрдүүлэх
- Сонсголгүй хүүхдийн өссөн орчин болон бусад хүчин зүйлсээс шалтгаалаад хүүхэд бүрийн хөгжлийн түвшин харилцан адилгүй байдаг. Үүнд дохионы хэлний чадвар ч мөн орно. Тиймээс багш нар хүүхдийн түвшинд тохируулан харилцах хэрэгтэй.

СЭДЭВ 4: МОНГОЛ ДОХИОНЫ ХЭЛНИЙ ТАНИЛЦУУЛГА ХИЧЭЭЛ

Зорилго: Монгол дохионы хэлээр анхан шатны түвшинд харилцаж сурах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Дохионы хэл, Монгол дохионы хэлний талаарх ойлголтыг тайлбарлах
- Сонсголгүй хүүхэдтэй ажиллаж буй багш нар дохионы хэл сурах зайлшгүй хэрэгцээтэйг ухамсарлах
- Монгол дохионы хэлний хурууны үсгийг нүдлэх, хурууны үсгээр үсэглэж сурах
- Монгол дохионы хэлээр харилцах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Компьютер, проектор, дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчдын тоогоор хэвлэх
- Дохионы хэлний аппликэйшн-MSL

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Дохионы хэл, түүний таван бүрдүүлбэр (30 минут)

1. Оролцогчдоос дараах асуултыг асууж ярилцана.
 - Дохионы хэл гэж юу вэ?
 - Та дохионы хэл мэдэх үү?
 - Таны эргэн тойронд дохионы хэлээр ярьдаг хүн бий юу?
 - Дохионы хэлээр харилцаж байсан хүмүүсийг харж байсан уу?
 - Хэрэв харж байсан бол танд ямар санагдсан бэ?
 - Ямар онцлог зүйл ажиглагдсан бэ?
2. Тэдэнд дохионы хэлний тодорхойлолт, дохионы хэлний 5 бүрдүүлбэрийн тухай тайлбарлана. Дохионы хэлний таван бүрдүүлбэртэй холбож төлөөний үгсийг заана. Багш дохиог биеэр үзүүлж, оролцогчид дуурайн хийнэ.
3. Дохионы хэлний таван бүрдүүлбэртэй холбож орон цагийн нэрсийг заана. Багш дохиог биеэр үзүүлж, оролцогчид дуурайн хийнэ.
4. Дохионы хэлний таван бүрдүүлбэртэй холбож мэндчилгээний үгсийг заана. Багш дохиог биеэр үзүүлж, оролцогчид дуурайн хийнэ.

Үйл ажиллагаа 2: Монгол хурууны үсгийн цагаан толгой (20 минут)

1. Монгол хурууны үсгийн цагаан толгойг сурна гэдгийг хэлж, монгол хэлний хурууны үсгийн цагаан толгойн талаар тайлбарлана. Мөн хурууны үсгээр үсэглэх дүрмийг товч танилцуулна.
2. Монгол хэлний хурууны үсгийн цагаан толгойг дэлгэцээр харуулж, багш биеэр үсэглэж үзүүлнэ. Оролцогчид багштай хамт үсэглэнэ. Үсэглэх явцад зарим дүрмийг тодруулж тайлбарлана (урт эгшиг, хос эгшиг, давхар гийгүүлэгч)
3. Оролцогчдыг хурууны үсгийн цагаан толгойгоо дахин харж, өөрсдөө давтаж хийхийг хүснэ. Хүн бүр өөрийн нэрийг хурууны үсгээр үсэглэж сурах даалгавар өгнө. 2-3 оролцогч нэрээ хурууны үсгээр үсэглэж, бусад нь уншина.

Үйл ажиллагаа 3: Монгол дохионы хэлээр өөрийгөө танилцуулах (25 минут)

1. Дохионы хэлээр өөрсдийгөө танилцуулж сурцгаая гэж хэлнэ. Багш өөрийгөө дохионы хэлээр танилцуулна.
2. Дохионы хэлээр асуулт хэрхэн асуудаг талаар товчхон тайлбар хэлнэ.
3. Сургалтад оролцогчдыг дохионы хэлээр өөрийгөө танилцуулахыг хүснэ. Таны нэр хэн бэ? Та хаанаас ирсэн бэ? гэх мэт асуултууд асууж, оролцогчид асуултад дохионы хэлээр хариулна.

Үйл ажиллагаа 4: Монгол дохионы хэлний аппликэйшнийг танилцуулах, хэрхэн ашиглах талаар тайлбар өгөх (10 минут)

1. Гар утсан дээрээ MSL- Монгол дохионы хэлний аппликэйшн татах
2. Ангилал хайх
3. Үг хайх

Дүгнэлт (5 минут)

Багш дохионы хэлээр тухайн өдөр үзсэн сэдвийн хүрээнд дохино. Оролцогчид хараад орчуулна.

ХАВСРАЛТ 1

ДОХИОНЫ ХЭЛНИЙ ТУХАЙ

Улс орон, бүс нутгаасаа шалтгаалаад дэлхий дээр олон тооны дохионы хэл байдаг. Дохионы хэл нь олон улсын нийтлэг систем биш юм. Өөрөөр хэлбэл, монгол дохионы хэл мэддэг сонсголгүй хүн япон дохионы хэл мэддэг сонсголгүй хүнтэй шууд харилцаад ойлголцох боломжгүй. Улс орон бүр өөр өөрийн гэсэн онцлог бүхий дохионы хэлтэй байдаг. Үүний адил манай улс ч гэсэн өөрийн улсын хэл, соёлын онцлог бүхий Монгол дохионы хэлтэй. Дохионы хэл нь ярианы хэлний нэгэн адил хэлний бүх нэгж, бүтэцтэй бөгөөд дэлхийн олон улс оронд дохионы хэлийг хэл шинжлэлийн хувьд хэл хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг.

Дохионы хэлний таван бүрдүүлбэр

- Гарын хэлбэр
- Алганы байрлал
- Байрлал
- Хөдөлгөөн, үүн дээр үгэн бус илэрхийлэл буюу нүүр хувирал нэмэгдээд эдгээрийг дохионы хэлний таван бүрдүүлбэр гэж нэрлэдэг.

Дохионы хэлээр үгийг зөв дохихын тулд дээрх дээрх таван бүрдүүлбэрээр зөв илэрхийлэх ёстой.

Төлөөний үг:


- Би/ бид; Чи; Та/ та нар
- Миний; Манай; Танай; Таны
- Бид; Тэд

Орон цагийн нэр:

- Хаана; Хэзээ; Хаашаа

Мэндчилгээ:

- Сайн байна уу? / Сайн байцгаана уу?; Сайн/ сайхан
- Сонин юу байна?; Бие сайн уу? Ажил, амьдрал сайн уу?
- Хичээл, сурлага өндөр үү?; Сургалт амжилттай юу?
- Мэнд хүргэе! /өглөө, өдөр, орой, төрсөн өдөр/
- Баярлалаа
- Баяртай
- Уучлаарай
- Дараа уулзъя



МОДУЛЬ 5:

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ



Зорилго	Тулгуур хөдөлгөөний бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэгээ нэмэгдүүлж, тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцэх хүртээмжтэй орчин бүрдүүлэх ба тэдэнтэй ажиллах арга зүйд суралцах
Зорилт	<ul style="list-style-type: none"> ▪ Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах талаар үндсэн ойлголттой болох ▪ Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжтэй сургалтын орчин хэрхэн бүрдүүлэх талаар тайлбарлах ▪ Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжих арга зүйг эзэмших ▪ Багш, эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх
Хугацаа	6 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлог (90 минут)</p> <p>Сэдэв 2. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх (90 минут)</p> <p>Сэдэв 3. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах стратеги (90 минут)</p> <p>Сэдэв 4. Багш, эцэг эхтэй хамтран ажиллах стратеги (90 минут)</p>	

СЭДЭВ 1: ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Зорилго: Тулгуур хөдөлгөөний бэрхшээл, түүний онцлог, сурах үйл явцад хэрхэн нөлөөлдөг болохыг тайлбарлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тулгуур хөдөлгөөний болон хавсарсан бэрхшээл, түүний нийтлэг шалтгааны талаар ерөнхий ойлголттой болох
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий онцлогийг танин мэдэх
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээл нь цэцэрлэг, сургуульд сурах үйл явцад хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлох

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Багшид зориулсан материал
- Хавсралт 2: Тараах материалд байгаа мэдээлэл бүрийг карт хэлбэрээр А4-ийн 1/2 хэмжээтэй цаасан дээр хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тулгуур хөдөлгөөний ба хавсарсан бэрхшээлийн талаарх ойлголт (30 минут)

1. Тус сэдвийн хүрээнд тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаар судална гэдгийг хэлж, оролцогчдоос энэ талаар юу мэдэхийг асууж, ярилцана.
2. Оролцогчдыг 3 багт хуваана. Баг тус бүрт дараах асуултаас нэг нэгийг оноон өгч, багаараа ярилцан өөрсдийн санааг дэлгэц цаасан дээр бичихийг хүснэ.
 - Тулгуур хөдөлгөөний бэрхшээл гэж юуг хэлэх вэ?
 - Хавсарсан бэрхшээл гэж юуг хэлэх вэ?
 - Тулгуур хөдөлгөөний бэрхшээл үүсгэх нийтлэг шалтгаан юу вэ?
3. Баг тус бүр бичсэн зүйлээ ээлжлэн танилцуулна. Бусад багаас асууж тодруулах болон нэмэх зүйл байгаа эсэхийг лавлана. Шаардлагатай тохиолдолд багш хавсралт 1-д байгаа мэдээллийг ашиглан нэмж тайлбарлана.

Үйл ажиллагаа 2: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг тодорхойлох (55 минут)

1. Танхимын ханан дээр “Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлог”, “Тулгуур хөдөлгөөний бэрхшээлийн сурах үйл явцад үзүүлэх нөлөө” гэсэн гарчгийг өөр хооронд нь зайтай байрлуулна.
2. Оролцогчдыг 5 багт хуваана. Баг тус бүрт хавсралт 2-т байгаа урьдчилан хольж бэлдсэн картуудаас ойролцоогоор 5-6 ширхгийг оноож өгнө. Эдгээр карт тус бүрийг дээрх 2 гарчгийн алинд нь хамаарахыг хамтран ярилцаж, тохирох хэсэгт байрлуулна.
3. Ханан дээр байрлуулсан карт нэг бүрийг зөв байрлуулсан эсэхийг бүгдээрээ хамтран ярилцана.
4. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд ямар онцлогтой байдаг, тухайн бэрхшээл нь хүүхдийн сурах үйл явцад хэрхэн нөлөөлж болох талаар багш нэгтгэн тайлбарлана.

Дүгнэлт: (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Та бүхэн тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаар бусдад хэрхэн тайлбарлах вэ?
- Ердийн цэцэрлэг, сургуульд сурах тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн талаар багш юу мэдэж байх хэрэгтэй вэ?

ХАВСРАЛТ 1

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БОЛОН ХАВСАРСАН БЭРХШЭЭЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Тулгуур хөдөлгөөний бэрхшээл гэдэг нь биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх, биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар алдагдсаны улмаас амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй болохыг хэлнэ.

Нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол хавсарсан хөгжлийн бэрхшээлд хамруулна (Тухайлбал, оюун ухааны болон тулгуур хөдөлгөөний хавсарсан бэрхшээлтэй байж болно).

Тулгуур хөдөлгөөний бэрхшээлийн нийтлэг шалтгаанд төрөлхийн болон олдмол өвчин эмгэг, осол гэмтэл орно. Тухайлбал: тархины олдмол гэмтэл (цус харвалтын дараах), нугасны гэмтэл, тархины саажилт, нугасны ивэрхий, нэг ба түүнээс дээш мөчдийн тайралт, булчингийн дистрофи, чихрийн шижин, ясны сүрьеэ, түлэгдэл, хугарал гэмтэл гэх зэрэг. Зарим бэрхшээл нь нүдэнд шууд харагдахуйц байдаг бол зарим нь гаднаас нь хараад мэдэх боломжгүй байдаг.

Тулгуур хөдөлгөөний зарим бэрхшээл аажмаар улам хүндрэх тохиолдол байдаг бол зарим нь үе үе хүндэрч, эсвэл намжмал байдалтай байдаг. Тулгуур хөдөлгөөний зарим бэрхшээл суралцагчдын сурах үйл явц, чадварт нөлөөлөхгүй байж болох ба тэдэнд зөвхөн туслах хэрэгсэл шаардлагатай байх ч тохиолдол бий. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагч бүрийг тусад нь үнэлж, тэдний өвөрмөц хэрэгцээнд тулгуурлан боломжит тохируулга хийх шаардлагатай байдаг.

ХАВСРАЛТ 2

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

- Нэг ба түүнээс олон мөчний хөдөлгөөний чадвар алдагдах
- Том булчингийн хөдөлгөөний чадвар алдагдах
- Булчингийн хүчдэл буурах
- Биеийн тэнцвэр алдагдах
- Бие даан алхах, явах, гүйх зэрэг үйлдэл хязгаарлагдмал болох
- Босох, суух, зогсох зэрэг биеийн байрлалтай холбоотой хүндрэл үүсэх
- Жижиг, нарийн хөдөлгөөн хийх чадвар буурах эсвэл алдагдах
- Рефлекст буюу автомат үйлдэл (толгой, гар хөлийн удирдлагагүй хөдөлгөөн, бие засах гэх зэрэг)
- Гараараа аливаа зүйлийг барих, удирдах чадваргүй байх
- Юм залгих эсвэл ярих чадвар алдагдах

- Бие даан хооллох чадвар алдагдах
- Сонсголгүй эсвэл сул сонсголтой байх
- Хэл ярианы бэрхшээл үүсэх
- Амархан ядрах
- Туслах хэрэгсэл (таяг, тэргэнцэр зэрэг) ашиглах
- Удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэх
- Хараагүй эсвэл сул хараатай байх
- Өдөр бүр эмийн бодис хэрэглэх
- Эрүүл мэндийн тусламж, асаргаа шаардах
- Амьсгалын аппарат зэрэг төхөөрөмж хэрэглэх

Сурах үйл явцад үзүүлэх нөлөө

- Үзэг харандаа барьж, бичих чадвар буурах, алдагдах
- Ном, дэвтрийн хуудас эргүүлж чадахгүй байх
- Бусадтай харилцахад хүндрэлтэй
- Аялал экскурсээр явахад хүндрэлтэй
- Сургалтын техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүн ашиглахад бэрхшээлтэй
- Барилга байгууламж, өрөө тасалгаа руу орох, гарах боломж хязгаарлагдмал
- Сонсгол, хараагаар мэдээлэл хүлээн авч чадахгүй
- Стандарт хэмжээтэй хэвлэмэл материалыг унших боломжгүй
- Хичээлээс завсардах
- Стандарт ширээ сандал хэрэглэх боломжгүй
- Хичээлээс хоцрох
- Хүлээн авсан мэдээллээ боловсруулах чадвар буурах, алдагдах
- Сурах итгэлгүй болох
- Нийтийн тээврийн хэрэгсэл ашиглах боломжгүй
- Тэргэнцэртэйгээ явах, өрөө тасалгаа руу орох, гарахад хүндрэлтэй
- Лабораторийн эд зүйл тоног төхөөрөмжид хүрэх, ажиллахад хүндрэлтэй байх
- Шалгалт өгөхөд нэмэлт хугацаа шаардах
- Асуулт асуух болон хариулахад илүү урт хугацаа шаардагдах

СЭДЭВ 2: ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

Зорилго: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явц дахь хэрэгцээ, түүнд нийцэх сургалтын орчин бүрдүүлэх талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцад үүсэх нийтлэг хэрэгцээг таньж мэдэх, тодорхойлох
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурч буй цэцэрлэг, сургуулийн орчныг үнэлэх, туслах хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хүртээмжтэй орчныг хэрхэн бүрдүүлэх талаар тайлбарлах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Үнэлгээний хуудсыг 2 хувь олшруулах
- Хавсралт 2: Үнэлгээний хуудсыг 2 хувь олшруулах
- Хавсралт 3: Тараах материал 3А, 3Б, 3В, 3Г, 3Д тус бүрийг нэг хувь хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн нийтлэг хэрэгцээг тодорхойлох (20 минут)

1. Оролцогчдыг 5 багт хуваана. Баг тус бүрт өмнөх сэдвийн хүрээнд ашигласан тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн онцлог болон сурах үйл явцад үзүүлэх нөлөөг илэрхийлсэн картуудыг хольж, ойролцоо тоогоор хувааж өгнө. Багууд өөрт оногдсон карт бүртэй холбоотой хэрэгцээг тодорхойлж, дэлгэц цаасан дээр бичнэ.
2. Багууд хийсэн зүйлээ ээлжлэн танилцуулна. Баг тус бүрийн танилцуулгын дараа доорх асуултын дагуу ярилцана:
 - Тус багийн танилцуулсан зүйлтэй санал нийлж байна уу?
 - Тухайн бэрхшээлтэй хүүхдийн онцлог болон сурах үйл явцад тус бэрхшээлийн үзүүлэх нөлөөтэй энэхүү хэрэгцээ уялдаж байна уу?
 - Үүнээс өөр хэрэгцээ байж болох уу? Тийм бол ямар хэрэгцээ байж болох вэ?

3. Дээрх байдлаар бүх багийн ажлыг хамтран хэлэлцэнэ. Дараа нь тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэг, сургуульд сурахад ямар хэрэгцээ үүсэж болохыг нэгтгэн тайлбарлахыг 1-2 оролцогчоос хүснэ. Бусад оролцогчдоос нэмэх зүйл байгаа эсэхийг асууна.

Үйл ажиллагаа 2: Орчны хүртээмжийг үнэлэх ба туслах хэрэгслийн хэрэгцээг тодорхойлох (40 минут)

1. Оролцогчдыг 6 багт хуваана. Баг тус бүрт дараах даалгаврыг оноож, тэдэнд 15-20 минутын хугацаа өгнө.
 - 1 ба 4 дүгээр баг цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн орчны хүртээмжийг үнэлэх хуудсыг (хавсралт 1) ашиглан нэг сургуулийн жишээн дээр үнэлгээ хийж, түүнд тулгуурлан цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн орчныг хүртээмжтэй болгохын тулд хийх зүйлсийн жагсаалт гаргана.
 - 2 ба 5 дугаар баг тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй нэг бодит хүүхдийн жишээн дээр туслах хэрэгслийн хэрэгцээг багшийн өгсөн хуудсыг (хавсралт 2) ашиглан тодорхойлно. Тус хүүхдийн жишээн дээр тулгуурлан цэцэрлэг, сургуульд зайлшгүй шаардлагатай туслах хэрэгслийн жагсаалт гаргана.
 - 3 ба 6 дугаар баг цэцэрлэг, сургуулийн хүрээнд хүртээмжтэй орчин хэрхэн бүрдүүлэх механизм буюу авах арга хэмжээ, зохицуулалт, удирдлага зохион байгуулалтын тодорхой бүтэц загвар, зураглал боловсруулна.
2. Багууд хийсэн ажлаа ханан дээр байрлуулна. Баг бүр багшийн өгөх дохиогоор нар зөв тойрон явж бусад багийн хийсэн ажилтай танилцана.
3. Бүх багийн ажилтай танилцсаны дараа бүгд хамтран нэгтгэн дүгнэж ярилцана.

Үйл ажиллагаа 3: Тохирох хэрэглэгдэхүүн (25 минут)

1. Оролцогчдыг 5 багт хувааж, баг тус бүрт хавсралт 3А, 3Б, 3В, 3Г, 3Д хавсралтаас нэг нэгийг өгнө.
2. Баг бүр өөрт оногдсон зүйлийг судалж, урьдчилан слайд болгон бэлдсэн зураг ашиглан, зориулалт болон зааврыг бусдадаа танилцуулна.
3. Танилцуулгын дараа багш дараах асуултыг асууж, ярилцана.
 - Эдгээрээс аль нь бидэнд нэн тэргүүнд хэрэгцээтэй вэ?
 - Алийг нь бид худалдан авах боломжтой вэ?
 - Алийг нь санаа авч, орон нутгийн нөөц боломжоо ашиглан хийж болох вэ?

4. Дараах асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ.

- Цэцэрлэг, сургууль дээр тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хүртээмжтэй орчин бүрдүүлэх, шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг хэрхэн зохион байгуулах вэ?
- Та бүхэн өөрсдийн орон нутаг, цэцэрлэг сургууль дээрээ хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүн бий болгохын тулд юу хийх боломжтой вэ?

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцтай холбоотой хэрэгцээг заавал тодорхойлох ёстой юу? Хэрвээ тийм бол хэн, хэзээ, хэрхэн тодорхойлох ёстой вэ?
- Цэцэрлэг, сургуулийн хүрээнд хүртээмжтэй орчин бүрдүүлэх ажлыг хэн хариуцан зохион байгуулах вэ? Үүнд шаардлагатай хөрөнгө төсвийн асуудлыг хэрхэн шийдэх вэ?
- Эдгээртэй холбоотой хууль эрх зүйн ямар зохицуулалт байдаг вэ?

ХАВСРАЛТ 1

ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН ОРЧНЫ ХҮРТЭЭМЖИЙГ ҮНЭЛЭХ ХУУДАС

Цэцэрлэг, сургуулийн нэр: _____ Он/сар/өдөр: _____

Нийт суралцагчдын тоо: _____ Эрэгтэй: _____ Эмэгтэй: _____

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо: _____ Эрэгтэй: _____ Эмэгтэй: _____

Нийт багш, ажилтны тоо: _____ Багш/ багш бус ажилтны тоо: _____

Тусгай хэрэгцээт боловсролын багшийн тоо: _____

Хөгжлийн бэрхшээлтэй багш, ажилтны тоо: _____

Нэр	Албан тушаал	Хөгжлийн бэрхшээлийн төрөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд:

Нэр	Хүйс	Анги	Хөгжлийн бэрхшээлийн төрөл

Цэцэрлэг, сургуулийн хүртээмжтэй байдал

Орц/ гарц	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Явган хүний зам болон бусад замын хоорондох хашлага, шат гишгүүрийн бүх түвшинд налуу зам бий юу?			
а) Сургуулийн ойр орчмын болон сургууль доторх явган хүний гарцад?			
б) Сургуулийн гаднах болон доторх машины зогсоолд?			
в) Сургуулийн орох, гарах хаалган дээр?			
Сургуулийн хаалга/орц, гарцын орчим саад учруулах ямар нэгэн зүйл байгаа эсэх (машин тавьсан, савтай цэцэг байрлуулсан, нүх байх зэрэг)			
Сургуулийн орчин тойрны талбай тэгш гадаргуутай, үргэлж цэвэрлэж арчилдаг уу?			
Налуу зам	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Шатны хажууд налуу зам бий юу?			
Налуу зам хаана байгааг харуулсан тодорхой тэмдэглэгээ бий юу?			
Налуу зам стандартын дагуу налуу хийгдсэн үү?			
Налуу зам халтиргаагүй/матт өнгөлгөөтэй юу?			
Налуу замын 2 талд тэргэнцэр унахаас хамгаалсан хашлага хамгаалалт бий юу?			

Шат	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Шатны байршлыг харуулсан, ойлгомжтой, тодорхой тэмдэглэгээ бий юу?			
Шатны өргөн хамгийн багадаа 1200 мм байна уу?			
Шатны 2 талын үргэлжилсэн бариул шалнаас 760-900 мм байна уу?			
Шатны бариул барихад хялбар 38-45 мм диаметртэй юу?			
Сул хараатай хүүхэд харахад хялбар байх үүднээс шатны бариул нь хананаас ялгагдахуйц өөр өнгөөр будагдсан уу?			
Шатны гишгүүрийн ирмэг нь харааны бэрхшээлтэй хүүхэд ялгаж харах боломжтой өөр өнгөтэй, өөр материалаар хийгдсэн үү?			
Аваарын шатны байршлыг харуулсан, олж харахад хялбар тэмдэглэгээ бий юу?			
Шатны гишгүүр/алхам хооронд онгорхой зай байхгүй эсэхийг баталгаажуулсан уу?			
Шатны алхмын өндөр 150 мм ба түүнээс бага уу?			
Шатны доорх хөндий зайг бөглөсөн үү?			
Коридор	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Коридор саадгүй бөгөөд 1200 мм-ээс багагүй өргөнтэй юу?			
Коридорын хананаас 100 мм-ээс дээш өргөнтэй зүйл байхгүй эсэхийг нягталсан уу?			
Шалнаас хамгийн багадаа 2200 мм-ээс дээш өндөрт эд зүйлийг тогтоон байрлуулж, толгойд саад учрахааргүй зайтай юу?			
Тэмдэглэгээ	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Давхар бүрт хэд дэх давхар гэдгийг бичсэн тэмдэглэгээ байдаг уу?			
Анги танхим болон сургуулийн бусад өрөө тасалгааны байршлыг харуулсан тэмдэглэгээ байдаг уу?			
Бүх тэмдэглэгээ брайль үсэг болон текст бичвэр ашигласан уу?			
Тэмдэглэгээг шалнаас 1000-1600 мм өндөрт байрлуулсан уу?			
Охид, хөвгүүдийн нийтийн ариун цэврийн өрөөнд зориулсан тэмдэглэгээ байдаг уу?			
Охид, хөвгүүдэд зориулсан хүртээмжтэй ариун цэврийн өрөөний тэмдэглэгээ бий юу?			

Хаалга	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Хүүхдүүд хаалгыг амархан онгойлгож, хааж чадах уу?			
Гялгар/шилэн бүрхүүлтэй хаалган дээр харааны бэрхшээлтэй хүүхдийн харааны түвшинд өнгөт туузан дээр байрлуулсан тэмдэглэгээ бий юу?			
Хоёр хавтастай хаалганы хувьд тэргэнцэртэй хүмүүст нэг хавтсыг нээхгүйгээр орж/гарч болохуйц өргөн нь дор хаяж 900 мм байна уу?			
Хаалганы хэрэгслүүд (барил, цоож) шалнаас 800мм-1000мм өндөрт байрладаг уу?			
Үүдний дэвсгэрийн ирмэгийг шалан дээр аюулгүй бэхэлсэн үү?			
Хаалганы босго 10 мм-ээс ихгүй өндөр, налуу (огцом налуу биш) байна уу?			
Самбар	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Ангиудад самбар бий юу?			
Тэргэнцэртэй хүүхэд ашиглах боломжийг бүрдүүлэн самбарын доод ирмэг шалнаас 500 мм-ээс дээшгүй бус зайд байрлуулсан уу?			
Цонх	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Цонхнууд нь коридор руу биш, анги болон бусад өрөө рүү нээгддэг үү?			
Цонхны өндөр нь 600 мм (доод ирмэг) ба 1450 мм (дээд ирмэг) хооронд буюу хүүхэд сууж байхдаа гаднах зүйлийг харах боломжтой юу?			
Хүүхдийг унахаас хамгаалахын тулд цонхонд сараалж/ тор байрлуулсан уу?			
Шал	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Сургуулийн шал халтиргаанаас хамгаалагдсан уу?			
Ариун цэврийн өрөөний шалыг гулсахаас хамгаалсан уу?			
Ариун цэврийн өрөөний шалан дээрх усыг зайлуулах хоолой байдаг уу?			
Ундны ус	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Ундны усны талбайн хэсэг тэгш гадаргуутай (жишээ нь шат байхгүй) юу?			
Түвшний гадаргуугаас 400 мм-ийн өндөрт нэг цорготой, хүртээмжтэй ундны усны төхөөрөмж байна уу?			
Цорго нь хөшүүрэг бүхий бариултай юу?			
Ундны усны эргэн тойронд асгарсан илүүдэл усыг зайлуулах боломжтой юу?			
Хүүхдийн хөдөлгөөнийг дэмжих хэрэгсэл дээр цоргоны ус асгарахгүй байхаар зохицуулагдсан уу?			

Ариун цэврийн өрөө	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Ариун цэврийн өрөөнд хүртээмжтэй налуу зам бий юу?			
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бие засах газар (хөвгүүд, охидын бие засах газар тус бүр нэг) байдаг уу?			
Ариун цэврийн өрөөний кабины хэмжээ нь хамгийн багадаа 2000 мм x 2200 мм байна уу?			
Ариун цэврийн өрөө, угаалтуурын эргэн тойронд 1500 x 1500 мм хэмжээтэй тэргэнцэртэй маневр хийх хангалттай зай байгаа юу?			
Угаалтуурыг шалнаас (дээд ирмэг) 700мм-800мм өндөрт суурилуулсан уу?			
Толины доод ирмэгийг шалнаас 1000 мм өндөрт байрлуулсан уу?			
Ариун цэврийн өрөөний ойролцоо бариул (ханан талдаа L хэлбэртэй, жорлонгийн задгай талд U хэлбэртэй) байдаг уу?			
Бүх бариулууд шалнаас 700мм-800мм өндөрт байна уу?			
Ариун цэврийн өрөө дохиоллын системээр тоноглогдсон уу?			
Хаалгыг дотроос нь түгжиж, онцгой нөхцөлд гаднаас нь онгойлгох боломжтой юу?			
Ариун цэврийн өрөөний усыг татахад хялбар уу?			
Ариун цэврийн өрөөний хаалга нь 900м ба түүнээс дээш өргөнтэй юу?			
Ариун цэврийн өрөөний хаалга гадагшаа онгойдог уу?			
Ариун цэврийн өрөөний суултуур шалнаас 450мм-480мм өндөрт байна уу?			
Тоглоомын талбай	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Тоглоомын талбай бий юу?			
Тоглоомын талбай зүлгээр хучигдсан уу?			
Тоглоомын талбай нь тэргэнцэр/таяг/алхагч хэрэглэдэг хүн явах боломжтой, хамгийн багадаа 1800мм өргөнтэй, хатуу хучилттай замтай юу?			
Онцгой байдалд бэлэн эсэх	Тийм	Үгүй	Тэмдэглэгээ
Яаралтай онцгой тохиолдолд ашиглах гарцыг сумаар чиглүүлэн зааж харуулсан тодорхой тэмдэглэгээ бий юу?			
Бүх газарт дуут болон нүдээр харах боломжтой яаралтай үед хэрэглэх дохиолол байдаг уу?			

ХАВСРАЛТ 2

ТУСЛАХ ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ ХУУДАС

Цэцэрлэг, сургуулийн нэр: _____ Он/сар/өдөр: _____

Суралцагчийн нэр: _____ Эрэгтэй: _____ Эмэгтэй: _____

Хөгжлийн бэрхшээлийн төрөл: _____ Суралцаж буй анги: _____

Бичихэд туслах хэрэгсэл	Тоо бодоход туслах хэрэгсэл
<input type="checkbox"/> Үзэг/ харандаа барихад туслах хэрэгсэл	<input type="checkbox"/> Тоо
<input type="checkbox"/> Тохируулгатай дэвтэр, цаас (Тод шугамтай, мөрийг тодруулсан)	<input type="checkbox"/> Ярьдаг тооны машин
<input type="checkbox"/> Бичгийн машин	<input type="checkbox"/> Сампин
<input type="checkbox"/> Дэвтэр, номын налуу тавиур	<input type="checkbox"/> Дэлгэц дээр харах боломжтой тооны машин
<input type="checkbox"/> Компьютер	<input type="checkbox"/> Том товчлуууртай тооны машин
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/> Хэмжүүрийн дуугардаг хэрэгсэл /шугам, цаг/
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/> Брайль шугам
Хүртээмжтэй компьютер	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/> Гар дэмжигч	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/> Компьютерын тусгай гар (зүүн/баруун)	Уншихад туслах хэрэгсэл
<input type="checkbox"/> Компьютерын тусгай хулгана	<input type="checkbox"/> Текстийг хэмжээ, өнгө, дэвсгэр өнгө зэргийг тохируулан өөрчлөх боломжтой төхөөрөмж
<input type="checkbox"/> Компьютерын гар дээр ажиллах тусгай заагуур (толгойны, амны гэх зэрэг)	<input type="checkbox"/> Хуудсыг эргүүлэхэд тохируулан өөрчилсөн ном, гарын авлага
<input type="checkbox"/> Үг урьдчилан таамаглаж илэрхийлдэг программ	<input type="checkbox"/> Ном, дэвтрийн хуудас эргүүлэгч
<input type="checkbox"/> Дуу хоолой, үгийг ялгаж таних программ	<input type="checkbox"/> Зураг болон текстийг зэрэгцүүлэн харуулсан ном гарын авлага
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/> Хэлэхэд төвөгтэй хэцүү үгийг хэлэх төхөөрөмж
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/> Сканер болон хөрвүүлж ярьдаг программ
Бичгээр даалгавар гүйцэтгэх	<input type="checkbox"/> Электрон номууд
<input type="checkbox"/> Үгийн картууд	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/> Толь бичиг	<input type="checkbox"/>
<input type="checkbox"/> Цахим, ярьдаг толь	Суралцахад туслах хэрэгсэл
<input type="checkbox"/> Дүрмийн алдаа шалгагч программ /цахим	<input type="checkbox"/> Хичээлийн хуваарь (үгээр/зургаар)
<input type="checkbox"/> Дуу хоолойг таньж бичгээр хөрвүүлэгч	<input type="checkbox"/> Сургалтын хэрэглэгдэхүүн

Санаагаа илэрхийлэхэд зориулсан
мультимедиа программ

Хэрэглэгдэхүүнийг хялбархан олоход
зориулсан өнгөөр ялгасан тусгаарлагчтай
хавтас

Текстиг тодруулагч /цаасан наалт,
тодруулагч маркер, шугам зэрэг/

Харилцаанд туслах хэрэгсэл

Харилцах самбар /зургаар илэрхийлсэн ном/
үсэг/ үгс

Дасгал даалгавар, үйл ажиллагааны
дараагийн алхам руу шилжихийг сануулах
дуутай дохио өгөх хэрэгсэл

Нүдээр харах самбар

Дуу хураагчид бичсэн ном, сурах бичиг, гарын
авлага гэх зэрэг

Дуу хоолойгоор илэрхийлэх төхөөрөмжүүд

ХАВСРАЛТ 3А

Булчин хөгжүүлэх тоглоомууд



Зориулалт: Тоглоомууд нь цэцэрлэгийн насны болон бага ангийн хүүхдийн хөдөлгөөний эвсэл, гар, хөл, нуруу болон бусад эрхтнүүдийн булчингийн үйл ажиллагааг сайжруулах, хөгжлийг дэмжихэд чухал үүргийг гүйцэтгэнэ. Тоглоомууд нь хүүхдийн эрүүл мэндэд хоргүй, хүүхдийн тоглоомд тавигдах монгол улсын стандартыг хангасан, хяналтын байгууллагын лабораторийн дүгнэлттэй байна. Тоглоомууд нь барихад эвтэйхэн, жижиг хэсэггүй байх хэрэгтэй.

Ашиглах заавар: Тоглоомыг угсрах, хэлхэх, үдэх, товчлох зэрэг тоглоомууд нь гарын жижиг булчинг хөгжүүлдэг тул сургалтын бүх л хэлбэрт өргөн ашиглана. Гарын саажилттай хүүхдэд том ширхэгээс бүтсэн тоглоомыг ашиглана. Бүх төрлийн бөмбөлгүүдийг сэргээн засах хичээлүүд дээр өргөн ашиглана.

Бөмбөгний нүхтэй самбар /шийд/

Зориулалт: Хүүхдийн харааны хүртэхүй, гарын булчин, оновчтой хөдөлгөөнийг хөгжүүлэх зорилготой.

Ашиглах заавар: Самбар дээр байгаа том, жижиг нүх рүү бөмбөгийг оновчтой шидэж оруулна. Хавтанг шалан дээр байрлуулж бэхэлнэ.



Алхалтын шат, хана

Зориулалт: Шатаар өгсөх, уруудах, тэгш гадаргуу дээр алхах хөдөлгөөний чадварыг сайжруулах, хөлийн булчингийн хөгжлийг дэмжих, зүрхний ачаалал, хэмнэлийг тэнцвэржүүлэх, нөхөн сэргээхэд зориулагдсан хэрэглэгдэхүүнүүд юм.



Ашиглах заавар: Алхалтын шат нь өөр өөр өндөртэй байдаг бөгөөд энэ нь анхаарал шаарддаг. Налуу хавтгай дээр хөдөлгөөн хийж сургахад ашигладаг. Алхалтын ханыг тэгш гадаргуу дээр явж сургахад өргөнөөр хэрэглэнэ. Хүүхдийн хөлийн булчинг хөгжүүлэх зорилгоор сургалтад ашиглана. Өгсөх, уруудах, алхах зэрэг хөдөлгөөн хийх итгэл төрүүлэх үүднээс бариулаар тоноглогдсон байдаг. Бариулын өндрийг тохируулж болно. Мөн тод өнгөөр будсан нь харааны бэрхшээлтэй бол ашиглахад хялбар болно.

ХАВСРАЛТ 3Б



Савлуур

Зориулалт: Савлуур нь хөдөлгөөнөө зохицуулах, биеийн тэнцвэрээ олж сургахад ач холбогдолтой.


Ашиглах заавар: Савлуурыг ганцаарчилсан болон хэсгээр ажиллах үед ашиглаж болно. Савлуурын сандал нь 3 төрөлтэй. Үүнд: Бөөрөнхий, дөрвөлжин байхаас гадна толгойны хамгаалалт, хантааз бүхий эмчилгээний гэсэн гурван төрөл байдаг.

Уян тууз

Зориулалт: Уян тууз нь булчингийн уян хатан байдлыг сайжруулах, хүч чадал, тэсвэр тэвчээрийг бий болгох, хүнд хэрэгсэл ашиглахгүйгээр булчингийн сунгалтын дасгал хийхэд зориулагдсан тальк багатай, удаан эдэлгээтэй резинээр (латекс) хийсэн спортын хэрэгсэл юм.



Мэдрэгчтэй хавтангууд



Зориулалт: Энэхүү бүтээгдэхүүн нь хүүхдийн хүрэлцэх мэдрэмж, хөдөлгөөний чадвар, уян хатан байдлыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг. Биеийн хөдөлгөөнийг нөхөн сэргээх үйлчилгээтэй хэрэгсэл юм.

Ашиглах заавар: Мэдрэгчтэй замууд нь сонирхолтой, хэлбэр, бүтэц өөр өөр гурван хэмжээст мэдрэгчтэй хавтангаас бүрдэнэ. Хавтан тус бүрийн суурь нь өндөр чанартай хус модон шахмалаар хийгдсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан хөлийн болон биеийн хүртэх мэдрэхүйг хөгжүүлэх зорилгоор дасгал, хөдөлгөөн хийх боломжтой.

Харандаа, үзэг бэхлэгч

Зориулалт: Харандаа, үзгийг гараас салгахгүйгээр бэхэлж өгөх зориулалттай.

Ашиглах заавар: Хүүхдийг бичих, зурах үед харандаа, үзгийг гарын хуруунд бэхэлж өгснөөр харандааг унагахгүй зурах, бичих боломж олгоно. Гар саажилттай үед тухайн хэрэгслийг сургалтад өргөнөөр ашиглана.



ХАВСРАЛТ ЗВ



Хурууны багс

Зориулалт: Багсыг хуруундаа салгахгүйгээр өмсөнө.

Ашиглах заавар: Хүүхэд зурах, будах үед ашиглана. Гар саажилттай үед тухайн хэрэгслийг

сургалтад өргөнөөр ашиглана.

Үзэг, харандааг барихад туслах хэрэгсэл



Зориулалт: Харандаа, үзэг барихад хялбар болгох үүднээс харандаа, үзгийн бариулыг баруун болон солгой гартай хэрэглэгчдэд зориулан хийсэн. Хэлбэр, дүрс олон янз, гарыг ядрахаас сэргийлнэ.



Зөөлөн сандал

Зориулалт: Сандлыг тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийг амраах, завсарлагааны үед өргөн ашиглана. Хүүхдийн биеийн хэлбэрт орж, хэрэглэхэд хялбар, тааламжтай мэдрэмжийг өгнө. Зөөлөн, буцаж хэвэндээ амархан орно.



Эмчилгээний зориулалттай бөмбөгтэй сандал

Зориулалт: Эмчилгээний зориулалттай бөмбөгтэй сандал нь 55 см диаметртэй бөмбөг бүхий бэлтгэл хийх сандал юм. Энэхүү сандал нь хүүхдийн биеийн булчинг суллах зориулалттай хэрэгсэл. Биеийн ерөнхий хөгжлийг дэмжинэ. Хүүхдийг сандлын тусламжтай дасгал хийлгэнэ.

ХАВСРАЛТ 3Г



Дээд мөчний хөгжлийг дэмжих төхөөрөмж

Зориулалт: Хөдөлгөөний эвсэл, гарын булчин, хүчний хөгжлийг дэмжих зорилготой. Төхөөрөмж нь их бие, хөдөлгөөнтэй бариулуудаас бүтнэ.

Ашиглах заавар: Хөдөлгөөн, хүч чадлын зохицуулалтыг хөгжүүлдэг. Бариулыг татах замаар хөдөлгөж, булчинг бэхжүүлнэ. Хэмнэлтэй хөдөлгөөнүүд нь булчинг агшааж, сулруулна.

Нөхөн сэргээх сургалтын үед ашиглахад тохиромжтой.



Алхагч, хөлд оруулагч

Зориулалт: Хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийг хөлд оруулж, алхуулж сургах зорилготой.

Ашиглах заавар: Алхагч, хөлд оруулагч нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулагдсан. Дотор болон гадаа алхахад ашигладаг. Хүүхдийн биеийг босоо байрлалд оруулж зогсооно. Бие даан алхуулж, аажмаар явж сургах зорилготой.

Массажны сандал



Зориулалт: Ядаргаа тайлах /жүрж/, өвдөлт намдаах /ногоон/, тав тухтай мэдрэмж төрүүлэх.

Ашиглах заавар: Массажны өмнө бүх биеийг автоматаар сканердана. Цахим товчлуурын тусламжтайгаар нурууны хазайлт, хөлийн тулгуурыг тохируулна. Хөлийн түшлэг нь 20 градус хүртэл эргэлддэг бөгөөд энэ нь ядарсан, хавдсан шагайны өвчнийг арилгана. Массажны булын өргөнийг таны биеийн онцлогоос хамааран хүссэнээрээ тохируулж болно. Нэг удаагийн

үргэлжлэх хугацаа 20 минут, хэсэг тус бүр 5 минут байна. Аажмаар хугацааг нэмэгдүүлж болно. Массажны сандлыг автомат болон гар аргаар өөрийн сонголтоор эхлүүлж болно. Ерөнхий массаж, хүзүүний массаж, бугуй, гарын массаж, нурууны массаж, бүсэлхийн тойргийн массаж гэсэн дарааллаар хийнэ. Хөлийн массаж нь энэ хэсгийн цусны эргэлтийг сайжруулдаг.

ХАВСРАЛТ ЗД



Тэнцвэржүүлэгч мастер төхөөрөмж

Зориулалт: Тэнцвэржүүлэгч мастер төхөөрөмж нь хөдөлгөөний тэнцвэрийг бий болгоход чиглэгдсэн. Нэмэлт программ хангамж, хөдөлгөөн мэдрэгчийн тусламжтай нь интерактив тоглоомын аргаар хүүхдийн сонирхлыг өдөөж, урам зориг өгөхийн зэрэгцээ хөдөлгөөнийг сэргээн засахад үр дүнтэй төхөөрөмж юм.

Ашиглах заавар: Тэнцвэржүүлэгч мастер нь:

- Их бие болон бүсэлхий орчмын хөдөлгөөний тогтвортой байдлыг нэмэгдүүлэх
- Хөдөлгөөнийг тэнцвэржүүлэх
- Булчингийн чангарлыг багасгах
- Ясны сийрэгжилтээс урьдчилан сэргийлэх
- Ходоодны үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Үе мөч хөшихөөс сэргийлэх зорилгоор ашиглана.

Компьютерын техник хэрэгслийн багц




Компьютерын тусгай хэрэгслүүд



Компьютерийн алсын товчлуурууд



Утасгүй роллер



Компьютерийн гар /джойстик/



Толгойн хулгана

СЭДЭВ 3: ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ СТРАТЕГИ

Зорилго: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжихийн тулд багш тэдэнтэй хэрхэн ажиллах арга зүй, стратегийн талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн боловсролын болон эрүүл мэндийн хэрэгцээг үнэлэх
- Хэрэгцээнд тулгуурлан төлөвлөгөө боловсруулах
- Хичээлийн явцад тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах, хичээлийн үнэлгээ хийхэд анхаарах зүйлийн талаар бусдад тайлбарлах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1-5: Тараах материал тус бүрийг 2 хувь хэвлэх
- Хавсралт 6: Тараах материалыг 1 хувь хэвлэж, тасархай зураасны дагуу хайчилж бэлтгэх
- Хавсралт 7: Тараах материалыг 1 хувь хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хэрэгцээг үнэлэх тухай (20 минут)

1. Оролцогчдыг 6 багт хуваана. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахын тулд эхлээд боловсролын хэрэгцээг үнэлэх шаардлагатай, мөн эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээг мэдэх нь чухал гэдгийг хэлнэ. 1-3 дугаар баг боловсролын хэрэгцээний талаар, 4-6 дугаар баг эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээний талаар өөрсдийн мэддэг зүйл болон төсөөллөө хамтран ярилцаж, дэлгэц цаасан дээр жагсаан бичихийг хүснэ. Баг бүр өөрсдийн бичсэн зүйлээ хананд байрлуулна.
2. Хавсралт 1 ба 2-т байгаа тараах материалыг баг бүрт тарааж, уншиж танилцахыг хүснэ. Тус материалд тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн боловсролын болон эрүүл мэндийн хэрэгцээг үнэлэх тухай ерөнхий мэдээлэл байгаа гэдгийг тайлбарлана. Багууд өөрсдийн бичсэн жагсаалтад байгаа зүйлтэй харьцуулан санал бодлоо солилцоно.
3. Оролцогчдоос боловсролын болон эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээг үнэлэхтэй холбоотой асуулт асууж, хамтран ярилцана.

Үйл ажиллагаа 2: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах ерөнхий төлөвлөгөө боловсруулах (40 минут)

1. Өмнөх багаар үргэлжлүүлэн ажиллана. Баг тус бүр өөрсдийн мэдэх тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн жишээн дээр түүнтэй ажиллах төлөвлөгөө боловсруулна. Төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх үйл ажиллагаагаар гүйцэтгэсэн боловсролын болон эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээнд тулгуурлах ёстойг анхааруулна.
 - 1 ба 2 дугаар багт хавсралт 3-ыг,
 - 3 ба 4 дүгээр багт хавсралт 4-ийг,
 - 5 ба 6 дугаар багт хавсралт 5-ыг дэлгэц цаас, маркерын хамт оноож өгнө.
2. Хугацаа дуусмагц багууд өөрсдийн боловсруулсан төлөвлөгөөг хананд байрлуулж, танилцуулна. Оролцогчдоос тус үйл ажиллагаагаар өөрсдийн мэдэж авсан зүйлээ нэгтгэн дүгнэж хэлэхийг хүснэ.

Үйл ажиллагаа 3: Хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хичээл тус бүрээр боломжит тохируулгыг хэрхэн хийх тухай (25 минут)

1. Оролцогчдыг 5 багт хувааж, хавсралт 6 ба 7-д байгаа материалаас баг тус бүрт дараах байдлаар хуваарилна.
 - 1 дүгээр багт дуу хөгжим, дүрслэх урлаг хичээлийн хүрээнд хийх тохируулга
 - 2 дугаар багт эх хэл, уран зохиол
 - 3 дугаар багт эрүүл мэнд, биеийн тамир
 - 4 дүгээр багт математик, байгаль шинжлэл, технологийн хичээлийн хүрээнд хийх тохируулга
 - 5 дугаар багт хавсралт 7-д байгаа үнэлгээний тухай мэдээлэл
2. Баг бүр өөрт оногдсон материалыг уншиж судлаад, сургуулийн өмнөх боловсролын хүрээнд эдгээр тус бүртэй холбоотой хичээлийн хүрээнд болон үнэлгээнд ямар тохируулга хийж болох талаар саналаа нэмж, бусдадаа танилцуулахад бэлтгэнэ. Тэдэнд дэлгэц цаас, маркер тарааж өгнө.
3. Багууд бэлдсэн зүйлээ ээлжлэн танилцуулж дуусмагц дараах асуултын дагуу ярилцана.
 - Хичээл тус бүрийн хувьд хийх боломжит тохируулга хэр ижил төстэй эсвэл ялгаатай байна вэ?
 - Хэцүү буюу хүндрэлтэй зүйл байна уу? Тийм бол ямар зүйл байна вэ? Үүнийг хэрхэн шийдэх боломжтой вэ?
 - Эдгээрийг хийхэд хэн оролцох вэ? Үүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалт бий юу? Тийм бол ямар зохицуулалт байна вэ?

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах төлөвлөгөөг хэн боловсруулах вэ? Хэзээ боловсруулсан байх ёстой вэ?
- Ердийн сургуульд сурч буй тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай тохируулга хийхэд оролцогч талуудыг нэрлэнэ үү?

ХАВСРАЛТ 1

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн онцлогоос хамааран тухайн хүүхдийн боловсролын хэрэгцээг тодорхойлох үнэлгээний багт олон төрлийн нарийн мэргэжлийн хүмүүс орж болно. Тухайлбал: хөдөлгөөн засалч, хэл ярианы эмгэг судлаач, биеийн тамирын багш, сургуулийн эмч, мэдрэлийн эмч, ангийн багш, хичээл заадаг багш, тусгай хэрэгцээт боловсролын багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан гэх зэрэг.

Үнэлгээг дараах чиглэлийн хүрээнд хийнэ. Үүнд:

- Өдөр тутмын үйл ажиллагааг хийж гүйцэтгэх байдал: Өдөр тутмын үйл ажиллагаа болон өөртөө үйлчлэх чадварыг үнэлнэ. Тухайлбал, бие даан хооллох, бие засах, ариун цэвэр сахиу, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих гэх зэрэг.
- Хөдөлгөөний чадвар: Одоогийн нөхцөлд нэг байршлаас нөгөө рүү бие даан ганцаараа явж чадах; тэргэнцэр, таяг гэх зэрэг ямар нэгэн туслах хэрэгсэл шаардлагатай эсэхийг тодорхойлно.
- Бие эрхтний чадвар ба хязгаарлалт: Сургалтын үйл ажиллагаа, сургалтаас гадуурх үйл ажиллагаа, ажил хөдөлмөр хийх, бие даан гүйцэтгэх үйл ажиллагаа зэрэгтэй холбоотой тухайн хүүхдийн одоогийн болон ирээдүйн төлөвлөгөөнд нөлөөлөх бие эрхтний ямар нэгэн хүчин зүйл байгаа эсэхийг тодорхойлно.
- Нийгэм, сэтгэл зүйн хөгжил: Тухайн хүүхдийн нийгмийн болон сэтгэл зүйн хөгжил, бусадтай харилцах чадвар, боломжуудын талаар үнэлгээ хийнэ.
- Харилцаа: Хэл яриа ойлгох, өөрийгөө үг хэлээр илэрхийлэх чадварыг үнэлнэ. Харилцааны ямар нэгэн туслах хэрэгсэл, тухайлбал, компьютер тоног төхөөрөмж, харилцах самбар зэрэг хэрэгсэл шаардлагатай эсэхийг тодорхойлно.

- Академик чадвар: Бусад суралцагчийг үнэлдэгтэй адил үнэлгээг ашиглана. Үнэлгээ хийхдээ орчны болон цаг хугацааны хувьд тохируулга хийх, бичгээр шалгалт авахын оронд амаар авах зэргийг анхаарна.
- Суралцах үйл явцад дасан зохицох байдал: Бие даан суралцахад материаллаг орчны хувьд болон хичээлийн үйл явцтай холбоотой зайлшгүй хийх ямар тохируулга шаардлагатай болохыг тодорхойлно.
- Шилжилтийн үед шаардлагатай чадвар: Бусадтай хамт ажиллаж амьдрах, сургуулиас нийгмийн амьдралд болон олон нийтийн дунд амжилттай шилжихэд шаардлагатай хүчин зүйлсийг тодорхойлно. Энэ нь зөвхөн ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой бус, сургууль төгссөний дараа хэрэг болох чадваруудыг хамарсан байна.

ХАВСРАЛТ 2

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДТЭЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээг дараах үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлно. Үүнд:

Эрүүл мэндийн нөхцөл байдал:

- Үндсэн бэрхшээлээс гадна өөр ямар нэгэн дагалдах өвчин эмгэг байгаа эсэх
- Эм хэрэглэдэг эсэх? Өдөрт, ямар хэмжээгээр, хэдэн удаа?
- Сургууль дээр байх хугацаанд эмээ уух шаардлагатай бол үүнийг хэрхэн зохицуулах шаардлагатай вэ?
- Эм нь ямар нэгэн гаж нөлөө үзүүлдэг эсэх? Тийм бол ямар? Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах ёстой вэ?
- Ямар нэгэн ноцтой тохиолдол үүсвэл эцэг эх, асран халамжлагч болон өөр хэнд хандах хэрэгтэй эсэх?
- Хүүхдэд ямар нэгэн хориотой зүйл бий юу?

Тээвэрлэх, зөөх ба өргөх:

- Сургууль, гэрийн хооронд ямар тээврийн хэрэгсэл ашиглах вэ?
- Сургуулийн орц, гарц дээр туслах хүн шаардлагатай эсэх?
- Сургууль, анги танхимд ороход бусдын дэмжлэг шаардлагатай эсэх?
- Сургуулийн унаанд суух, тэргэнцрээс сандал эсвэл шалан дээр шилжиж суухад хэрхэн өргөх вэ?
- Зөөх, өргөхөд онцгой анхаарах шаардлагатай ямар нэгэн зүйл байгаа эсэх?
- Байрлалаа өөрчлөх, шилжихэд хэр хэмжээний дэмжлэг шаардлагатай вэ?

Харилцаа:

- Хэрвээ хүүхэд ярьдаггүй бол бусадтай хэрхэн ойлголцдог вэ?
- Тухайн хүүхэд дохио зангаа ашигладаг уу? тийм бол ямар? Түүний хувьд тийм, үгүй болон бусад үгийг тодорхой дохио зангаагаар тогтмол илэрхийлдэг үү?
- Хүүхэд гараараа эсвэл компьютер дээр бичиж чадах уу? Хэрхэн бичдэг вэ?
- Хэрвээ харилцааны электрон хэрэгсэл ашигладаг бол түүнийг хэрхэн ашиглах вэ? Багш үүнтэй холбоотой юуг мэдэж байх шаардлагатай вэ? Батарей болон цэнэглэгч хэрэглэдэг үү?
- Хүүхэд өөрийнхөө хэрэгцээг багшдаа хэлж чадах уу? хэрхэн илэрхийлэх вэ?

Өөртөө халамж анхаарал тавих:

- Хооллох, хувцаслах, бие засах гэх зэрэг өөртөө үйлчлэх үйлдэлд ямар дэмжлэг туслалцаа шаардлагатай вэ?
- Хоолны тусгай хэрэгсэл гэх зэрэг зүйл тухайн хүүхдэд хэрэгтэй юу?

Биеийн байрлал:

- Биеийн байрлалыг дэмжихэд туслах ямар зүйлийг (хашлага, дэр гэх зэрэг) хүүхэд хэрэглэдэг вэ?
- Хүүхэд ямар хичээл дээр ямар байрлалд байвал хамгийн тохиромжтой вэ? Амрах үедээ ямар байрлалд байвал тухтай байх вэ?
- Бие засах, хувцас өмсөх, хооллох болон бусад үйлдэл хийх үед ямар байрлал хамгийн тохиромжтой вэ?
- Багшийн мэдвэл зохих өөр нэмэлт туслах хэрэгсэл бий юу?

ХАВСРАЛТ 3

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Боловсролын хэрэгцээг үнэлсний дараа тухайн хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар төлөвлөгөө боловсруулна. Үүний тулд багш дараах зүйлийг хийх шаардлагатай:

- Тухайн хүүхдийн бэрхшээлийн талаар судлах
- Нэг ангид сурч буй бусад суралцагчдад тухайн хүүхдийн онцлогийн талаар тайлбарлах
- Анги танхимд болон хичээлийн хүрээнд боломжит тохируулга хийх
- Шаардлагатай тохиолдолд ГСТ боловсруулах
- Нэмэлт хөтөлбөрөөр хичээллэх шаардлагатай бол хуваарь гаргах

- Бусад шаардлагатай үйлчилгээнд хэрхэн хамруулахыг төлөвлөх

Зарим хүүхдийн хувьд ердийн ангидаа бүх хичээлийг судлахын зэрэгцээ хүүхдийн хөдөлгөөний чадвар, гараар бичих чадвар, бусадтай харилцах чадвар зэргийг нэмэгдүүлэх нэмэлт хөтөлбөрт хамруулах шаардлагатай байдаг. Эдгээр нь хүүхдэд зориулсан тусгай боловсролын хөтөлбөрийн хэсгүүд юм.

Боловсролын хэрэгцээнээс гадна эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээг үнэлэх шаардлагатай. Түүнд тулгуурлан цэцэрлэг, сургууль дээр байх хугацаанд эрүүл мэндтэй холбоотой асуудлаар хэнд хандах, хэрхэн арга хэмжээ авах зэргийг урьдчилан төлөвлөнө.

Эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээг дунд болон ахлах ангийн суралцагчид өөрсдөө илэрхийлж болно. Мөн эцэг эх, асран хамгаалагч, эмчлэгч эмч, өмнө тухайн хүүхэдтэй ажиллаж байсан бусад мэргэжилтнүүдээс мэдээлэл авч болно.

Тухайн хүүхэд хүсвэл өөрт нь ямар хэрэгцээ байдаг талаар багш нар болон бусад суралцагчдад танилцуулах боломжтой. Ингэснээр тухайн хүүхдэд ямар тохиолдолд, хэрхэн туслах талаар бусад хүмүүс ойлголттой болно. Тухайн хүүхдэд хориотой зүйлийн талаар мэдэх нь чухал бөгөөд хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд үүнийг тооцоолж, зарим зохицуулалт, дүрэм журмыг өөрчлөх, уян хатан хандах зэргээр боломжит тохируулга хийнэ.

ХАВСРАЛТ 4

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН БОЛОМЖИТ ТОХИРУУЛГА

Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн нийтлэг онцлог	Нийтлэг хэрэглэх боломжит тохируулга
Хангалттай орон зай хэрэгцээтэй учраас анги танхим/ лабораторийн өрөөнд байгаа сандал ширээг ашиглахад хүндрэлтэй байх	Хөдөлгөөнийг үл хязгаарлах хүртээмжтэй орон зай бүхий орчныг бүрдүүлэх. Явган хүний зам, анги танхимын дундуур саадгүй зорчих боломжийг бүрдүүлж, саад болох зүйлсийг холдуулж чөлөөлөх.
Суралцагчид тусгай тээврийн хэрэгсэл хэрэгтэй	Хичээлийн хуваарийг тэдний хувьд уян хатан болгох. Тээврийн хэрэгслийн үйлчилгээтэй холбоотойгоор тэд хичээлд хоцорч ирэх эсвэл хичээл дуусахаас өмнө эрт явах магадлалтай байдаг.
Бал, харандаа барьж чадахгүй байх эсвэл удаан бичих, эсвэл дасгал даалгавар, шалгалтын үед мэдээллийг авах, гаргах, боловсруулахад хүндрэлтэй байх	Бичгээр өгөх даалгавар болон шалгалтыг амаар өгөх эсвэл ярьж танилцуулах хэлбэрээр солих. Тэмдэглэл хөтлөгч ашиглах. Туслах технологи ашиглах (жишээ нь: компьютер, мини дуу хураагч гэх зэрэг). Шалгалт өгөхдөө бичигч эсвэл яриаг текст болгон хөрвүүлэх программ ашиглах. Шаардлагатай бол шалгалт өгөх тусдаа өрөө гаргаж өгөх.

Оюутан оногдсон хугацаанд даалгавар болон шалгалтыг хийж дуусгахад бэрхшээлтэй байдаг	Шалгалт/сорил, ангийн ажлын зарим бүрэлдэхүүн хэсэгт нэмэлт хугацаа өгөх
Хүнтэй удаан хугацаанд ярихад ядарч сульдах, хөдөлгөөн хязгаарлагдах	Тэргэнцэр дээр удаан хугацаагаар сууж байгаа хүнтэй ярилцахдаа тэдэнтэй ижил нэг түвшинд сууж эсвэл тэдэн рүү тонгойж ярих нь тэднийг ядарч сульдахаас сэргийлнэ. Тэд зогсож байгаа хүнтэй ярихын тулд дээшээ харах нь ачаалал өгч, өвдөлт үүсгэдэг.
Туслах технологи ашиглан өөрт тохирох хэлбэрээр мэдээллийг авах илүү их цаг шаардах	Текстийн дижитал хувилбарыг өгөх. (суралцагчдад ашиглах материалын жагсаалтыг аль болох эрт буюу улирал эхлэхээс өмнө өгөх нь маш чухал)
Бүлгээр ажиллах дасгал ажлын үед гадуурхадсан мэт мэдрэмж төрөх буюу анги дотор явахад бэрхшээлтэй байх	Бүлэг үүсгэн ажиллуулахдаа тухайн суралцагчийг бусадтай хамтран ажиллаж байгаа эсэхийг нягтлах хэрэгтэй
Өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд маш их энерги зарцуулдаг	Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдын ядрахыг багасгахын тулд өдөрт эсвэл долоо хоногт өгөх шалгалтын тоог хязгаарлах. Хэл ярианы бэрхшээлтэй бол амаар илтгэх, амаар танилцуулах зэрэгт нэмэлт цаг хуваарилах. Хичээлийн ачааллыг багасгахыг санал болгох.
Амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа, хөдөлгөөнтэй холбоотой бэрхшээлтэй тулгардаг	Сургуулиас гадуурх бүх үйл ажиллагаа нь хүртээмжтэй байгаа эсэхийг шалгах эсвэл өөр сонгох хувилбар боловсруулах.
Цахилгаан шатгүй, олон давхар бүхий сургуульд сурах тохиолдолд шатаар өгсөж, уруудахад хүндрэлтэй	Хэрэв дээд давхар руу гарах боломжгүй бол дээшээ өгсөх шаардлагагүйгээр тохируулгыг хийх хэрэгтэй. Цэцэрлэг, бага сургуулийн орчинд тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурдаг анги танхимыг сургуулийн хамгийн хүртээмжтэй хэсэгт байрлуулах. Дунд, ахлах ангийн хувьд багш нар тухайн хүүхдийн ангид очиж хичээлээ заах.
Бусдын туслалцаа, дэмжлэг хэрэгтэй болох	Туслах найз нөхдийн систем бий болгох. Энэ нь анги дотор болон ангиас гадуур аль алинд нь тустай. Найз нөхөд нь шаардлагатай бол тэмдэглэл хөтлөх, нийгмийн харилцаанд ороход нь тусална.
Тухайн хүүхдийн өмнөөс бусад хүмүүс шийдвэр гаргах магадлалтай	Эцэг эх, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахаас гадна тухайн суралцагчийг суралцах хэрэгцээ, зорилгынхоо талаар шийдвэр гаргахад өөрөө оролцох боломжийг олгох.

ХАВСРАЛТ 5

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗОРИЛГО БА БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛИЙГ ХЭРХЭН ТУСГАХ ЖИШЭЭ

Хичээлийн жилийн зорилго

1. Тус хичээлийн жилийн төгсгөлд, Дарьхүү хичээлээс гадуурх бүлгийн цэнгээнт 2 үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай үндсэн чадварыг хийж үзүүлнэ.

Хариуцах хүн: Тохируулгат биеийн тамирын хичээл зааж буй багш

2. Тус хичээлийн жилийн төгсгөлд, Дарьхүү өөрт нь чиглэсэн цэнгээнт үйл ажиллагаанд долоо хоног бүр 4 цаг оролцсон байна.

Хариуцах хүн: Тохируулгат биеийн тамирын хичээл зааж буй багш

3. Тус хичээлийн жилийн төгсгөлд, Дарьхүү б дугаар ангийн түвшний материалыг уншиж, үгийн утгыг нь сайн ойлгодог болно.

Хариуцах хүн: Тусгай боловсролын багш эсвэл тус сурагчтай ажиллаж буй багш

4. Дарьхүү 8 дугаар ангийн математик, монгол хэл, нийгмийн ухаан болон байгаль шинжлэлийн хичээлүүдийг амжилттай бүрэн судалж дуусна.

Хариуцах хүн: 8 дугаар ангид хичээл зааж буй бүх багш нар

Дарьхүү өөрийн сурч буй ангийнхантай хамт бүх хичээлийг судална.

Тусгай боловсрол ба бусад шаардлагатай үйлчилгээ

1. Дарьхүү тохируулгат биеийн тамирын хичээл заах багшаас тусгай боловсролын үйлчилгээг (хичээлийн жилийн төлөвлөгөө 1 ба 2) өдөрт нэг удаа авна.
2. Дарьхүү өөртэй нь тусгайлан ажиллаж буй багшаас тусгай боловсролын үйлчилгээг (хичээлийн жилийн төлөвлөгөө 3) өдөрт нэг удаа авна.
3. Шаардлагатай тохиолдолд тусгай боловсролын багш эсвэл тусгайлан ажиллаж буй багш тохируулгат биеийн тамирын хичээл зааж буй багш, сургуулийн эмч Дарьхүүгийн сурч буй 8 дугаар ангид хичээл заадаг багш нарт зөвлөгөө, чиглүүлэг өгч хамтран ажиллана.

ХАВСРАЛТ 6

ХИЧЭЭЛИЙН ҮЕД ХЭРЭГЛЭХ БОЛОМЖИТ ТОХИРУУЛГЫН ЗАРИМ ЖИШЭЭ

Дуу хөгжим, дүрслэх урлаг

- Урлаг нь тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй оюутнуудад сэтгэл хөдлөл, санаа бодлоо бүтээлчээр илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлж чадна.
- Тэдний бүтээлч байдал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг хэрхэн дэмжих талаар багш нар, эцэг эх, дэмжлэгийн багийн гишүүд хамтран ярилцаж болно.
- Хичээлийн хэв маягийг хэрхэн өөрчлөх талаар хичээл зааж буй багш, бусад багш нартай ярилцаж болно.
- Тухайн суралцагчийг бүрэн оролцуулахын тулд түүнд тохируулсан материал шаардлагатай байж болно. Жишээлбэл, барихад хялбар бүдүүн харандаа, хурууны багс гэх зэрэг. Цаасыг ширээн дээр цаасан скочоор нааж бэхлэх, эсвэл доороо хашлагатай гадаргуу дээр байрлуулж болно.
- Бүгдээрээ бүжиглэж тоглох төрөл бүрийн аргуудаас сонгон тухайн суралцагчийг оролцуулах боломжтой.

Эх хэл

- Тухайн суралцагчийн бусадтай харилцах, суралцах чадварыг хамгийн сайн дэмждэг, тэдний бие махбодын онцлог хэрэгцээнд хамгийн сайн тохирох төхөөрөмж, эд зүйлсийг ашиглах. Жишээлбэл, зарим суралцагч аман зааварчилгааг зурган карттай хамт ашиглахад илүү сайн сурах бол зарим нь аудио ном эсвэл текстийг яриа руу хөрвүүлэхэд туслах технологийг ашиглахад илүү сайн сурдаг.
- Унших, бичихэд туслах компьютерын программ хангамжийг боломжтой бол ашиглах. Энэ талаар эцэг эх, дэмжлэгийн багийн гишүүдтэй ярилцаж болно.
- Бичиг үсгийн дасгал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг дэмжих. Төрөл бүрийн аргуудыг (унших, зурах, видео бичлэг гэх мэт) ашиглах нь тухайн суралцагчийг сэдэлжүүлж, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх боломжтой.
- Төрөл бүрийн текстэн бичвэр, зураг дүрслэл бүхий материал, эд зүйлийг хялбархан хүрч болохуйц, харагдахуйц газарт байрлуулах нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын бичиг үсгийн чадварыг хөгжүүлэхэд тустай. Ханан дээр болон номын тавиур дээр зурагт хуудас, үзүүлэн, эд зүйлийн шошго, төрөл бүрийн өгүүллэг, зурагтай ном тавьж, суралцагчдад чөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлбэл зохино.
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчид үлгэрийн ном болон бусад бичмэл хэсгүүдийг олон удаа давтан унших нь тэдэнд ихээхэн тустай байдаг.

Энэ нь тэдний унших чадвар, ойлгох чадварыг нэмэгдүүлэхэд тусална.

- Сурах үйл явцын хүрээнд хийж гүйцэтгэж буй дасгал даалгавар, үйл ажиллагаанд эерэг урамшуулсан санал дүгнэлт өгч, тусалж дэмжин, засаж залруулах зүйлийг нэн даруй хийж байх хэрэгтэй.

Эрүүл мэнд, биеийн тамир

- Хөдөлгөөн, тэнцвэр, хөдөлгөөнөө зохицуулах зэрэгт дэмжлэг шаардлагатай суралцагчдад биеийн тамирын хичээлийн хүрээнд тохируулга хийх.
- Багаар ажиллахыг дэмжиж, суралцагчдыг спортын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах. Энэ нь суралцагчдад үйл ажиллагаанд оролцох боломжийг олгож, тэдэнд харьяалагдах, хүлээн зөвшөөрөгдөх мэдрэмжийг төрүүлнэ.
- Суралцагчдын дунд бусдад хүндэтгэлтэй хандах соёлыг төлөвшүүлэх. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн үлгэр дуурайл болох оролцоо, давуу талыг харуулсан видео бичлэгүүдийг үзүүлж, ярилцлага хийх.
- Суралцагчдын давуу талыг биеийн тамирын дасгал, үйл ажиллагаанд чиглүүлэг болгон ашиглах. Бүрэн оролцоог дэмжихийн тулд спортын тоглоомуудын зарим дүрмийг өөрчилж болно. Жишээлбэл, сурагч бөмбөг өшиглөхийн оронд бөмбөгийг барьж явж болно гэх зэрэг. Мөн зарим хугацаатай холбоотой дүрэмд тухайн суралцагчийн хувьд гурав, тав эсвэл арван секунд удаан буюу хугацааг хойшлуулсан дүрэм гаргаж болно.
- Спортын талбайн гадаргуу нь хүүхэд халтирч гулгах эсвэл хэт зууралдаж наалдах эсэхийг шалгах шаардлагатай.
- Спортын тоног төхөөрөмжийг тухайн хүүхдийн онцлогт тохируулан сонгож болно. Жишээлбэл, хөнгөн бөмбөг, тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдад зориулсан цохиур гэх зэрэг. Тэргэнцэртэй суралцагчдад зориулан сагсан бөмбөгийн нэг торыг доор байрлуулж болно.
- Өвдөх, ядрах шинж тэмдэг илэрч буй эсэхийг анхаарах. Нүүрний хувирал, хөдөлгөөний өөрчлөлт, зан үйлийн өөрчлөлт, үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны өөрчлөлт гэх мэт аман бус шинж тэмдгүүдийг анхаарч байх хэрэгтэй.
- Зарим суралцагч ядрах болон өвдөлтийг намдаахын тулд ойр ойрхон амрах шаардлагатай болдог.

Математик

- Хэрэв суралцагч өдөр тутмын үйл ажиллагаандаа туслах технологийг ашигладаг бол тэдгээрийг математикийн хичээлд ч мөн ашиглах. Жишээлбэл, хэрэв суралцагч тохируулга бүхий гартай зөөврийн компьютер ашигладаг бол тухайн суралцагчид зориулж онлайн хэлбэрээр ашиглах боломжтой математикийн бодлого, дасгалуудыг оруулж болно.

- Компьютерын зарим программ хангамж суралцагчийн тоо бодох чадварт суралцах, дадлага хийхэд тусална.

Байгаль шинжлэл

- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчид аюулгүй суралцах боломж олгох сургалтын орчныг бүрдүүлэх. Жишээлбэл, хичээлд ашиглах зүйлс буюу сургалтын хэрэглэгдэхүүн тухайн хүүхдэд хүртээмжтэй эсэхийг нягтлах шаардлагатай.
- Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тохируулга хийх. Жишээлбэл, ширээ нь тэргэнцэр дээр суудаг хүмүүст тохирсон өндөрт байгаа эсэх, микроскоп гэх зэрэг тоног төхөөрөмж нь тухайн суралцагч хүрч авахад хялбар боломжтой эсэхийг нягтлах хэрэгтэй.

Технологи

- Ширээний ард тэргэнцэртэй суралцагч тухтай суух хангалттай зай байгаа эсэхийг нягтлах. Өөрт тохиромжтой байрлалаар суух, хэр удаан суух зэрэгтэй холбоотой асуудалд бусдын туслалцаа дэмжлэг шаардлагатай эсэхийг анхаарах хэрэгтэй.

ХАВСРАЛТ 7

ТУЛГУУР ХӨДӨЛГӨӨНИЙ БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг үнэлэхдээ үнэлгээний стандартыг бууруулахгүй, харин тэдэнд сурсан зүйлээ харуулах боломж олгох нь чухал байдаг.

Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчийн үнэлгээний даалгавруудад тусгайлан тохируулга хийх шаардлагатай байж болно. Тулгуур хөдөлгөөний бэрхшээл нь тухайн суралцагчийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлдөг талаар мэддэг болсны дараа түүнд тохирох үнэлгээний стратегийг оновчтой сонгон хэрэглэх боломжтой.

- Аман шалгалт нь ердийн бичгээр авах шалгалтын өөр нэгэн хувилбар юм. Амаар шалгалт өгөхдөө тухайн суралцагч шалгалтын хариултыг гар утас, дуу хураагч дээр бичиж өгч болно. Бичгийн шалгалттай адил амаар шалгалт өгөх, хариултыг сонсох, сайжруулах, засварлахад суралцагчид нэмэлт цаг гаргах хэрэгтэй.
- Зарим суралцагчийн хувьд бичгийн болон аман шалгалтыг хослуулах нь хамгийн тохиромжтой. Суралцагчдад хариултаа тоймлон зураглаж тэмдэглэл хийж, дараа нь асуултад амаар хариулах боломж олговол зохино. Багшийн үнэлгээ нь суралцагчийн тоймлон тэмдэглэсэн зүйл болон ярьсан зүйл дээр суурилсан ёстой.

- Суралцагч шалгалт өгөхдөө хувийн компьютер эсвэл хувийн туслах ашиглах шаардлагатай байж болно. Хэрэв тийм бол тухайн ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэлд зориулан зай талбай гаргаж өгөх эсвэл тоног төхөөрөмжөөс (жишээ нь, дуу авиаг шилжүүлэн хувиргагч) гарах чимээ бусад суралцагчийн анхаарлыг сарниулах магадлалтай бол шалгалт өгөх тусдаа өрөө гаргах шаардлагатай.
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлийн улмаас удаан бичдэг суралцагчдад шалгалтын цагийг уртасгаж нэмэлт цаг өгнө. Зарим суралцагчийн хувьд шалгалтын дундуур амрах шаардлага гарах магадлалтай. Зарим суралцагчийн хувьд шалгалт өгөхөд хоёр дахин их хугацаа шаардагддаг тул шалгалтын зарим хэсгийг гэрт нь хийлгэх сонголт байж болно.
- Бие даан гүйцэтгэх даалгаварт судалгаа хийх ажил өгсөн бол даалгавар хүлээн авах эцсийн хугацааг сунгаж, уян хатан хандах хэрэгтэй. Учир нь тэдний хувьд номын санд суух, олон газраас мэдээлэл цуглуулах гэх зэрэгт бусад суралцагчдаас илүү хугацаа шаардагдана.

СЭДЭВ 4: БАГШ, ЭЦЭГ ЭХТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ СТРАТЕГИ

Зорилго: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч болон бусад багш, мэргэжилтнүүдтэй хэрхэн хамтран ажиллах талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд ердийн цэцэрлэг, сургуульд сурах үйл явц дахь эцэг эхийн оролцоог тодорхойлох
- Цэцэрлэг, сургуулийн багш нар хэрхэн хамтран ажиллах талаар тайлбарлах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Багшид зориулсан материал
- Хавсралт 2: Багшид зориулсан материал
- Хавсралт 3: Тараах материалыг багийн гишүүдийн тоог харгалзан хэвлэж, тасархай зураасны дагуу хайчилж бэлтгэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцад эцэг эхийн оролцоог тодорхойлох (40 минут)

1. Оролцогчдыг 4 бүлэгт хуваана. Танхимын ханан дээр 4 ширхэг дэлгэц цаас байрлуулна. Баг тус бүрт дараах даалгавар өгнө. Тус даалгаврыг гүйцэтгэхэд ашиглах хүснэгтийн загварыг (хавсралт 1) багш самбарт зурж харуулна. Тэдэнд 10 минутын хугацаа өгнө.
 - 1 дүгээр баг - тухайн ангид суралцаж буй хүүхдийн тулгуур хөдөлгөөний бэрхшээлийн онцлог, боловсролын болон эрүүл мэндтэй холбоотой хэрэгцээг тодорхойлоход эцэг эх, бусад багш нарын үүрэг, оролцоо
 - 2 дугаар баг - тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн сургалт, сургалтаас гадуурх үйл ажиллагааг төлөвлөх, ГСТ боловсруулахад эцэг эх, бусад багш нарын үүрэг, оролцоо
 - 3 дугаар баг - тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд сурах цэцэрлэг, сургуулийн орчныг хүртээмжийг сайжруулах болон боломжит тохируулга хийхэд эцэг эх, бусад багш нарын үүрэг, оролцоо
 - 4 дүгээр баг - тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдийн хичээл, сургалтын үйл ажиллагаа болон сургалтаас бусад үйл ажиллагаанд эцэг эх, бусад багш нарын үүрэг, оролцоо

2. Хугацаа болмогц баг бүр хийж байсан зүйлээ зогсоож, багшийн өгөх дохиогоор нэгэн зэрэг баруун гар талынхаа багийн ажил руу шилжинэ. Тус багийн ажилтай танилцаж, өөрсдийн саналыг нэмнэ. Ийм маягаар бүх багийн ажилд өөрсдийн саналыг тусгана.
3. Эцэст нь баг бүр өөрсдийн эхний ажилласан цаасан дээр ирнэ. Баг тус бүр тухайн дэлгэц цаасан дээр бичигдсэн бүх санаануудыг нэгтгэн бусдадаа танилцуулна. Бусад оролцогчдын зүгээс асууж тодруулах зүйл болон нэмэх санаа байгаа эсэхийг асууж, хамтран ярилцана. Багш хавсралт 2-т байгаа мэдээллийг ашиглан тус үйл ажиллагааг нэгтгэн дүгнэнэ.

Үйл ажиллагаа 2: Сургуульд суурилсан хамтын ажиллагаа (45 минут)

1. Оролцогчдыг 4 хүнтэй багт хуваана. Багийн гишүүдийг дотор нь 1-4 хүртэл тоолуулна. Багийн 4 гишүүнд өөр өөр унших материал тараан өгч, өөрсдийн судалсан материалаа багийн бусад гишүүддээ тайлбарлахыг хүснэ. Багийн гишүүдэд унших материалыг дараах байдлаар оноож өгнө.
 - Баг тус бүрийн 1 гэсэн дугаартай оролцогчдод хавсралт 3-т байгаа сургуулийн удирдлага ба бусад мэргэжилтнүүд гэсэн хэсгийг,
 - 2 гэсэн дугаартай оролцогчдод хавсралт 3-т байгаа багш нар гэсэн хэсгийг,
 - 3 гэсэн дугаартай оролцогчдод хавсралт 3-т байгаа туслах багш гэсэн хэсгийг,
 - 4 гэсэн дугаартай оролцогчдод хавсралт 3-т байгаа тусгай хэрэгцээт боловсролын багш гэсэн хэсгийг тус тус өгөх
2. Багийн гишүүн тус бүр өөрт оногдсон мэдээллийг судалж, бусдадаа ээлжлэн тайлбарлана. Багийн гишүүд мэдээлэл тус бүрийг сонссоны дараа тухайн зүйлийн талаар санал бодлоо солилцон хамтран ярилцана.
3. Багууд ярилцаж дууссаны дараа бүгд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжихэд оролцогч талуудын тухай өөрсдийн ойлгосон зүйлээ нэгтгэн ярилцана.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Та бүхэнд ямар мэдээлэл онцгой санагдсан бэ?
- Та өөрийн ажилладаг цэцэрлэг, сургууль дээр тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжихийн тулд хэнтэй, хэрхэн хамтран ажиллахаар төлөвлөж байна вэ?
- Эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах вэ?

ХАВСРАЛТ 1

ЭЦЭГ ЭХ, БАГШ НАРЫН ҮҮРЭГ ОРОЛЦООГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Бусад багш нарын оролцоо	Эцэг эхийн оролцоо
<ul style="list-style-type: none">••••	<ul style="list-style-type: none">••••

ХАВСРАЛТ 2

ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦОО БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн сурах үйл явцад чухал оролцогч тал байдаг. Тэд хуулиар тогтоосон эрх болон үүрэг хариуцлагаа сайн мэддэг, хэрэгжүүлдэг байх нь чухал юм.

Цэцэрлэг, сургуульд сурах үйл явцтай холбоотой бүхий л үе шатанд тэд оролцох ёстой. Тухайлбал, хүүхдийн бэрхшээлийн онцлог, боловсролын ба эрүүл мэндтэй холбогдох хэрэгцээг тодорхойлж, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх зэрэг бүхий л үйл явцад оролцож, өөрсдийн санаа бодол, хувь нэмрээ оруулах шаардлагатай.

Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс цэцэрлэг, сургуулийн холбогдох хүмүүс, багийн гишүүд, багш нарт тодорхой мэдээллийг өгч, хамтран ажиллах ёстой. Жишээ нь:

- Хүүхдийнхээ юунд дуртай, дургүй
- Давуу тал ба хэрэгцээ
- Хүүхдийн харилцааны хэв маяг
- Санаа зовж буй асуудал
- Хүүхдийн итгэл найдвар, хүсэл мөрөөдөл
- Хүүхдийн ирээдүйн талаарх эцэг эхийн итгэл найдвар, хүсэл мөрөөдөл
- Гэр бүл, олон нийтийн орчинд хүүхдэдээ аливаа зүйлийг зааж сургах талаар ямар зүйлийг хэрхэн хийдэг гэх зэрэг

Хэрвээ хүүхэд өөрөө ярих боломжгүй тохиолдолд эцэг эхчүүд хүүхдийнхээ бэрхшээлийн онцлогийн талаар ангийн сурагчид, хичээл ордог багш нар зэрэгт танилцуулж болно. Хүүхдийн боловсролын үнэлгээ хийх явцад эцэг эх холбогдох мэдээллийг өгнө. ГСТ боловсруулах үйл явцад оролцох бөгөөд түүний хэрэгжүүлэхэд өөрсдийн зүгээс гүйцэтгэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.

Тухайлбал, өдөр тутмын сургалтын үйл ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэсэн үйлдэл, дасгал даалгаврыг давтуулах, урамшуулан дэмжих, сургуулийн бодлого, үйл ажиллагаа, дүрэм журмыг дагаж мөрдөх, шаардлагатай тохиолдолд хүүхдийн сургалтын үйл ажиллагаанд хамтран оролцох, ажиглах, өөрийн санал бодлыг зөв зохистой илэрхийлэх зэрэг.

Эцэг эхтэй холбоотой байхын тулд харилцааны ямар арга хэрэгсэл ашиглах, тухайлбал, утсаар ярих, и-мэйл, чат бичих, биечлэн уулзах зэргийг тодорхой болгох шаардлагатай.

ХАВСРАЛТ 3

СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарт тусламж дэмжлэг үзүүлэх баг бүрдүүлэн ажиллах ёстой. Сургуульд суурилсан хамтын ажиллагааны багт сургуулийн удирдлага, ангийн багш, туслах багш, тусгай хэрэгцээт боловсролын багш, тухайн бэрхшээлтэй хүүхдэд хичээл зааж буй багш нар болон сэтгэл зүйч, орон нутаг, олон нийтийн байгууллагын ажилтан зэрэг бусад мэргэжилтнүүд орж болно. Эдгээр хүмүүс дараах үүргийг гүйцэтгэх боломжтой. Тухайлбал:

Сургуулийн удирдлагын үүрэг

- Суралцагчдад зориулсан боловсролын хөтөлбөрт хяналт тавих
- Суралцагчийн ГСТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, шаардлагатай өөрчлөлт засвар орсон эсэхэд хяналт тавих
- Багш нар ангид байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллахад шаардлагатай мэдээллээр хангах, багш нарыг чадавхжуулахад анхаарал хандуулах
- Сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах
- Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдад шаардлагатай дэмжлэгийн хэрэгцээг хүлээн зөвшөөрч, дэмжлэг үзүүлэх

Хэрэв сургуулийн удирдлага тэгш хамран сургах боловсролын талаар төдийлөн сайн ойлголтгүй эсвэл дэмждэггүй бол хөгжлийн бэрхшээлийн суралцагчдад шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд хүндрэлтэй байх магадлалтай. Бүх удирдлага энэ чиглэлээр мэдлэгтэй байх албагүй ч мэдлэгээ хуваалцах замаар суралцахад нь туслах боломжтой.

Багш нар

Бага сургуульд ангийн багш нь тухайн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай өдөр тутамд ажиллана. Дунд сургуульд сурахад хичээл зааж буй багш нараас гадна туслах багш, нөөц багш эсвэл сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын багш хамтран ажиллана. Ангийн багш нар хүүхэд бүрийн ахиц дэвшлийг хариуцдаг. Багш нар дараах үүрэг гүйцэтгэнэ:

- Сургалтын аюулгүй орчныг төлөвлөх, бий болгох, тогтвортой байлгахын тулд суралцагч, тэдний эцэг эхтэй хамтран ажиллах, бусад мэргэжилтэн болон туслах багштай хамтран ажиллах
- Ангийн бүх суралцагч болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан ганцаарчилсан зааварчилгааг төлөвлөх
- ГСТ-ний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх, шаардлагатай бол өөрчлөлт оруулах
- Хүүхдийн боловсролын талаар эцэг эхчүүдтэй харилцах
- Тусгай мэргэжилтнүүдээс (хэл засалч, хөдөлгөөн засалч гэх мэт) өгсөн мэдээллийг зохицуулах, удирдан чиглүүлэх
- Туслах багш нарын ажилд хяналт тавих, зохицуулах
- Суралцагч бүрийг амжилттай суралцуулахын тулд заах арга барил, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт тохируулга хийх
- Суралцагчдын ахиц дэвшлийг үнэлэх, тайлагнах
- Ангийнхан буюу үе тэнгийнхэнтэйгээ хэрхэн харилцах харилцааг дэмжих

Ангийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бусад хүүхдүүд хэрхэн харилцахад нь багш яаж туслахаа мэддэг байх нь чухал ач холбогдолтой байдаг. Багш нар хүүхэд бүрт харьяалагдах мэдрэмжийг бий болгох ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулахын тулд ангийн багш бусадтай хамтран ажиллах хэрэгтэй. Тэд мөн юу хийхээ мэдэхгүй тохиолдолд үүнийг хүлээн зөвшөөрч, зохих тусламж хүсэх хэрэгтэй.

Туслах багш

Цэцэрлэг, сургууль боломжтой бол туслах багш авч ажиллуулах хэрэгтэй. Туслах багш нар хичээл зааж буй багш нартай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд ихэвчлэн тодорхой нэг хүүхэдтэй эсвэл хэд хэдэн хүүхэдтэй ажиллаж болно. Тэд сургуулийн удирдлага болон багш нарын шууд удирдлага дор ажиллаж дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай халамж асаргаа (ариун цэврийн өрөөнд орох; биеийн тохиромжтой байрлал, хөдөлгөөн; хооллох; хувцаслах зэрэгт туслах)
- Аюулгүй байдлыг хангах ба хараа хяналт тавих
- Харилцаа болон техник хэрэгсэл ашиглахад туслах, дэмжих
- Анги танхимд ажиглах
- Суралцагч бие даан эсвэл жижиг бүлгээр суралцах үйл ажиллагаанд нь туслах
- Багш, бусад мэргэжилтнүүдийн тогтоосон зан үйлийн менежментийн хөтөлбөрийг дагаж мөрдүүлэх
- Эмчийн зааж өгсөн эмчилгээний хөтөлбөрийг дагаж мөрдүүлэх
- Суралцагчийн нийгмийн харилцаанд дэмжлэг үзүүлэх
- Ангийн багш, сургуулийн удирдлагын хүсэлтийн дагуу мэдээлэл цуглуулах, бүртгэл хөтлөх

Суралцагчийн хэрэгцээ болон гүйцэтгэвэл зохих үүрэг хариуцлагатай холбогдуулан туслах багш нарыг бэлтгэх сургалтад хамруулсан байх ёстой. Тэдний ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэгт нийцүүлэн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах шаардлагатай. Тухайлбал, зан үйлийн менежмент, суралцагчдын нийгмийн болон харилцааны чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр бэлтгэгдсэн байх ёстой.

Тусгай хэрэгцээт боловсролын багш буюу суралцахууд дэмжлэг үзүүлэх багш

Зарим сургуульд ангийн багш болон бусад багш нарт тусгай хэрэгцээт боловсролын багш нар маш их дэмжлэг үзүүлдэг. Тус багш нар анги хариуцдаггүй. Эдгээр багш нарыг зарим газар нөөц багш гэж нэрлэдэг. Тэд өөр өөр үүрэгтэй байж болох ба энэ нь сургууль, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, онцлог хэрэгцээ зэргээс шалтгаалах магадлалтай. Сургуулийн хэрэгцээ шаардлагаас хамааран тэдгээр багшийг бүтэн болон хагас цагаар сургуульд ажиллуулж болно. Тэд тусгайлан бэлтгэгддэг учраас багш, суралцагчдын аль алинд дэмжлэг үзүүлэх боломжтой. Тэд дараах үүрэг гүйцэтгэнэ:

- Суралцагчдын сурах үйл ажиллагааг дэмжих стратегийг сургууль, гэр бүлд санал болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад боловсролын тодорхой чиглэлээр үйлчилгээ үзүүлэх
- Бие махбодын буюу зан үйлийн хэрэгцээнд зориулан сургалтын хөтөлбөрт тохиргоо хийх/ интервенцийг хэрэгжүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэжилтнүүдийн багийг удирдах зохицуулах
- Ангийн багш нарт дэмжлэг үзүүлж туслах
- Тухайн хүүхдийн сургалтын болон сургалтаас гадуурх үйл ажиллагаа, тусгай боловсролын үйлчилгээний хуваарь гарган төлөвлөх, хугацааг зохицуулах
- ГСТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг зохицуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг шинэ анги, сургуульд шилжүүлэхэд туслах, дэмжлэг үзүүлэх
- Дэмжлэг шаардлагатай суралцагчтай хэрхэн ажиллах талаар багш нар, эцэг эх, холбогдох бусад хүмүүст зөвлөх
- Эцэг эхтэйгээ тогтмол харилцаж, шаардлагатай үед хүүхэдтэй шууд тулж ажиллах боломжтой.

Бусад мэргэжилтнүүд

Багш нар бусад мэргэжилтнүүдтэй хамтран багийн нэгэн хэсэг болж ажиллана. Тухайлбал, сэтгэл зүйч, хэл засалч, хөдөлгөөн засалч, ахуй засалч, хөдөлмөр засалч, физик эмчилгээний эмч гэх зэрэг. Эдгээр бусад мэргэжилтнүүдийн үүрэг бол хөгжлийн бэрхшээлтэй тухайн хүүхдийн ГСТ-д тусгагдсан тусгай боловсролын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм.

МОДУЛЬ 6:

ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ



Зорилго	Хэл яриа, харилцааны бэрхшээлийн талаар ойлголттой болох, хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг танин мэдэх, тэдгээр хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйг эзэмших
Зорилт	<ul style="list-style-type: none"> ▪ Хэл яриа, харилцааны бэрхшээлийн талаар болон хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг танин мэдэх ▪ Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх арга зүйг эзэмших ▪ Анги, хамт олны дунд суралцахуйн эерэг орчин бүрдүүлэх арга зүйд суралцах
Хугацаа	6 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Хэл яриа, харилцааны бэрхшээлийн талаар ерөнхий ойлголт (60 минут)</p> <p>Сэдэв 2. Суралцахуйн түгээмэл загварыг ашиглан хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй (90 минут)</p> <p>Сэдэв 3. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, тохируулгат сургалтын хэрэглэгдэхүүн (60 минут)</p> <p>Сэдэв 4. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах арга зүй (90 минут)</p> <p>Сэдэв 5. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн нэмэлт мэдээлэл (60 минут)</p>	

СЭДЭВ 1: ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Зорилго: Хэл яриа, харилцааны бэрхшээл, түүний онцлог, суралцагчдын сурах үйл явцад үзүүлэх нөлөөг тайлбарлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Хэл яриа, харилцааны бэрхшээл, түүний нийтлэг шалтгааны талаар ерөнхий ойлголттой болох
- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий онцлогийг танин мэдэх
- Хэл яриа, харилцааны бэрхшээл нь цэцэрлэг, сургуульд сурах үйл явцад хэрхэн нөлөөлж болохыг тодорхойлох

Хугацаа: 60 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, скоч, стикер цаас
- Хавсралт 1: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Хэл яриа, харилцааны бэрхшээлийн талаарх ойлголт (30 минут)

1. Оролцогчдоос дараах асуултыг асууж, оролцогчдын хэлсэн зүйлийг дэлгэц цаасан дээр бичиж тэмдэглэн, ярилцана.
 - Танай ангид ярих, өөрийгөө илэрхийлэх, харилцах ямар ямар онцлогтой хүүхэд суралцдаг вэ?
 - Хэрвээ байдаггүй бол та ямар хүүхдийг хэл яриа, харилцааны бэрхшээлтэй гэж хэлэх вэ?
2. Оролцогчид хоёр хоёроороо хоорондоо хэл яриа, харилцааны бэрхшээл үүсэх нийтлэг шалтгааны талаар 2 минутын турш ярилцана.
3. Оролцогчдын хэлсэн зүйлд тулгуурлан хавсралт 1-д байгаа мэдээллийг танилцуулж, нэгдсэн ойлголтод хүрнэ.

Үйл ажиллагаа 2: Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг тодорхойлох (25 минут)

1. Хэл яриа, харилцааны бэрхшээлийн төрлүүдийг стикер цаасан дээр бичиж багуудаар сугалуулна. Тухайн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэл яриа,

харилцааны бэрхшээлийн сурах үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөний талаар жагсаан бичиж ярилцана.

2. Багуудын бичсэн хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэд ямар онцлогтой байдаг, тухайн бэрхшээл нь хүүхдийн сурах үйл явцад хэрхэн нөлөөлж болох талаар тоймлон тайлбарлана.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Та бүхэн тус сэдвийн хүрээнд юуг шинээр мэдэж авсан бэ?
- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлогийн талаар бусдад хэрхэн тайлбарлах вэ?
- Ердийн цэцэрлэг, сургуульд сурах хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн талаар багш юуг мэдэж байх хэрэгтэй вэ?

ХАВСРАЛТ 1

ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд бусдын хэлж ярьж буйг ойлгохгүй байх, ойлгож байгаа боловч хариултаа үгээр илэрхийлэн хэлж чадахгүй байх, үгээ зөв сонгож, хооронд нь нийлүүлэн утга төгс өгүүлбэр бүтээхдээ хүндрэл бэрхшээлтэй тулгарах (үг зүй, өгүүлбэр зүйн дүрмийн алдаатай ярих), үгийн нөөц хомс (ахуйн хүрээний, энгийн үгээр харилцах), авиа, үе, үгийг буруу дуудах, өөр авиагаар сольж дуудах, огт дуудаж чадахгүй байх, дуу хоолойны өнгөний өөрчлөлттэй байх, ээрч гацаж ярьдаг. Мөн бусадтай харилцах, хүний нүд рүү эгцлэн харах зэрэг нийгмийн энгийн харилцааг ойлгохгүй байх тохиолдол байдаг.

Үг хэлэхийн тулд юмс үзэгдлийн нэр, үйл хөдлөлийг илэрхийлсэн янз бүрийн үг хэллэг, түүний утга, хэрэглэх аргыг сайн мэддэг байх хэрэгтэй. Мөн ярихыг хүссэн зүйлээ толгойдоо боловсруулан, түүнийгээ өгүүлбэр болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, ярих гэдэг нь юу ярихаа толгойдоо боловсруулан, дууны хөвч болон авиаг өгүүлэх эрхтнийг оролцуулан, үг бүтээх процессыг хэлдэг. Мөн харилцан ярихын тулд харилцагчийнхаа яриаг чихээрээ сонсон, толгойдоо боловсруулж ойлгох шаардлагатай. Эдгээр процессын аль нэг хэсэгт доголдол үүсвэл хэл ярианы бэрхшээл үүсдэг.

Хэл яриа, харилцааны бэрхшээл үүсэх шалтгаан

Ургийн хөгжлийн, төрөх үеийн болон төрсний дараах үеийн уураг тархины дутуу хөгжил ба гэмтэл, түүнчлэн хэл ярианы захын эд эрхтний органик гэмтэл, төв мэдрэлийн тогтолцооны хөөрөл саатлын процессын харилцан үйлчлэлийн алдагдал, сэтгэл зүйн хүчтэй цочрол, айдас түгшүүр, оюуны хомсдол, ой тогтоолт, анхаарал, сэтгэцийн бусад үйлийн гэмтэл өөрчлөлт, орчны, гэр бүлийн таагүй нөлөө орох ба эдгээр нь хэл ярианы хоцрогдол, бэрхшээлийг дагуулдаг.

Хэл яриа, харилцааны бэрхшээлийн ангилал

Хэл яриаг хүлээн авах бэрхшээл	Хүүхдийн мэдрэхүйн эрхтэн буюу сонсгол, хараа нь хэвийн боловч сонсож байгаа үг яриаг хүлээн авч, ойлгож чадахгүй байх явдал юм.
Ярианы бэрхшээл	Ярих үйл ажиллагаа буюу үг, авиаг зөв дуудах, хэлэх, үг ярианы хурд хэмнэлийг зөв хэрэглэх чадвар алдагдахыг хэлнэ.
Дуу хоолойн өнгөний өөрчлөлт	Хоолойн өөрчлөлтийн улмаас дууны өнгө өөрчлөгдөх, эсвэл огт дуугүй болохыг хоолой, дууны өнгөний өөрчлөлт гэнэ.
Хэл ярианы хурдны эмгэг удаашралт	Ярих үйл ажиллагаа удаашралтай болж ирнэ. Энэ нь уураг тархины гэмтлийн шинжтэй эсвэл органик буюу дотоод бүтцийн хэвийн бус байдлаас үүссэн байж болно.
Хэл ярианы хурдны эмгэг түргэсэлт	Өгүүлж ярих үйл түргэссэн байдлаар илэрнэ. Хэл ярианы хурд удааширсан нөхцөлд яриа нь удаан, гуршсан, нэг хэвийн, идэвхгүй, түргэссэн нөхцөлд яарсан, түргэн, хурдан, түрэлттэй байна.

Авиа, дуудлагын согог	Өгүүлэх эрхтний хөгжил, хөдөлгөөн, сонсгол хэвийн нөхцөлд авианы зөв дуудлага алдагдахыг хэлнэ. Авиаг огт дуудаж чадахгүй байх, буруу дуудах, хооронд нь солих байдлаар илэрнэ.
Ээрүү	Өгүүлэх эрхтний булчингийн таталтын улмаас үүсэлтэй ярианы хурд хэмнэлийн алдагдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, хүн ярьж эхлэхэд эхлээд авиа нь гарч өгөхгүй гацах ба нэг үг, нэг дуудлагыг олон дахин давтан ярих, жигд ярьж чадахгүй байхыг ээрүү гэнэ.
Гуншаа	Өгүүлэх эрхтний бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтийн улмаас авиа дуудлага, дуу, хоолойн өнгө өөрчлөгдөхийг хэлнэ.
Дультраа	Нүүр амны өгүүлэх эрхтний булчингийн сулралаас үүдэлтэй, хэл ярианы дуудлагын эмгэг өөрчлөлтийг хэлнэ.

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдэд ажиглагдах нийтлэг шинж (онцлог)

Хэл ярианы талаас:

- Оройтож хэлд ордог (Анхны үгээ 3 – 4 насандаа зарим үед 7 нас хүрч хэлдэг)
- Өөрт нь хандсан яриаг ойлгох боловч эргүүлэн санаа бодлоо илэрхийлэх чадвар хомс
- Шууд утгаар ойлгодог (Амандаа орсон шар тосыг хэлээрээ түлхэх)
- Хэл яриа нь ойлгомжгүй
- Хүний хэлснийг давтаж хэлдэг (эхолалия)
- Ярих сонирхолгүй хэрвээ засан сайжруулах сургалтад хамрагдахгүй бол хүүхэд томрох тусам улам ярих сонирхолгүй болдог.
- Өөрийн хэл яриандаа шүүмжлэлтэй ханддаг

Танин мэдэхүй талаас:

- Анхаарал сарнимтгай, анхаарлын хуваарилалт хязгаарлагдмал
- Утгачлан тогтоох болон хараа, сонсголын ой тогтоолт тодорхой түвшинд хөгжсөн байх боловч сонсоод тогтоох сэргээн санах чадвар сул байдаг.
- Хэл ярианы бэрхшээл нь сэтгэцийн хөгжлийг зарим талаар саатуулдаг боловч сэтгэн бодох үйл ажиллагаа нь өөрийн онцлог шинжтэй байдаг.
- Үгээр илэрхийлэх чадвар дутмаг учраас нэгтгэн дүгнэх, задлан ялгах, харьцуулах зэрэг үйлдлүүдийг хийж сурахдаа ихээхэн бэрхшээлтэй тулгардаг.

Хөдөлгөөний эвсэл талаас:

- Хөдөлгөөний эвсэл муу
- Аливаа дасгал хөдөлгөөнийг хийхдээ аймхай, итгэлгүй гүйцэтгэдэг. (жишээ нь: өндөр юм руу авирах, буух)

- Хөдөлгөөний хурд самбаа алдагдсан
- Аман зааварчилгаагаар үйлдэл гүйцэтгэхдээ сул
- Орон зай цаг хугацаагаар хэмжигдэх үйлдлийг муу гүйцэтгэдэг.
- Дасгал хөдөлгөөний дарааллыг орхих буюу хооронд нь хольж хутгадаг.
- Гарын жижиг булчингийн хөдөлгөөн сул, хөшүүн, нарийн хөдөлгөөн гүйцэтгэх чадвар (үдээс үдэх, уяа уях, товч товчлох, хурууны өндөгнүүдийг шилжүүлэн нийлүүлэх) муу хөгжсөн байдаг.

Зан төрх талаас:

- Хэт цочмог, ууртай, зодоонч бусдын эд зүйлийг дураараа авдаг (сэтгэл хөөрөл давамгайлсан)
- Бүрэг ноомой, зожиг ганцаардмал (сэтгэл хөөрөл сааталд орсон)
- Нийтийн дүрэм журам, ээлж дараалал баримтлах, ээлжлэх үйлдлийг хийхдээ тааруу
- Мэдрэмжээ илэрхийлэх чадвар дутмаг, буруу илэрхийлдэг
- Харилцагч нь гомдох байх, ингээд хэлбэл эвгүй сэтгэгдэл төрүүлэх байх гэж санаа зовохгүй, нөхцөл байдлыг шууд илэрхийлдэг.

Түүнчлэн хэл ярианы бэрхшээл нь хүүхдийн нийгмийн харилцааны чадварт сөргөөр нөлөөлдөг. Бэрхшээлтэй хүүхэд бусадтай хэрхэн харилцахаа мэддэггүй. Мөн эргэн тойрны хүмүүсийн гаргаж байгаа дуу авиа, үг хэл, яриаг ойлгохгүйн улмаас хүүхэд тухгүй байдлыг мэдэрч, түгшүүрт автах, аль болох харилцаанаас зайлсхийж, бүрэг ичимхий, өөртөө итгэлгүй болдог. Зарим хүүхдүүд гэр бүлийнхэнтэйгээ чөлөөтэй харилцдаг ч цэцэрлэг, сургууль дээрээ бусадтай ярьж харилцахгүй байдаг нь үүнтэй холбоотой юм.

СЭДЭВ 2: СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРЫГ АШИГЛАН ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Зорилго: Суралцахуйн түгээмэл загварыг ашиглан хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг тайлбарлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар ойлголттой болж, ашиглаж турших
- Эдгээр арга зүйг суралцахуйн түгээмэл загварын зарчмуудтай уялдуулан хэрэгжүүлэх талаар бусдад тайлбарлах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, скоч
- Хавсралт 2: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн өөрийгөө илэрхийлэх аргуудыг тайлбарлах (25 минут)

1. Оролцогчдыг хоёр хоёроороо өөд өөдөөсөө харж байгаад дохио зангаа, биеийн хэлэмжээрээ өнөө өглөө сургалт руугаа хэрхэн явж ирсэн, өглөөний цайндаа юу уусан зэргээ илэрхийлэхийг хүснэ.

(Эхний хүн – хэрхэн явж ирснээ, 2 дахь хүн – өглөөний цайндаа юу ууснаа илэрхийлнэ)

2. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн өөрийгөө илэрхийлэх аргуудыг тайлбарлана.

Үйл ажиллагаа 2: Суралцахуйн түгээмэл загварыг ашиглан хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг тайлбарлах (60 минут)

1. Оролцогчдыг 3 багт хуваана. Баг тус бүрт дараах асуултаас нэг нэгийг оноон өгч, багаараа ярилцан өөрсдийн санааг дэлгэц цаасан дээр бичнэ.
 - Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийг **сэдэлжүүлж оролцоог хангах** аргууд
 - Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдэд олон хэлбэрээр **үзүүлэх** аргууд
 - Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд сурсан мэдсэн зүйлээ олон хэлбэрээр **илэрхийлэх** аргууд
2. Баг тус бүр бичсэн зүйлээ ээлжлэн танилцуулна. Бусад багаас асууж тодруулах болон нэмэх зүйл байвал нэмж ярилцана.

3. Тэдний хэлсэн зүйлд тулгуурлан сургагч багш хавсралт 1-д байгаа мэдээллийг танилцуулж, нэгдсэн ойлголтод хүрнэ.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Та бүхэн тус сэдвийн хүрээнд ямар, ямар аргуудыг шинээр мэдэж авсан бэ?
- Суралцахуйн түгээмэл загварын гурван зарчим тус бүрт тохирох аргуудыг нэрлэнэ үү.

ХАВСРАЛТ 1

СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРЫГ АШИГЛАН ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлэхийн өмнө багш тухайн сурагчийн бодит байдал, хэрэгцээ сонирхол, өөрийгөө илэрхийлэх байдал, харилцааны хэлэмж зэргийг ажиглалт, мөн өөртэй нь болоод эцэг эхтэй нь ярилцах замаар тухайн хүүхдэд тохирсон аргыг сонгож олох нь зүйтэй.

Ажиглалтын явцад багш тухайн хүүхдийн юу чадахгүй байгааг зөвхөн харах биш харин юу чадаж байгааг мөн олж харах хэрэгтэй.

Харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд үг хэлээр ярихгүй ч өөрийгөө олон арга замаар илэрхийлж байдаг. Үүнд:



➤ Хүүхдийн сонирхолд тулгуурлан хичээлээ заах нь илүү үр дүнтэй

Аутизмтай хүүхдүүд ихэнхдээ тодорхой нэг сэдэв эсвэл эд зүйлд (тоглоом, тодорхой нэг бүтэц найрлага, комик дүр, түүхэн хүн гэх мэт) онцгой их анхаарч, ач холбогдол өгдөг учир багш хүүхдийн сонирхлоор дамжуулж, өдрийн тодорхой цагуудад хүүхдийн оролцоог хангасан хэлбэрээр хичээлээ зааж болно.

➤ Хүүхдийн суурь чадвар дээр үндэслэж, хичээлээ заах

Хүүхдийн суралцахуйн үйл явцыг дэмжиж, хөгжлийн дараагийн шатанд хүрэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх гол хүн нь багш юм. Жишээ нь: Багш хүүхдийн хэлсэн үгийг давтаж хэлэхдээ үг нэмэх замаар өгүүлбэрийг баяжуулж болно.

Жишээгээр тайлбарлавал хүүхэд шил рүү заагаад “УУ” гэвэл багш түүнийг

буцааж хэлэхдээ “УС” болгож өөрчлөх, хүүхэд “БӨМБӨГ” гэвэл багш “УЛААН БӨМБӨГ”, хүүхэд “ААВ ЯВЧИХЛАА” гэвэл багш “ААВ ДЭЛГҮҮР ЯВЧИХЛАА”, хүүхэд “ТОГЛООМ УС УУЯ” гэвэл “ХҮҮХЭЛДЭЙ ЧИНЬ АМ НЬ ЦАНГАСАН ЮМ УУ, УС УУМААР БАЙНА УУ?” гэх мэтээр тухайн нөхцөлд байдалд нь тохируулж хүүхдийн хэл ярианы чадварыг хөгжүүлж болно.

Хэрэв хүүхэд ямар нэг зүйлийг буруу хэлбэл багш заавал алдааг нь тодотгох шаардлагагүй. Тухайн хүүхдийг юун дээр алдаж буйг ажиглаад зөв хувилбарыг хариултаараа өгөхөд болно. Жишээ нь, хүүхэд нохой руу заангаа “ХАВ, ХАВ” гэвэл багш “ТИЙМЭЭ ЭНЭ БОЛ НОХОЙ. НОХОЙ ХАВ ХАВ ГЭЖ ДУУГАРДАГ” гэж хариулах хэрэгтэй.

➤ Ярьдаггүй хүүхдийн нийгмийн харилцааг дэмжих, урамшуулах

Хамт тоглох

Хэрэв бусадтай тоглох дургүй хүүхэд байвал багш тухайн хүүхдийг удирдан чиглүүлэх хэрэгтэй. Ингэхдээ чимээгүйхэн хүүхдийн хажууд очоод үйлдлийг нь дуурайх, тоглоомд нь оролцох зэргээр хамт тоглож эхэлнэ. Хүүхэд юунд төвлөрч, юуг сонирхон харж буйг сайтар ажиглах бөгөөд тухайн хүүхдийг эхэлж харилцан яриа эхлүүлэх хүртэл тэвчээртэйгээр хүлээгээрэй.

Хүүхдийн хийж буй үйлдэлд багш тайлбар хэлэх

Асуулт асуухаас илүүтэй хийж буй үйлдэлд нь санал сэтгэгдэл хэлбэл харилцааны бэрхшээлтэй хүүхдүүд харилцан ярилцаж эхэлдэг. Хэрэв багш “тийм”, “үгүй” гэж хариулагдах богинохон асуулт асуувал харилцан ярианы эрч буурдаг. Түүний оронд “Чи үнэхээр өндөр цамхаг босгожээ” гэх мэтээр хүүхдийн үйлдэл дээр сэтгэгдлээ хэлэх замаар харилцвал илүү үр дүнтэй. Энэхүү сэтгэгдэл хэлэх арга нь хийж буй зүйлээс нь хүүхдийн анхаарлыг сарниулахгүй байхаас гадна хүүхдийн ярианы хөгжлийг дэмжиж өгдгөөрөө давуу талтай юм.

Харилцан яриа - жишээ

Хүүхэдтэй харилцахдаа насанд хүрэгчдийн яриа нь тодорхой харилцан ярианы бүтэцтэй байх бөгөөд гол нь насанд хүрэгчээс хүүхдэд зориулсан асуултад хамаардаг бөгөөд тэр өөрөө хариулт өгдөг.

- энэ юу вэ? - аяга
- би юу авсан бэ? - аяга
- чи энд юу тавьсан бэ? - аяга гэх мэт.

Өөртэйгөө ярих

Насанд хүрэгч харсан, сонссон зүйлээ хүүхдийн хажууд чангаар хэлнэ. “Цамц хаана байна?”, “Цамц энд байна”, “Цамц сандал дээр байна”, “Гоё цамц байна” гэх мэт. Ингэхдээ удаан (гэхдээ үг сунжруулахгүйгээр) тодорхой, ойлгомжтой ярих нь чухал юм.

Зэрэгцээ харилцан яриа

Энэ техник нь өмнөхөөсөө ялгаатай нь хүүхдийн харж, сонсож, хүрч байгаа зүйл гэх мэт хийж буй бүх үйлдлийг дүрсэлсэн байдаг. Энэ арга нь хүүхэд өөрийн хийж буй үйлдэл, хэрэгцээгээ үгээр илэрхийлж ярьж сурахад үр дүнтэй байдаг.

Хүүхдийг өдөөн хатгах, эсвэл зохиомлоор үл ойлголцох

Хүүхдийн хүслийг нэн даруй биелүүлэх гэж яаралгүй, түүний чимээгүй заасан тоглоомыг биш харин өөр тоглоом өгнө. Насанд хүрсэн хүн түр зуур «юм сонсохгүй», «юм ойлгохгүй» болж: «Чи юу хүсэж байгааг би ойлгохгүй байна: бамбарууш уу, хүүхэлдэй юу, машин уу?» гэх мэтээр асууна. Насанд хүрэгчдийн «ойлголтгүй байдал» нь нялх хүүхдэд авах гэсэн тоглоомоо нэрлэхийг өдөөдөг анхны сэдэл байх болно.

Дуулж харилцах

Хүүхдүүдтэй хамт хүүхдийн дууны аянд ярих, хэлэх зүйлийг оруулж дуулж харилцах нь тэдэнд маш их баяр баясгалан өгдөг.

Дуурайж дуугарах

Амьтан, гол горхи, эд юмсын дууг дуурайж дуугарах нь хүүхдийн яриаг хөгжүүлэх, идэвхжүүлэх үр дүнтэй арга юм.

Сонголт хийлгэх

Хүүхдэд сонгох боломжийг олгоно. Сонгох боломжийг ашиглах нь түүнд өөрийн ач холбогдол, өөрийгөө үнэлэх мэдрэмжийг өгдөг. «Чи бөмбөгөөр тоглохыг хүсэж байна уу, эсвэл машинаар тоглох уу?», «Сүү уух уу, эсвэл цай уумаар байна уу?» гэх мэт асуулт асууна. Хариултыг хүүхэд заавал үгээр илэрхийлэх ёстой. Хүүхдийн сонголт нь үгээр хариу үйлдэл хийсний дараа л хангагдана.

Жүжигчилсэн болон дүрийн тоглолт

Хүүхдийн сайн мэдэх үлгэрийн баатар, дүрд хувирах, утсаар ярих, худалдагч, худалдан авагч болох зэргээр тоглох нь мөн хүүхдийн хэл яриа, харилцааны чадварыг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Ээрүү хүүхдийн оролцоог дэмжих хамгийн боломжит хувилбарыг ашиглах

Ээрүү хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих хэд хэдэн арга бий. Үүнд:

- Хүүхдийн өмнөөс үгийг нь гүйцээх гэж яарах хэрэггүй - Хүүхдэд үгээ гүйцээх хугацаа олгоорой. Хүүхдийг ээрсэн үед өмнөөс нь үгийг нь гүйцээгээд хэлчихвэл амар санагдаж болох ч хүүхдэд үгээ гүйцээж хэлэх цаг өгч, яаруулахгүй байх нь хамгийн үр дүнтэй арга юм. Бусад хүүхдүүд мөн ярианахаа хэмнэлийг удаашруулах, цэгцтэй ойлгомжтой ярих зэргээр тухайн хүүхдэд яарах шаардлагагүй гэдэг дохиог өгөх хэрэгтэй.

- Хүүхдэд “Яриагаа удаашруулаарай, хурдлаарай эсвэл гүнзгий амьсгаа аваарай” гэж хэлэх хэрэггүй. Ээрдэг хүн өөрийнхөө хэл ярианд учирдаг бэрхшээлүүдийг анзаардаг ч үүнийгээ засах боломжгүй байдаг учраас бусад хүмүүсийн зөвлөгөөг төдийлөн сайшаадаггүй.
- Самбарын өмнө гарах, илтгэх тавих зэрэг стресс ихтэй нөхцөл байдалд хэрхэн өөрийгөө удирдах талаар ярилцаж, ойлголцох. Хүүхэд аль болох бэлтгэлтэй байх тусмаа стресстэй нөхцөл байдал тулгарахад өөрийгөө удирдаж, даван гарч чаддаг. Харилцааны бэрхшээлтэй хүүхэд хичээлийн туршид аль болох бусдын өмнө гарах, санаагаа ойлгуулах зэрэг нийгмийн харилцааны чухал чадваруудыг эзэмшиж байх хэрэгтэй. Гэхдээ багш үүнд хэт их ач холбогдол өгч, хүүхдийг онцгойрон анхаараад эхэлбэл бэрхшээлтэй хүүхэд стресс мэдэрч, түгшүүрт автаж эхэлдэг байна. Тиймээс багш нар хэрхэн стресстэй орчинд өөрийгөө илэрхийлэх вэ гэдгийг тухайн хүүхэдтэй сайн ярилцах хэрэгтэй.
- Хүүхдийг нэрсийн дарааллаар эсвэл ширээ ширээгээр нь дуудаж, чанга унших дасгал хийлгэх нь ээрүү хүүхдийн хувьд бүр хүндрэлтэй байдаг. Учир нь хүүхэд ээлжээ хүлээх зуураа тогтворгүй болж, түгшүүрт автаж эхэлдэг. Иймд багш тухайн хүүхдийн нэрийг хамгийн эхэнд дуудах болон тохиолдлоор дуудах аргуудыг хэрэглэж болно. Хүүхэдтэйгээ ярилцсаны үндсэн дээр аль нь тохиромжтой болохыг шийдээрэй.
- Хэрэв ангийн сурагчдаас дээрэлхсэн, тохуурхсан өнгө аяс мэдрэгдвэл багш асуудлыг нэн даруй шийдэх хэрэгтэй. Удах тусам хүүхдийн ээрүү байдал хүндэрнэ.
- Бусдыг сонсох чадвар, ээлжээ хүлээх, бусадтай найрсаг харилцах, цэвэрлэгээнд туслах, урлаг спортын авьяас зэрэг сайн чаддаг зүйлийг нь урамшуулан магтаарай.
- Хүүхдийн үгийн санг баяжуулах
Багш аливаа сэдвийг заахдаа тухайн сэдэвтэй холбоотой хүүхдийн өмнөх мэдлэг ойлголт дээр нь тулгуурлан заавал үр дүнгээ өгдөг. Зарим сурагчид багшийн заах гэж буй сэдвийн талаар ямар ч ойлголтгүй байж мэднэ, ойлголттой ч шинээр заах үед сэдэвтэй хэрхэн уялдахыг мэдэхгүй байж болно. Тиймээс өмнөх мэдлэгийг сэргээж, танин мэдэхүйн чадваруудыг идэвхжүүлэх, эсвэл шинээр зааж буй сэдэв нь өмнөх мэдлэгтэй нь хэрхэн холбогдохыг тайлбарлаж өгөх зэргээр хүүхдийн суралцахуйг олон янзаар дэмжиж болно. Нэмэлт аргуудыг дурдвал:
 - Хүүхдийн өмнөх мэдлэгийг сэргээхийн тулд утгын зураглал хийх
Сурагчдыг баг болгон хувааж хичээлийн сэдвийн талаар а) юу мэдэх, б) юуг мэдмээр байна, в) хичээлийн төгсгөлд юу сурснаа эргэж дүгнэж, ярилцах даалгавар өгөөрэй. Сурагч сэдвийн талаар юу мэдэж буйгаа заавал хэл

яриагаар илэрхийлэх шаардлагагүй бөгөөд цаасыг гурван багана болгон нугалаад дээр нь зурах эсвэл утгын зураглал хийж болох юм. Мөн бичих чадварт сайн суралцагчийг сонгон бүлэгт ярилцсан санааг бичүүлж болно.

- Сурагчдад ойлгуулах ёстой гол санаагаа урьдчилан бэлдэх

Багш зааж буй сэдвийн гол агуулгаа бэрхшээлтэй хүүхдэд хэрхэн ойлгуулах арга зүйгээ хичээл эхлэхээс өмнө төлөвлөх нь зүйтэй. Ингэхдээ аудио ном, диаграмм үзүүлэн, бичлэг, харьцуулалт эсвэл зүйрлэлийн аргуудаас тохиромжтойг нь ашиглаж болно. Хүүхдэд тохирч буй аргыг эцэг эхэд нь мөн тайлбарлаж таниулбал тухайн хүүхэд сургуулийн орчноос гадна гэртээ суралцах боломж бүрдэнэ.

СЭДЭВ 3: ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИХ ТӨХӨӨРӨМЖ, ТОХИРУУЛГАТ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Зорилго: Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих, туслах төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг танилцуулах, тайлбарлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, хэрэглэгдэхүүний талаар тайлбарлах
- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг сургалтад тохируулан ашиглаж сурах

Хугацаа: 60 минут

Хэрэглэгдэхүүн:

- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйг хөнгөвчлөх туслах төхөөрөмж, хэрэглэгдэхүүнүүд
- Хавсралт 1: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Туршлага солилцох (20 минут)

1. Оролцогчид хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа ямар ямар дэмжих төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг хэрхэн бэлтгэн хэрэглэдэг талаар өөрсдийн арга, туршлагаа хуваалцана гэдгийг хэлнэ. Оролцогч бүр өөрийн сайн туршлагаа хуваалцан ярина.
2. Бусад оролцогчдын зүгээс асууж тодруулах, нэмж хэлэх санал байгаа эсэхийг лавлаж, харилцан ярилцана.

Үйл ажиллагаа 2: Сургалтын хэрэглэгдэхүүний судлах (35 минут)

1. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйг хөнгөвчлөх туслах төхөөрөмж, хэрэглэгдэхүүний зураг, бодит хэрэглэгдэхүүнийг үзүүлэн, тэдгээрийн зориулалт, хэрхэн ашиглах талаар хавсралт 1-д байгаа мэдээллийг танилцуулж тайлбарлана.
2. Оролцогчдоос асуух, тодруулах зүйл байгаа эсэхийг лавлаж, эдгээрээс алийг нь түлхүү хэрэглэдэг талаар харилцан ярилцана.

Дүгнэлт (5 минут)

Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан, хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдэд зориулан сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн хийж, ашиглах боломжтой талаар ярилцаж дүгнэнэ.

ХАВСРАЛТ 1

ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИХ ТӨХӨӨРӨМЖ, ТОХИРУУЛГАТ СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн харилцааг дэмжих зорилгоор энгийн зурагт карт, эд зүйлсийн болон үйл явдалт зургуудаас эхлээд олон үйлдэл бүхий дижитал хэрэглэгдэхүүнүүдийг сургалтад өргөнөөр ашигладаг. Эдгээр хэрэглэгдэхүүнийг тухайн хүүхдийн хэрэгцээнд тохируулан багш нар өөрсдөө хийж болох ба цахим, олон үйлдэлт төхөөрөмж нь худалдаанд өргөн байдаг.

➤ Хөгжимт, дуут, зурагт номууд



Зориулалт: Хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжих, үгийн нөөцийг нэмэгдүүлэх, авиан сонгол хөгжүүлэх чухал ач холбогдолтой. Хөгжимт, дуут тоглоом, зурагт хуудаснууд үлгэр, шинжлэх ухааны хялбаршуулсан эх, дуунаас агуулсан байдаг. Өөр дээрээ мэдрэгчтэй товчлууртай байдаг. Батарейгаар ажилладаг. Тоглоом нь асах, унтрах товчлууртай. Тоглоомууд нь хэлбэр, загварын олон сонголттой. Бага насны хүүхдийн сонирхол татдаг, дуртай хүүхэлдэйн баатрыг амилуулан, загвар болгон ашиглах нь олонтоо. Жишээлбэл, “Ами, Тами хоёр”, “Пороро монгол хэлээр”, “Цэцэн туулай”, “Унагалдай” гэх мэт.

Ашиглах заавар: Асах товчлуурыг асаасны дараа амьтан эсвэл сонсох үлгэр, дуу, танин мэдэхүйн эх, амьтны дуу гэх мэтийн ойролцоох товчлууруудыг дарснаар тухайн үлгэр, дуу, эхүүдийг сонсох боломжтой болно. Зарим тоглоомууд нь өөрийн олж авсан мэдлэгээ асуултад хариулах замаар шалгаж болно. Хэл яриа хөгжүүлэх үйл ажиллагаанд түлхүү ашиглана. Багш хичээлийн агуулгаас шалтгаалан тоглоомыг оновчтой сонгох нь чухал.

➤ **Хөгжимт, дуут тоглоомууд**



Зориулалт: Сонсголын хүртэхүй хөгжүүлэх чухал ач холбогдолтой. Тоглоомууд нь хэлбэр, загварын олон сонголттой.

Ашиглах заавар: Дуу чимээг ялгуулах, ритм, хэмнэлтэй цохих, дуугаргах, нэгэн зэрэг, ижил өнгө хэмнэлээр дуугаргах зэргээр ашиглана.

➤ **Зурган карт солилцох замаар харилцах**



Зориулалт: Өөрийгөө хэл яриагаараа илэрхийлж чаддаггүй хүүхэд зураг ашиглан юу хүсэж буйгаа илэрхийлж болно. Багш хүүхдийн харахыг эсвэл хийхийг хүссэн зүйлийг илэрхийлсэн зургийг солилцох байдлаар ашигладаг. Хүүхэд нэг зурагтай харьцаж эхлэх ба аажмаар хэрэглэдэг зурагнууд нэмэх байдлаар багштай харилцана.

Ашиглах заавар: Хүүхэд авахыг хүссэн зураг болон эд зүйл рүү хуруугаараа заах, авчрах нь багшид дохио өгч, үйлдэл хийхэд хүргэдэг гэдгийг хүүхдэд зааж өгөх хэрэгтэй. Тиймээс эхний алхам нь хүүхэд авахыг хүссэн эд зүйлтэй зургаараа дамжуулж харилцаа үүсгэхээс эхэлнэ. Багш тухайн үед хүүхдийн хажууд сууж, шаардлагатай тохиолдолд дэмжинэ. Багш аажмаар дэмжлэгээ багасгаснаар хүүхэд зургаар дамжуулан өөрийгөө бүрэн илэрхийлэх чадварт суралцана.

➤ Эхний үе шат - Зургаар дамжуулан хүсэлтээ илэрхийлж сурахад сургах

Хүүхэд ямар нэгэн хөдөлгөөн хийх үед багш зургийг үзүүлж, тэднийг зургаар дамжуулан хүсэлтээ илэрхийлж буйг магтах хэрэгтэй. Хэрэв тухайн хүүхэд багшийг ойлгохгүй бол эд зүйл танилцуулж, хүүхдийг аажмаар зурагт дасгаж болно.

➤ Хоёрдугаар шат - Холын зай ба тууштай байдал

Зургийг хүүхдээс тодорхой хэмжээнд хол самбарт байршуулна. Мөн багш болон хүүхдийн хоорондын зайг аажмаар нэмнэ.

➤ Гуравдугаар үе шат – Тэмдэгтүүдээс сонголт хийх

Илүү олон зургийг самбар дээр аажмаар байрлуулах бөгөөд хүүхэд хүссэн зургаа сонгох шаардлага тулгарна. Хүүхэд үүнийгээ багшид дахин танилцуулж, эергээр сонголтоо бататгана.


Гарын жижиг булчин хөгжүүлэх хэрэглэгдэхүүн



Зориулалт: Гарын жижиг булчингийн хөдөлгөөнийг хөгжүүлэх зориулалттай. Хүний тархины бүтэц, зохион байгуулалт, онцлогоос хамааран тархин дах хэл ярианы бүс, гарын жижиг булчингийн хөдөлгөөнийг хариуцсан бүс хамт зэрэгцэн оршдог. Ийм учраас хэл яриа, анхаарал, ой тогтоолт, дүрслэн бодох чадвар, гарын жижиг булчин хөгжүүлэх зорилгоор хэрэглэнэ.

Ашиглах заавар: Төрөл бүрийн хэлбэртэй дүрс, шүрийг утсанд нэг нэгээр хэлхэх, үдээс үдэх, хэвээр зурах, будах, элсэн самбар дээр зураг зурах, үсэг бичих, шагай няслах зэрэг үйлдлийг хийснээр гарын жижиг булчингийн хөдөлгөөн сайжирна.

➤ **Харилцаа, хэл ярианы бэрхшээлтэй (аутизмтай) хүүхдэд зориулсан “ШУВУУ” АППЛИКЕЙШН**



Зориулалт: Өөрийгөө илэрхийлэх болон, хэрэгцээгээ илэрхийлэхэд зориулагдсан.

Ашиглах заавар: Аппликейшнаа ашиглан зурган мэдээлэл дээр дарж өөрийн хэрэгцээтэй үгээ бүтээхэд аппликейшн түүнийг уншиж, бичиж харуулна.

СЭДЭВ 4: ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Зорилго: Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог нэмэгдүүлэн, хамтран ажиллах арга зүйн талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн гэр бүл дэх хэлний орчныг судлах аргыг тодорхойлох
- Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах аргыг тайлбарлах
- Оролцогчид харилцан туршлага солилцох

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Хавсралт 1: Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад зориулан хэвлэсэн зөвлөмж, гарын авлагын зураг
- Хавсралт 2: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Гарын авлагыг танилцуулах (15 минут)

1. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах талаар оролцогчдыг хаанаас ямар мэдээлэл авч ашигладаг болохыг асууж ярилцана.
2. Оролцогчдод хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад зориулан хэвлэсэн зөвлөмж, гарын авлагаас (хавсралт 1) танилцуулж, агуулгыг тайлбарлана.

Үйл ажиллагаа 2: Зөвлөгөө өгөх чиглэл (45 минут)

1. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн гэр бүлд ямар зөвлөгөө өгдөг талаар оролцогчдоос асууж ярилцана.
2. Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн гэр бүл дэх хэлний орчныг судлах арга, эцэг эх, асран хамгаалагчид өгөх зөвлөгөөний чиглэлийг хавсралт 2-т байгаа мэдээллийг танилцуулна.

Үйл ажиллагаа 3: Сайн туршлага хуваалцах (25 минут)

1. Оролцогчдыг хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр тэдний эцэг эх, асран хамгаалагчтай хэрхэн хамтран ажилладаг талаар туршлагаа бусадтай хуваалцахыг хүснэ.
2. Оролцогчид эцэг эх, асран хамгаалагчтай хэрхэн хамтран ажилладаг талаарх

өөрийн сайн туршлагыг ээлжлэн танилцуулна.

3. Бусад оролцогчдын зүгээс тухайн туршлагатай холбоотой тодруулах зүйл, нэмэлт санал байгаа эсэхийг асууж, харилцан ярилцана.

Дүгнэлт (5 минут)

Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан, цаашид хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай хэрхэн хамтран ажиллах талаарх оролцогчдын санаа бодлыг сонсож сэдвийг дүгнэн ярилцана.

ХАВСРАЛТ 1



ХАВСРАЛТ 2

ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн гэр бүл дэх хэлний орчныг судлах арга

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үр дүн нь багш, эцэг эх, асран хамгаалагчийн нягт хамтын ажиллагаа, хичээл зүтгэлээс шууд хамааралтай юм.

Эцэг эхтэй хамтран ажиллахын тулд юуны түрүүнд тухайн хүүхдийн гэр бүл дэх хэлний орчныг судлах хэрэгтэй. Үүний тулд гэр бүлийн гишүүд, эцэг эх, асран хамгаалагчтай ярилцах, асуулга, ажиглалтын аргыг хэрэглэж болохоос гадна гэр бүлийн харилцаа, мэдээллийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас асуухгүй судлах арга байдаг. Үүнд:

- Хүүхдээр гэр бүлийн гишүүдийн тухай “Миний гэр бүл” сэдэвт зураг зуруулах ба энэхүү зургаас гэр бүлийн гишүүдээс хэнтэй илүү ойр байдаг, гэр бүлийн гишүүдийн тухайн хүүхдэд хандах харилцаа хандлага, хүүхдийн өөрийн үнэлэмж, сонирхол зэрэг олон зүйлийг мэдэж болно.
- Хувь хүний, гэр бүлийн ном аялуулах
- Ангидаа захидал илгээдэг “Аялагч Тэди” (Тэди тухайн зочилсон айлдаа юу хийснийг бичиж тэмдэглэн, зургийг авч явуулдаг) аялуулах гэх мэт.

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах

Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад өгөх зөвлөгөөг дараах чиглэлээр явуулж болно. Үүнд:

1. Зөвлөн туслах
2. Хэл яриа, харилцааг хөгжүүлэх
3. Урьдчилан сэргийлэх

Зөвлөн туслах. Эцэг эхэд хүүхдийн хэл яриа, харилцааны онцлог байдлын талаар бодит мэдээлэл өгч, ямар чиглэлээр, юун дээр анхаарч, хэрхэн ажиллах талаар зөвлөн хамтран ажиллана.

Хүүхдийн хэл яриа, харилцааны талаар эцэг эх, асран хамгаалагч дараах зүйлийг мэдэх нь чухал.

- хүүхдийн хэл яриа даган дуурайх замаар хөгждөг тул эцэг эх, асран хамгаалагч өөрсдөө зөв ярих
- хүүхэд авиа, үгийг буруу дуудаж хэлж байвал засаж хэлж өгөх
- хүүхэдтэйгээ эерэг сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлж харилцаж байх
- хүүхдийнхээ үгийн нөөцийг нэмэгдүүлэхийн тулд шинэ үг зааж хэлж өгөх, хүүхдийн зурагтай ном үзүүлэх, ном уншиж өгөх, ном уншуулах, агуулга, үйл явдлын талаар харилцан ярилцах
- хүүхдийн хэл ярианы хөгжилд бэрхшээл, эмгэг согог үүсэж болох эмзэг үеүд /1-2 нас, 3-5 нас, 6-7 нас/ байдаг тухай мэдэх
- хүүхэдтэйгээ байнга харилцан ярилцаж, тэдний тавьсан асуултад нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хариултыг заавал өгч байх
- хүүхдийг айлгаж цочоохгүй байх
- гэр бүлийнхээ сэтгэл зүйн уур амьсгалыг ая тухтай байлгахад анхаарах

Хэл яриа, харилцааг хөгжүүлэх. Хүүхдийн хэл яриа, харилцааг хөгжүүлэх ажил нь тухайн хүүхдийн хэл яриа, харилцааны онцлог байдлаас шалтгаалан янз бүр байна. Иймээс нэн түрүүнд юунд анхаарч ажиллах талаар багш, эцэг эх, асран хамгаалагч харилцан ярилцаж, хамтран төлөвлөнө.

Урьдчилан сэргийлэх. Хэл яриа, харилцааны бэрхшээл нь бие организмын өвчлөл, уураг тархины үйл ажиллагааны эмгэг өөрчлөлттэй холбоотой байдаг. Иймээс хүүхдийг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн өсөлт хөгжлийг анхаарах, хэрэв ямар нэгэн өөрчлөлт ажиглагдвал цаг алдалгүй мэргэжилтэнд хандан зөвлөгөө авах хэрэгтэй.

СЭДЭВ 5: ХЭЛ ЯРИА, ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙГ – ДАСГАЛ АЖИЛ

Дасгал ажил 1

Зорилго: Хэл яриа, харилцааны бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг танин мэдэх, тохирох арга зүйг хамтдаа илэрхийлэх, ангидаа эерэг суралцахуйн орчин бүрдүүлэх

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Өгөгдсөн кейст тохирох арга зүйг сонгон түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
- Боловсруулан төлөвлөгөөний талаар санал бодлоо солилцон хэлэлцүүлэг зохион байгуулах

Хугацаа: 30 минут

Кейс 1.

Сурагч М 7 настай. Тэр ангийнхантайгаа чөлөөтэй харилцаж, өөрийгөө ойлгуулж чаддаггүй. Багшийн асуусан асуултад ч хариулдаггүй. Багшийн зүгээс өмнө нь ийм төрлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан туршлагагүй учраас түүнтэй хэрхэн харилцах аргаа мэдэхгүй байгаа.

Энэ тохиолдолд яах вэ?

1-р алхам	2-р алхам	3-р алхам	4-р алхам
<i>Багш ангийн сурагчдыг 4-5 бүлэг болгон хуваах</i>	<i>Багш бүрт хэл яриа харилцааны бэрхшээлтэй хүүхдийн талаарх ерөнхий, харилцааны аргуудыг хэвлэж тарааж өгөх</i>	<i>Багийн гишүүд багшийн бэлдэж өгсөн арга зүйгээс сурагч М-д тохирох арга зүйг хамтдаа сонгож түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах</i>	<i>Багийн ахлагч нар төлөвлөгөөгөө бусдадаа танилцуулж, санал солилцох</i>

Заавар:

Дасгал ажил 2

Зорилго: Харилцааны бэрхшээлтэй хүүхэдтэй хэл ярианаас өөрөөр харилцах арга техникт суралцах

Зорилт:

- Зурган карт хэрхэн бэлтгэх, хэрхэн хэрэглэх талаар ойлголттой болох
- Зурган картын загвар жишээтэй танилцах

Хугацаа: 30 минут

Үйл ажиллагаа: Зурган картын төрөл, хэрхэн ашиглах, хэрхэн бэлтгэх тухай сургагч багш хавсралт 1-т байгаа мэдээллийг танилцуулж, тайлбарлана.



ХАВСРАЛТ 1

Зурган карт ашиглах арга

Зурган карт ашиглан харилцаж сурах сургалтын үйл явц нь өөрөө үе шаттайгаар явагдах ёстой.

1. Материал бэлтгэх. Хамгийн эхний хийх зүйл бол хүүхдийн сонирхлын хүрээг тодорхойлох явдал юм. Та хүүхдэд хамгийн их хэрэгцээтэй байдаг эдгээр үйл ажиллагаа эсвэл эд зүйлсээс эхлэх хэрэгтэй.
2. Чадварыг хөгжүүлэх. Энэ үе шатанд хүүхдэд хүссэн дүрс бүхий картыг олж, санал бодлоо илэрхийлэхийн тулд ярилцагчдаа дамжуулахыг заах шаардлагатай. Жишээлбэл, татгалзсан эсвэл зөвшөөрч байгаагаа дохио зангаагаар хэрхэн харуулахаа мэдэхгүй байгаа хүмүүст “үгүй”, “тийм” гэсэн утгатай цэнхэр, улаан гэх мэт хоёр өнгийн картыг хөтөлбөрт оруулах хэрэгтэй. Хүүхэд тэдний тусламжтайгаар өөрийн үзэл бодол, хүслээ бусдад илэрхийлж, үр дүнд нь хүссэн зүйлээ олж авах боломжтой гэдгийг ойлгох хүртэл ийм картуудыг ашиглах ёстой.
3. Урам зориг. Хүүхдийг суралцах сонирхолтой болгохын тулд та түүний хамгийн дуртай үйлдэл эсвэл эд зүйлийг дүрсэлсэн урам зоригийн картуудыг сонгон авах хэрэгтэй. Хүүхэд дүрсийг нь харахгүйгээр тухайн үгийг хэлж сурах хүртэл та тэдгээрийг ашиглах хэрэгтэй. Хүүхэд хүссэн зүйлээ үгээр илэрхийлэхийг оролдсон даруйд энэ картыг нэн даруй хэрэглэхээ болих нь зөв.

Хүүхэд бүх зургуудаас хүссэн үйлдэл, эд зүйлийг ялгаж сурсан үед та үйл явдал бүхий карт ашиглаж эхлэх боломжтой. Жишээлбэл, «шүдээ угаах», «идэх», «алхах», «тоглоомын талбай дээр тоглох», «хүүхэлдэйн кино үзэх» гэх мэт. Үүний нэгэн адил хүүхдийг хэд хэдэн картыг зөв дарааллаар нь байрлуулснаар өгүүлбэр зохиож сургаж болно.

МОДУЛЬ 7:

СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ



Зорилго	Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн онцлогийг танин мэдэж, тус бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах, тэдэнтэй ажиллах арга зүйг эзэмших
Зорилт	<ul style="list-style-type: none"> ▪ Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийг тэгш хамран сургах талаар үндсэн ойлголттой болох ▪ Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжих, багш, эцэг эхтэй хамтран ажиллах арга зүйг эзэмших ▪ Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд чиглэсэн сургалтын орчин, хэрэглэгдэхүүний талаар тайлбарлах
Хугацаа	5 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. СХЗҮЭ-тэй хүүхдийн онцлог ба зан үйлийн үнэлгээ (90 минут)</p> <p>Сэдэв 2. СХЗҮЭ-тэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжих, багш, эцэг эхтэй хамтран ажиллах арга зүй, стратеги (120 минут)</p> <p>Сэдэв 3. СХЗҮЭ-тэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжих төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн (90 минут)</p>	

СЭДЭВ 1: СХЗҮЭ-ТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ БА ЗАН ҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ

Зорилго: Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн онцлогийг танин мэдэж, асуудал бүхий зан үйлийг үнэлж сурах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгийн талаар ерөнхий ойлголттой болох
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн талаар багш нарын мэдвэл зохих зүйлийг тайлбарлах
- Асуудал бүхий зан үйлийг үнэлэх үнэлгээний нэг аргыг хэрэглэж турших

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Хавсралт 1: Тараах материалыг нийт оролцогчийн ½ тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Тараах материалыг нийт оролцогчийн ½ тоогоор хэвлэх
- Хавсралт 3: Үнэлгээний хуудсыг багийн тоогоор хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгийн талаарх ойлголт (25 минут)

1. Тус сэдвийн хүрээнд сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн онцлогийн талаар судална гэдгийг хэлнэ. Оролцогчдыг хосоороо ажиллахыг хүснэ. Хос бүр дотроо 1 ба 2 гэж тоолох бөгөөд тэдэнд дараах даалгавар өгнө.
 - Хос бүрийн 1 гэсэн дугаартай хүн – сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн онцлогийн талаар,
 - 2 гэсэн дугаартай хүн – багш нарын мэдвэл зохих зүйлийн талаар дэвтэртээ жагсаан бичнэ. Тэдэнд 2 минутын хугацаа өгнө.
2. Хоёр минутын дараа өөрсдийн бичсэн зүйлээ бие биедээ ээлжлэн танилцуулна.
3. Багш хавсралт 1-ийг 1 гэсэн дугаартай хүмүүст, хавсралт 2-ыг 2 гэсэн дугаартай хүмүүст тарааж өгнө. Хүн бүр өөрт оногдсон материалыг уншиж судлаад, хосдоо тайлбарлаж өгнө. Тайлбарлах явцдаа өмнөх өөрсдийн бичсэн жагсаалттай ижил төстэй болон ялгаатай зүйлийг ярилцана.
4. Ярилцаж дууссаны дараа том бүлгээрээ хамтран тэдний өмнөх төсөөлөл болон унших материал дахь мэдээллийг нэгтгэн дүгнэж ярилцана.

Үйл ажиллагаа 2: Асуудал бүхий зан үйлийг үнэлэх (60 минут)

1. Оролцогчдыг 6 бүлэгт хуваана. Бүлэг тус бүрт хавсралт 3-т байгаа үнэлгээний хуудсыг тарааж өгнө. Багийн гишүүд хамтран өөрийн цэцэрлэг, сургуульд явдаг сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн зан үйлийн үнэлгээг хийнэ. Үнэлгээний багт ямар хүмүүс орох, мэдээлэл хэнээс авах талаар ярилцаж, өөрсдийн мэдэж буй мэдээллийн хүрээнд тус загварыг ашиглан үнэлгээ хийнэ.
2. Багууд хийсэн зүйлээ ээлжлэн танилцуулна. Баг бүрийн танилцуулгын дараа асууж тодруулах болон нэмж хэлэх зүйл байгаа эсэхийг лавлана.
3. Багуудын танилцуулгын дараа бүгд хамтран дараах асуултын дагуу ярилцана.
 - Асуудал бүхий зан үйлийн үнэлгээ хийх нь амархан байна уу хэцүү байна уу? Үүнийг хийхэд юуг анхаарах шаардлагатай вэ?
 - Тус үнэлгээнд ямар хүмүүс оролцох ёстой вэ?
 - Асуудал бүхий зан үйл гэж юуг хэлэх вэ?
 - Зорилтот зан үйл гэж юуг хэлэх, түүнийг хэрхэн сонгох вэ?
 - Баг бүрийн нэгдсэн дүгнэлт өөр хоорондоо юугаараа ижил төстэй, юугаараа ялгаатай байсан бэ?
 - Тус үнэлгээг хийх нь ямар ач холбогдолтой вэ?
4. Тус үйл ажиллагааг дүгнэн өөрсдийн санаа бодлоо илэрхийлэхийг 1-2 оролцогчоос хүснэ.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Та бүхэн тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгийн талаар бусдад хэрхэн тайлбарлах вэ?
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэд бүр өөр хоорондоо хэрхэн ялгаатай байж болох вэ?
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн талаар багш нар юу мэдэж байх хэрэгтэй вэ?
- Та бүхэн асуудал бүхий зан үйлийн үнэлгээний талаар бусад багш нар, эцэг эх, сургуулийн удирдлагад хэрхэн тайлбарлах вэ?

ХАВСРАЛТ 1

СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэг нь зохисгүй, эмх замбараагүй зан үйлийг байнга үйлдэх шинж тэмдгээр илэрдэг. Энэ нь тухайн хүүхдийн сурах үйл явц болон нийгэмшилд сөргөөр нөлөөлдөг. Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн оюун ухааны чадвар ихэнх тохиолдолд дундаж болон түүнээс дээш байдаг учраас өөрийн үе тэнгийнхэнтэйгээ нэг ангид суралцах бүрэн боломжтой. Тус эмгэг нь оюуны чадамжтай шууд холбоотой биш боловч тэдний асуудал бүхий зан үйл нь сурах үйл явцад нөлөөлдөг.

Хүүхдийг сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй эсэхийг тодорхойлохын тулд дараах үндсэн 4 зүйлийг анхаарах хэрэгтэй байдаг. Нэгдүгээрт, тухайн хүүхэд нийгэмшил, сэтгэлийн хөдөлгөөн, хийж буй үйлдлийн хувьд үе тэнгийнхнээсээ маш их ялгаатай байдаг. Эдгээр зан үйл нь насны хувьд тохирохгүй; бусад хүмүүс үл хүлээн зөвшөөрөх; тухайн хүүхдийн сурлагын ахиц амжилт, ангид даасан зохицох, нийгмийн харилцаа холбоо, өөртөө анхаарал халамж тавих зэрэгт сөрөг нөлөө үзүүлдэг. Хоёрдугаарт, эдгээр зан үйл нь хүнд хэлбэрийн, архаг явцтай, байнга илрэхийн зэрэгцээ сургууль дээр болон өөр ямар нэгэн газарт илэрдэг онцлогтой. Гуравдугаарт, ГСТ-ний эсвэл дэмжлэгийн баг ярилцлага, ажиглалт, өмнөх багш, мэргэжилтнүүдийн тухайн хүүхэдтэй ажиллах явцдаа хэрэгжүүлж байсан үйл ажиллагааны талаарх баримт мэдээлэл зэрэг бүхий л холбогдох эх сурвалжийн олон талын мэдээллийг ашиглана. Дөрөвдүгээрт, ГСТ боловсруулах баг тухайн хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдал, гарал угсаа, соёлын хүчин зүйлсийг зайлшгүй харгалзан үзэх ёстой.

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд дараах шинж тэмдгүүд илэрнэ: түрэмгий буюу нийгмийн эсрэг зан үйл; хайхрамжгүй байдал; анхаарал амархан сарних, хэт хөдөлгөөнтэй байх; бусадтай хэвийн харилцаж чаддаггүй; өдөр тутам хийдэг үйл ажиллагааны дэглэмийг сахиж мөрдөх суурь чадваргүй; нэг үйлдлээ байнга буюу улиг болтол давтах; хийж буй зүйл, үе тэнгийнхэн, багш нарт хандах хандлага муу, сөрөг харилцаатай гэх мэт анхаарал татахуйц зан үйл; мөн сэтгэл гутрах, сэтгэл түгших, аливаа зүйлээс байнга татгалзах, зан ааш нь өөрчлөгдөх гэх зэрэг. Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй зарим сурагчид өөрийнхөө талаар сөрөг бодолтой, өөрийгөө үнэлэх үнэлэмж багатай байдаг. Хичээл дээр тэд ихэвчлэн хичээлийн үйл ажиллагаанд оролцохгүй байх ба бусдын сурах үйл явцад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Бусдад түрэмгий хандах эсвэл хамтран ажиллахаас татгалзах зэргээр хүүхдүүдтэй бүлгээр ажиллах, харилцахад бэрхшээлтэй байх магадлалтай.

ХАВСРАЛТ 2

СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ТАЛААР БАГШ НАР ЮУ МЭДЭЖ БАЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд тохирох үйлчилгээ үзүүлэхийн тулд боловсролд тасралтгүй хамруулах шаардлагатай. Ердийн цэцэрлэг, сургуульд эдгээр хүүхдэд зориулсан нэмэлт туслах хэрэгсэл ашиглах, интервенцийг хэрэгжүүлэх, зарим хүүхдийн хувьд зөвхөн түүнд тусгайлан зориулсан хөтөлбөр боловсруулах, тусад нь ганцаарчлан ажиллах, тусдаа ангид эсвэл анги дотроо тусгай боловсролын багштай хичээллүүлэх зэргээр ажиллана. Тухайн хүүхдийн зан үйл өөрийнх нь болон бусад суралцагчийн сурах үйл явцад сөрөг нөлөө үзүүлж буй тохиолдолд цэцэрлэг, сургуулийн зүгээс эерэг зан үйлийн интервенцийн төлөвлөгөөг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний нэг хэсэг болгон боловсруулна. Тус төлөвлөгөө нь тухайн хүүхдийн одоогийн зан үйлд болон сурах үйл явцыг сайжруулахад төвлөрсөн байна.

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллахын тулд тухайн хүүхдийн гэр бүлтэй сайн харилцаа бүрдүүлснээр илүү үр дүнд хүрнэ гэдгийг мэдэх нь маш чухал юм. Эцэг эх, гэр бүлтэй хамтран ажиллах харилцааг бий болгохын тулд гэр бүлд төвлөрсөн аргыг ашиглах хэрэгтэй бөгөөд энэ нь тухайн хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, боловсролын үйл явцад тэднийг идэвхгүй хүлээн авагчийн байр сууринаас бус харин багш, мэргэжилтнүүдтэй ижил тэгш, идэвхтэй байр суурьтай оролцуулдаг. Зан үйлийн асуудалтай хүүхдийн эцэг эх, гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд гэр бүл, эцэг эхэд суурилсан эерэг зан үйлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх; хүүхдийн зан үйлийн дүн шинжилгээ, интервенцийг гэр бүлийн өдөр тутмын үйл ажиллагаанд тулгуурлан өргөжүүлэх шаардлагатай.

Суралцагчид хичээл сурлага, зан үйлийн хувьд ахиц амжилтад хүрэх нь олон боломж бүрдүүлсэн, сургалтын эерэг орчноос ихээхэн хамаарна. Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэд болон багшийн хоорондох харилцаа маш чухал үүрэгтэй. Хэрвээ багш суралцагчтай эерэг харилцаатай бол тухайн хүүхэд зан үйлийн үр дагаврыг хүлээн зөвшөөрөх, дүрэм журмыг дагаж мөрдөхдөө илүү байдаг. Багш болон суралцагчийн хоорондын харилцаа таарамжгүй бол тухайн хүүхэд санаатай зөрүүдлэх, үүрэг даалгаврыг биелүүлэхгүй байх, хичээл сурлагадаа муу, зан үйлийн олон асуудал гаргах зэрэг сөрөг нөлөөтэй.

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн асуудалтай хүүхэдтэй ажиллахын тулд тухайн хүүхдийн зан үйлийн үнэлгээг хийж ямар хэрэгцээ байгааг тодорхойлно. Тус үнэлгээг хийснээр асуудал бүхий зан үйлд чиглэсэн арга зүй, стратегийг тодорхойлох боломж бүрдэнэ. Асуудал бүхий зан үйлийн үнэлгээ нь аливаа үйлдлийг ямар зорилго, сэдлийн улмаас хийж буйг тодорхойлохын тулд тухайн хүүхдийн зан үйл, түүнтэй холбогдох нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх үйл явц юм. Тус үнэлгээ нь багш нарт дараах ач холбогдолтой:

- Тухайн хүүхэд зохистой буюу хүлээн зөвшөөрөгдөх зан үйл үйлдэхэд нь туслахын тулд хаана буюу ямар орчинд хичээл сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, түүний сурах орчныг өөрчлөх шаардлагатай эсэхийг тодорхойлох
- Асуудал бүхий буюу зохисгүй зан үйлийг бууруулахад чиглэсэн эерэг интервенцийг тодорхойлох
- Асуудал бүхий буюу зохисгүй зан үйлийг орлуулах эерэг, тохиромжтой зан үйлийг тодорхойлох

ХАВСРАЛТ 3

АСУУДАЛ БҮХИЙ ЗАН ҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ (ЖИШЭЭ)

Суралцагчийн нэр:

Анги:

Он сар өдөр:

А. Үнэлгээ хийсэн багийн гишүүдийн нэр, албан тушаал:

Б. Мэдээллийн эх сурвалж: Дараах зүйлээс сонгоно уу.

<input type="checkbox"/> Эцэг эхийн өгсөн мэдээлэл	<input type="checkbox"/> Сургууль/ анги дахь ажиглалт
<input type="checkbox"/> Сургуулийн оношилгоо	<input type="checkbox"/> Ирцийн бүртгэл
<input type="checkbox"/> Бусад байгууллагын оношилгоо	<input type="checkbox"/> Хувийн хэргийн тэмдэглэл
<input type="checkbox"/> Дараах хүмүүстэй хийсэн ярилцлага	<input type="checkbox"/> Зан үйлийн эрэмбийн шкал
<input type="checkbox"/> Эцэг эх	<input type="checkbox"/> Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
<input type="checkbox"/> Суралцагч	<input type="checkbox"/> Бусад: _____
<input type="checkbox"/> Багш	<input type="checkbox"/> Бусад: _____
<input type="checkbox"/> Бусад мэргэжилтэн	<input type="checkbox"/> Бусад: _____

В. Суралцагчийн мэдээлэл:

1. Суралцагчийн давуу тал бүхий зан үйлийг тодорхойлно уу (тухайлбал, сургуулийн багш, ажилтнууд, үе тэнгийнхэнтэйгээ эерэг харилцаатай, үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрдөг, бусад суралцагчдын сөрөг буюу зохисгүй зан үйлийг зөвшөөрөхгүй байх гэх зэрэг).
2. Суралцагч юунд баярладаг талаар дүрслэн бичих. (жишээлбэл, хэн, юу түүнийг сэтгэл хангалуун, баяр баясгалантай болгодог вэ?)
3. Асуудал бүхий зан үйлийг өөрчлөхийн тулд өмнө нь ямар оролдлогууд хийж байсан бэ?

Г. Зан үйлийн талаарх мэдээлэл:

1. Асуудал бүхий зан үйлийг тодорхойлно. Тэдгээр зан үйл тус бүрээр ямар үйлдэл, авир гаргадаг; нэг өдөрт, долоо хоногт, сард хэр олон удаа давтагддаг; хэр удаан үргэлжилдэг; хэр хүчтэй илэрдэг (сул, дунд зэрэг, маш хүчтэй) болохыг тодорхойлон бичнэ.

№	Зан үйл	Хэрхэн илэрдэг	Хэр олон удаа	Хэр удаан үргэлжилдэг	Хэр хүчтэй илэрдэг
1					
2					

Дээрх зан үйлүүдээс зарим нь хамт буюу нэгэн зэрэг илэрдэг эсэхийг тодорхойлно. (жишээ нь, нэгэн зэрэг илэрдэг, аль нэг нь урьдал байдлаар, тодорхой нөхцөл байдлын улмаас буюу нэг нь нөгөөгөө дагалдах, хариу арга хэмжээ авах үед илэрдэг эсэхийг тодруулна)

3. Дээрх жагсаалт дахь зан үйлүүдээс хамгийн хүнд хэцүү 2 зан үйлийг сонгоно уу.

Зан үйл	
1.	
2.	

Д. Тухайн зан үйлд нөлөөлж болзошгүй үйл явдал, нөхцөл байдал:

1. Тухайн хүүхэд ямар нэг эм уудаг уу? Тус эм хүүхдийн зан үйлд хэрхэн нөлөөлдөг гэж та бүхэн бодож байна вэ?
2. Хүүхдийн зан үйлд нөлөөлдөг байж болзошгүй тус эмийн үр дагавар бүхий нөхцөл байдлыг тодорхойлно уу. (багтраа, харшил, ухаан алдах гэх зэрэг)
3. Тухайн хүүхдийн нойрны мөчлөг, түүнтэй холбоотой зан үйлд нөлөөлж болзошгүй зүйлийг тодорхойлно уу.
4. Тухайн хүүхдийн хоолны дэглэм, түүнтэй холбоотой зан үйлд нөлөөлж болзошгүй зүйлийг тодорхойлно уу.
5. Тухайн хүүхдийн өдөр тутам хийдэг үйл ажиллагааг жагсаан бичиж, тэдгээр тус бүрийг тухайн хүүхэд хэр сайн гүйцэтгэдэг болохыг тодорхойлно уу.

Хугацаа	Үйл ажиллагаа	Хүүхдийн хариу үйлдэл

Е. Асуудал бүхий зан үйлийг сэдэлжүүлдэг үйл явдал, нөхцөл байдал:

6. Өдрийн ямар цагт: Тухайн зан үйл хэзээ хамгийн их болон хамгийн бага илэрдэг вэ?

Хамгийн их илэрдэг үе:

Хамгийн бага илэрдэг үе:

7. Орчин: Тухайн зан үйл ямар орчинд хамгийн их болон хамгийн бага илэрдэг вэ?

Хамгийн их илэрдэг газар:

Хамгийн бага илэрдэг газар:

8. Нийгэмшил: Ямар хүмүүстэй хамт байхад хамгийн их болон хамгийн бага илэрдэг вэ?

Хэнтэй хамт байхад хамгийн их илэрдэг:

Хэнтэй хамт байхад хамгийн бага илэрдэг:

9. Үйл ажиллагаа: Ямар үйл ажиллагааны үед хамгийн их болон хамгийн бага илэрдэг вэ?

Хамгийн их илэрдэг:

Хамгийн бага илэрдэг:

10. Урьтал хүчин зүйл: Зорилтот зан үйлийн өмнөх холбоо хамаарал бүхий үйл явдлыг тодорхойлно уу.

11. Үр дагавар: Зорилтот зан үйлийн үр дүнг тодорхойлно уу. (жишээ нь, тухайн зан үйлийн улмаас хүүхдэд зориулан ямар зүйл хийсэн буюу ямар үр дүнд хүрсэн бэ?)

12. Тухайн зорилтот зан үйл үйлдэгдэх болон түүний үр дагавар/үр дүнгийн хооронд хэр хугацаа болдог вэ? шууд буюу тэр даруй, хэдэн секундйн дараа эсвэл нэлээд хугацааны дараа гэх зэрэг?

13. Тухайн асуудал бүхий зан үйл илрэхэд таны хийж чадах хамгийн үр дүнтэй нэг зүйл юу вэ?

14. Тухайн хүүхдийг асуудал бүхий тус зан үйлийг үйлдэхгүй байлгахын тулд таны хийж чадах хамгийн үр дүнтэй нэг зүйл юу вэ?

Ё. Зорилтот зан үйлийг үйлдсэнээр тухайн хүүхдийн олж авдаг болон зайлсхийдэг үйлдлийг тодорхойлох. Дээрх Г хэсэгт жагсаан бичсэн зан үйлийг ашиглан, тухайн хүүхэд зорилтот зан үйлийг үйлдсэнээр юу олж авч, юунаас зайлсхийж буйг тодорхойлно.

	Зан үйл	Үйлдэл, үйл ажиллагаа Тэр юу олж авдаг? Юунаас зайлсхийдэг вэ?
1		
2		
3		

Ж. Нэгдсэн дүгнэлт

	Орчны үйл явдал	Урьтал хүчин зүйл	Зан үйл	Үр дагавар	Үйлдэл/үйл ажиллагаа
1					
2					
3					

СЭДЭВ 2: СХЗҮЭ-ТЭЙ ХҮҮХДИЙН СУРАХ ҮЙЛ ЯВЦЫГ ДЭМЖИХ, БАГШ, ЭЦЭГ ЭХТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ

Зорилго: Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжихийн тулд багш тэдэнтэй хэрхэн ажиллах арга зүй, стратегийн талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжихэд чиглэсэн арга зүй, стратегийн талаар ойлголттой болох
- Зан үйлийн үнэлгээнд тулгуурлан сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллах төлөвлөгөө боловсруулах
- Багш, эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах талаар тайлбарлах

Хугацаа: 120 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1-7: Тараах материалыг бүлгийн тоогоор хэвлэж, нэг нэг багц болгох

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллах арга, стратеги (70 минут)

1. Оролцогчдыг тус бүр 7 хүнтэй багт хуваана. Багуудад хавсралт 1-7-д байгаа материалыг тарааж өгнө. Багийн гишүүн бүрт нэг нэг материал оногдох ба гишүүн бүр өөрт оногдсон мэдээллийг уншиж судална. Тэдэнд 3 минутын хугацаа өгнө.
2. Гишүүн бүр судалсан зүйлээ багийн бусад гишүүддээ ээлжлэн тайлбарлана. Мэдээлэл тус бүрийн дараа багийн гишүүд тухайн зүйлийн талаар асууж тодруулан, өөрсдийн санаа бодлоо илэрхийлж, жишээ гарган бусдад тайлбарлаж чадах хэмжээнд ярилцана.
3. Баг бүр дотроо нэгдсэн ойлголттой болсны дараа сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллах талаар юу мэдэж авсан талаар ангиараа хамтран ярилцана. Дараах асуултыг ашиглан ярилцаж болно.
 - Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллахад нэн түрүүнд юу анхаарах шаардлагатай вэ?
 - Цэцэрлэгийн насны хүүхдүүд болон бага ангийн суралцагчтай ажиллахад анхаарах ямар ялгаатай аргууд байна вэ?

- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийг сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй татан оролцуулахын тулд ямар аргуудыг ашиглаж болох вэ?
 - Ахлах ангийн суралцагчидтай ажиллахдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?
 - Аутизмтай хүүхэдтэй ажиллахад ашиглах ямар аргууд байна вэ?
 - СХЗҮЭ-тэй хүүхдүүд өөрийгөө илэрхийлэхэд нь дэмжлэг үзүүлэх ямар аргууд байна вэ?
4. Тус үйл ажиллагаанаас олж мэдсэн зүйлээ нэгтгэн дүгнэж хэлэхийг 1-2 оролцогчоос хүснэ. Бусад оролцогчдоос нэмэх зүйл байгаа эсэхийг асууна.

Үйл ажиллагаа 2: Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллах төлөвлөгөө боловсруулах (45 минут)

1. Өмнөх багаар үргэлжлүүлэн ажиллана. Баг тус бүр эхний сэдвийн хүрээнд зан үйлийн үнэлгээ хийсэн жишээн дээр тулгуурлан сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах төлөвлөгөө боловсруулна. Төлөвлөгөө боловсруулахдаа эцэг эх, багш нарыг хэрхэн татан оролцуулах талаар тус төлөвлөгөөнд тусгана гэдгийг хэлнэ. Тэдэнд 20 минутын хугацаа өгч, цаас маркер тараана.
2. Баг бүр өөрсдийн боловсруулсан төлөвлөгөөг ээлжлэн танилцуулна. Баг бүрийн танилцуулгын дараа бусад багийн гишүүдээс асууж тодруулах, нэмэх зүйл байгаа эсэхийг лавлана.
3. Бүх багийн танилцуулгын дараа оролцогчдоос дараах асуултыг асууж ярилцана.
 - Баг тус бүрийн боловсруулсан төлөвлөгөө өөр хоорондоо юугаараа ижил төстэй, юугаараа ялгаатай байна вэ?
 - Аль төлөвлөгөө нь хамгийн оновчтой болсон гэж үзэж байна вэ? Яагаад?
 - Төлөвлөгөө боловсруулахад сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй ажиллах аргуудын талаарх ямар мэдээллийг ашигласан бэ?
 - Тус төлөвлөгөөг боловсруулахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгарсан уу?
 - Багш юу нэмж судлах шаардлагатай вэ?

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Тухайн сэдвийн хүрээнд судалсан зүйлээ бусдад хэрхэн түгээн дэлгэрүүлэх вэ?
- Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн сурах үйл явц, зан үйлийг өөрчлөхөд эцэг эх, багш нарыг хэрхэн оролцуулах боломжтой вэ?

ХАВСРАЛТ 1

СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХДҮҮДИЙГ СЭДЭЛЖҮҮЛЖ ОРОЛЦООГ ХАНГАХ АРГА ЗАМУУД

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийг суралцах үйл явцад олон арга замаар идэвхтэй оролцуулах нь тэднийг сэдэлжүүлэх хамгийн үр дүнтэй арга болдог. Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдүүд удаан хугацаагаар анхаарлаа төвлөрүүлж чадахгүй бөгөөд хүүхдийн оролцоог хангахын тулд сонирхолд тулгуурлан сэдэлжүүлэх дасгалууд нэлээд хугацаагаар хийх хэрэгтэй. Түүнчлэн багш нар хүүхдийг хичээл эхлэхээс дуусах хүртэл хэрхэн идэвхтэй татан оролцуулж, олон төрлийн арга замаар сэдэлжүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулах шаардлагатай. Мөн тухайн хүүхэд багш, ангийн найз нөхөд зэрэг бусдын яриаг сонсож байхдаа анхаарлаа төвлөрүүлж сурахад дэмжлэг үзүүлбэл сайн үр дүн гарна.

Хүүхдийн сонирхолд тулгуурлах

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдүүдийн хэрэгцээ сонирхол, арга туршлагыг танин мэдэхийн тулд багш эхлээд өөртэй нь болон эцэг эхтэй нь сайн ярилцах нь хамгийн үр дүнтэй арга байдаг. Цэцэрлэгийн насны хүүхдийг ажиглаж, нэг үйл ажиллагаанд хэр удаан төвлөрч байгааг мэдэх хэрэгтэй. Ингэснээр багш хүүхэд юунд дуртай, хэр удаан анхаарлаа төвлөрүүлж чаддаг гэх зэрэг хэрэгцээтэй мэдээллийг цуглуулж чадна. Бага ангийн хүүхдийн хувьд юунд сонирхолтой байна гэдгээс гадна яг ямар төрлийн үйл ажиллагаа хүүхдийн оролцоог хангаж буйг таньж мэдэх нь чухал. Тухайлбал, хүүхэд сонсоод өнгөрөөхөөсөө илүүтэй өөрөө хийж үзэх сонирхолтой байна уу, үйл ажиллагаанд шууд оролцож эхлэхэд өөрийгөө бэлдэх цаг хэрэгтэй эсэх гэх зэрэг.

Өдөр тутамд хэвшүүлж мөрдүүлэх

Бага насны хүүхэд цэцэрлэг, сургуулийн тогтсон дэг журам, дүрмийн талаар төдийлөн сайн ойлгодоггүй бөгөөд хүүхэд тухайн өдөр сургууль дээр юу хийхээ мэдэхгүй байж болно. Иймд өдөр тутамд мөрдөх дадал хэвшлийн талаар сайтар тайлбарлаж өгвөл тухайн хүүхэд өдөрт юу хийх, яах ёстойгоо төвөггүй ойлгодог болно. Багш хичээл бүрийн эхэнд цагийн хуваарийн зурагт үзүүлэн ашиглан хүүхдэд тодорхой тайлбарлаж өгөх нь зүйтэй. Зарим хүүхдэд “одоо”, “дараа” гэсэн зурган картуудыг ашиглахад ганцаарчилсан туслалцаа хэрэг болох магадлалтай. Бага ангийн сурагчид мөн өдрийн тогтсон хэвшилтэй байх нь олон талын эерэг ач холбогдолтой. Багш шинэ хичээл орох бүрт цагийн хуваарийн үзүүлэнг байршуулах ба үйл ажиллагаа дуусахад хурааж, дараагийн хичээлийн цагийн хуваарийн үзүүлэнг гаргаж тавингаа сурагчидтайгаа яриа өрнүүлж болно.

Хүүхдэд сонгох боломж олгох

Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэд хүсэл сонирхолдоо хөтлөгдөн ямар үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцохоо ухамсаргүйгээр шийдэх чадвартай болсон байдаг. Тиймээс хүүхдийн оролцоог хангахын тулд багш сурагчдад сонголт өгч болно. Жишээ нь нэг хичээл дуусахад дараа нь юу хийхээ хүүхдээр сонгуулж шийдэх боломжтой. Сонголтын хувилбаруудаа хэлэхээс гадна сонголт хийхэд нь хэрэг болох зураг, карт ашиглан үзүүлж болно.

Идэвхтэй оролцоо, бүтээлч хандлага бүхий үйл ажиллагаануудыг санал болгох

Сургуулийн өмнөх насны хүүхдүүд тоглоомд суурилсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бөгөөд практик, тоглоом, даалгаврын тусламжтайгаар суралцах үйл явц идэвхжиж байдаг. Тэдэнд дуу дуулах, шүлэг унших, усаар тоглох, баримлын шавраар тоглох, жүжиглэх чадваруудыг зааж өгвөл ахлах ангийн сурагчид шиг ширээний ард удаан суух шаардлага гарахгүй, хичээлд идэвхтэй оролцоно (айл гэр болж тоглох, хувцаслах гэх мэт). Харин бага ангийн сурагчид ширээний ард 15-20 минутаас илүү удаан суувал залхаж эхэлдэг. Тиймээс багш 15-20 минут тутамд хүүхдийн сонирхлыг өдөөх үйл ажиллагаа явуулах эсвэл сурагчдад завсарлах хугацаа өгөх хэрэгтэй. Энэ үеэр сунгалтын дасгал хийх, дуу дуулах, шүлэг унших зэргээр ангийг бүхэлд нь хамарсан үйл ажиллагаа зохион байгуулж болно.

Нэг үйлээс нөгөөд шилжих цаг хугацааг үр дүнтэй ашиглах

Нэг үйл ажиллагаа дуусаад нөгөөд шилжих завсарт ангийн эмх замбараагүй байдал нь хүүхдийн зан үйлд нөлөөлдөг. Иймд багш нар шилжилтийн үед ангийг хэрхэн эмх цэгцтэй байлгах талаар бодолцох хэрэгтэй. Багш хичээл дуусаж буйг амаараа хэлэх, элсэн цаг, хөгжим гэх мэт биет үзүүлэн ашиглан мэдэгдэж болно. Шилжилтийн үед багш суудал хуваарилах, даалгавар оноож өгөх зэргээр дараагийн хичээлийнхээ бэлтгэл ажлыг хийвэл үр дүнтэй байдаг.

Хүүхдийг магтаж, урамшуулах

Хүүхдийн сайн, зөв хийж буй үйлдлийг урамшуулан дэмжих хэрэгтэй. Ялангуяа, ангидаа эерэг уур амьсгал бүрдүүлж буй хүүхдийг магтаж, дүрмээ дагахгүй байгаа сурагчдад эелдгээр сануулж хэлэх хэрэгтэй. Зарим хүүхдэд бусдын өмнө багшид магтуулах нь ичгэвтэр байдаг тул багш эрхий хуруугаа гозойлгох, мөрөн дээр нь гараа тавих зэрэг энгийн аргуудаар санаагаа ойлгуулах боломжтой.

ХАВСРАЛТ 2

АХЛАХ АНГИД ХИЧЭЭЛ ЗААХДАА АШИГЛАХ АРГА ЗҮЙ

Хүүхдүүд юуг, яагаад сурч буйгаа сайтар ойлгосон цагтаа хичээлд идэвхтэй оролцох хандлагатай байдаг. Чухам ийм учраас сурагч суралцахуйн зорилгодоо хэрхэн хүрэхийг өөрөөр нь тодорхойлуулах хэрэгтэй. Хичээл эхлэхээс өмнө хүүхэд өнгөрсөн хугацаанд юу сурсныг товчхон дүгнээд одоо судалж буй агуулга нь ямар ач холбогдолтой болохыг тайлбарлаж өгнө.

Ихэнхдээ хүүхдийн суралцахуйн зорилгыг багш тодорхойлдог боловч тэрхүү зорилго, зорилтдоо хэрхэн хүрэх, ямар хэрэглэгдэхүүн, дэмжлэг шаардлагатайг сурагчаар өөрөөр нь тодорхойлуулах хэрэгтэй. Ийнхүү сурагчдад сонголт өгөх нь тухайн хүүхэд биеэ даах, амжилтаараа бахархах, суралцахуйн зорилготойгоо өөрийгөө холбож ойлгох зэрэг давуу талтай. Гэсэн хэдий ч сурагчид хэр их, ямар төрлийн сонголт хийх нь тэдний онцлогоос хамаарч харилцан адилгүй байна.

Багш суралцагчид сонголт хийх боломж өгөөд орхих нь хангалтгүй бөгөөд оролцоог хангахын тулд тухайн сонголтуудыг хүүхдийн бие даасан байдалтай уялдуулан анхаарч үзэх нь чухал юм. Ингэхдээ дор дурдсан зүйлүүдийг харгалзан үзвэл зохино. Үүнд:

- Суралцагчдад сонгох боломж олгосноор тухайн хүүхдийн бие даасан, чөлөөтэй байдлыг дэмжих
- Тулгарах бэрхшээлийн түвшин
- Хүрэх үр дүн, амжилт, хамт олонд хүлээн зөвшөөрөгдөх боломж
- Чадварыг үнэлэхэд ашигладаг шалгуурууд
- Мэдээлэл цуглуулах, гүйцэтгэлд ашигладаг хэрэгслүүд
- Өнгө, дизайн, график эсвэл зохион байгуулалт
- Даалгаврын дэд хэсгүүдийн гүйцэтгэх дараалал эсвэл цаг хугацаа
- Суралцагчдыг ангийн үйл ажиллагаа, хичээл даалгаврыг төлөвлөх явцад оролцох боломжоор хангах
- Сурагчдыг хичээлийн ба зан үйлийн зорилгоо тодорхойлох явцад оролцуулах
- Сурагчдыг өөрийн оролцоо болон анхаарал төвлөрөлтөө хянах арга барилд сургах

Хүүхэд сурах хүсэл эрмэлзлээр дүүрэн байх үедээ аливаа зүйлийг суралцахад шаардлагатай хүч хөдөлмөр, анхаарал төвлөрөлтийг өндөр түвшинд байлгахын тулд сэтгэл хөдлөл болоод анхаарлаа удирдаж эхэлдэг. Гэхдээ ийм байдлаар өөрийгөө удирдах чадвар сурагчдын хувьд харилцан адилгүй байна. Сурагчдын сурах сэдэл, чадвар чадамж, өөрийгөө удирдах чадвар, анхаарлаа төвлөрүүлэх

чадвар нь суралцагч бүрийн хувьд ялгаатай байх бөгөөд эдгээр бүгд хүүхдийн ахицад нөлөөлнө. Хүүхэд өөртөө зорилго тавих нь өөрийнхөө ахицыг өөрөө үнэлж, зан үйлээ удирдах боломж олгоно. Гэхдээ зорилгодоо хүрэх зам хялбар биш байдаг тул сэтгэлээр унах, уур уцаартай болох тохиолдол гарна. Багш сурагчийг сурах хүсэл эрмэлзлээ алдахгүй байхад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй бөгөөд заавар, сануулга, гарын авлага, товхимол, хийх зүйлсийн жагсаалт зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж өгөх нь зүйтэй. Эдгээр хэрэглэгдэхүүн нь:

- Анхаарал сарнисан үед буцаад дасгалдаа төвлөрөх хугацааг нэмэгдүүлэх
- Уур уцаараа хянах, сэтгэл зүйн эрүүл мэндээ дэмжих зэргээр өөрийгөө удирдах
- Хүүхдийн хичээлийн төлөвлөгөөнд өөрийгөө эргэцүүлэх, өөрийгөө “шахах” хугацаа төлөвлөх
- Бусадтай харилцаа тогтоох, зөрчилдөөнийг шийдвэрлэх

ХАВСРАЛТ 3

Боловсролын бүх түвшинд зан үйлийн асуудалтай хүүхдийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлнэ гэдэг нь тэднийг анги, сургуулийн нэг хэсэг гэдгийг ойлгуулж, үнэ цэнийг нь мэдэрч байгаа гэдгээ тухайн хүүхдэд ойлгуулах явдал юм. Гэвч хүүхэд бусадтай харилцаа тогтоож, ярилцаж чадахгүй үед хүүхдийг дэмжих үйл явц удааширдаг. Бэрхшээлтэй хүүхдийг бусадтай харилцаа холбоо тогтооход тохирсон арга зүйгээр дэмжинэ гэдэг тухайн багшаас нөр их хөдөлмөр, бүтээлч сэтгэлгээ шаардана. Үүнд туслах зарим боломжит дараах арга барилууд байдаг:

Хүүхдийг эд зүйлээ бусадтай хуваалцаж сургах

Бүх хүүхэд тоглоомоо бусадтай хуваалцах дургүй байдаг ч зарим тохиолдолд суралцахуй, харилцаа, зан үйлийн асуудалтай хүүхэд бусдын тоглоомыг булаах, бусад хүүхдийг түлхэх, цохих зэрэг зан авир гаргадаг. Жишээ нь, тоглоомоо хуваалцах дургүй хүүхэд байвал багш тоглох явцыг удирдаж зааварчилна:

а. Хүүхдэд нэн түрүүнд тоглоомоо бусадтай хуваалцан тоглоход тоглоом буцаад өөрт нь ирнэ гэдгийг тайлбарлах хэрэгтэй, тоглоомыг аваад ... (хүүхдийн нэрийг хэлж)-ний ээлж, одоо ... –ний (хүүхдийн нэр) ээлж буюу өгөх гэж буй хүүхдийнхээ нэрийг дуудна/дуулна. Дараа нь багш тоглоомоо буцааж аваад (багшийн) ээлж, (багшийн ээлж) гэж давтан хэлнэ/дуулна. Түүний дараа тоглоомоо анх авсан хүүхдэдээ буцааж өгөөд (хүүхдийн нэр) ээлж, (хүүхдийн нэр) ээлж гэж хэлнэ/дуулна. Энэ дасгалаар хүүхэд тоглоомоо хуваалцсан ч эргээд ирнэ гэсэн ойлголтыг авах ёстой бөгөөд бусдыгаа хүндэлж, өөрийнхөө ээлжийг хүлээж сурдаг.

б. Тоглоомоо 1-3 хүнтэй хуваалцаж сургах хэрэгтэй. Эхлээд нэг хүүхэдтэй тоглоомоо хуваалцаж сурсан бол аажмаар хүүхдийн тоог нэмж жижиг бүлгийн хүрээнд тоглоомыг нь хуваалцаж сургах хэрэгтэй. Хуваалцах бүрт багш хэний ээлж вэ гэдэг зааварчилгааг өгнө.

▪ Хүүхдийн сонирхолд тулгуурлаж харилцаа тогтоох

Багш хүүхдийн хүсэл сонирхлыг олж мэдсэнээр ижил сонирхолтой хүүхэдтэй уулзуулах, хамт дасгал даалгавар ажиллах боломжийг бүрдүүлж өгнө. Жишээ нь, аутизмтай хүүхэд тодорхой сэдэв эсвэл тоглоомыг чин сэтгэлээсээ сонирхон судалдаг учир ижил төрлийн сонирхолтой хүүхэдтэй уулзвал бат бэх харилцаа холбоо тогтоож чадна.

▪ Том хүн болон хүүхдийн хооронд харилцаа бий болгох

Том хүн ба хүүхдийн хооронд харилцаа тогтоох ажлыг олон хувилбараар зохион байгуулж болно. Энд зарим арга барилыг санал болгож байна. Тухайлбал, “Чангаар гайхах” техникийг ашиглах арга байж болно. Хэрэв хүүхэд маш их стресст өртөж, уурлаж, мэдрэмжээ хүнтэй хуваалцахгүй байвал энэ арга үр

дүнтэй. “Чангаар гайхах” үед хүүхэд ямар нэртэй сэтгэл хөдлөл мэдэрч байгаагаа ойлгох бөгөөд хажууд нь сэтгэл зүйг нь ойлгох хүн байна гэсэн санааг өгдөг. Жишээ нь, “Чи Цэцгээтэй дээс тоглоё гэтэл тэр ...Үгүй ээ. Одоо... биш гэж хэлсэн учраас чамайг уурлаж байгааг ойлгож байна. Чи сэтгэлээр унасан байна, Чи ярилцахыг хүсвэл би чамтай ярилцахад бэлэн байна” гэх мэтээр хүүхдэд хандаж ярилцахад үр дүн өгөх боломжтой. Энэхүү техник нь хүүхдийн юу мэдэрч байгааг нэрлэж, яагаад/юу ажигласнаа хэлээд, өөрт нь хэцүү байгааг ойлгож байгаа гэдгээ хэлээд, тайвширсан үедээ ярилцах арга замыг зааж өгч буй арга барил юм.

- **Нэг нь хожиж нөгөө нь хожигдох ярианаас зайлсхийх**

Багш ялж, хүүхэд ялагдсан мэт мэдрэмж төрүүлдэг ярианаас аль болох зайлсхий. Жишээлбэл, багш “Хэрвээ чи ийм зүйл дахиад нэг л удаа хийвэл би чамайг ингэж шийтгэнэ шүү”. Үүн шиг шийтгүүлдэг хүүхдүүд айдсаа дарахын тулд бодлогогүй алхам хийх эрсдэлтэй тул багш илүү эергээр хүүхдэд санааг ойлгуулах ёстой. Жишээ нь, “Хэрвээ чи үүнийг хийчихсэн бол хоёулаа одоо ингэж болно” гэх маягийн агуулгатай яриа бол хүүхдэд би ялагдлаа гэсэн сэтгэгдэл төрүүлэх магадлалтай гэдгийг ямагт анхаараарай.

ХАВСРАЛТ 4

ЗАН ҮЙЛ БА АУТИЗМ

Аутизмтай хүүхэд ихэнхдээ ердийн хүний санамсаргүй хийсэн үйлдэлд уурлаж, сэтгэлээр унах тохиолдол элбэг байдаг. Хүүхэд түгшүүртэй болох тусам дуу нь өндөрсөж, бүдүүлэг авир гаргах, бусдыг цохих эсвэл нөхцөл байдлаас зугтаах гэж оролддог. Аутизмтай хүүхэд өөрийгөө удирдаж, зан үйлээ хянахад багшийн зүгээс суралцахуйн орчинд ямар зүйл хүүхдийн айдас түгшүүрийг төрүүлээд байна вэ гэдгийг тодорхойлох хэрэгтэй. Аутизмтай хүүхдүүд дараах бэрхшээлүүдтэй тулгарч болно. Жишээлбэл:

- Аутизмтай хүүхэд мэдрэхүйн ачаалал амархан авдаг. Аутизмтай хүүхдүүд зарим тохиолдолд дуу, хүрэлцэх, тод өнгийн гэрэл, үнэр, амтны мэдрэхүйд хэт мэдрэг байдаг. Мөн аутизмтай хүүхэд болон том хүн анхаарал сарнисан үедээ анхаарлаа төвлөрүүлэх гэж маш их хичээх шаардлага гардаг бөгөөд заримдаа өвдөлт мэдэрдэг.
- Аутизмтай хүүхэд эмх замбараагүй зүйлд дургүй байдаг. Аутизмтай хүүхдүүд аливаа зүйлийг жагсааж, эгнүүлж, тодорхой эмх цэгцтэй байрлалд оруулж тавих дуртай бөгөөд зурагт хуудас, дэлгэцийн байрлал тэгш бус байвал шууд стресстдэг. Аливаа зүйл өөрийнх нь хүлээлтэд нийцэхгүй бол мөн стресстэнэ. Үүнтэй адил ангийн найз нөхөд нь дүрэм журмаа дагахгүй бол анхаарал нь сарниж, эргээд хэвийн байдалдаа орох гэж ихээхэн хүндрэлтэй тулгардаг.
- Хүнд биш аливаа зүйлд төвлөрдөг. Ердийн хүүхдүүд тодорхой нэг биет эд зүйлд анхаарал нь төвлөрдөг бол бага насны аутизмтай хүүхдийн анхаарал хаа сайгүй “тэнэж” байдаг. Багш эдгээр хүндрэл бэрхшээлээс аль болохоор сэргийлж, хэрэв хүүхэд айдас түгшүүрт автвал түүнийгээ даван гарахад нь туслах хэрэгтэй. Дэмжих арга зүй нь зөвхөн аутизмтай хүүхдэд бус ангийн бүх суралцагчдын онцлог хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан үзсэн байх нь илүү үр дүнтэй байдаг учраас багш аль болох нийтийн хэрэгцээг чухалчлах арга замаар суралцахуйн үйл явцыг зохион байгуулах нь чухал. Үүнд:
 - “Одоо” ба “Дараа” харьцуулсан зурагт хуудас: Цэцэрлэгийн насны хүүхдэд одоо ямар хичээл зааж буйгаа болон дараа нь ямар үйл ажиллагаа болохыг зурагт хуудсаар үзүүлэх. Хэрэв хүүхэд эхний сэдвийг сонирхохгүй бол хичээлийнхээ хугацааг багасгаж, хүүхдийн суралцахуйн үйл явцыг сэдэлжүүлсэн дараагийн үйл ажиллагаанд анхаараарай.
 - Цагийн хуваарийн үзүүлэн: Үзүүлэн ашиглаж тухайн өдөрт ямар үйл ажиллагаа төлөвлөгдсөнийг хүүхдэд ойлгуулан ярилцаарай.
 - Хичээл, ямар нэг үйл ажиллагаа үргэлж дуусдаг гэдэгт хүүхдийн сэтгэл зүйг бэлтгэх: Элсэн цаг ашиглах, ангийн бусад сурагчид эд зүйлээ эмхэлж цэгцэлж эхлэх, үйл ажиллагаа дуусаж буйг мэдэгдэж цагийн хуваарийг зургаар үзүүлсэн ширээ рүү хүүхдийг хөтлөөд зургийг хураах даалгавар

өгөх, ангийн сурагчдад дараа нь ямар үйл ажиллагаа төлөвлөгдсөнийг хэлэх аргуудыг ашиглаж болно.

- Биед нь тухгүй байвал заавал сурагчийн дүрэмт хувцас өмсөхийг шаардахгүй байх: Аутизмтай хүүхдүүд бие барьсан, тухгүй хувцас болоод материалд дургүй байдаг тул сургууль хүүхдийг заавал дүрэмт хувцас өмсөхийг шаардахгүйгээр уян хатан хандах хэрэгтэй. Хүүхдийг спорт өмд, үдээсгүй гутал өмсөх боломж өгснөөр тэдэнд учирч болох стрессийг бууруулж, анхаарал төвлөрөлтийг нь дэмжиж буй хэрэг юм.
- Завсарлага: Аутизмтай хүүхдийг чимээ шуугиан, гэрэл багатай орчинд завсарлах боломж олгосноор хүүхэд өөрийгөө удирдахад дөхөм болдог.

ХАВСРАЛТ 5

СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХДЭД МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН ХЭЛБЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй суралцагчид бэрхшээлийн төрөл, түвшнээс хамаарч мэдлэг, мэдээллийг харилцан адилгүй арга хэлбэрээр хүлээн авч, ойлгодог учир багш сурагчдыг мэдээллийг хүлээн авах, мэдлэг эзэмших олон арга замыг хэрэглэх шаардлагатай байдаг.

Хүүхдийн хамгийн сайн хөгжсөн чадварт суурилж хичээлээ заах

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй ихэнх хүүхдүүд өөртөө итгэх итгэл сул байдаг учир өөрийгөө ичгүүртэй, сул дорой харагдуулна гэж бодсон зүйлээсээ зугтах хандлагатай байдаг. (жишээ нь унших, бичих чадвар сул бол). Зарим сурагчид өөрсдийгөө муу хүн гэж боддог бөгөөд муу хүн шиг ааш авир гаргадаг. Тиймээс ийм бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах үндсэн зарчим нь тэдний хамгийн сайн хөгжсөн чадварт түшиглэн суралцахуйн үйл явцыг нь дэмжих юм.



Хүүхдэд тохирсон суралцахуйн хэв маягийг тодорхойлж, түүнд нийцсэн үйл ажиллагаа зохион байгуулах

Багш ангийн үйл ажиллагааг төлөвлөхдөө бэрхшээлтэй хүүхдийн давуу талыг бодолцох хэрэгтэй. Жишээлбэл, тухайн хүүхэд олон төрлөөр өөрийгөө илэрхийлж, шинэ зүйл бүтээж чаддаг уу, аливаа зүйлийг сонсоод өнгөрөхөөсөө илүүтэй өөрөө хийж үзэхдээ сонирхолтой байдаг уу гэх мэт асуудлыг аль болох таньж мэдэхийг хичээх хэрэгтэй.

Хэрэв хүүхдийн анхаарал төвлөрөх чадвар муу бөгөөд хичээлийн хэрэглэгдэхүүний ихэнх нь хэвлэмэл материал байвал хүүхдийн зан үйл тогтворгүй болж ирдэг. Зөвхөн хэвлэмэл байдлаар агуулга сэдвийг хүргэж, үр дүнг тайлбарлах нь өрөөсгөл бөгөөд ялангуяа хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд тохирсон арга биш юм. Иймд багш хичээлээ олон төрлийн үзүүлэх аргуудыг ашиглан заах нь үр дүнтэй. Жишээ нь, гол санаагаа тэмдэгтүүдээр дүрслэх бөгөөд (жишээ нь тайлбар текст эсвэл математикийн тэгшитгэл) сурагчдын онцлог хэрэгцээнд тохируулан олон хэлбэрээр хүргэж болно (тухайлбал, дүрслэл, бүжиг/ хөдөлгөөн, диаграмм, загвар, видео, комикс, үлгэрийн самбар, гэрэл зураг, хөдөлгөөнт дүрс гэх зэрэг). Сурагч мөн өөрийн сонирхсон хувилбарыг бүтээж болно.

ХАВСРАЛТ 6

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдүүд үйлдэл хийх, илэрхийлэх арга замууд

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхэд бүр өөр өөрийн онцлог байдалдаа тохирсон ялгаатай арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг учраас багш сурагчдад суралцах болон өөрсдийгөө илэрхийлэх олон арга зам бүхий боломжийг хангаж ажиллах хэрэгтэй.

Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдүүд өөрсдийн сонирхол, чадварт тохирсон арга замаар өөрийгөө илэрхийлэх үед зан ааш нь тогтвортой байдаг. Энэ өвөрмөц байдлыг нь харгалзан суралцахуйн үйл явцыг зохион байгуулах нь багшийн ажилд ихээхэн тустай байх болно. Үүнд дараах арга замуудыг ашиглах нь үр дүнтэй.

Олон хэлбэрээр илэрхийлэх арга зүйг ашиглах

Энэхүү арга зүй нь дан ганц зан үйлийн эмгэгтэй хүүхдэд биш ерөнхийдөө харилцааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тохирдог арга зүй юм. Жишээлбэл, бүх суралцагч бичих чадварт суралцахаас илүүтэй найруулан бичих чадварт давхар суралцана. Тодорхой нөхцөл байдлыг харгалзан тооцож багш нар хүүхдүүдэд янз бүрийн хэлбэрээр суралцахуйн үйл явцаа төлөвлөж, бүтээх боломж олгох хэрэгтэй. Тухайлбал:

- Текст, яриа, зураг, чимэглэл, дизайн, кино, хөгжим, бүжиг/хөдөлгөөн, дүрслэх урлаг, уран баримал, видео гэх мэт олон төрлийн арга хэрэглэх
- Биет үзүүлэн дээр ажиллах (жишээ нь блок, 3D загвар, үндсэн арван блок)
- Текст, яриа, зураг, чимэглэл, комикс, үлгэрийн самбар, дизайн, кино, хөгжим, дүрслэх урлаг, уран баримал, видео гэх мэт олон төрлийн арга хэрэглэх

ХАВСРАЛТ 7

СУРАЛЦАГЧИЙГ ӨӨРИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ ЧАДВАРТ СУРГАХ

Суралцагч багшаасаа санал зөвлөмж сонсохгүйгээр суралцах боломжгүй бөгөөд ахиц гаргаж буй эсэхээ нарийн хэмжих нь чухал ач холбогдолтой. Багш тохирсон арга барилаар, тогтмол хугацаанд хүүхдийн ахицыг үнэлэхгүй бол сурагчийн суралцахуйн үйл явц зогсонги байдалд ордог. Суралцагч юуг засаж сайжруулахаа мэдэхгүй бол хичээлдээ идэвхгүй хандаж эхэлдэг бөгөөд бэрхшээлтэй хүүхдүүдийн ахицыг тогтмол, ердийн хүүхдүүдийн ахицыг тодорхой хугацаанд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар үнэлж, санал зөвлөмж өгөх нь маш чухал үйл явц юм. Ялангуяа багш ахицын үнэлгээний үр дүнд суурилсан заавар зөвлөмжийг суралцагчдад тогтмол өгч байх хэрэгтэй бөгөөд суралцагч сурлагын ахицаа өөрөө үнэлж сурах нь ихээхэн ач холбогдолтой.

Багш нарын хувьд:

- Өөрийнхөө ахицыг хэмжих, эргэцүүлэн бодоход чиглүүлсэн асуулт асуух
- Ахицыг дүрслэн харуулах (жишээ нь, өмнө болон дараах зураг, тодорхой цаг хугацаанд гарсан ахиц дэвшлийг харуулсан график, үйл явцын багц зураг)
- Суралцагчдаас ямар төрлийн санал зөвлөмж авах хүсэлтэй байгааг сонсож, тодорхойлох
- Чанар болон гүйцэтгэлийг хэмжихдээ загвар ашиглах
- Өөрийгөө үнэлэх стратегийн ялгаатай загваруудыг ашиглах (жишээ нь, дүрд тоглох, видео тойм, үе тэнгийнхний санал зөвлөмж)
- Үнэлгээний хяналтын хуудас, онооны хүснэгт, сурагчийн гүйцэтгэлийг хэмжих олон төрлийн жишээ ашиглах зэрэг олон арга замыг ашиглаж суралцагчдад өөрсдийгөө үнэлэх боломж олгохыг хичээгээрэй.

Багшийн үнэлгээ болон санал зөвлөмж нь гүйцэтгэлээс гадна хүүхдийн хичээл зүтгэлийг давхар харгалзан үзсэн байх

Хүүхэд тухайн бэрхшээлийг тогтсон хэв шинжтэй, өөрчлөгдөх боломжгүй гэж үзэж байгаа тохиолдолд өөрийн чадварт итгэх итгэл сул байдаг бөгөөд өөрийгөө хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж бат итгэсэн байдаг. Багш ийм төрлийн хүүхдийг үнэлэхдээ чадварт суурилсан үнэлгээний аргачлалыг ашиглана. Энэ нь хүүхдийн гүйцэтгэл, зохицлын талаар тогтсон ойлголтод ач холбогдол өгөхөөс илүүтэй суралцагчийг чадварын талаас нь чиглүүлж, дэмжиж байдаг үнэлгээний төрөл юм. Энэ арга нь сурагч урт хугацааны зорилгодоо хүрэх, суралцахуйн дадлага туршлага эзэмшихэд тухайн хүүхдийн “оюун ухааны чадамж”, “байгалийн өгөгдөл” гэхээсээ илүүтэй гаргаж буй хичээл зүтгэлийг гол хүчин зүйл гэж авч үздэг. Багш сурагчдад санал зөвлөмж өгөхдөө:

- Санал зөвлөмж нь тэсвэр хатуужилтай байхыг уриалсан, үр дүн, өөрийгөө

танин мэдэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байхын зэрэгцээ бэрхшээл сорилттой тулгарахад тодорхой дэмжлэг, стратеги ашиглахыг зөвлөсөн байна.

- Гүйцэтгэлээс илүүтэй хичээл зүтгэл, сайжруулалт, ололт амжилтыг харгалзан үзэх
- Санал зөвлөмжийг тогтсон хугацаанд, ойр ойрхон, тодорхой өгөх, Харьцуулсан, өрсөлдүүлсэн биш илүү бодитой, мэдээллийн чанартай санал зөвлөмж өгөх
- Багш сурагчийг юун дээр голчлон алдаж буйг нь тодорхойлж, үнэлгээний хэсэгт тусгах ба уг үнэлгээг ирээдүйн зорилгодоо хүрэх эерэг стратегидаа хэрхэн тусгаж болохыг загварчилсан байна
- Хэрэв хүүхэд “Би чадахгүй байна” гэж хэлбэл багш “Чи одоохондоо л чадахгүй байгаа юм” хэмээн тодотгох гэх мэт.

СЭДЭВ 3: СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН СУРАХ ҮЙЛ ЯВЦЫГ ДЭМЖИХ ТӨХӨӨРӨМЖ, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Зорилго: Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд зориулан ашиглаж болох сургалтын хэрэглэгдэхүүн, зарим төхөөрөмжийн талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- СХЗҮЭ-тэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх туслах хэрэгслийн талаар ойлголттой болох
- СХЗҮЭ-тэй хүүхдэд зориулсан сургалтын туслах хэрэгсэл, зарим төхөөрөмжийн зориулалт, ямар хүүхдэд тохиромжтой талаар тайлбарлах
- СХЗҮЭ-тэй хүүхдэд зориулсан тусдаа өрөө тасалгаа, ангийн булан зэргийг хэрхэн бүрдүүлж болох талаар туршлагаа хуваалцах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1-3: Тараах материалыг бүлгийн тоогоор олшруулах

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: СХЗҮЭ-тэй хүүхдийн ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн, төхөөрөмж (50 минут)

1. Оролцогчдод хосоороо ажиллана гэдгийг хэлнэ. Хос бүрт хавсралт 1-3-т байгаа төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний тухай нэг нэг материалыг өгнө. Хосууд өөрт оногдсон хэрэглэгдэхүүний талаар судлаад, ямар хүүхдэд хэрэглэхэд тохиромжтой, анги, цэцэрлэг, сургуулийн хаана байрлуулах зэргийн талаар мэдээллийг хамтран ярилцаж бэлтгэхийг хүснэ. Тэдэнд 10 минутын хугацаа өгнө.
2. Бэлтгэсэн мэдээллээ бусад оролцогчдод танилцуулна. Танилцуулга бүрийн дараа бусад оролцогчдоос тодруулах асуулт, нэмэх санал байгаа эсэхийг лавлана.
3. Бүх хос мэдээллээ танилцуулсны дараа сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн эмгэгтэй хүүхдийн сурах үйл явцыг дэмжих төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний талаар ямар ойлголттой болсон тухай ангиараа хамтран ярилцана.

Үйл ажиллагаа 2: СХЗҮЭ-тэй хүүхдэд зориулсан орчин бүрдүүлэх (35 минут)

1. Оролцогчдыг 5 багт хуваана. Багууд өөрсдийн цэцэрлэг, сургууль дээрх болон өөр бусад газруудад СХЗҮЭ-тэй хүүхдэд зориулсан орчныг хэрхэн бүрдүүлсэн байдаг талаарх сайн туршлагыг жагсаан бичнэ.
2. Тэдгээр сайн туршлагыг ээлжлэн бусдадаа танилцуулж, санал бодлоо хуваалцана.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд ямар зүйлийг шинээр мэдэж авсан бэ?
- Өөрийн эзэмшсэн зүйлээ та бүхэн хэрхэн ашиглах вэ?

ХАВСРАЛТ 1

Зурган карт, ажлын хуваарь:



Зориулалт: Ангид нь зурган хуваарь хийж өгч хүүхдэд хичээлийн хуваарь, сургуулийн дүрэм гээд олон зүйлд сургахад ашиглана. Танин мэдэхүй, үйл хөдлөл, дэс дараалал зэргээр олон янзын багц байна. Зурган картаас сонголт хийснээр бие даасан байдал, шийдвэр гаргах, өөрийгөө тайвшруулах чадварыг хөгжүүлэхэд тусална.

Сургалтын багц хэрэгсэл



Ярьдаг зургийн цомог:

Өөрийн дуртай зургаар ярьдаг ном бүтээж болно.



Мэдрэгчтэй тайвшруулагч

Атгах рефлексийг хөгжүүлэх, шалтгаан, үр дагаврын холбоог судлах зорилготой юм.



Том цаг

Сурагчдад ашиглахад тохиромжтой, цагаа хэрхэн өнгөрөөж байгаа баримжааг олгоно. Энэхүү цаг хугацааг хянах хэрэгсэл нь цаг хугацааны хийсвэр ойлголтыг өвөрмөц, харааны чадвараар нь хялбар ойлгоход тусална. Улаан талбар нь багасах тусам цаг хугацаа өнгөрч байгааг сурагчид хурдан ойлгох болно. Төөрөгдөл үүсгэхгүй байх, анхаарал сарниулахгүйн тулд уламжлалт цаг шиг тоо болон зүү байхгүй. 60 минут хүртэл ямар ч интервалаар тохируулах боломжтой.



Гэрлэн сэрүүлэгтэй цаг

Хүүхдийн сурах үйл ажиллагааны үргэлжлэх хугацааг тодорхой болгох, зохицуулахад тусална. Дугуй загвартай цаг нь сурагчдыг ямар ч өнцгөөс харахад хялбар. Энэхүү хугацаа хэмжигчийг сурагчдын ширээн дээр байрлуулж хүүхдийн анхаарал төвлөрөлт, цагийн менежментийн талаар суралцахад нь тусална.



Трамплин

Трамплиныг өөрийгөө зохицуулах, тэнцвэр бий болгоход ашиглана. Анхаарал суларсан, нойрмог үед биеийн энерги зарцуулж, анхаарал төвлөрөхөд тусална.



Суудлын зөөлөвч резин

Зориулалт: Удаан суух дургүй хүүхдэд тайвшруулах зорилгоор хэрэглэнэ. Анхаарал төвлөрөл сул сурагчдад ашиглана. Тэнцвэр, анхаарал төвлөрөлтийг сайжруулахын тулд дээр нь суулгах болон зогсох зэргээр хэрэглэнэ. Анхаарал төвлөрүүлэх болон булчингийн хөгжилд тустай.



Тайвшруулах буйдан

Тэврүүлж тайвширдаг хүүхдүүдийг стресстэй байх үед нь суулгаж түр тайвшруулах зөөлөн суудал юм. Энэхүү мэдрэхүйн хэрэглэгдэхүүн нь даралт мэдрэх дуртай хүүхдүүдэд хэрэглэнэ.



Тусгай сандал

Зориулалт: Сууж сураагүй суух дургүй хүүхдийг сууж сургахад ашиглана. Удаан хугацаагаар суухад нуруунд ачаалал ирдэг ба энэ сандал нь тухайн ачааллын 2/3 хувийг бууруулж зөв суухад тусална. Биеийн жингээ суудалдаа зөв хуваарилахад тусална.



Мешок, савлуур

Зориулалт: Хүүхдийг юм хийх хүсэлгүй болсон, ядарсан, тавгүй үед тоглуулж тайвшруулж амраана. Энэхүү дүүжин савлуур нь зөөлөн хөдөлгөөнөөр хүүхдийг тайвшруулж, бүүвэйлж өгдөг.



Зууж, хаздаг тоглоомууд

Зориулалт: Зарим аутизмтай хүүхдүүд амаараа аливаа зүйлийг мэдрэх, ямар нэг эд зүйл байлгахыг хүсэх тэр үед нь хэрэглүүлнэ. Жишээ нь: хуруу гараа хөхөх, хумсаа мэрэх, цаас элдэв зүйлс идээд байх тохиолдолд хэрэглүүлж болно. Зөөлөн болон хатуу биет учир мэдрэхүйд тохируулан сонгох боломжтой.



Хүндрүүлэгчтэй хантааз

Зориулалт: Аутизм болон анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх хавсарсан эмгэгтэй хүүхдэд суух, анхаарал төвлөрүүлж тогтож сургахад зориулсан бөгөөд хугацаа болон жинг нь тухайн хүүхдэд тохируулна. Богино хугацаанд зүүлгэж тайвшруулж, тайлаад хэсэг хугацааны дараа бас дахин 5 минут өмсгөөд тайлах зэргээр хэрэглэнэ. Хантааз нь жингийн даралт мэдрүүлж анхаарал төвлөрүүлэх, тайвшруулах, шилжилтийг хялбар болгох, бүлгийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.



Биеийн оймс

Зориулалт: Тэврүүлэх, биедээ даралт мэдрэх дуртай хүүхдэд тохиромжтой. Жишээ нь: орон доор орж хэвтдэг, хүнд тэврүүлж тайвширдаг гэх мэт. Оймсон дотор орж, толгойгоо гадагш гарган хэрэглэхэд зориулагдсан. Өмссөний дараа авирах, алхах, мөлхөх, үсрэх, сунах зэргээр ашиглана. Олон удаагийн хэрэглээг даах чадвартай, бат бөх.



Бичгийн хэрэгсэл

Зориулалт: Аутизмтай хүүхдийн хувьд гарын жижиг булчингийн хөгжил сул байдаг учир үзгээ барьж чадахгүй, эсвэл зөв барьж мэдэхгүй тохиолдол их байдаг. Сүлжмэл туузаар хийгдсэн. Үзгийн буруу барилттай бүх насны хүүхдэд хэрэглэнэ. Жижиг гогцоог үзэгт, том гогцоог бугуйнд хийж өгснөөр зөв атгалттай болох боломжтой. Өөрсдийн гараар хийх боломжтой.



Тэнцвэрийн тоглоом

Зориулалт: Аутизмтай хүүхдүүд тэнцвэрээ олж явахдаа муу, мөн булчингийн хөгжил сул байх магадлалтай тул тэнцвэрийн хэрэглэгдэхүүн шаардлагатай. Энэхүү бат бөх гишгүүр бүхий олон төрлийн хэмжээтэй хэрэглэгдэхүүн нь тэнцвэрээ олох, өөрийн биеийн үйлдлээ удирдан зохицуулах чадвар суулгана. Чулуу бүр өөр өөр өндөртэй учир нэмэлт саадыг бий болгож өгдөг. Энэ нь сурагч оюун ухаан, бие махбодын оролцоотойгоор дараагийн алхмаа бодож төлөвлөхөд түлхэц болж өгдөг. Сурагчдын тэнцвэрийг сайжруулах, хөдөлгөөн хийх чадвар, зохицуулалт, булчингийн ерөнхий байдлыг сайжруулахад тусална.

МОДУЛЬ 8:

СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ, СТРАТЕГИ



Зорилго	Суралцахуйн бэрхшээл, түүний төрөл, хүүхдэд илрэх байдлын талаар ерөнхий ойлголт мэдээлэл өгөх, ажиллах арга зүй, стратеги, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, суралцахуйн түгээмэл загварын зарчмыг хэрэгжүүлэх арга замын талаар судлах
Зорилт	<ul style="list-style-type: none"> ▪ Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах үндсэн ойлголт мэдлэгтэй болох ▪ Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, дэмжлэг үзүүлэх арга зүйд суралцах ▪ Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад багш, эцэг эх, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны талаар мэдлэг эзэмших ▪ Хүүхэд бүрийн суралцах явцад үүсэх өвөрмөц онцлогийг ойлгох, таних, дэмжлэг үзүүлэх, урамшуулах, ахиц өөрчлөлт гарна гэсэн итгэл үнэмшил, хандлагатай болох
Хугацаа	5 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн онцлог (90 минут)</p> <p>Сэдэв 2. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, суралцахуйн түгээмэл загварын гурван зарчмыг хэрэгжүүлэх арга замууд (120 минут)</p> <p>Сэдэв 3. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, эцэг эх, багшийн хамтын ажиллагаа (90 минут)</p>	

СЭДЭВ 1: СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ОНЦЛОГ

Зорилго: Суралцахуйн бэрхшээл (цаашид СБ), түүний төрөл, суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд (цаашид СБХ)-ийн онцлогийн талаар таниулах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Суралцахуйн бэрхшээл, тэгш хамран сургах боловсролын талаарх ерөнхий ойлголтыг тайлбарлах
- Суралцахуйн бэрхшээлийн төрлүүдийн ялгаа, илрэх байдлыг тодорхойлох
- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн онцлогийг тайлбарлах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчдын тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1. Товч танилцуулга (5 минут)

Модулийн зорилго, эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага, хичээлийн сэдэв, зорилго, үйл ажиллагааг танилцуулж сургалтад оролцогчид, багш нарын хамтын зорилгыг тодорхойлно.

Үйл ажиллагаа 2. Суралцахуйн бэрхшээлийн талаарх ойлголт (25 минут)

1. Оролцогчидтой дараах асуултын дагуу харилцан ярилцана.
 - Суралцахуй гэдэг үгийг хэрхэн ойлгож байгаагаа тайлбарлана уу. Өөр ямар үгээр илэрхийлж болох вэ?
 - Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд гэдгийг хэрхэн ойлгож байгаагаа өөрт тохиолдсон жишээн дээр тайлбарлана уу. Бэрхшээлтэй гэдэг үгийг өөр үгээр хэлнэ үү.
 - Суралцахуйн бэрхшээлийн талаар өмнө нь ямар нэг мэдээлэл авч байсан уу?
 - Мэдээлэл авч байсан бол бусадтайгаа хуваалцана уу.

Оролцогчдын оролцоог хангаж, өөрийн үзэл бодол, дүгнэлтээ хэлэх боломж олгоно.

2. Хавсралт 1-д байгаа мэдээллийг ашиглан слайд бэлтгэж оролцогчдод тайлбарлана.
3. Дараах асуултын дагуу ярилцана.
 - Ямар шалтгаанаас бэрхшээл үүсдэг бол? өөрийн тайлбарыг хэлнэ үү.
 - Сургуульд сурахад хүндрэл, бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд юуг анхаарвал зохих вэ?

Ярилцлагын эцэст багш суралцахуйн бэрхшээл үүсэх шалтгаан, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгнө.

Үйл ажиллагаа 3. Суралцахуйн бэрхшээлийн төрөл, хүүхдийн онцлог (35 минут)

1. Оролцогчдоос дараах асуултыг асууж ярилцана.
 - learning disability, dyslexia, dysgraphia гэх мэт нэр ухагдахууныг сонсож байсан уу? Тийм бол ямар утгатай үг болохыг хэлнэ үү?
 - Хүүхэд аливаа шинэ зүйлийг сурч мэдлэг эзэмшихэд ямар суурь чадвар хэрэгтэй вэ? Нэрлэнэ үү? (унших, бичих, ярих, тооцоолон бодох, учир шалтгааныг олох, дүгнэлт хийх)

Нэр ухагдахууны талаар оролцогчдын тайлбар, санал бодлыг хэлэлцэж дүгнэнэ.

2. Багш хавсралт 2-т байгаа мэдээллийг ашиглан суралцахуйн бэрхшээлийн төрлийг тайлбарлана.
3. Багш хавсралт 3-ыг ашиглан “Сурах бэрхшээлтэй хүүхдийн онцлог” сэдвээр мэдээлэл өгнө.

Үйл ажиллагаа 4. Тэгш хамран сургахад хүүхдэд ямар дэмжлэг үзүүлэх талаар хэлэлцэх (20 минут)

1. Оролцогчдыг 5 багт хуваана. Багийн гишүүд дараах бэрхшээлийн үед ямар онцлог, шинж тэмдэг илэрдэг талаар кейс жишээ гаргаж хамтран ярилцаад, бусдадаа танилцуулна.
 - 1-р баг: Унших бэрхшээл
 - 2-р баг: Бичих бэрхшээл
 - 3-р баг: Тоо бодох бэрхшээл
 - 4-р баг: Ярих, харилцах бэрхшээл
 - 5-р баг: Сонсох болон учир зүйн шалтгааныг олохдоо хүндрэл бэрхшээлтэй

2. Багийн гишүүд дараах асуултын дагуу хамтран ярилцаж, өөрсдийн хариултыг дэлгэц цаасан дээр бичээд, бусдадаа хуваалцана.
- Сурагчдын гаргадаг онцлог алдаа, шинжүүдээс жишээ гарган тайлбарлана уу.
 - Алдаа гаргахад хүргэж буй ямар боломжит шалтгаанууд байж болох вэ?
 - Багшийн зүгээс юуг анхаарах, ямар ажил хийж болох вэ?
 - Ийм төрлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургахад багшид Та ямар зөвлөмж өгөх вэ?

Дүгнэлт (5 минут)

- Суралцахуйн бэрхшээл гэдгийг өөрийн үгээр тодорхойлно уу.
- Суралцахуйн бэрхшээлийг ямар төрөлд хуваан үзэж байна вэ?
- Ямар нэр томьёо, ухагдахуунтай шинээр танилцсан бэ? Ямар ялгаа байна вэ?
- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд илрэх онцлогийн талаар дүгнэж ярина уу.
- Өмнө төсөөлж байснаас өөр ямар шинэ мэдээлэл олж авсан бэ?

Даалгавар:

- Сэдэвтэй холбоотой материалыг уншиж 1-2 асуулт бэлтгэж ирэх
- Нэр томьёо, ухагдахууныг бичих, тайлбарлаж сурах
- Цахим орчноос тус сэдэвтэй холбогдох мэдээлэл олж унших

ХАВСРАЛТ 1

СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Суралцахуйн бэрхшээлийг эрдэмтэд сэтгэл судлал, боловсрол судлалын талаас авч үзэж дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: Суралцахуйн бэрхшээл гэдэг (learning disability) нь сэтгэхүйн хөгжлийн хэвийн хурд алдагдах, өөрөөр хэлбэл хүүхдийн хөгжлийн явцад тодорхой нэгэн сэтгэцийн үйл ажиллагаа (ой тогтоолт, анхаарал, сэтгэхүй, сэтгэлийн хөдөлгөөний хүрээ) тухайн насанд байвал зохих сэтгэл зүйн хэвийн үзүүлэлтээс хоцрохыг хэлнэ.

Суралцахуйн бэрхшээл гэдэг нь сурагч, үе тэнгийн хүүхдүүдтэй ижил түвшинд мэдлэг, чадвар, боловсрол эзэмшихэд саад болж буй нөхцөлийг хэлнэ гэж зарим эрдэмтэд тодорхойлсон байна. Хүүхэд ой тогтоолт, анхаарал төвлөрөлт зэрэг танин мэдэхүйн бэрхшээлтэй байж болно. Өөрөөр хэлбэл суралцахуйн бэрхшээл нь танин мэдэхүйн үйлийн (мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах, илэрхийлэх) алдагдлаас шалтгаалж суралцах явцад үүсэх бэрхшээлийг хэлнэ.

Сургуульд тохиолдох суралцахуйн бэрхшээлийг 2 хэлбэрт хуваан үзнэ. Үүнд:

Суралцах чадвараар ангилсан түгээмэл хэлбэр. Үүнд: уншихын бэрхшээл ([дислексия](#)), бичих бэрхшээл (дисграфия), тоо бодох бэрхшээл (дискалькулия), зорилго чиглэлтэй хөдөлгөөн хийх, хөдөлгөөний тэнцвэрийн бэрхшээл (диспраксия)

Нейро сэтгэл судлалын буюу суралцахад үүсэж буй бэрхшээлийн мөн чанар, механизмыг задлан шинжлэх байдлаар ангилсан хэлбэр. Мэдрэлийн үйл ажиллагааны ямар нэгэн дутуу хөгжил нь суралцахуйн бэрхшээл үүсэхэд хүргэж байна гэж нейро сэтгэл судлаачид тайлбарлаж дүгнэдэг. Жишээлбэл,

Хүний бичих үйлийг мэдрэл, уураг тархины бүтцийн талаас авч үзвэл маш нарийн үйл ажиллагаа бүхий дараах 3 чухал хэсгээс бүрддэг. Үүнд:

- Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг: хүний аливаа зүйлийг төлөвлөх, удирдан зохион байгуулах үйлдлийг хянах үйл буюу уураг тархины дух хэсэг
- Хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг: сонор, хүрэлцэхүйн мэдээллийг боловсруулах үйлдэл буюу уураг тархины зүүн тал бөмбөлгийн чамархай, зулайн хэсэг
- Гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг: хараа ба харааны орон зайн баримжааны мэдээллийг боловсруулах үйлдэл буюу гол төлөв уураг тархины баруун тал бөмбөлгийн дагзны хэсэг

Эдгээр бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн үйл ажиллагааны сулралын үед бичих бэрхшээлийн өвөрмөц хэлбэр үүсдэг. Аль нэг бүрэлдэхүүн хэсэг тус бүр янз бүрийн үүрэг бүхий үйл ажиллагаанд орж болно. Жишээлбэл, тоо бодохтой холбоотой бэрхшээл, ихэнхдээ нэг ба гуравдугаар бүрэлдэхүүн хэсгийн сулралын үед үүсэх боломжтой гэж тайлбарлаж байна.

ХАВСРАЛТ 2

А. Унших бэрхшээл- дислексия

Дээд мэдрэлийн үйл ажиллагааны аль нэг хэсгийн хэвийн бус үйл ажиллагаанаас үүдэж унших үйлийн зарим хэсэгт тогтвортой, байнга, давтагдсан алдаа гарч, бэрхшээл үүсэхийг хэлнэ. Энэ төрлийн бэрхшээлтэй хүүхэд нь унших болон уншсан зүйлээ ойлгох, түүнийг сэргээн санах, бичих, үсэглэх зэрэгт бэрхшээл үүсдэг.

Унших бэрхшээлийн үед илрэх шинж тэмдэг:

- Цагаан толгойн үсгээ таньж зөв дуудаж чаддаггүй.
- Урт, хос эгшиг, Я-гийн төрлийн үсэг орсон үе, үгийг зөв уншиж чаддаггүй.
- Үсэг алгасах, тааж унших зэрэг алдаа гаргадаг.
- Үсэглэж, үелж удаан уншина.
- Үсгийг солих, орхих байдлаар алдаж, тааж уншина.
- Уншсан зүйлийн утгыг ойлгох чадвар сул байна.

Б. Тоо бодох, тооцоолол хийхэд үүсэх бэрхшээл-дискалькулия

Хүүхэд тоо тоолол, тооцоолон бодох үйлдэл хийх, тооны ухагдахуунуудыг ойлгох, цифр, тэмдэг, тэмдэглэгээ хийх, санах, давтах, ойлгож хэрэглэх, математик үйлдлүүдийг гүйцэтгэхдээ бэрхшээлтэй тулгардаг.

Тоо бодох бэрхшээлийн үед илрэх шинж тэмдэг:

- Цифр, тоон утга, тэмдэгтийг ойлгож чаддаггүй, хооронд нь сольдог.
- Өгүүлбэртэй бодлогын нөхцөл, асуултыг ялгадаггүй.
- Үйлдлийн дараалал сольдог.
- Математик үг хэллэгийг хэрэглэхдээ алдаж, утгыг нь ойлгодоггүй.
- Багалан бичиглэл хийхдээ орон ангийг сольж бичнэ.

В. Бичих бэрхшээл - дисграфия

Бичих үйлд оролцдог сэтгэцийн үйл ажиллагаа дутуу хөгжсөний улмаас давтагдсан, тогтонги шинжтэй алдаагаар илэрч байгаа бичих үйлийн өөрчлөлтийг бичих бэрхшээл гэнэ. Үсэг, тэмдэгт ашиглан бичих гарын нарийн жижиг булчингийн хөдөлгөөнүүдээ зохицуулах чадварын алдагдал үүснэ.

Бичих бэрхшээлийн үед илрэх шинж тэмдэг:

- Гаргацтай ойлгомжтой бичиж чаддаггүй.
- Үсэг, үе, үг орхиж бичнэ.

- Үсгийг буруу харуулж бичнэ.
- Дармал бичмэл, том жижиг үсгийг ялгаж чаддаггүй.
- Самбараас хуулан бичихдээ алдана.

Хүүхдэд булчингийн хүч болон хөдөлгөөний далайц хадгалагдсан үед зорилго чиглэлтэй хөдөлгөөн хийх чадвар хөдөлгөөний тэнцвэр алдагдах байдал үүсэх тохиолдол байх бөгөөд энэ бэрхшээлийг диспраксия гэж нэрлэдэг.

Мөн хөдөлгөөн, хараа-орон зайн баримжаа, нийгэмшлийн чадвар сул хөгжсөн тохиолдолд хүний нүүрний хувирал, биеийн хэлэмжийг ойлгох чадвар сул байна.

Хэл яриагаа аман болон бичгийн хэлбэрээр илэрхийлэхэд хүндрэлтэй, сонсголоор хүртэн хүлээн авч буй мэдээллийг боловсруулахад бэрхшээл үүсэж болно.

Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд тухайн нэг суралцах чадварын бүрэлдэхүүн хэсэг бэрхшээлтэй байх ч бусад талаар хөгжил нь үе тэнгийнхэнтэйгээ ижил эсвэл бүр илүү ч байж болно.

ХАВСРАЛТ 3

СУРАЛЦАХҮЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ

Хүүхдэд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл, жишээлбэл, оюун ухааны хомсдол илэрдэггүй, харин үндсэн хүндрэл бэрхшээл нь нийгэмшил, сурах, дасан зохицох чадвартай нь холбоотой байдаг.

Ийм байдлын гол шалтгааныг сэтгэцийн хөгжил бүрэн гүйцэд хөгжин төлөвших хурд удааширч саарсантай холбон тайлбарладаг.

Гэхдээ суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд бүрийн сургалтад тохиолдох хүндрэл бэрхшээл өөр өөр, хугацаа болон хүндрэлийн түвшнээрээ бие биеэсээ ялгаатай ч дараах нийтлэг онцлог илэрнэ. Үүнд:

- Сэтгэл хөдлөл, зоригийн хүрээ дутуу хөгжсөн, суралцах явцдаа ямар нэгэн үйл ажиллагааг гүйцэтгэх, дуусгахын тулд өөрийгөө дайчлан зоригийн хүч гарган хичээн ажиллаж чаддаггүй, анхаарал нь тогтворгүй тодорхой үйлдэлд төвлөрөх чадвар нь буурсан, сарнимтгай байдаг.
- Хүртэхүйн өөрчлөлт нь дүрсийг бүхлээр нь нэгтгэн хүртэж чадахгүй байдлаар илэрдэг. Жишээлбэл: хүүхэд, ямар нэгэн танил дүрсийг өөр байдлаар зурж илэрхийлсэн тохиолдолд буруу хүртэж, таньж, илэрхийлэхдээ алддаг.
- Хүртэхүйн дутуу хөгжил нь хүрээлэн буй орчны талаарх мэдээллийг хязгаарлагдмал болгодог.
- Үгээр илэрхийлснээс, хараагаар мэдээллийг илүү тогтоох онцлог илэрдэг.
- Сургалтын явцад үүсэх хүндрэл нь зарим үед хэл ярианы хөгжлийн хоцрогдол, бэрхшээл хавсарсантай холбоотой байдаг.
- Сэтгэхүйн хөгжил хоцрогдолтой тул хэл яриа, логик сэтгэхүйн хөгжил шаардсан өгүүлбэртэй бодлогыг бодоход хүндрэл бэрхшээлтэй тулгардаг.
- Сургуульд орж сургалтын үйл ажиллагаа эхлэх үед хүүхдэд оюуны үйлдэл хийхэд шаардлагатай сэтгэхүйн үйлдлийг (анализ, синтез, нэгтгэн дүгнэх, харьцуулах, хийсвэрлэх) бүрэн гүйцэд эзэмшээгүйгээс хүндрэл бэрхшээл үүсдэг.

СЭДЭВ 2: СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АРГА ЗҮЙ, СУРАЛЦАХУЙН ТҮГЭЭМЭЛ ЗАГВАРЫН ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

Зорилго: Суралцахуйн түгээмэл загварыг суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлэх талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Унших бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйг дэмжих, ажиллах арга зүйн талаар тайлбарлах
- Бичих бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйг дэмжих, ажиллах арга зүйн талаар тайлбарлах
- Тоо бодох, ярих бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйг дэмжих, ажиллах арга зүйн талаар тайлбарлах

Хугацаа: 120 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, скоч
- Хавсралт 1, 4: Тараах материалыг оролцогчдын тоогоор хэвлэх
- Хавсралт 2, 3: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1. Хичээлийн сэдэв, зорилго үйл ажиллагааг таниулах (5 минут)

1. Өмнөх хичээлээр үзсэн агуулгыг бататгаж ярилцана. Даалгавар биелэлтийг шалгаж, харилцан мэдээлэл түгээнэ.
2. Бие дааж нэмэлт мэдээлэл уншсан байдалтай танилцана.

Үйл ажиллагаа 2. Суралцахуйн түгээмэл загварын дараах 3 зарчим, хэрэгжүүлэх арга замын талаар ойлголт мэдлэг олгох (60 минут)

1. Багш “Суралцахуйн түгээмэл загварын 3 зарчим”-ийн талаар доорх мэдээллийг танилцуулна.
 - 1) Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг сэдэлжүүлж оролцоог хангах арга замууд
 - 2) Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд олон хэлбэрээр үзүүлэх арга замууд
 - 3) Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд олон янзаар үйлдэл хийх ба илэрхийлэх арга замууд
2. Оролцогчдыг 6 багт хуваана. Суралцахуйн түгээмэл загварын 3 зарчмыг хэрхэн ойлгож, хэрхэн хэрэгжүүлэх арга замыг хамтран хэлэлцэж дэлгэц цаасан дээр тайлбарлан бичнэ.

3. Хавсралт 1-ийг оролцогчдод тарааж, багш нэмэлт мэдээлэл өгч дүгнэнэ.

4. Дараах асуултыг асууж, харилцан ярилцана.

- Анги нийтийн сургалтын явцад хүүхдийн оролцоог хангахын тулд хичээлийг ямар хэлбэрээр хэрхэн зохион байгуулах вэ?
- Хүүхэд өөрийгөө хэрхэн илэрхийлэх вэ?

Үйл ажиллагаа 3. Багшийн тайлбар мэдээлэл (45 минут)

1. Унших, бичих, тоо бодох бэрхшээлтэй хүүхдийн суралцахуйг дэмжих, ажиллах зарим арга зүйн талаар багш слайд ашиглан мэдээлэл өгч тайлбарлана.

2. Оролцогчид 5 багт хуваагдана. Баг бүр “Багшийн туршлага судлах, тохиолдол жишээн дээр харилцан ярилцах” сэдвийн дор “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж” (УБ, 2019) номоос унших, бичих, тоо бодох, ярих бэрхшээлтэй монгол хүүхдийн тохиолдол жишээ бүхий тараах материалтай танилцаж дараах чиглэлээр дүн шинжилгээ хийнэ.

- Унших, бичих, тоо бодох, ярих бичих бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хичээл дээр тохиолддог бэрхшээлүүд
- Тухайн бэрхшээл үүсэхэд хүргэж буй боломжит шалтгаанууд
- Тохируулгат орчин

3. Багшийн зүгээс авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар хэлэлцэнэ.

Оролцогчид өөрсдийн туршлагаа хуваалцана. “Суралцахуйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай хүүхдийн онцлог, хэрэгцээг таних” асуулгыг танилцуулж хэрхэн бөглөх болон анхаарах зүйлсийн талаар танилцуулна. Асуулгын хуудсыг оролцогч бүрт тарааж өгнө.

Дүгнэлт (10 минут)

- Унших, бичих, тоо бодох үед хүүхдэд ямар бэрхшээл үүсэж болох вэ?
- Ямар шалтгааны улмаас үүсэж болох вэ? Яаж урьдчилан сэргийлэх вэ?
- Багш ямар аргаар ажиллаж болох вэ?
- Танд ямар сайн туршлага байна вэ? Бусдадаа хэлнэ үү.
- Өмнө төсөөлж байснаас өөр ямар шинэ мэдээлэл олж авсан бэ?

Даалгавар: Өгсөн линкийг ашиглан мэдээлэлтэй танилцах

- Суралцахуйн бэрхшээл1 學習障害1 <https://www.youtube.com/watch?v=Hwi8izUqlzE>
- Суралцахуйн бэрхшээл2 學習障害2
- <https://www.youtube.com/watch?v=HcQCGp9CSXo>

ХАВСРАЛТ 1

1-р зарчим. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэдэлжүүлж тэдний оролцоог хангах арга замууд

- Хүүхдийн сонирхол хэрэгцээ, чадвар чадамжид нь тулгуурлах
- Биечлэн оролцох боломжтой үйл ажиллагааг санал болгох

Бага ангийн сурагчид ширээний ард 15-20 минутаас удаан суувал залхаж эхэлдэг.

Мэдрэхүйн олон эрхтэн зэрэг ашиглах замаар суралцах, суралцах үйл ажиллагааг хөгжилтэй байдлаар хөтлөн явуулах




- Бие даалтын ажлыг олон янзаар гүйцэтгэх сонголт өгөх
- Нэг үйлээс нөгөөд шилжих цаг хугацааг үр дүнтэй ашиглах
- Хүүхдийг магтаж, урамшуулах
- Нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх үйл явцад нь дэмжлэг үзүүлэх

Хүүхдийн сайн, зөв хийж буй үйлдлийг сайшаан урамшуулах

2-р зарчим. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдэд олон янзаар үзүүлэх арга замууд

- Унших эхийг хялбаршуулах
- Зураг, график, эд зүйл, бичлэг ашиглах
- Хүүхдийн үгийн нөөцийг баяжуулах



- Хүүхдийн өмнөх мэдлэгийг сэргээхийн тулд утгын зураглал хийх
- Сурагчдад ойлгуулах ёстой гол санаагаа урьдчилан бэлтгэх

3-р зарчим. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдүүд үйлдэл хийх ба илэрхийлэх олон арга замууд

Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн арга замаар суралцахуйн үйл явцаа чиглүүлж, сурсан мэдсэнээ илэрхийлдэг тул багш сурагчдаа өөрсдийгөө олон аргаар илэрхийлэх боломжоор хангах нь зүйтэй.

Бод-Хамтар-Хуваалц аргачлалыг ашиглах

Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхэнтэй нь хамт сургах хэрэгтэй.

- Багш хичээлийн сэдэвтэй холбоотой асуулт асуухад хүүхэд бүр дор бүрнээ ямар зөв хариулт байж болох талаар бодно (Бод);
- Хосоороо сууж байгаа сурагчид хоорондоо аль нь зөв хариулт болох талаар ярилцана (Хамтар);
- Ангийн нэг хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зөв хариултаа бичихэд нь туслах эсвэл хоорондоо ярилцаад зөв гэж үзсэн асуултаа цаасан дээр бичнэ (Хуваалц).
- Багш, асуултын хариултаудыг зургаар үзүүлж, сурагчид зөв хариултын холбогдох зургийг сонгож хариулна.

ХАВСРАЛТ 2

Багшийн мэдээлэл

Багш оролцогчдод, суралцах явцад хүүхдэд үүсдэг хүндрэл бэрхшээл болон сургуулийн өмнөх болон бага ангийн (5-10 нас) “Эрсдэлт бүлэг”-ийн хүүхдийг илрүүлэх, таних аргачлалын зорилго, хэрэглэгдэхүүн, боловсруулах талаар танилцуулна. “Эрсдэлт бүлэг” гэдэг дор анги нийтийн сургалтаас хоцорч хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй тулгарч, багшийн зүгээс дэмжлэг тусламж шаардаж байгаа хүүхдийг авч үздэг.

ХАВСРАЛТ 3

“Эрсдэлт бүлэг”-ийн хүүхдийг таних аргачлал нь хүүхдийн хөгжлийг дараах 6 үзүүлэлтээр тодорхойлж, хүүхдэд үзүүлэх дэмжлэг, ажиллах арга зүйг чиглэлийг тодорхойлдог.

- Хүүхдийн хөгжлийн ерөнхий үзүүлэлт
- Анхаарлын тогтворгүйжилт, хөдөлгөөнтэй байдал
- Хүүхдийн нийгмийн дасан зохицох чадварын байдал
- Сэтгэл хөдлөлийн тогтворгүйжилтийн байдал
- Оюун ухааны хөгжлийн түвшин
- Хүүхдийн хүмүүжил, дэмжлэг тусламж, сурган хүмүүжүүлэх нөлөөлөл авах байдал

СЭДЭВ 3: СУРАЛЦАХУЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИХ ТОХИРУУЛГАТ ОРЧИН, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, ЭЦЭГ ЭХ, БАГШИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Зорилго: Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүйн онцлог, дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах, арга зүйд тохирсон хэрэглэгдэхүүн, багш, эцэг эхийн хамтын ажиллагааны талаар судлах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургалтын хэрэглэгдэхүүн, түүнийг хэрэглэх, бэлтгэх, сонгох арга зүйд суралцах
- Эцэг эх, багш, бусад мэргэжилтний хамтын ажиллагааг хөгжүүлэх, ажлыг төлөвлөн зохион байгуулах

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Хавсралт 1: Багшид зориулсан материал
- Хавсралт 2: Багшид зориулсан материал
- Хавсралт 3: Багшид зориулсан материал
- Хавсралт 4: Багшид зориулсан материал
- Хавсралт 5: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1. Хичээлийн сэдэв, зорилго үйл ажиллагааг таниулах (5 минут)

1. Өмнөх хичээлээр үзсэн агуулга бататгана.
2. Даалгавар биелэлтийг шалгана.
3. Өгсөн линкний мэдээллийн талаар ярилцана. Оролцогчдын бие даан уншиж судалсан мэдээлэлтэй танилцана.

Үйл ажиллагаа 2. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүний талаарх ойлголт (35 минут)

1. Сургалтын хэрэглэгдэхүүн, бодит үзүүлэнгийн талаар хавсралт 1-ийг ашиглан мэдээлэл өгнө. Тохирох хэрэглэгдэхүүний жишээ, зураг үзүүлнэ. Багш слайд ашиглан унших, бичих, тоо бодох бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад хэрэглэх зарим нэг хэрэглэгдэхүүний талаар танилцуулна.
2. Унших, бичих, тоо бодох бэрхшээлтэй хүүхэдэд сургалт явуулахад ашиглах дасгал тоглоомуудын жишээг хавсралт 2-ыг ашиглан танилцуулна. Оролцогчид дасгал, тоглоомын жишээ гарган ярилцана.

3. Оролцогчдыг 5 багт хувааж тараах материал өгнө. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласан багш нарын сургалтын тохируулгат орчин хэрэглэгдэхүүн бэлтгэсэн туршлага жишээг уншиж судалж, мөн өөрийн сайн туршлагыг бусад багт танилцуулна. Доорх асуултыг ашиглан ярилцана.
 - Багш ямар хэрэглэгдэхүүн бэлтгэсэн байна вэ?
 - Хүүхэдтэй ямар арга зүйгээр ажиллаж, ямар үр дүнд хүрсэн байна вэ?
4. Тохирох хэрэглэгдэхүүнийг сургалтын гарын авлагаас зураг ашиглаж тайлбарлана.

Үйл ажиллагаа 3. Эцэг эх, багш, бусад мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны талаарх ойлголт (45 минут)

1. Оролцогчдыг 5 багт хуваана. Багийн гишүүд дараах сэдвийн дагуу ярилцаж бусдадаа танилцуулна.
 - Эцэг эхийн зүгээс хүүхэдтэй харилцахад гаргадаг түгээмэл алдаа
 - Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүй, зан төлөв, бие хүний хөгжилд гардаг өөрчлөлт
2. Багш, эцэг эхийн зүгээс хүүхэдтэй харилцахад анхаарах зүйлсийн талаар зөвлөмж боловсруулна.

Багийн ажиллагаанд өгөх зааварчилгаа:

- Сургуулийн орчинд багш, сурагч, эцэг эхийн зүгээс боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд хэрхэн хандаж байна вэ? Сэтгэл зүй, зан төлөвийн хувьд ямар нийтлэг өөрчлөлт гардаг талаар хэлэлцэж бичнэ үү?
 - Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургахын тулд багш нарт ямар зөвлөмж өгөх вэ?
 - Багш ангид сурагчдын дунд ямар үйл ажиллагаа зохиох нь оновчтой вэ?
 - Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийн давуу талуудын бодит жишээнээс нэрлэнэ үү?
3. Багш оролцогчдод дараах мэдээллийг танилцуулна.
 - Эцэг эх, гэр бүлийн гишүүд хүүхдийн хүмүүжлийн асуудлаар нэгдмэл бус ойлголттой, хүүхэд хүмүүжүүлэх асуудлаар өөр өөр байр суурьтай байдаг.
 - Хүүхэдтэй харилцахдаа бодит бус, эмх цэгцгүй, зөрчилтэй байдлаар ханддаг.
 - Хүүхдийн амьдралын бүхий л хүрээнд хэт анхаарсан эсвэл хэт заагласан байдал гаргаж улмаар эцэг, ялангуяа эхийн зүгээс асуудлыг хэт ойр хүлээж авдаг.

- Хүүхэд тохиолдож байгаа асуудлаа айдасгүйгээр давах, өөрийн хүчиндээ итгэж сурах нь чухал болохыг ойлгодоггүй.
- 4. Эцэг эх, багшийн зүгээс суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцахдаа анхаарах дараах зүйлсийг хавсралт 3 ба 4-ийг ашиглан танилцуулна.
- 5. Багш хавсралт 5-ыг ашиглан слайд бэлтгэж, үнэлгээний аргачлалыг хүүхдийн чадварт нийцүүлэн тохируулах талаар танилцуулна.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцаж, хичээлийг дүгнэнэ.

- Хүүхдэд зан төлөвийн ямар бэрхшээл үүсдэг вэ? Бодит жишээ гаргана уу?
- Эцэг эх, багшийн зүгээс гаргадаг түгээмэл алдаанаас тоочно уу?
- Багш, эцэг эхийн зүгээс баримтлах гол зарчмыг, хүүхэдтэй яаж харилцах талаар тайлбарлана уу?

Даалгавар: Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн зөвлөмж. Эмхэтгэсэн Г.Батцэнгэл, бусад УБ., 2020 ном унших. Хуудас 13-19

Багшийн арга зүйд анализ хийж өөрт шинэлэг гэж үзэж буй 2-3 арга зүйг тэмдэглэнэ.

ХАВСРАЛТ 1

Тооллын материал



Зориулалт: Хүүхдийг тоо тоолуулж сургах, тоон утгыг таниулах, олон цөөн, их бага, урт богино гэх мэт ойлголтыг тайлбарлан таниулах, харьцуулах зэрэгт ашиглах зорилготой. Энэхүү иж бүртэл нь төрөл бүрийн өнгийн, урт богино дөрвөлжин дүрсээс бүрдэнэ. Мөн олон төрлийн хувилбарууд байдаг.

Ашиглах заавар: Тоо тоолол болон математикийн бэлтгэл үеийн хичээл болон хөгжүүлэх үйл ажиллагаанд өргөн хэрэглэнэ.

Математикийн хичээлийн хэрэглэгдэхүүнүүд



Монгол хэлний хичээлийн хэрэглэгдэхүүнүүд



Тохируулгат нүхтэй хавтан



Зориулалт: Хэрэглэгдэхүүн нь хэмжээсний тухай ойлголт, харааны хүртэхүйг хөгжүүлэх, орон зайн баримжааг хөгжүүлэх зорилготой. Хэрэглэгдэхүүн нь «том - жижиг», «өргөн - нарийн», «өндөр - бага» гэсэн ойлголтыг таниулахад чухал үүрэгтэй. Бөмбөг хэлбэртэй бариул нь хүүхдийн гарын жижиг булчинг хөгжүүлэх, хөдөлгөөний чадварыг сайжруулах, бичлэгт гарыг бэлтгэх үүрэг гүйцэтгэнэ.

ХАВСРАЛТ 2

Унших, бичих бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ангийн болон сурагчийн үсэг болон үеийн сан, хүснэгт. Жишээлбэл:

Үеийн хүснэгттэй ажиллах арга зүй.

- Хүүхэд үгийн салангид үе дээр ажиллах нь тааж уншихаас сэргийлдэг сайн талтай. Эхний хичээлээс эхлэн хүүхэд үеийг холбож уншиж сурах шаардлагатай болдог.

НА	ХҮ	СО
СУ	РУ	АС
АМ	МУ	ЗО
СӨ	ЛИ	ШИ

- Сонсгол хөгжүүлэх дасгал тоглоомууд
- Харааны хүртэхүй хөгжүүлэх дасгал тоглоомууд. Жишээлбэл:

Харааны уншлага

Ийм төрлийн арга нь 2-р ангид илүү үр дүнтэй ба хүүхдийн түргэн хугацааны ой тогтоолтыг сайжруулдаг. Хүүхэд үгийн утгыг дор нь амархан ойлгосноор уншиж сурах нь зугаатай, сонирхолтой болж уншлагад сургах үйл ажиллагаа нь илүү хурдан хялбар болж ирдэг. Жишээлбэл:

Цас хайллаа.

Бороо орлоо.

Тэнгэр цэлмэв.

Бат дуулав.

Шувуу нислээ.

Нар гарлаа.

Унших бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн нэг хэлбэр бол түргэн хэллэг дээр ажиллах явдал юм. Оролцогчид түргэн хэллэг хэлнэ.

Түргэн хэллэг

Өгүүлэх эрхтний хөдөлгөөнийг сайжруулах зорилготой, үгийг зөв, тод хэлэхэд анхаарна. Ийм төрлийн дасгал нь хүүхдийн авиан сонсголыг хөгжүүлж өгдөг.

Уншлага болон хэлний дасгал

Унших эх ямар ч байж болох хэдий ч агуулга нь сонирхолтой төгссөн хэлбэртэй байвал зохино. Хүүхэд эхийн гол агуулгыг хэрхэн ойлгосныг тодруулах зорилгоор хүүхдээс 3 асуулт асууна.

Нохой

Зуслан дээр гэрийн эзэнд нохой байлаа. Хүүхдүүд түүнтэй тоглодог байв.

Намар боллоо.

Бүгд зуслангаас явцгаав. Нохой үлдэв.

Хүүхдүүд уйлав. Нийт 19 үг. Асуулт:

Нохой хаана амьдарч байв? Нохой хаана үлдсэн бэ?

Хүүхдүүд яагаад уйлав?

Харааны цээж бичиг бичих

Эхний өгүүлбэр 8 үсэг буюу 2 богино үгээс бүтсэн байх бөгөөд дараа дараагийн өгүүлбэрүүд 1-2 үсгээр нэмэгдэх байдлаар нийт 5 өгүүлбэр бичих дасгал хийнэ. Жишээлбэл:

Ном ав. (5 үсэг) Ус урсав. (7 үсэг)

Дорж ирэв. (8 үсэг)

Цас шуурав. (9 үсэг)

Бороо орлоо. (10 үсэг)

Хүүхэд өгүүлбэр тус бүрийг анхааралтай тайван уншиж тогтооно. Ийм төрлийн дасгалыг өдөр бүр тогтмол хийвэл зохино.

Чанга дуугаар унших

Өгсөн эхийг чанга дуугаар хүүхэдтэй хамт хэт хурдан биш, гэхдээ 5 минутаас илүүгүй хугацаанд уншина.

Унтахын өмнө унших

Оройн унтлагын өмнө унших арга үр дүнтэй, учир нь тухайн өдрийн хамгийн сүүлийн үйл явдал хүүхдийн сэтгэл хөдлөл, ойд нь хадгалагддаг бөгөөд сайхан дурсамж нойронд үлддэг бөгөөд ийм байдалд организм дасаж эхэлдэг.

Хуруу гарын жижиг булчин хөгжүүлэх дасгал тоглоомууд.

Хурууны дасгал. Хүүхдийн хэл ярианы хөгжлийн түвшин нь үргэлж гарын жижиг булчингийн хөдөлгөөний хөгжлийн түвшинтэй шууд хамааралтай байдаг.

Дадлага ажил. Орос багш нарын боловсруулсан “Хурууны дасгал” сэдэвтэй цахим хичээлийг монгол тайлбартайгаар үзүүлж, дасгал бүрийг багшийн удирдлага дор оролцогчид даган дуурайж хамтарч хийнэ.

ХАВСРАЛТ 3

Хүүхэдтэй ажиллахдаа багш дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:

- Хүүхэд солгой буюу зүүн гараар бичдэг эсэх
- Өмнө солгой байгаад, одоо баруун гараараа бичиж байгаа эсэхийг шалгах
- Хүүхдийн өсөж буй орчин хос хэлтэй өөр өөр хэлээр ярьдаг гэр бүл эсэх
- Хүүхэд өмнө хэл засалч багштай ажиллаж байсан эсэх
- Ой тогтоолт, анхаарлын талаас хүүхдэд ямар нэг асуудал байгаа эсэх
- Хүүхэд сургуульд орох наснаасаа өмнө эрт орсон эсэх
- Хүүхэд бичихдээ үсэг, үе, үгээ орхиж бичдэг эсэх
- Хүүхдэд авиаг сонсож хүртэх үйлийн өөрчлөлт байгаа эсэх
- Хүүхэд өөрийнхөө хэлж байгаагаар бичиж байгаа эсэх

ХАВСРАЛТ 4

БАГШ, ЭЦЭГ ЭХИЙН БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ

- Хүүхдэд “хангалтгүй” гэдэг дүн яаран тавихгүй байх.
- Хүүхдээ, үе тэнгийнхэн, найз нөхөд, ах эгч нартай нь ялангуяа амжилттай болон амжилтгүй сурсан байдлаар нь харьцуулж жишихгүй байх. Багш, эцэг эхчүүд хүүхдэдээ сайн сэдэл тэмүүлэл төрүүлэхийн тулд “Дорж багадаа сайн байсан, Тэрнийх сайн болсон.”, “Ах чинь надад ийм асуудал үүсгэдэггүй байсан” гэх мэтээр ярих нь хүүхдийн сэтгэл зүйд хүндээр тусдагийг анхаарах.
- Бага ч гэсэн эерэг хандлага, амжилт гаргавал хүүхдийнхээ зүтгэлийг үнэлж, урам зориг, итгэл өгөх нь хүүхдэд маш чухал болохыг ойлгох.
- Хүүхдийг “Өнөөдөр ямар дүн авав?, Онц авсан уу?, сайн хариулж чадав уу?” гэх мэт асуулт асууж залхаахгүй байх.
- Хүүхэд хичээл дээр ядарсан байдаг тул гэрийн даалгавраар аль болох залхаахгүй байх. Хөдөлгөөн бүрийг нь байнга хянаж “бас л даалгавраа хийгээгүй юу? аль хэдийн дуусмаар юм” гэх мэтээр цагдах нь хүүхдэд дарамт үүсгэдэг байна.
- Сургуульд амжилтгүй сурч байгаагаас нь болж хүүхдийн дуртай хичээл, дугуйлан, секц, бусад зүйлийг хорихгүй байх. Хичээлээ хийсний дараа, компьютер тоглоорой гэх мэт хязгаарлалт хийх нь буруу, харин хүүхэд дуртай зүйлээсээ таашаал авдаг гэдгийг ойлгох.
- Хүндрэл бэрхшээлийн шалтгааныг эрж хайх, түүнийг хүүхдээс нуухгүй байх, шийдэх арга замыг хамтдаа хайх, түүнд тусалж чадахаа илэрхийлэх.

- Хүүхдэд сайн жишээнүүдийг, олон алдартай хүмүүс сургуульд сурч байхдаа иймэрхүү бэрхшээлтэй тулгарч байсан талаар заавал ярьж өгч байх зүйтэй.
- Ихэнх хүмүүс хүүхдэд “тэнэг”, “мангар”, “чадваргүй” гэх мэт нэр хаяг зүүдэг тул хүүхдийн өөртөө итгэх итгэл, ирээдүйн сурлага, хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг. Харин ч асуудалтай тулгарч байгаа хүүхдэд багагүй авьяас чадвар байдгийг санаж түүнийг олж илрүүлэхэд анхаарвал зохино.

Алдартай хүмүүсийн намтар түүхээс танилцуулах

Эрдэмтэд дислексиг тухайн хүүхдэд бусад салбарт ямар нэг гоц авьяас чадвар байгаагийн илрэл гэж үзэх тохиолдол байна.

Леонардо Да Винчи солгой гараараа зурж бичиж заримдаа буруу харуулж бичдэг байсан байна. Тэрээр 7000 хуудас өдрийн тэмдэглэлийг бичсэн ба түүнийг нь толинд ойлгож, эсвэл цаасыг эргүүлж гэрэлд харуулж уншиж байжээ.

Альберт Эйнштейн (1879-1955) орчин үеийн физикийн онолыг үндэслэгч, харьцангуй онолыг нээгч, Нобелийн шагналт. Тэрээр бүхий л амьдралдаа муу бичдэг, уншихдаа сул байжээ. Гэхдээ энэ байдал нь АНУ-ын ерөнхийлөгчид Фашист Германд цөмийн зэвсэг бүтээж байгаа аюулын талаар захидал бичихэд нь саад болоогүй байна.

Томас Алва Эдисон (1847-1931) бол агуу зохион бүтээгч. Сургуульд байхад нь багш нар түүнийг “тэнэг” гэж цоллож байсан. Яагаад? гэвэл тэрээр муу ярьдаг, муу бичдэг, юу ч тогтоож чаддаггүй, түүнийг математикт ямар ч авьяасгүй гэж үздэг байсан бөгөөд 12 насанд нь сургуулиас нь гаргажээ. Хэрэв ийм явдлын дараа тэрээр сэтгэл санаагаар унасан бол хэзээ ч фонограф буюу дэлхийн анхны дуу бичлэгийн төхөөрөмжийг бүтээхгүй байсан.

Эцэг эхийн гаргадаг түгээмэл алдаа

Бүх л хүүхэд сургуульд суралцахдаа ямар нэг байдлаар бэрхшээлтэй тулгардаг бөгөөд нэг хэсэг нь амархан даван туулж байхад нөгөө нэг хэсэг нь өөрсдөө зовохын зэрэгцээ эцэг эх, багш нартаа нэлээдгүй хүндрэлтэй асуудлыг үүсгэдэг.

Судлаачид эцэг эх, багш, насанд хүрэгчдийн зүгээс хүүхдэд туслахад саад болж байгаа асуудлыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүүхдийн сурах үйл ажиллагааг хүндрүүлж байдаг асуудлын нэг нь хүүхэд эцэг эх, багш нарын хооронд байнга үүсдэг зөрчил, маргаан гэж үзсэн.
- Эцэг эх, багш нарын зүгээс гаргах дургүйцэл нь хүүхдийг насанд хүрэгчдээс хөндийрүүлэхийн зэрэгцээ, бодитой тусламж дэмжлэг үзүүлэхгүй бол хүүхэд өөртөө итгэх итгэлээ бүрмөсөн алддаг.
- Хүүхдийн сэтгэл зүйд багш, эцэг эхийн дараах “тэнэг юм”, “чамтай зууралдаж байх тэнхэл алга”, “арай ч дээ ийм амархан юмыг ойлгохгүй байна уу?”, “тэртэй тэргүй чи сурахгүй юм байна” гэх мэт үг хэллэг хүндээр тусдаг.

- Багшийн зүгээс эцэг эхэд өгөх энгийн, нэгэн хэвийн “Хүүхэдтэйгээ ажиллах хэрэгтэй” гэсэн зөвлөгөө үр дүн муутай байдаг.

Бодит амьдрал дээр дараах асуудал түгээмэл байдаг.

- Хүүхэд насанд хүрэгчдийн тусламжгүйгээр өөрөө бие дааж сурч чаддаггүй.
- Эцэг эхчүүд ч хүүхэдтэйгээ ажилладаг. Гэхдээ хичээл хийхэд хүүхэд, эцэг эхийн аль алинд нь хүч тэнхээ нь барагдсан зөвхөн оройн цаг оногдож үр дүн багатай өнгөрдөг. Ийм нөхцөлд эцэг эх ямар ч үр дүн алга гэж гомдоллож, хүүхдийн хувьд өөртөө итгэх итгэл, сурах үйл ажиллагаа нь улам мохдог.
- “Би чадахгүй ээ”, “Энэ хэзээ ч бүтэхгүй юм байна”, “Би сайн сурч чадахгүй юм байна даа” гэсэн ойлголт хүүхдэд үүсэх нь насанд хүрэгчид бидний буруугаас болж, улмаар тэднийг өөрийнхөө хүчинд итгэхгүй байх, идэвхтэй үйл ажиллагаанаас татгалзах, амжилтгүй байдлаас айх байдалд хүчээр оруулдаг.

Иймэрхүү байдлаас болоод хүүхэд хүчээ дайчлан хичээж ажиллахаас татгалзахад хүргэдэг бөгөөд энэ бол залхуурал бус зөвхөн “хүсэлгүй” болсонд л оршдог байна. Сурах сонирхолгүй болох нь хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, сэтгэцэд хүндрэл бэрхшээл учруулдаг.

ХАВСРАЛТ 5

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫГ ХҮҮХДИЙН ЧАДВАРТ НИЙЦҮҮЛЖ ТОХИРУУЛАХ

Багш хүүхдийн ахицыг тогтмол ажиглаж, тэмдэглэж байхаас гадна, үнэлгээний аргачлалыг тухайн хүүхдэд хүртээмжтэй байдлаар тохируулж болно. Хүүхэд сурсан мэдлэг ойлголтоо илэрхийлэхэд дараах 4 хүчин зүйл саад болж байдаг бөгөөд багш эдгээрийг анхааран авч үзэх ёстой.

1. Үзүүлэх арга барил

Багш нар чиглэл, заавар, мэдээ мэдээллийг хүргэх арга барилаа өөрчилж болно. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд унших, сонсох зэргээр харааны болон сонсголын мэдрэхүйгээр мэдээлэл хүлээн авахаас илүүтэй, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр эзэмших өөр бусад аргуудыг ашиглах боломж бүрдэнэ гэсэн үг юм. Харилцааны бэрхшээлтэй хүүхдийн хувьд чухал мэдээллийг тодруулах, дасгал даалгаврыг харахад ойлгомжтой болгох, багшийн хэлсэн энгийн зааварчилгааг ашиглах зэргээр тохируулга хийж болно.

2. Хариу үйлдэл

Сурагч сурсан мэдлэгээ зөвхөн аман яриагаар илэрхийлж танилцуулах хэрэгцээг багасгах нь зүйтэй. Түүний оронд өөр бусад үнэлгээний аргачлалыг туршиж болно. Жишээ нь компьютер дээр шивэх, гол санааг дугуйлах эсвэл заах, математикийн хичээлийн хариуг тооны машин дээр үзүүлэх эсвэл 1-100 хүртэлх тооны үзүүлэн дээр зааж болно.

Санаагаа зураглах буюу цэгцтэй бодож сэтгэх дасгалаар дамжуулж хүүхэд оюун бодлоо цэгцлэх боломжтой.

3. Зохион байгуулалт

Багш хүүхдийн мэдлэг чадварыг хамгийн боломжит байдлаар үнэлэхэд ямар зохион байгуулалтууд шаардагдах вэ гэдгийг сайтар бодолцох хэрэгтэй. Жишээ нь аутизмтай хүүхдүүд хэт их чимээ, тод гэрэл, хурц үнэрт анхаарал нь сарнидаг тул гал тогоотой ойр биш чимээгүй орчинд шалгалтаа өгөх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

4. Хугацаа

Энэ нь сурагчдад шалгалт, даалгавраа дуусгах нэмэлт хугацаа өгөх, их даалгаврыг жижиг хэсгүүдэд хуваах, ойлгохгүй тохиолдолд заавар чиглүүлэг авах, өдрийн тодорхой цагт шалгалт авах зэрэг цаг хугацаатай холбоотой тохируулгууд багтана.

МОДУЛЬ 9:

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН УДИРДЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО



Зорилго	Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй ойлголт мэдлэгтэй болох, өөрийн сургууль, цэцэрлэгтээ тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө хийж сурах
Зорилт	<ul style="list-style-type: none"> ▪ Өөрсдийн сургууль, цэцэрлэгтээ тэгш хамран сургах боловсролын бодлого боловсруулах, соёл, дадлыг бий болгох талаар үндсэн ойлголттой болох ▪ Тэгш хамран сургах боловсролын соёл бий болгохын ач холбогдлыг танин мэдэх ▪ Сургууль, цэцэрлэгийн хүрээнд хүртээмжтэй боловсролыг бий болгоход шаардлагатай нэн тэргүүний алхмуудыг багтаасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах арга зүй эзэмших
Хугацаа	3 цаг
Модулийн агуулгын хүрээ	
<p>Сэдэв 1. Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд удирдлагын үүрэг, оролцоо (60 минут)</p> <p>Сэдэв 2. Тэгш хамран сургах соёл бүхий сургууль, цэцэрлэгийг бий болгох нь (90 минут)</p> <p>Сэдэв 3. Шийдлийн тойрог: Асуудлаа бүтээлчээр шийдэх арга зүй (30 минут)</p>	

СЭДЭВ 1. ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УДИРДЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Зорилго: Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын удирдлага, багш нарын үүрэг, оролцоог тодорхойлж, танин мэдэх

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын удирдлагын зүгээс анхаарч авч үзэх зүйлийн талаар ойлголттой болох
- Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын удирдлагын гүйцэтгэх үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх
- Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд багш нарын гүйцэтгэх үүрэг, түүний хэрэгжилтийн байдлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх

Хугацаа: 60 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Тараах материалыг оролцогчдын тоогоор хэвлэх
- Хавсралт 2: Багшид зориулсан материал
- Хавсралт 3: Оролцогчдын 1/4 тоогоор хэвлэх
- Хавсралт 4: Тараах материалыг оролцогчдын тоогоор хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд удирдлагын үүрэг, манлайлал (25 минут)

1. Тус сэдвийн хүрээнд тэгш хамран сургах боловсролыг өөрийн сургууль, цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэхэд удирдлагын зүгээс үзүүлэх манлайлал, хүлээх үүрэг, үзүүлэх нөлөө, ач холбогдлын талаар судална гэдгийг хэлж, оролцогчдоос дараах асуултыг асууж, тэдний хэлсэн зүйлийг самбарт жагсаан бичнэ.
 - Сургууль, цэцэрлэгийн удирдлагууд тэгш хамран сургах боловсролын талаар юу мэдэж байх ёстой вэ?
 - Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд сургууль, цэцэрлэгийн удирдлага ямар үүрэгтэй вэ?
2. Оролцогч бүрт хавсралт 1-ийг тараан өгнө. Тус мэдээллийг уншиж танилцаад санал хэр зэрэг нийлэх эсэх өөрийн хариултыг сонгож, тохирох баганад тэмдэглэгээ хийнэ гэдгийг тайлбарлана.

3. Оролцогчдоос өгөгдөл тус бүрийг эхнээс нь нэг нэгээр хэрхэн хариулсан талаар асууж, самбарт эсвэл дэлгэц цаасан дээр хариултын тоог бичиж тэмдэглээд, дүгнэн ярилцана. Хавсралт 2-т байгаа мэдээллийг ашиглан нэмж тайлбарлана. Дараа нь өөрсдийн нэмж бичсэн саналуудыг танилцуулж, санаа бодлоо хуваалцана.
4. Хавсралт 3-ыг 4-5 оролцогчдын дунд тараан өгч, уншиж судлаад, хамтран ярилцахыг хүснэ.

Үйл ажиллагаа 2. Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь (30 минут)

1. Цэцэрлэг, сургуульд элсэн суралцаж байгаа хүүхэд бүр тухайн цэцэрлэг, сургуульдаа суралцахуйн эерэг туршлага хуримтлуулахад дэмжлэг үзүүлдэг гол хүчин зүйл нь багшийн хүртээмжтэй арга барил гэдгийг тайлбарлана.
2. Оролцогчдод хавсралт 4-ийг тараан өгч, тус мэдээлэл дэх өгөгдөл тус бүрийг анхааралтай уншаад өөрийн сургууль, цэцэрлэгийн багш нарын бүх хүүхдийг тэгш хамран сургахад чиглэсэн арга зүй болон суралцагчийн сурлагын ахицыг үнэлэх үйл ажиллагааг дэмжих тогтолцооны талаас анхаарч, бөглөхийг хүснэ. Мөн өөрсдийн удирдаж буй цэцэрлэг, сургуулийн онцлог, нөхцөлтэй холбогдуулан өөрийн хэлэх санал, тайлбараа хамгийн доод талын хоосон мөрөнд бичихийг хүснэ.
3. Тэдний хариултыг өгөгдөл тус бүрээр асууж, самбарт эсвэл дэлгэц цаасан дээр тэмдэглэж, хамтран ярилцана.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд та бүхэн шинээр юу мэдэж авсан бэ?
- Сургууль, цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхийн тулд тухайн цэцэрлэг, сургуулийн удирдлага нэн тэргүүнд юу мэдэж байх хэрэгтэй вэ?
- Тус сэдвийн хүрээнд судалсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?

ХАВСРАЛТ 1

Дараах хүснэгт дэх мэдээллийг уншиж танилцаад, санал хэр зэрэг нийлэх талаар өөрийн хариултыг сонгож, тохирох баганад + тэмдэглэгээ хийнэ үү.

Тэгш хамран сургах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлд	Огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна
Бид сургууль, цэцэрлэгийнхээ ойр, орчимд амьдарч буй бүх хүүхдийг боловсролд хамруулахыг зорьдог.				
Манай сургууль, цэцэрлэгийн барилга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй байдлаар баригдсан.				
Туршлагатай багш, хүний нөөцтэй, тэрхүү нөөц, бололцоогоо бүрэн ашигладаг.				
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээг тодорхойлж, хангах үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарласан.				
Багш нар ангийн бүх хүүхдийн ахиц дэвшилд анхаарч, хариуцах ёстой гэдгээ ухамсарладаг.				
Удирдлага төлөвлөлт хийхдээ багш ажилтнууд, сурагчдын эцэг эхийн саналыг сонсож, тэднийг татан оролцуулдаг.				
Төлөвлөх, төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, санал бодлоо бусадтай хуваалцах зэрэг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай цаг хугацаа, эх үүсвэр байдаг.				
Бусад санал:				

ХАВСРАЛТ 2

Тэгш хамран сургах боловсролын бодлого гэдэг нь боловсролын үйлчилгээ үзүүлж буй аливаа сургууль, цэцэрлэгийн дагаж мөрддөг бодлого, дүрэм журам нь хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, суралцагчдын болон тэдний эцэг, эхийн өмнө тулгамдаж буй асуудал, бэрхшээл зэргийг хүлээн зөвшөөрч, түүнд нийцсэн боловсролын үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн бодлого байх тухай асуудал юм. Жишээлбэл, зарим сургуулийн хувьд сургуулийн барилга дэд бүтцийн хувьд тэргэнцэртэй хүүхэд орох боломжгүй байх, дунд шатны боловсролоос эрэгтэй хүүхдүүд, эмэгтэй сурагчидтай харьцуулахад илүү сургууль завсардах гэх мэт.

Дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлоготой, хэрэгжүүлэх арга хэмжээ, алхмуудаа төлөвлөсөн байх нь тэгш хамран сургах боловсролын бодлоготой байгааг илтгэнэ.

ХАВСРАЛТ 3

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УДИРДЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Бүх хүүхдийн боловсрол эзэмших эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх, бүх хүүхдийг цэцэрлэг, сургуульдаа тэгш хамран сургах нь аливаа сургалтын байгууллагын удирдлага, захирлын үндсэн зорилго байх ёстой. Тэгш хамран сургах боловсрол гэдэг нь боловсролын тогтолцооны бүх шатанд хүүхдийг тэгш хамран сургах явдал юм.¹ Тэгш хамран сургах боловсрол нь бүх хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хангахтай холбоотой дараах боломж, нөхцөлийг хангаж ажиллах явдал юм:

- Бүх хүүхэд өөрийн насны үе тэнгийн хүүхдүүдтэй нэг анги, сургуульд зэрэгцэн суралцах
- Бүх хүүхдэд нээлттэй байх
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд сурч боловсрон, тодорхой ахиц дэвшил гаргахад нь дэмжлэг үзүүлэх тохируулгат хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө гаргасан байх
- Бусдаас ялгаатай байх нь асуудал биш, харин амьдралын нэг хэсэг гэсэн үзэл санаанд суурилсан байх

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар дэлхийн хүн амын 15 орчим хувь, хүүхдийн 1.5-5 хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байна гэсэн үр дүн гарчээ.² Энэ дэлхийн дундажтай харьцуулж үзвэл Монгол Улсад 485,000 гаруй насанд хүрэгчид, 59,150 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байх магадлалтай гэсэн үг юм.

1 Booth & Ainscow, 2011

2 ДЭМБ ба Дэлхийн Банк 2011

2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” Монгол Улсын хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрхийг баталгаажуулж, сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай хэрэгцээ шаардлагад нийцсэн орчныг бүрдүүлж, эцэг эх хүүхдээ сургуульд тэгш хамруулах, үүнд сургуулийн нийгмийн ажилтан мэдээллээр ханган, дэмжиж ажиллах үүрэгтэй хэмээн тусгажээ. Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүд чанартай боловсрол эзэмших боломжоо бүрэн эдэлж чадахгүй байгаа бөгөөд боловсролын түвшин доогуур байгаа нь анхаарал татаж байна.

Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, тэднийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах гэдэг нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах асуудал биш бөгөөд үүнд олон хүчин зүйл хамаарна. Тухайлбал, жендэр, үндэс угсаа, төрөлх хэл, соёл, нийгэм эдийн засгийн нөхцөл, байр суурь гэх мэт бусад олон хүчин зүйл хүүхдийн сурч боловсрох үйл явцад нь нөлөө үзүүлдэг.

Тиймээс захирал таны удирдаж буй сургууль, цэцэрлэгийн орчин бол хүүхдийн амьдарч буй, хүрээлэн буй орчны тодорхой хэсгийг бүрдүүлж, онцлог байдлыг илэрхийлж байдаг газар бөгөөд сургууль, цэцэрлэгийн орчинд авч хэрэгжүүлсэн аливаа үйлдэл, үйл ажиллагаа нь тухайн нийгэм, хүрээлэн буй орчиндоо эерэг хандлагыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл тэгш хамран сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэх, орчин, соёлыг бий болгох, улмаар нэг ч хүүхдийг ардаа орхилгүй, бүх хүүхдэд нээлттэй байж хүлээн авдаг анхдагч орчин бол сургууль, цэцэрлэг байх ёстой юм. Сургалтын байгууллагын удирдлага, захирал өөрийн удирдаж буй сургалтын байгууллагадаа тэгш хамран сургах боловсролын бодлого баримталж, соёлыг бий болгосноор багш, ажилтнууд сургалт хүмүүжлийн ажилдаа тэгш хамран сургах үйл ажиллагааг бодитой нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж чадна.

Тэгш хамран сургах боловсрол удирдлагаас эхэлнэ. ТХБ-ыг сургууль, цэцэрлэгийн орчинд амжилттай нэвтрүүлэх нь удирдлагын багийн тэгш хамруулах бодлого, орчны талаарх ойлголт, хандлага, үйлдэл, үйл ажиллагаанаас шууд хамаарна. Удирдлагын зүгээс хийсэн сонголтууд тухайн орон нутгийн иргэдийн хандлагад мөн нөлөө үзүүлдэг. Тухайн цэцэрлэг, сургуулийн онцлогоос хамааран тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх, орчин бүрдүүлэх арга замууд өөр байна.

ХАВСРАЛТ 4

Дараах хүснэгт дэх мэдээллийг уншиж танилцаад, санал хэр зэрэг нийлэх талаар өөрийн хариултыг сонгож, тохирох баганад + тэмдэглэгээ хийнэ үү.

Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	Огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна
Бүх хүүхдийн хэрэгцээг харгалзан үзэж сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөдөг.				
Бидний сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа бүх хүүхдийн оролцоог хангахад чиглэдэг.				
Бидний үнэлгээ бүх хүүхдийн амжилтыг үнэлэхээс гадна тэдний суралцах үйл явцыг дэмжих, урамшуулан сайшаахад чиглэдэг.				
Сахилга бат нь харилцан хүндлэл дээр суурилдаг.				
Багш нар хичээлээ төлөвлөх, заах, төлөвлөгөөний биелэлтээ хянаж үзэхдээ хамтран ажилладаг.				
Туслах багш бүх хүүхдийн суралцахуйн үйл явц оролцоог дэмжин ажилладаг.				
Сургууль, цэцэрлэгийн орчимд байгаа эх үүсвэрүүд нь тодорхой, тэдгээрийг бүрэн ашиглаж чаддаг.				

СЭДЭВ 2. ТЭГШ ХАМРАН СУРГАХ СОЁЛ БҮХИЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙГ БИЙ БОЛГОХ НЬ

Зорилго: Тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааны талаар ойлголт мэдлэгээ нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролын бодлого, соёл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж сурах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Тэгш хамран сургах боловсролын соёл бий болгохын ач холбогдлыг танин мэдэх
- Тэгш хамран сургах боловсролын соёл бий болгоход анхаарах зүйлсийн талаар мэддэг болох
- Тэгш хамран сургах боловсролын соёл бий болгох төлөвлөгөө боловсруулж чаддаг болох

Хугацаа: 90 минут

Хэрэглэгдэхүүн:

- Дэлгэц цаас, маркер, цаасан скоч
- Хавсралт 1: Багшид зориулсан материал
- Хавсралт 2: Тараах материалыг оролцогчийн тоогоор хэвлэх
- Хавсралт 3: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх
- Хавсралт 4: Тараах материалыг багийн тоогоор хэвлэх

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: Тэгш хамран сургах боловсролын соёл, орчин бий болгох нь (15 минут)

1. Тус сэдвийн хүрээнд тэгш хамран сургах соёл бүхий сургууль, цэцэрлэгийг бий болгох, ашиглахын ач холбогдол, давуу талыг бодит жишээн дээр үндэслэн судална гэдгийг хэлнэ. Оролцогчдоос дараах асуултыг асууж, ярилцана. Оролцогчдын хэлсэн зүйлийг самбарт эсвэл дэлгэц цаасан дээр бичиж тэмдэглэнэ.
 - Та тэгш хамран сургах соёл хэмээх ойлголтыг хэрхэн тодорхойлох вэ?
 - Танай сургууль хэр нээлттэй вэ?
 - Таны бодлоор тэгш хамран сургах соёлыг бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн онцлог шинж юу вэ?
2. Тэдний хэлсэн зүйл дээр тулгуурлан ярилцана. Хавсралт 1-д байгаа мэдээллийг танилцуулж, нэгдсэн ойлголтод хүрнэ.

Үйл ажиллагаа 2: Тэгш хамран сургах боловсролын соёл, орчны өнөөгийн бодит байдлыг үнэлэх (25 минут)

1. Оролцогч бүрт хавсралт 2-ыг тараан өгч, зааврын дагуу ажиллахыг хүснэ. Тухайлбал, өгөгдөл тус бүрийг уншаад, өөрийн хариултад тохирох нүдэнд тэмдэглэгээ хийж, тус үнэлгээнд тулгуурлан сургууль, цэцэрлэгийнхээ давуу тал болон сайжруулах шаардлагатай зүйлсийг тодорхойлж бичнэ гэдгийг тайлбарлана.
2. Тэдний хариултыг өгөгдөл бүрээр нэгтгэн, дүгнэж ярилцана.
3. Оролцогч бүрийн нэмэлт санал болон тайлбарыг сонсож, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлнэ. Тэгш хамран сургах боловсрол нь захирал, удирдлагын зүгээс сурагчид, багш, ажилтнуудаа дэмжиж, сургалтын орчноо илүү тэгш хүртээмжтэй болгох үйл явц гэдгийг оролцогчдод хэлнэ.

Үйл ажиллагаа 3: Тэгш хамран сургах боловсролын соёл, орчин бий болгох төлөвлөгөө боловсруулах (45 минут)

1. Өмнөх багаараа үргэлжлүүлэн ажиллана. Хавсралт 3-ыг ашиглан багуудад алхамчилсан заавар өгч ажиллуулна. Тус үйл ажиллагааны үр дүнг баг тус бүр ээлжлэн танилцуулж, санал бодлоо хуваалцана.
2. Дараа нь баг тус бүрт хавсралт 4-ийг тарааж өгнө. Тус загварыг ашиглан багаараа хамтран төлөвлөгөө боловсруулна.
3. Баг тус бүр өөрсдийн боловсруулсан төлөвлөгөөг ээлжлэн танилцуулж, ярилцана. Бусад багийн гишүүдээс асууж тодруулах зүйл байгаа эсэхийг лавлана. Баг тус бүрийн биелэгдэх боломжтой шилдэг санаануудыг асууж, тэдгээрийг самбарт бичиж, санал бодлоо солилцоно.

Дүгнэлт (5 минут)

Дараах асуултын дагуу ярилцан, тус сэдвийг дүгнэнэ.

- Тус сэдвийн хүрээнд та бүхэн шинээр юу мэдэж авсан бэ?
- Тэгш хамран сургах соёл бүхий сургууль, цэцэрлэгийг бий болгохын ач холбогдол, давуу тал юу вэ?
- Сургууль, цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхийн тулд тухайн цэцэрлэг, сургуулийн удирдлага нэн тэргүүнд юу хийх хэрэгтэй вэ?
- Сургууль, цэцэрлэгт тэгш хамран сургах боловсролын соёл бүрдүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэн боловсруулах вэ?
- Тус төлөвлөгөөнд ямар зүйлсийг тусгавал зохих вэ?

ХАВСРАЛТ 1

ТЭГШ ХАМРАН СУРГАХ СОЁЛ БҮХИЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙГ БИЙ БОЛГОХ

Аливаа сургууль, цэцэрлэгийн хамт олон, багш ажилтнуудын дунд тогтсон харилцаа, хандлага, соёл зэрэг нь тэдний итгэл үнэмшил, үнэт зүйлсээр илэрхийлэгддэг. Тиймээс тэгш хамран сургах соёл, хандлага гэдэг нь сургууль, цэцэрлэгийн хувьд бүх багш, ажилтан, сурагч, тэдний эцэг эхийн ялгаатай хэрэгцээ, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, өөрсдийн үнэт зүйл хэмээн хүлээн зөвшөөрсөн соёл, хандлагатай байхыг хэлдэг. Үүнд дараах хүчин зүйлс багтаж болно:

ТЭГШ ХАМРУУЛАХ СОЁЛ

- Сургууль цэцэрлэг маань бүх хүүхдүүдэд нээлттэй.
- Багш, ажилтнууд хоорондоо хамтран ажиллах соёл хэвшсэн байх
- Бүх хүүхдээс сурлагын өндөр ахиц дэвшил гаргахыг хүлээдэг
- Сургуулийн зүгээс аливаа зөрчил, маргааныг хүч үл хэрэглэж, харилцан ярилцах замаар шийдвэрлэхийг зорьдог байх
- Сурагчдын давуу тал, чадвар амжилт тэдний хэрэгцээ, тулгарч буй бэрхшээлийг анхаарч үздэг байх
- Бүх сурагчдынхаа гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчтай харилцаатай байх

ХАВСРАЛТ 2

Заавар:

- Доорх хүснэгт дэх өгөгдөл тус бүрийг анхааралтай уншаад санал хэр зэрэг нийлэх талаар өөрийн хариултыг сонгон, хүснэгтийн харгалзах нүдэнд ✓ тэмдэглэгээ хийгээрэй.
- Эдгээр асуултын тусламжтайгаар сургуулийнхаа давуу тал болон сайжруулах хэрэгтэй байгаа хэсгийг тодорхойлоорой.
- Та өөрийн цэцэрлэг, сургуулийн онцлог, нөхцөлтэй холбогдуулан хэлэх санал, тайлбарыг хамгийн доод хэсэгт бичээрэй.

Тэгш хамран сургах боловсролын соёл	Огт нийлэхгүй байна	Санал нийлэхгүй байна	Санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна
Манай сургууль /цэцэрлэг бүх хүүхдэд нээлттэй				
Багш, ажилтнууд хоорондоо хамтран ажиллах соёл хэвшсэн				
Бүх хүүхдээс сурлагын өндөр ахиц дэвшил гаргахыг хүлээдэг				
Сургуулийн зүгээс аливаа зөрчил, маргааныг хүч хэрэглэлгүй, харилцан ярилцах замаар шийдвэрлэхийг зорьдог.				
Сурагчдын давуу тал, чадвар, амжилт, тэдний хэрэгцээ, тулгарч буй бэрхшээлийг анхаарч үздэг.				
Бид бүх сурагчдынхаа гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчтай харилцаатай байдаг.				
Бусад санал:				

ХАВСРАЛТ 3

ТЭГШ ХАМРАН СУРГАХ СОЁЛ БҮХИЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙГ БИЙ БОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛ

Сургууль, цэцэрлэгийн удирдлагын хувьд өөрийн удирдаж буй сургалтын байгууллагад тэгш хамран сургах боловсролыг хөгжүүлэхэд нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудаа эрэмбэлнэ. Тэгш хамран сургах боловсролыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүхэл бүтэн удирдлагын баг, ажилтнууд, эцэг эхчүүд оролцох шаардлагатай. Тэгш хамран сургах боловсролын үйл ажиллагааг зөвхөн захирал, удирдлага бусдад тулгах замаар хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд үүнд багш, ажилтан, эцэг эх, олон нийтийн зүрх сэтгэл, бодол санааг татан оролцуулахгүйгээр хэрэгжих боломжгүй юм.

Тиймээс удирдлагын хувьд хийх анхны алхам бол БУСАД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ХЭРХЭН ТАТАН ОРОЛЦУУЛАХ ВЭ? гэдгээ тодорхойлох явдал юм. Тэдэнд өөрийн санаагаа танилцуулах уу, эсвэл тэдний саналыг сонсож, ТХСБ-ыг сургууль, цэцэрлэгтээ хэрэгжүүлэхэд нэн тэргүүний ач холбогдолтой асуудлуудыг тодорхойлсон шалтгаан, үндэслэлийг сонсох уу?

Санал болгох алхмууд:

1. Төлөвлөгөө боловсруулах багаа нэн түрүүнд бүрдүүлэх

Тэгш хамран сургах боловсролыг өөрийн сургууль, цэцэрлэгтээ хөгжүүлэх таны аялалд өөрийн хүсэл, сонирхлоор нэгдэн хамтдаа төлөвлөгөө гаргах баг бүрдүүлж ажлаа эхлүүлэх нь зүйтэй. Энэ багт сонирхсон бүх хүмүүс тэр дундаа орон нутгийн удирдлага, сургуулийн багш, ажилтнууд болон холбогдох бусад бүлгийн төлөөллийг оролцуулах нь өөр хоорондоо ялгаатай хүн бүхэнд тулгарч болох саад, бэрхшээл, ялгаатай хэрэгцээг мэддэг туршлагатай гишүүдийг оруулж, хүчирхэг баг бүрдүүлэх нь таны ажлыг харьцангуй хялбар болгодог.

2. Өөрсдийн нөхцөл байдлыг үнэлэх арга ашиглах

Та өөрийн багтайгаа хамтран өөр хоорондоо ялгаатай иргэд, олон нийт, багш ажилтнуудаас сургууль, цэцэрлэгийнхээ талаарх сэтгэгдлийг нь асууж болно. Багийн гишүүд болон бусад хүмүүс танай сургууль, цэцэрлэгийн хувьд нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай асуудлыг хэрхэн тодорхойлж байна?

Гэхдээ сургууль, цэцэрлэгийн орчиндоо тэгш хамран сургах боловсролын соёл, хандлагыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд зөвхөн сургууль, цэцэрлэгт ажиллаж буй багш ажилтнуудаас гадна хүрээлэн буй орчин, олон нийтийг (орон нутгийн байгууллагын ажилтнууд, эцэг эх, хүүхдүүд, орон нутгийн иргэд гэх мэт) татан оролцуулах, тэдний ойлголт, хандлагыг эерэг болгох нь чухал ач холбогдолтой. Иргэд, олон нийтийг (орон нутгийн байгууллагын ажилтнууд, эцэг эх, хүүхдүүд, орон нутгийн иргэд гэх мэт) ойлголт мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэхэд ямар төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлбэл танай сургууль, цэцэрлэг тэгш хамран сургасан байгууллага болж чадах вэ?

3. Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө эцэслэх

Доорх жишиг төлөвлөгөөг ашиглан, өөрийн сургууль, цэцэрлэгийн онцлог, шинж байдал, тантай хамтран ажиллах багийн бүрэлдэхүүнд тохируулан өөрчлөн ТХСБ-ын орчин, соёл, хандлагыг бий болгох өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргаарай.

“Хариуцлагатай хэдхэн хүнээс бүрдсэн жижиг бүлэг иргэдийн үйлдэл дэлхий ертөнцийг өөрчилж чадна гэдэгт хэзээ ч бүү эргэлз, учир нь өнгөрсөн хугацаанд тийм хүмүүс л өөрчлөлтийг авчирч чадсан байдаг.”

Тэгш хамран сургах боловсрол гэдэг нь хүрэх цэг биш бидний хийх аялал юм.



ХАВСРАЛТ 4

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сургууль, цэцэрлэгийн нэр		Огноо			
Тэргүүлэх чиглэлүүд	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Шаардагдах эх үүсвэр	Төлөвлөгөөний биелэлтийг хэрхэн хэмжих вэ?	Хариуцан ажиллах талууд	Хэрэгжүүлэх хугацаа
ТХСБ-ын бодлого					
ТХСБ-ын соёл					
ТХСБ-ын үйл ажиллагаа					

СЭДЭВ 3: ШИЙДЛИЙН ТОЙРОГ: АСУУДЛАА БҮТЭЭЛЧЭЭР ШИЙДЭХ АРГА ЗҮЙ

Зорилго: Сургууль, цэцэрлэгийн хүрээнд тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгарах асуудлыг шийдэх арга зүйд суралцах

Зорилт: Оролцогчид тус сэдвийг судалснаар дараах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Цэцэрлэг, сургуульд тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгарах асуудлыг тодорхойлох
- Тулгамдсан асуудлыг шийдэх арга замын хувилбаруудыг хэлэлцэж, санаа бодлоо хуваалцах
- Хамгийн оновчтой байж болох арга замыг сонгох

Хугацаа: 30 минут

Хэрэглэгдэхүүн:

- Хавсралт 1: Багшид зориулсан материал

АЛХАМ

Үйл ажиллагаа 1: “Шийдлийн тойрог” аргыг танилцуулах (3 минут)

1. Багш хавсралт 1-д байгаа мэдээллийг оролцогчдод товч танилцуулна.
2. Нэг багт 5-аас доошгүй хүнтэй байхаар тооцон оролцогчдыг багт хувааж, багийн гишүүдийг хоорондоо ярилцаж, дараах дүрүүдийг хуваарилан авахыг хүснэ.
 - Асуудлыг танилцуулагч (гол хүн)
 - Үйл явцыг чиглүүлэгч (багийн менежер, цаг харагч)
 - Тэмдэглэл хөтлөгч буюу бүртгэл хөтлөгч
 - Шийдэл олох баг

Үйл ажиллагаа 2: “Шийдлийн тойрог” аргыг хэрэгжүүлэх (24 минут)

1. Тус аргачлалын 4 алхмыг нэг бүрчлэн зургаа, зургаан минутаар хэрэгжүүлнэ. Багш алхам бүрийн хугацааг оролцогчдод давхар сануулж, дараагийн алхам руу орохыг сануулна.
2. Багууд алхмуудыг хэрэгжүүлж дуусмагц, нэг багийг тодорхойлсон асуудал болон шийдлийн хувилбараа товч танилцуулахыг хүснэ.

Дүгнэлт (3 минут)

Дараах асуултын дагуу ярилцаж, дүгнэлт хийнэ.

- Тус аргыг хэрэглэхэд ямар санагдсан бэ?
- Тулгамдсан асуудал болон шийдлийг олоход хэрэглэх боломжтой юу?

ХАВСРАЛТ 1

“ШИЙДЛИЙН ТОЙРОГ” АРГАЧЛАЛ

Энэхүү шийдлийн тойргийн арга зүйг Канад гаралтай зохиолчид болох Жак Пийрпойнт болон Марша Форест нар анх санаачилжээ. Энэхүү аргыг хэрэгжүүлэхэд 30 орчим минут зарцуулдаг бөгөөд ажил, амьдралд тань тулгарсан асуудлын “гацааг гаргах”-д үр дүнтэй арга юм. Энэ арга нь аливаа асуудлын шийдлийг шууд олоход тусалдаггүй ч дараагийн логик алхам юу байх вэ гэдгийг тодорхойлоход тусалдаг.

Шийдлийн тойрог бүрт орох хүн: 5-9 хүн оролцоно.

Багийн гишүүдийн үүрэг буюу дүрүүд:

- Асуудлыг танилцуулагч (гол хүн)
- Үйл явцыг чиглүүлэгч (багийн менежер, цаг харагч)
- Тэмдэглэл хөтлөгч буюу бүртгэл хөтлөгч
- Шийдэл олох баг

Хэрэгжүүлэх алхмууд:

Алхам 1: (6 минут) Асуудлыг танилцуулагч нь 6 минутын турш тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, ярина. Үйл явцыг чиглүүлэгч цаг барьж, асуудлыг тодорхойлж буй хүнд хэн нэгэн саад болохгүй байхад анхаарна. Тэмдэглэл хөтлөгч тэмдэглэл бичиж авна. Бусад хүмүүс (санаа, бодлоо илэрхийлэх хүмүүс) сонсоно. Хэрэв асуудал танилцуулагч 6 минутаас өмнө яриагаа дуусгавал бусад хүмүүс 6 минут дуустал чимээгүй хүлээх нь чухал! Учир нь асуудал танилцуулагчид саад бололгүй 6 минут олгох ёстой.

Алхам 2: (6 минут) Энэ бол асуудалдаа шийдэл олох хэсэг. Хүн бүр сонссон асуудалтай холбоотой өөрийн санаагаа хэлнэ. Энэ бол асуудлыг тодруулах эсвэл асуулт асуух цаг биш. Мөн ярилцах, лекц, зөвлөгөө өгөх цаг биш. Хүн бүр өөрийн санаагаа илэрхийлж, тусгах хэрэгтэй. Хэн нэгэн давамгайлан ярьж болохгүй. Асуудал танилцуулагч саад хийхгүйгээр сонсоно. Ярих, эсвэл хариулах ёсгүй.

Алхам 3: (6 минут) Бүлэг нь асуудал танилцуулагчаар удирдуулж хэлэлцүүлэг хийж болно. Энэ нь уг асуудлыг илрүүлж, илүү тодорхой болгох цаг юм. Хийж чадахгүй зүйлсээ бус, зөвхөн эерэг санаан дээр төвлөрнө.

Алхам 4: (6 минут) Эхний алхам. Асуудлыг шийдвэрлэхийн тулд ирэх 3 өдөрт юу хийж болохыг багийн ахлагч болон бүлгийн гишүүд хамтран шийднэ. Багадаа НЭГ алхмыг 24 цагийн дотор эхлүүлсэн байх хэрэгтэй. Бүлгээс нэг хүн сайн дураараа эхний алхмаа 3 өдрийн дотор хийж чадсан эсэхийг шалгаж утасдах эсвэл биечлэн уулзах хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

- Байгалмаа, Ч., Саранзаяа, Б., Уянга, Н., Хулан, Ж. (2022). МОДУЛЬ: Тэгш хамруулах боловсрол. Тусгай хэрэгцээт сурагчидтай ажиллах арга зүй. УБ.
- Байгалмаа, Ч., Золзаяа, Б., Амарзаяа, Ч., Өлзийсайхан. (2021). Брайль бичгийн сургагч багш бэлтгэх сургалтын модуль. УБ.
- Ред. Г. Батцэнгэл., Ч. Байгалмаа; Орч. С. Батхишиг, Б. Золзаяа, Н. Оюунтунгалаг, Б. Түвшинжаргал (2018). Тусгай хэрэгцээт боловсрол
- БСШУС-ын сайдын А/155 дугаар тушаал “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал батлах тухай”
- БСШУС-ын сайдын 2019 оны А/292 тушаал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”
- БСШУС-ын сайдын А/249 дүгээр тушаал. (2020)
- Зориг сан. (2021). Харааны бэрхшээлтэй хүүхдэд заах арга зүйн зөвлөмж
- БСШУС-ын сайдын 2018 оны А/425 тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”
- Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол “Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4 дүгээр хавсралт 3.3 дахь хэсэг
- МУ-ын хууль. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн 4.1.3
- Назаровой, М.Н. Специальная педагогика.
- НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц
- Д.Одгэрэл, Д.Ганболд, О.Мөнхцэцэг, Ч.Нямдорж, А.Бадамцэрэн, Б.Бат-Оюун (2020). Тэгш хамруулах боловсролын багш нарт зориулсан модуль
- Д.Одгэрэл, Б.Намираа (2018) Тусгай боловсрол
- Кирк Хортон, Ж. (2008). Хараагүй иргэдийг гэр бүл, хамт олонд нь тулгуурлан сэргээн засах. УБ.
- Сэнди Ниман., Намита Якоб. (2000). Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд гэр бүл хамт олны зүгээс үзүүлэх дэмжлэг тусалцаа.
- Цэвэгмид, Ц. (2018). Тэгш хамран сургах багшийн боловсролд
- ХНХЯ, БСШУСЯ. (2018). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг. Улаанбаатар.
- Цэвэгмид,Ц. Гэрэлтуяа, Б нар. (2018). “Яриа бичиг” сонсголын бэрхшээлтэй хүүхдийн багшийн ном

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2012). Хараагүй болон харааны бэрхшээлтэй хүмүүсийн талаар. <https://www.who.int/en/news-room/fact-sheets/detail/blindness-andvisual-impairment>-ээс гаргасан.

Монгол Улсын Засгийн газар. (2020 оны 12/23). Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай. www.legalinfo.mn: <https://legalinfo.mn/law/details/15845?lawid=15845>-ээс гаргасан

Сусан Карни, Кони Энгбретсон, Карен Скаммел, Валерий Шепард. (2003). Харааны бэрхшээлтэй сурагчдад заах нь. <https://pubsaskdev.blob.core.windows.net/pubsaskprod/40209/40209-Vision.pdf>-ээс гаргасан

<https://www.pinterest.com/pin/315885361372734176/?mt=login>

<https://yandex.ru/search/?text=%D0%B1%D1%80%D0%B0%D0%B9%D0%B-B%D1%8C+%D0%BF%D1%80%D0%B8%D0%B-D%D1%82%D0%B5%D1%80&lr=10606>

https://yandex.ru/search/?text=%D1%82%D0%B0%D0%BA%D1%82%D0%B8%D0%B%D1%8C%D0%BD%D0%BE%D1%81%D1%82%D1%8C&lr=10606&src=-suggest_Pers

